

**ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ**



**АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР**

**ТАВДУГААР БОТЬ**



Бясалгал дэвшихийн хэрээр тухайн хүний энерги улам аядуу зөөлөн болдог тул хүмүүс түүнд улам их татагддаг.

*“Бие далдлах ид шид” айлдвараас.*





Хамаг төрөлтийг аврах арга зам нь цаг үе өөр болоход ч бас зохицож байх ёстой.

*“Бие далдах ид шид” айлдвараас.*



Нэгэн Их Багшийн хүнийг гэтэлгэх арга нь хачирхалтай бөгөөд сэтгэгдэшгүй. Их Багш маань: “Бүжгээр ч гэсэн хүнийг гэтэлгэж болно.” хэмээсэн.

**ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ**

**АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР**

**ТАВДУГААР БОТЬ**

**ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ОЛОН УЛСЫН НИЙГЭМЛЭГ**



## АГУУЛГА

Намтрын өмнөх үг .....	6
Товч илгээлт.....	7
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар.....	8
Өмнөх үг .....	12
1. Бие далдлах ид шид.....	13
2. Өөрийн бурхан чанараа танихуй.....	28
3. Төгс Гэгээрсэн Их Багш хамаг төрөлтнийг гэтэлгэхийн төлөө л энэ дэлхийд ирдэг .....	46
4. Хэрхэн үргэлж буяны үрийг суулгаж, нүглийн түйтгэрээс ангид явах вэ?.....	69
5. Гай гамшиг бүхэн бодол санаанаас л үүсдэг .....	79
6. Орчлонгийн од гарагийн үлгэр .....	95
7. Бясалгал дэвших нууц арга .....	109
8. Төвөдийн нууц бясалгал, хувцас хатаах номын ёс... 118	
9. Арьяабалын бясалгалын арга ид шидээс юугаараа ялгаатай вэ? .....	130
10. Төгс Гэгээрсэн Их Багшийг харахын төдийд туулан гэтэлнэ.....	146
11. Бодьсадва Махасадвагийн ажил төрөл.....	158
Веган хоолны ач тус.....	186
Эрүүл мэнд ба хоол хүнс.....	187
Экологи ба хүрээлэн буй орчин.....	190
Дэлхийн өлсгөлөн .....	191
Амьтны зовлон зүдүүр.....	191
Гэгээнтнүүд ба үйлс нэгтнүүд .....	192
Авшиг хүртэхүй - Арьяабалын бясалгалын арга .....	194
Таван сахил.....	196
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт .....	197
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ? .....	200

## **НАМТРЫН ӨМНӨХ ҮГ**

Ихээр билиг нээгдсэн нэгэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар болон энэ ертөнцийн үг хэлээр илэрхийлэх боломжгүй байдаг. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичээнгүйлэн тодорхой дүрсэлсэн ч бүрэн гүйцэд өгүүлэх аргагүй. Эрт цагт Энэтхэгийн нэгэн бясалгагч Багшийнхаа намтар түүхийг бичихээр томилогджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг түүнээс асуухад дуусаагүй гэв. Дахин хэсэг хугацаа өнгөрсний дараа мөн л асуухад: “Миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн болохоор түүний дэсэд хүрч байж л би Багшийнхаа дүрстэй, дүрсгүй ажлыг жинхэнээр нь ойлгож чадна. Тийм болохоор энэ ажлыг хэзээ ч дуусгах аргагүй юм.” гэжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн урьдын амьдралын түүхээ дурдсан нь тун бага. Гэвч олон орны шавь нар нь Багшийнхаа намтрыг ихэд сонирхож, янз бүрийн асуултыг давтан тавьдаг учраас өөрийн түүхээ нээн өгүүлсэн билээ. Энэхүү товч намтарт Их Багшийн амьдралын замнал, түүхээс нь эмхэтгэн цуглуулж, найруулан бичсэн байна. Иймээс бүрэн гүйцэд биш байхыг үгүйсгэх аргагүй тул хүлцэл өчье.

## ТОВЧ ИЛГЭЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь уран бүтээлч, оюун санааны агуу хөтчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх бүхий л хэлбэрт дуртай. Иймээс Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр бөгөөд амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” (үзэсгэлэнтэй сайхан) гэдэг нэр энэхүү эрдэнийн арал болоод ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн нутаг орон, ард иргэдэд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.



## **ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР**

### **ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМ**

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинаа алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн юм. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лак (Вьетнам)-ын төв нутагт мэндэлж, Европт очиж суралцсан бөгөөд тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажилласан байна. Тэрээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон зүдүүрээр дүүрэн байгааг даруй олж мэдээд үүнээс ангижрах арга замыг эрэн хайхаар шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болжээ.

Тэрбээр тухайн үед герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн, өөрийн зорилгоо биелүүлэх аяндаа морджээ. Ийнхүү Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрэн хайж, сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнаж эхэлсэн байна. Эцэст нь Энэтхэгийн Хималайн ууланд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш түүнд дотоодын Гэрэл ба Аялгууг ажих “Арьяабалын Бясалгалын Арга”-ыг уламжилжээ. Ийнхүү тэрбээр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрчээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980-аад онд байгуулагджээ. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, тэднийг өөрийн дотоод дахь бурханлаг чанараа нээн илрүүлэхэд нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк зэрэг таван тив болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном тайлуулахаар урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай зовж зүдэрсэн олонд энэрэн нигүүлсэх сэтгэлээрээ бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь бүхий л хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуучууд, дорой буурай амьдралтай өндөр настнууд, хоригдлууд, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг хүмүүст түгэн хүрчээ.

Дулаарлаас үүдэлтэй төрөл бүрийн хямрал дэлхий дахинд нүүрлээд байгаа өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг бөгөөд байгалийн элдэв гамшигт нэрвэгдэгсдэд туслуулахаар нийгэмлэгийнхээ гишүүдийг дэлхийн бүхий л оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ дэлхийд бидэнтэй зэрэгцэн оршигч эрхэм ариун амьтад болон хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг билээ.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болж байна. Их Багш өөрийн уран зураг, дэнлүү чимэглэл, хувцасны загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлүүдийнхээ орлогоор Эзэн Бурханы тусламж хэрэгтэй үр хүүхдүүдийг дэмжин тэтгэдэг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдралд”, “Миний амьдрал дахь ноход”, “Эрхэм ариун амьтад” хэмээх гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулагдаад байна. Их Багш телепат холбоо болон сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг эдгээр бүтээлүүддээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 сард “Гэрэлт Дэлхийн Манлайллын Шагнал”-ыг, мөн удалгүй “Гэрэлт Дэлхийн Баатарын Шагнал”, “Гэрэлт Дэлхийн Нигүүлсэнгүй Үйлсийн Шагнал”, “Гэрэлт Дэлхийн Шударга Үйлсийн Шагнал”, “Гэрэлт Дэлхийн Зохион Бүтээгчийн Шагнал” зэрэг олон цол шагнал бий болгосон юм. Эдгээр нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс орнуудад олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлтай ажил үйлс нь гарагаа улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь

Ерөнхийлөгч доктор Янез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо /IPCC/-ны тэргүүн бөгөөд Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төв (НАСА)-ийн тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амиа үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг нь сайшаан “Тэрэлт Дэлхийн Баатарын Шагнал”, “Тэрэлт Дэлхийн Оюун Ухааны Шагнал”-ыг олгодог бөгөөд үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайр энэрлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон улс орны төр засгийн газар, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн шагнаж, хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Телли-гийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос-Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие сэтгэл харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд өндөр үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг билээ.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригоороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч юм. Үнэн хэрэгтээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Та ийм амьдралыг сонгож болно”, “SOS-дэлхийн дулаарлыг зогсоох нь” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ. Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн



хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан болон түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгоход олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё.” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн билээ. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход нь хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторан Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Гараг ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдсэн сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүн төрөлтөнд хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийдээ гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон, эцэс цуцалтгүйгээр тусалсаар байгаа билээ.

## ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгатай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой яриан хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог.

Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.



## БИЕ ДАЛДЛАХ ИД ШИД

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Шиндиан  
1986 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Өчигдөр Багш нь та нарт ид шидийн тухай ярьсныг санаж байна уу? Хэрвээ бид ид шидэд шунавал тэндээ зогсчихоод дэвшиж чадахгүй болно. Учир нь салхи дуудаж, бороо урих, уулыг нүүлгэж, усыг юүлэх, буурцаг хаян цэрэг болгон хувилгах гэх мэт нь сонирхолтой санагдаад яг л бяцхан хүүхэд тоглоомын зүйлдээ дурлаж, эцэг нь түүнд том машин өгсөн ч тоглоомын бяцхан зүтгүүр тэрэгтээ л дуртай байдагтай адил болох билээ.

Ид шид нь донтолттой адил, ид шидийг муу гэж байгаа юм биш, ид шидтэй байх нь муу явдал биш, Их Багш нар болгон ид шидтэй, гэвч дур зоргоороо ашигладаггүй, бусдын үйл үрийн холбоонд хөндлөнгөөс оролцдоггүй, харин тэднийг биеэ дааж том болоход нь тусалдаг. Та хэрвээ буурцгийн багсармал, дүүфүү мэтийн хоол таны хувьд амттай бөгөөд шим тэжээлтэй байдаг ч нялх хүүхдэд хүчээр идүүлбэл харин шингээж чадахгүй, хүүхэд үнээний сүү уухыг хүсдэг. Бусдад тусалж болно, гэвч түүнийг хүссэн үед нь тусалж болно, хүсээгүй байгаа бол туслах шаардлагагүй. Учир нь тэр хүсэж байна гэдэг нь аль хэдийн том болчихсоныг харуулж байгаа бөгөөд өөрөө гэтлэхийг тэмүүлэн хүсэх цагт нь л тусалж болдог. Тэгэхгүй бол төдийлөн их нэмэр болохгүй. Бясалгаад хоёрдугаар ертөнцөд хүрвэл өнгөрсөн, одоо, ирээдүйн үйл үрээ мэдэж, гуравдугаар ертөнцөд хүрвэл чөлөөтэй нисэн зорчиж, дөрөвдүгээр ертөнцөд хүрвэл жинхэнэ ид шидийн



орон болж, жинхэнэ ид шидийн хүч илрэн гарна. Энэ бол “би”-үгүй ид шид мөн. Хамаг Бурхан Бодьсадва хувилгаан биеэр хаана ч гэсэн илэрч чаддаг, ойлгож байна уу?

Тэд биеэ хувилан тэнд очъё гэж бодсон биш, гэвч хамаг амьтантай ерөөл барилдлагатай бөгөөд туслах шаардлагатай л бол бас дорхноо хувилгаан биеэр илэрдэг. Энэ үед жинхэнэ “би” үгүй учраас хаана ч гэсэн илэрч чаддаг. Гэтэл зарим хүн хэрвээ тиймэрхүү ид шидийг буруу зүйлд ашиглавал донтож, өөрийгөө бүр худалдчихаж ч магад. Яг л сүнсээ худалдсан шиг эцэстээ адын эзний улсад харьяалагдан адын хараат болж, хэчнээн сайн бясалгасан ч ихдээ л адын эзэн болно.

Тиймээс бясалгах нь ч хэцүү болж, ид шидийг буруу зүйлд ашиглавал өөрсдөдөө олон гай тарьдаг. Бид ид шидтэй хүн их байгааг хардаг хэдий ч тэр нь хамгийн дээд номын багш мөн гэдгийг харуулж байгаа хэрэг биш. Учир нь хамгийн дээд номын багш бол ид шидийг ашигладаггүй, өөрсдөө л мэдэж, тун цөөн ашигладаг. Жинхэнэ шаардлагатай үедээ л ашиглаж, шаардлагагүй үед ашиглахгүй. Бусдын сэтгэлийг унших, өнгөрснийг мэдэх, хувилгаан хөлөг мэтийн шидийг тэд ер ашигладаггүй. Чиний юу бодож байхыг мэддэг хэдий ч ярьдаггүй, учир нь яривал бусдын сэтгэлийг самууруулж, айх бодол төрүүлдэг.

Хэрвээ та нар бясалгалын төвд ирэх бүрдээ Багш юуг ч цөмийг мэднэ гэж бодоод надаас айна, ичнэ, тэгээд Багштайгаа уулзахаас эмээх болно. Та нар шиг шавь бол Багшийгаа нэлээд ойлгочихсон тул ичих бодол төрөхгүй байж мэднэ, гэтэл дөнгөж ирж байгаа буюу эхлэн шавилж байгаа хүмүүсийн бодлыг би ил болговол хэчнээн жил болсон ч Багштайгаа дахин уулзахаар ирэхгүй болчихож мэднэ, учир нь хүн болгоны сэтгэлийн хар тал нь сайн талаасаа илүү байдаг.

Үнэндээ хүмүүсийн тэр эмх замбараагүй явдлыг Багш нь ярих дургүй, та нарын боддог тэр явдал нь Багшийнх нь хувьд сайн ч биш, муу ч биш, сайн, муу нь зөвхөн хүмүүсийн үзэл төдий, харин Бурхан Бодьсадвагийн үзэл биш. Иймээс бусдын сэтгэлийг унших, эсвэл өвчин засах тиймэрхүү ид шид нь бүгд хүүхдийн тоглоом, түүнийг ашиглах нь тийм ч их ач тустай биш.

Бясалгаад нэг, хоёрдугаар ертөнцөд хүрвэл өвчин засаж чаддаг. Тиймээс Тайваньд өвчин засах бүлэгтэн их байдаг. Тайжун (tai zhong) буюу Тайнанд ч ийм шашны урсгал байх шиг. Тэд 21 үсгийн хувилгаан тарни уншин, сахиусны хөрөг шүтэн тахиж, бусдын өвчнийг засдаг. Үнэндээ энэ бол зөвхөн хоёрдугаар ертөнцийн дэс төдий, тийм ч сүрхий юм биш. Тэр өдөр би тэднээс:

“Та нар ийм өвчнийг зассаны хойно дараачийн долоо хоногт дахиад өвдөх үү?” гэж асуухад тэд: “Мэдээж өвдөнө!” гэсэн, тийм юм бол ийм өвчнийг засаад юу хийх вэ? Өнөөдөр өвчнөөс аварлаа гэхэд маргааш нь бас л өвдөнө, ингэх нь ямар ач тустай вэ? Тэгээд тэд бас хүмүүсийг ургамал хоол идээрэй гэж шаардахгүй: “Зүгээр ээ, өөрт чинь амар хялбар байвал болно.” гэдэг. Мэдээж гурван ертөнцийн дотор эргэлдэх гэвэл юу хийсэн ч болно, хэн ч тоохгүй. Учир нь та өөр газарт очсон ч, гурван ертөнцөөс салах боломж байхгүйг адын эзэн мэдэх учраас таныг юу хийсэн ч тэр баяртай зөвшөөрөн: “Уухай! Зүгээр юм байна.” гэдэг.

Аав, ээж бологсад хүүхдээ халамжлахгүй, зөвхөн сургуульд суулган хичээл сурлагадаа хэр сайн сурч байгаа эсэхийг нь мэдэхгүй, ухаантай эсвэл бядуу, мунхаг болж байхыг нь ч анзаарахгүй бол ийм аав, ээж нь лавтай чанга чамбай биш. Аав, ээж бологсад хүүхдээ сэргэлэн ухаантай болгоё гэвэл заавал хатуу чанга хандаж, үүнийг сур, түүнийг сур гэж захиж, чармайн сурахад нь тусална. “Юунд таныг дагаж ургамал хоол идэх хэрэгтэй юм бэ?” гэж маш олон хүн Багшаас нь асуудаг. Угаас ургамал хоол идэх ёстой, учир нь бид бар биш, зэрлэг араатан ч биш. Энэ бол тун хялбархан явдал, гэтэл зарим хүн ургамал хоол идэх дургүй байдаг.

Өнөөдөр би та нарт бие далдлах ид шидийн тухай ярина, яагаад бие далдлах ид шид байдаг вэ? Үнэндээ бие далдлах ид шид нь тийм ч сүрхий явдал биш. Биеэ далдлах үед энэ бие махбод чинь явчих биш. Бидний бие махбод урьдынхаараа байж л байдаг ч өөр хүн харж чадахгүй. Яагаад вэ гэвэл бидний биеийн эс бүгд хувирснаас болдог. Жишээлбэл, би ямар нэгэн хүнийг олж харах үед биеийн минь эсийн атомын хэлбэлзлийн давтамж нь дорхноо тэр хүний эсийн атомын хэлбэлзлийн давтамжийн хувиралтыг дагаж адилхан болж хувирсан болохоор “миний” оршиж байхыг тэр хүн харж чаддаггүй.

Гэвч та үүнийг хязгаарлаж чадахгүй, та одоо бие далдлах хэсгээ далдалчихлаа гээд болчих биш, эрхбиш тэр их хүч, хамгийн дээд хүч, бурхны хүчинд найдах хэрэгтэй. Бясалгаад, тэр дэсэд хүрвэл юу хүснэ, түүнийг өгдөг, үүнийг та өөрөө эзэмшиж болно гэсэн биш, бас ингэж биеэ далдалъя гэж бодсоноор биелчихдэг юм биш. Чамд бэрхшээл тулгарах үед тэр дороо “Би биеэ далдалъя, надад тусална уу?” гэж бодох хэрэгтэй. Тэр үед энэ хүч танд зохицуулж өгөх болно.

Иймээс бясалгалаар хэдий чинээ өндөр багш байна төдий чинээ даруу байдаг. Учир нь тэд энэ “би”-гүй болж, “би” үүнийг

хийсэн биш, аливаа Их Бурхад, орчлонгийн хүч л хийдэг, “би” зөвхөн бага зэрэг ашиглаж, түүний нэг хэсэг нь болж болно гэдгийг ойлгож байдаг. Гэвч тэр нэг хэсэг нь мөн л бүх хэсэг нь болно, хэрвээ та энэ саванд байгаа усыг горхинд юулбэл горхины нэг хэсэг нь болно. Энэ хэсэг нь бусад хэсэгтэйгээ нэвтрэлцэн энэ усны урсгал болов гэж ярьсан ч болно.

Үүнтэй адилаар бидний бясалгал дээшлэх тусам хамгийн дээд хүчний нэг хэсэг нь болдог. Учир нь энэ орчлонгийн хүчтэй нэвтрэлцээд нэг цогц болсон тул бид юу хэрэглэсэн ч бүгд байх болно. Гэвч бид эгэл хүн шиг би гэх үзлээрээ хийдэггүй. Их Багш нар бол “би” үүнийг хийсэн гэж ярьдаггүй, “Би хийсэн биш, миний эцэг Диваажинд хийсэн.” гэж Есүс Христ хэлсэн.

Гэвч хүн болгон ингэж хэлмэгц эцэг нь дорхноо диваажингаас бууж ирээд түүнд хийгээд өгчихдөг биш юм. Энэ нь Есүс Христийн дэстэй холбоотой. Иймээс, Есүс Христийг тийм ч сүрхий биш, энгийн хүнтэй адилхан гэж ярьж болохгүй. Хэрвээ түүний бясалгал нь сайн биш, үлэмж их буян байхгүй байсан бол их хүчний нэг хэсэг нь болж чадахгүй бөгөөд хүсэн даатгамагц эцэг нь дорхноо бууж ирээд түүнд тусалж чадахгүй.

Бие далдлах ид шидийг бид өөрсдөө эзэмшиж чадахгүй, гэхдээ бас бидний бясалгалын дэстэй холбоотой. Энэ нь хувилгаан биеийн байдалтай адил, хувилгаан бие ч мөн л аяндаа хувилдаг, “би” одоо биеэ хувилан хэн нэгнийг аварна гэж Багш нь бодсон биш, хэрвээ тэгэхэд хүрвэл жинхэнэ би гэх үзэл, мөн л адын эзэнд харьяалагддаг, ойлгож байна уу? “Хувилгаан бие” бол аяндаа байж, шаардлагатай үед дорхноо илрэн байж байх болно. Жишээлбэл: одоо энэ хүнд Багш туслах хэрэгтэй бол Багшийн хувилгаан бие дорхноо хүрч очин авардаг. Гэхдээ Багш энэ хүчийг эзэмшсэн биш, гэсэн ч тэр нь бас Багштай чинь холбоотой. Учир нь Багш чинь хэдийн энэ хүч болчихсон байна. Яг л нар шиг, түүнийг харъя гэж бодвол хаалгаа онгойлгомогц хардаг. Нар бол аяндаа гарч ирдэг, харин нар өөрөө хийж байгаа биш, нар угаасаа байсан, та харъя гэвэл хаалгаа онгойлгомогц, өрөөг чинь гэрэлтүүлнэ. Нар хэрвээ “Өнөөдөр би энэ айлыг гийгүүлнэ, маргааш тэр айлыг гийгүүлнэ.” гэж бодвол лавтай ихэд яарч, ядарч цуцна.

Иймээс өчүүхэн ид шидийг ашиглавал тун ядарсан шиг санагддаг. Учир нь эрхбиш эхлээд өөрийн толгой тархиараа тарни уншиж, сахил сахиж сурсны дараа л нэг, эсвэл хоёр хүн болж хувилдаг. Гэтэл том ид шид бол аяндаа байж, яг л агаар шиг шаардлагатай үед дорхноо байж байдаг, харин хэн нэгэн хүн тэнд зохиодог биш, ердөө л аяндаа бий болдог юм. Энэ бол “би” үгүй

ид шид юм.

Бясалгаад дөрөвдүгээр ертөнцийг давж, тавдугаар ертөнцөд хүрэх үед ийм “би” үгүй ид шидтэй болдог. Иймээс тун олон хүн Багшид нь: “Та биеэ хувилж чаддаг ид шидтэй тул үүнийгээ бусдад сургавал зохино.” гэж хэлдэг. Үнэндээ энэ бол “би” маань ид шидтэй юм биш, иймээс бусдыг би юунд сургах билээ? Ойлгож байна уу? Би ийм явдлыг ерөөсөө бодоогүй.

“Очир огтлогч судар”-г өгүүлснээр: Бурхан Бодьсадва бол өөрийгөө бурхан Бодьсадва гэж боддоггүй. Хэрвээ өөрийгөө бурхан Бодьсадва гэж бодох, эсвэл олон хэрэг явдлыг хийж, олон төрөлтнийг гэтэлгэж чаддаг гэж бодвол бас л жинхэнэ бурхан Бодьсадва биш гэжээ. Жинхэнэ Бурхан Бодьсадва бол аяндаа байдаг, иймээс хамаг төрөлтнийг гэтэлгэдэг ч гэтэлгүүлэх амьтан байхгүй гэдэг. Учир нь тэдэнд энэ “би” үгүйгээс болж байгаа юм. “Би” энэ хүнийг гэтэлгэнэ гэж ярьж болохгүй, үнэндээ би юу ч хийгээгүй. Энэ “би” бол зөвхөн их хүчний нэг хэсэг төдий, их хүчнээс хувиран хүмүүст харагдаж байдгаас биш, энэ нь жинхэнэ “би” биш. Жинхэнэ “би” бол хэзээ ямагт байж байдаг, юугаар ч дутахгүй бөгөөд юуг ч өгч чаддаг, энэ бол жинхэнэ “би” мөн.

Гэвч бас ингэж бодож болохгүй, үг хэлээр та нарт ярьж сонсохын тулд л би ингэж ярьж байна, тийм биш бол “би” угаас байдаггүй. Байна, гэвч байхгүй, хамаг амьтныг гэтэлгэдэг, гэвч бас гэтэлгэдэггүй. Аливаа бүхэн аяндаа байж байдаг, амьсгал бас аяндаа л байдаг. Учир нь зарим үед амьсгалаа бид бас сэрж мэдэрдэг. Үнэндээ бид амьсгалаа мартчихдаг ч заримдаа санаж болох бөгөөд санаж чаддаг. Бас хязгаарлаж ч чадна, амьсгалын их, бага аа ч хязгаарлаж хянаж чаддаг. Гэтэл хамаг төрөлтнийг гэтэлгэх нь үүнээс ч илүү аяндаа болдог, хамаг амьтад юу хүснэ, түүнийгээ дорхноо олно, Багш хийх шаардлагагүй.

Гэвч энэ (эгэл хүн) “би” нь тэр (хувилгаан бие) “би”-тэй бас холбоотой. Тэгэхгүй бол та яаж өөр хүний хувилгаан биеийг харж чадахгүй атлаа, харин зөвхөн Багшийнхаа хувилгаан биеийг харах билээ? Бүтээгчээс онцгой хүнийг сонгон бурханд тусалдаг нь яг л зарим хүн бурхан болж, бусад нь харин бурхан болдоггүйтэй адил. Нэгэн хүн үнэнхүү цэвэр цайлган, би гэх үзэлгүй бол сая энэ хүчийг шийдвэрлэж чаддаг, тэгэхгүй бол өөрт нь аюултайгаар барахгүй бусдад ч тийм их буян болохгүй. Жишээлбэл: энэ сав цэвэр биш бол ямар ч ховор нандин идээ хийсэн идэж болдоггүй. Идэж боллоо ч анхилам сайхан үнэр, амттай болж чадахгүй. Тийм цэвэр биш бөгөөд жаахан хортой, та нар ч гэсэн “Яагаад бас шороо амтагдана вэ? Муухай амттай юм!” гэж бодно. Энэ нь сав

цэвэр бишээс болсноос биш, доторх юм нь муу биш ээ. Үүнтэй адилаар зарим хүн тийм хүчний нэг хэсэг нь болох гэвэл үнэнхүү цагаан цайлган, өгөөмөр, эсвэл би гэх үзэлгүй бол сая сайн байдаг.

Нэг хүн биеэ далдлах үед түүний эсийн атомын хэлбэлзлийн давтамж нь нөгөө хүнийхээ хэлбэлзлийн давтамжтай адил болдгийг та нар одоо мэдэж авлаа. Гэтэл хүн ихтэй газар тэр илэрвэл энэ хүний хэлбэлзлийн давтамжтай ижил болоод нөгөө этгээддээ харагддаггүй ч өөр нэг хүнд харагдвал яах билээ? Бие далдлагчийн хэлбэлзлийн давтамж нь энэ хүнийхтэй ижил ч нөгөө хүнийхтэй ондоо бол яах вэ? Та нар мэдэх үү, үгүй юу? Гэвч энэ бол доод дэсийн биеэ далдлах эрдмийг үндэслэж ярьж байгаа хэрэг, дээд зэргийн бие далдлах эрдэм нь биеэ далдлагч хэлбэлзлийн давтамжаа ихээхэн өндөр болгодог тул эгэл хүний нүдээр харж чадахгүй. Жишээлбэл: би энд сууж байхад эргэн тойрон хааяагүй хүмүүс байвал яаж биеэ далдлах вэ? Энэ үед миний бие эрхбиш тал бүрд байгаа хэлбэлзлийн давтамжид хувирч, та түүнийг харвал бие минь тэр хүний хэлбэлзлийн давтамжтай адил болсон байна, энд бол харин дорхноо энэ хүний хэлбэлзлийн давтамж болж хувирдаг. Иймээс олон хүн байгаа газарт илэрч байсан ч хэн ч харж чадахгүй. Гэвч нөгөө этгээд чинь ойрвол тантай мөргөлдөх болно. Биеэ далдлах үед бусад хүн таныг хардаггүй ч та харин харж байдаг.

Иймээс зарим хүн наашаа ойртоод ирэх үед та жаахан зай гаргах хэрэгтэй. Тэгэхгүй бол тэр хүн таны байгааг анзаарч мэдэх болно. Тэр хэрвээ тантай мөргөлдвөл таныг олж хардаг. Учир нь тэр үед бидний мэдрэлийн систем эхлэн сэрдэг. Энэ эгэл хүний сэтгэл жаахан сэргэж эхлэх үед бие далдлах шугам таслагддаг, ойлгож байна уу? Биеэ далдлах ид шидийг шинжлэх ухаанаар тайлбарлаж болно, болохгүй зүйл биш юм.

**Асуулт:** -Бие далдлах үед хэдий олж хардаггүй ч бие махбод мөн л байж байдаг уу? Байдаггүй юу?

**Багш:** -Бие махбод байдгаараа байж байдаг, нүүр царай мөн л хэвээрээ, харин алга болчихдог биш. Саяхны ярьсан нь бол жинхэнэ бие далдлах явдал болно. Үүнээс гадна өөр бас нэг зүйлийн бие далдлах явдал нь: бид тун тайван, нэг зүйлийн уян зөөлөн ахуй орчинтой байвал, хэдий та бид энд байвч бусад хүн харин бидний байгааг мэддэггүй. Тэд биднийг хардаг ч байж магад, гэтэл хараагүй юм шиг байдаг. Учир нь бид тэдний орчинд харшилдаггүй. Бид бясалгалаа сайхан хийж байтал сэтгэл нь тун үймсэн хүн ирж шуугиан үүсгэвэл бид лавтай түүний байгааг анзаарч мэднэ. Гэтэл тэр тайван намуухан ирж тэр дорхноо ард

очиж бясалган сууж, үг ярихгүй, дэндүү хөөрсөн бодол байхгүй бол бид түүний байгааг мэддэггүй, ойлгож байна уу?

Иймээс заримдаа олон хүн ч хэрүүл зодоонгүй нам тайвнаар хамт амьдарч болдог. Учир нь тэдний ахуй орчин нь харилцан бараг ижил, бусдын ахуй орчинд харшилдаггүйгээс болж байгаа юм. Бид ямар нэгэн газраар явахдаа үг ярихгүй ч зөвхөн бурхныг санан дурсвал, бусад хүн хэдийгээр биднийг хардаг ч яг л ямар ч хамааралгүй шиг байдаг. Гэтэл үг яримагц бусад хүн бидний байгааг мэдчихдэг.

Иймээс үг хэлэх нь тун муу явдал байж бүхий л ахуй орчныг хэлбэлзүүлдэг. Учир нь үг хэлэх үед хэлбэлзэл үүснэ. Юу ярьсан ч бүх юманд хэлбэлзэл үүсдэг. Уул нь туйлын нам тогтуун хэлбэлзэлтэй байснаа үг хэлсний дараа самуурчихдаг. Иймээс олон явдал үүсэж, хожим нь харилцан зодолдож мэднэ. Хэрвээ бид нэлээд самгардсан ахуй орчныг үүсгэвэл, тэр хүчин бидний биед тусгагдаж, муу нөлөө үүсгэдэг. Иймээс хэдий бага яривал төдий сайн.

Бид үг ярихгүй үед бидний оршин байхыг хэн ч мэдэхгүй, энэ нь бас нэгэн зүйлийн бие далдлах эрдэм болно. Үнэн шүү, заримдаа та нэгэн том цайллагад оролцоод хүн бүр дуулан бүжиглэж, архи уун юм ярьдаг ч та дув дуугүйхэн орж очвол, таныг анзаарах хүн байхгүй. Өмнө нь очсон ч тэр бас таныг харахгүй ч байж мэднэ, тийм үү, үгүй юу? Учир нь тэд өөрийн хэрэг явдлаа ярилцан бид ч тэднийг анзаардаггүй тул яг л байхгүйтэй адилхан.

Бясалгалтан ч адилхан, түүний ахуй орчин нь улам уян зөөлөн болдог тул бясалгал нь өндөржих тусам хүмүүс улам ойртох дуртай болдог. Учир нь бясаллагчид ямарваа ахуй орчинд байсан ч сэтгэл хөөрдөггүй. Бясалгалын түвшин дээшлэх тусам олон хүнтэй зохицож чаддаг. Иймээс хүн болгон танд дуртай, учир нь хүн бүр тантай ойртвол бүгдэд л тун таатай санагдан, өөр хүнтэй ойртвол ер нь тааламжгүй мэт санагддаг. Учир нь дээд түвшний бясаллагч бол бусдын орон зайд халддаггүй тул сая хүмүүст таатай санагддаг. Бид ердөө: “Тэр, тэр тун уян зөөлөн, түүнтэй хамт байхад тун таатай.” гэж ярьдаг нь ийм санаа билээ! Ойлгож байна уу? Зарим хүн бусдын арга аашийг алдуулан юу ч яриагүй бөгөөтөл, юу ч хийгээгүй байтлаа бусдад таагүй тавгүй сэтгэгдэл төрүүлдэг. Учир нь түүний дотоодын ахуй орчин нь дэндүү үймээнтэй байдгаас болж байгаа юм. Бидний бодол санаа тун чухал, хэдийгээр гараа хөдөлгөж, бусдыг зодохгүй ч бодол санаа нь тун хэрцгий, түүнийг зодох сон гэж айхавтар боддог бол тэр хүн нь тавгүйтэж өвчлөхөд хүрдэг.

Зөвхөн урьд цагт ч биш, одоо ч гэсэн хар шидийг ашигладаг хүн бас байж, бодлоороо алсаас бусдыг хорлодог. Тэр тарни, ид шид хэрэглэж, нэг зураг, эсвэл нэг ширхэг үс тавьсан ч байж мэднэ. Тэгээд муу бодлоороо алсаас тэр хүнийг хорлодог. Харин заавал түүнтэй ойртвол сая хорлож чадна гэсэн хэрэг биш.

Иймээс бие, хэл, сэтгэл тун чухал. Зөвхөн бие махбодоороо л хүнийг зодож чадна гэсэн биш, бодол санаагаараа хорлох нь ч адилхан. Тэр ч байтугай бие махбодоос ч хэцүү байдаг. Учир нь бие махбодоо зодуулбал та жаахан шархтаж мэднэ, тэгээд эм түрхэх юм уу, жаахан анхаарч сувилбал сайн болж болно.

Гэтэл сүнслэг бие бол нэг зүйлийн харагддаггүй бие мөн. Хэрвээ шархадвал бид бас яаж эмнэж засахаа мэдэхгүй бөгөөд хялбархан эдгээж чаддаггүй. Эдгээе гэвэл сайтар бясалгах хэрэгтэй. Эсвэл нэгэн сайн багшийг эрж харгалзуулж байж хэсэг хугацаа өнгөрсний дараа сая эрүүлждэг. Гэвч бие махбод шиг тийм түргэн эрүүлждэг биш, иймээс бие махбодын хариу мэдрэмж нь бодол санаанаас нэн хэцүү биш. Жишээлбэл: бид нэг хүнд үнэхээр их уурлан зодохыг боддог ч гараа хөдөлгөлгүй, зөвхөн өдөржин боддог төдий байхад ч цаадах хүн мэдрэлийн өвчинтэй болох юм уу, санаа сэтгэл тогтуун бус болдог. Гэхдээ шалтгааныг нь өөрөө ч мэддэггүй. Бодлоороо бусдыг хорлох нь ийм хэцүү тул та нар өөрийн бие, хэл, сэтгэлээ сайтар анхаарч хянах хэрэгтэй.

**Асуулт:** -Багш аа, миний уншсан нэг номд Энэтхэгийн зарим хүн бие далдлах эрдмийг бясалгаж байна гэж тэмдэглэсэн байна. Гэтэл түүний дэс нь гурван ертөнцийг ч гэтлээгүй аж, бусад доогуур дэсийн бясалгалын аргаар бас бие далдлах ид шидийг бясалгаж болох уу?

**Багш:** -Тийм, энэ нь зөвхөн ид шид төдий, энгийн хүн бас бясалгаж болно. Тэд бясалгаад нэгдүгээр ертөнцөд хүрээгүй хэдий ч бас бясалгаж болно. Бие далдлах ид шид нь зөвхөн нэгэн зүйлийн мэргэжил болохоор мэдээж сурч болно. Ид шидийг бясалгаад жинхэнээр туулан гэтэлж чадахгүй. Унтуулах эрдэм ч адилхан, энгийн хүн бас сурч болно. Тэд мөн л үргэлжлэн мах идэж, архи уун, бясалгал хийдэггүй хүмүүсээс ялгаагүй. Миний очигдрийн ярьсан хоёр, гуравдугаар ертөнцийн ид шид бол аяндаа байдаг ид шид. Бясалгасны хойно аяндаа ийм ид шидтэй болдог. Харин зориудаар бясалгасан юм биш. Миний ярьж байгаа нь Арьяабалын бясалгалын арга болно. Та бясалгаад тийм дээд хүрэх юм бол аяндаа тийм ид шидтэй болдог. Үүнийг бид зориудаар хүссэн биш, ойлгож байна уу? Мэдээж бясалгавал яагаад ид шидтэй болохгүй байж болох вэ? Гэтэл зарим хүн



зориудаар ид шид хайж, ид шидийг суралцдаг, тэр хүн үнэндээ нэгдүгээр ертөнц хүртэл ч бясалгаагүй байтлаа гурван ертөнцийг яаж гэтэлж чадах билээ?

**Асуулт:** -Зарим хүн зориудаар бие далдлах ид шидийг бясалгавал, тэр бие далдлах хүчин нь орчлонгийн уугуул хүчнээс гаралтай биш гэж үү?

**Багш:** -Тийм, сайн, муу хүч нь бүхий л орчлонгоос үүсэлтэй гэж би хэдэнтээ ярьсан. Та цахилгаанаар хүнийг хорлож ч болно. Цахилгаан сайн, мууг хамаардаггүй. Тэр бол зөвхөн нэгэн зүйлийн хүч, түүгээр юу хийх нь чиний дур. Гэтэл цахилгаанаар бусдыг хорлох нь муу гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Иймээс хамгийн сайн нь бусдыг хорлож болохгүй, цахилгаанаар гэрэл гаргах, эсвэл бусдад туслах нь л сайн. Аливаа бүхнийг бидний чөлөөт үзэл ухамсар үйлдэж байгаа гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Эзэн Бурханыг битгий буруутга, тийм биш, Эзэн Бурхан тун сайн. Та нарын боддог шиг тийм Эзэн Бурхан чухам байдаг эсэхийг би мэдэхгүй. Гэтэл байдаг бол тэр тун сайн, ямар ч муу явдал үйлдээгүй, аливаа бүхнийг бид өөрсдөө үйлддэг.

**Асуулт:** -Багш аа, Бурханы тэнгэрийн нүд нь аль түвшинд байдаг вэ?

**Багш:** -Нэгдүгээр ертөнцөд ч тэнгэрийн нүдтэй байж болно. Гадаадын нэгэн увш (гэртээ байж бясалгадаг бясалгагч), чиний аль улсад байгааг чинь нэвт харж чаддаг. Тэр таныг таньдаг л бол чиний ямар өвчтэйг чинь ч мэддэг. Нэгдүгээр ертөнцөд ийм ид шидтэй байж болно. Түүний зорилго нь бусдад тусалж, бурхны шашинд нэг зүйлийн итгэл төрүүлэхийн төлөө л ид шидийг ашигладаг. Гэвч ингэх нь ч сайн биш, зориудаар бусдыг хүчээр бурхан шашинд итгүүлж байгаа хэрэг, ингэх нь мөн л ялгаварлах үзэлтэй байгаа хэрэг.

**Асуулт:** -Энэ увшийн ингэж хийж байгаа нь дөхөм аргад тооцогдох уу?

**Багш:** -Хэрвээ Шагжамуни Бурхан бас ингэсэн бол бүх дэлхийгээрээ бүгд түүнд итгэчих байсан. Гэтэл Тэрээр ид шид ашиглаж байгаагүй бөгөөд Моллом тойныг ид шид битгий ашигла гэж сануулсан байдаг. Моллом тойн байнга ид шид хэрэглэн үүнийгээ хүмүүст гайхуулах үед Бурхан Багш үргэлж загнадаг байжээ.

**Асуулт:** -Тэр увш бас ямар нэгэн номын багшид тусалж эмнэлэг байгуулбал ач буян нь хязгааргүй болох уу?

**Багш:** -Энэ бол нэгэн эрх чөлөөт улс болохоор юу хүснэ,

түүнийгээ хийж болно. Нэгэн эмнэлгийн газар байгуулах нь тийм ч сүрхий явдал биш. Америкчууд олон эмнэлэг байгуулсан, католик шашинтнууд ч ялгаагүй, гэвч хүн бүхэн ийм зүйл хийх шаардлагагүй. Энэ ертөнц хязгааргүй уудам, нэгэн эмнэлгийн газар байгуулах нь тун өчүүхэн хэрэг. Эмнэлгийн газар бол зөвхөн мөнх бусын махан биеийг түр зуур аврах төдий зүйл. Харин бидний сүнсэн биеийг мөнхийн амьсгалтай болгож чадахгүй. Гэтэл бүгдээрээ харин түүнийг том хэрэг явдал болгодог. Үнэндээ тийм ч сүрхий явдал биш. Католик шашинтны байгуулсан эмнэлгийн газар нь биднийхээс олон. Лан Ү Ди хаан сүм хийд ихээр байгуулж, тоолшгүй олон лам нарт өглөг өгсөн. Ингэсэн ч Бодьдармаа түүнийг жаахан ч ач буянгүй гэж ярьсан байхад нэгэн эмнэлгийн газар байгуулахыг бүр хэлэх ч юм алга. Хэрвээ хайр энэрлээс үүдэж, эмнэлгийн газар байгуулан өвчтөнийг аварсан бол тун сайн явдал мөн. Хэрвээ нэр ашиг, эсвэл ач буяны төлөө хийсэн бол тун ч буруу явдал болно.

**Асуулт:** -Багш та, сайн, муу хүч, эсвэл муу бодол нь бусдыг хорлоно гэж ярьсан. Хэрвээ би одоо: “Хэн нэгнийг багалзуурдана.” гэж байнга бодвол тэр хүн бусдад хоолойгоо багалзуурдуулж байх шиг байдалтай болдог уу?

**Багш:** -Тийм, зөн совиндоо мэднэ, тийм ч тод сэрж мэдрэхгүй байж магад, гэвч тэр хүнээс их айх мэт болдог. Үнэхээр багалзуурдуулж байгаа биш, зарим үед энэ нь зөвхөн нэг зүйлийн сэтгэлгээний үйлдэл төдий байдаг. Бид их уурлах үед багалзуурдуулчихсан шиг санагдаад амьсгалж чадахгүй болдогтой адилхан. Тийм төөрөгдөл нь бидний уурласан сэтгэлгээнээс үүсэж, өөрөө өөрийгөө хорлож байгаа хэрэг. Харин бусад хүн ингэж бодсон хэрэг биш.

**Асуулт:** -Гэтэл бясалгаж байх үедээ уурлахгүй бол зохих биш үү?

**Багш:** -Урд нь та ямар бясалгалын аргаар бясалгаж байсныг би мэдэхгүй. Яаж бясалгаж суудаг байв? (Урьд нь би бурхныг дурсаж, долоо хоногийн даяанд бясалгаж суух болгонд бясалгаж эхэлмэгц, хамт бясалгаж байгаа гурван хүнтэй хамт бидний зүрхийг ямар нэгэн юм дарж, хоолой багалзуурдаад байх шиг санагддаг.) Тийм, гэвч Шагжамуни Бурхан тэгээгүй, хожим нь бүгд л улам ээдрээтэй болсон. Мэдээж, зарим хүн бас мутрын чагж хийдэг. Гэвч тэр нь доод дэсийн түвшин юм. Таныг харахад багш тань мутрын чагж хийж байна уу? Би зөвхөн хүүхэд шиг энд суугаад, тэр ч байтугай заримдаа бас унтъя гэж санадаг. Гэвч та нар цөм нэлээд сайн ахуй ойлголттой, эрх дураар, тун таатай

болж, улам сайжирдаг. Би ямар нэгэн будилаантай аргаар бясалгаж суудаг биш, хэрвээ хүчээр ямар нэгэн сэтгэл догдлох явдлыг хийх, эсвэл санаачилгаараа ямар нэгэн явдал үйлдэх хэрэгтэй болсон бол аль хэдийн сайн биш болчихно. Учир нь орчлонгийн түмэн бодис цөм аяндаа бий болсон, ямар нэгэн зүйлийг онцгойлон үйлдсэн хүнгүй. Хамгийн дээд хүч ямар нэгэн юм зохиогоогүй. Уугуул хүч бол хамгийн дээд, ойлгож байна уу? Аливаа дүрстэй юм бүхэн дуу, өнгийн түвшинд багтдаг. “Хэрвээ өнгөөр надтай уулзаж, дуугаар намайг гоёж байвал энэ нь хүний явдаг буруу зам мөн. Түүнчлэн ирсэнтэй уулзаж чадахгүй.” гэж Очирт сударт тэмдэглэсэн байна. (Гэтэл нууц тарнийн бүлгийнхэн өөрсдийн бясалгалын аргаа бясалгалын хамгийн дээд арга мөн гэж хэлдэг.) Тэд ярьж болно шүү дээ! Би тэдний яриаг хайхрах шаардлагагүй. (Тийм дом, гарын хөдөлгөөн нь хамгийн төгс төгөлдөр мөн үү?) Нэг хүн бясалгаад нэгдүгээр ертөнцөд хүрвэл өөрийгөө хамгийн дээд, “Энэ бол хамгийн дээд Эзэн Бурхан мөн.” гэж ярина. Бясалгаад хоёрдугаар ертөнцөд хүрвэл: “Энэ бол хамгийн дээд түвшин мөн.” гэж ярина. Бясалгаад гуравдугаар ертөнц хүрвэл: “Эсэрваа тэнгэр бол хамгийн дээд нь мөн.” гэж хэлдэг. Гэхдээ бидний мэддэгээр дээшээ бас дөрөв, тав, зургаа, долоо, найм, есдүгээр гэх мэтийн ертөнц байдаг.

Иймээс энэ нь тийм ч сүрхий юм биш. Жишээлбэл: Энэтхэгт йогийн бясалгалтан мянган навчит эрдэнийн лянхуаны ертөнцөд хүрч чадахыг хамгийн дээд түвшин гэж үздэг. Иймээс хүн болгон бүгд л тун төвөгтэй явдал үйлдэж, хэдэн арван жилээр бясалган, янз бүрийн аргаар мянган навчит лянхуаны ертөнцөд хүртэл хөөрөх гэж чармайдаг.

Хэрвээ та тэднээс асуувал лавтай: “Мянган навчит лянхуаны ертөнцөд хөөрөх нь хамаг дээд нь мөн.” гэж хэлнэ. Гэтэл тэнд хүртэл хөөрөх нь дөнгөж эхлэл төдий зүйл гэдгийг бид мэддэг. Гэвч би тэдэнтэй маргалдаж болохгүй, тэд юу ярих нь тэдний эрх чөлөө. Өчигдөр би бас бясалгаад нэгдүгээр ертөнцөд хүрвэл маш олон том бясалгалтан хэмээгчид нааш цааш гүйлдэн байхтай тааралддаг гэж ярьсан. Миний ярьсныг та нар бүгд мартчихсан уу? Бүгдээрээ сэтгэлдээ тогтоогоогүй шиг байна.

(Багш аа, Өү И номын багш хэддүгээр ертөнцөд төрснийг ярьсан биш үү? Гэтэл тэр өөрөө мэдэхгүй, жинхэнэ амьд бурхныг хэрхэн ялган таних вэ? Ямар байдлаас эдгээр дэсийг харж чадах вэ?) Та үүнийг хараад яах гэсэн юм бэ? (Миний ярьсан санаа бол яавал сая өөрөө ойлгож чадах вэ? гэсэн л хэрэг) Багш нь та нарт харуулахгүй гэсэн биш, харсан ч нэмэргүй. Тэнд цөм л ад

чөтгөр, Багш нь та нарт харуулахгүй. Учир нь бясалгалын хүч чинь хүрэлцэхгүйгээс болж байгаа юм.

Нэгдүгээр ертөнцийг харлаа гээд ямар ач тус байх вэ? Авшиг өгсний хойно та нар хамгийн багадаа бүгд л нэгдүгээр ертөнц юм уу, хоёрдугаар ертөнцөд хүрдэг. Нэгдүгээр ертөнцөд хүрэх нь хамгийн цөөн. Хэрвээ нэгдүгээр ертөнцөд хүрээгүй бол гэрэл олж харахгүй, аялгууны ахуй ойлголттой ч болж чадахгүй, ойлгож байна уу? Энгийн хүн бол үнэндээ олж сонсохгүй, бас олж хардаггүй.

**Асуулт:** -Багш та сайн хүний бодол санаа нь нөгөө этгээддээ нөлөөлнө гэж ярьсан, энгийн хүн ч тийм үү? Эсвэл тэр ямар нэгэн дэсэд хүрснээс болсон уу?

**Багш:** -Тэрээр энэ бясалгалын аргаар бясалгадаг л бол бусдад нөлөөлж болно, жирийн хүн ч болно. (Тэр, нөгөө хүнийг хорсох үед, хэдийгээр нөгөө хүн мэддэггүй хэдий ч эцэс сүүлдээ нөлөөлөх үү, үгүй юү?) Нөлөөлдөг! (Хэрвээ түүний бодол нь тийм хүчтэй биш бол танд мэдрэгдэж чадах уу?) Бас жаахан нөлөөлнө, хэдий их хорсвол төдий ихээр нөлөөлнө. Бодол санаагаа хэдий чинээ их төвлөрүүлбэл үүсэх хүч нь төдий чинээ их байдаг. Сөрөг хүч ч ийм, сайн хүч ч адилхан.

**Асуулт:** -Энэтхэгт байдаг нэгэн зүйлийн йогийг кундалин гэдэг, энэ хүч сайн биш гэдгийг би мэднэ, гэтэл маш олон хүн энэ йогоор хичээллэж байх бөгөөд бас сүнсээ гаргаж чаддаг, тэд бас үүнийгээ самади гэж хэлдэг. Тэр нь үнэн үү, худал уу?

**Багш:** -Тэр нь самади мөн. Кундалин (Kundalini) бол бидний бие махбодын хамгийн доод хэсгийн үржлийн эрхтэнд нуугдаж байдаг. (Бидний дотоодод адын хүч байдаг уу?) Яагаад байхгүй гэж? Бидэнд юу л бол юу цөм байдаг, зөвхөн ашиглахгүй бол гарч ирдэггүй. Бидний дотоодод бас маш олон ялгадас байдаг, та түүнийг ашиглах уу? (Бүгд инээлдэв.) (Зарим хүн ийм аргаар бясалгадаг, хэдийгээр тун аажуу байдаг ч эцэс сүүлд нь мөн л сүнсэн бие нь бясалгалаар дамжин билгийн мэлмийгээр нь гарч болно.) Тэд өөрсдөө ингэж ярьдаг, үнэн эсэхийг би мэдэхгүй.

Зөв байж мэднэ. Гэвч тэд маш удаан бясалган, хамгийн доод талын төвөөс аажмаар дээш магнайдаа хүртэл бясалгадаг. Тэгээд тэнд хүрч чадалгүй нас нөгчиж мэднэ. Ингэж бясалгах нь даанч яршигтай, дэндүү ядаргаатай, тийм их цаг завтай хүн байхгүй. Энэ номын ёсоор бясалгахад хэдэн арван жил шаардагдах атлаа бие чинь хуванцар шиг болно.

Үнэндээ жинхэнэ номын цогцос бол зөвхөн Арьяабалын

номын цогцос мөн. Учир нь Их Багш нар таалал төгссөний дараа тэр бясалгалтнууд Эзэн Бурханыг эрж хайх маш дуртай байдаг ч, бясалгаж чадахгүй, яаж бясалгахаа бас мэдэхгүй байдаг тул өөрөө арга олж туршдаг. Тиймээс одоогийн йогийн систем бол диваажинд хүрч чадах зөв замын жинхэнэ номын цогцос биш гэдгийг бид мэднэ. Ойлгож байна уу? Бид ямар замыг итгэнэ, тийм л замаар явах болно.

**Асуулт:** - Католик шашин, эсвэл христос шашин нь зөв зам мөн үү, биш үү?

**Багш:** -Би танд хэлье, шашны нэр нь тийм ч ач тустай биш, тэр Их Багш нар л ач тустай. Шашин бол зөвхөн Их Багш нарын сургаал номлол төдий. Есүс Христ нирваандаа буцсаны дараа тэд Есүс Христийн сургаал ёсыг л уншиж чаддаг. Энэ нь яг л Багш нь өдөр бүр та нарт үг хэлж байхтай адил. Хэрвээ зарим хүн өдөр бүр ирж Багшийнх нь ярихыг сонсвол туулан гэтэлж чадах уу, үгүй юү? Чадахгүй, учир нь би түүнд ном уламжлаагүй. Бясалгалын арга л хамгийн чухал, ярих нь зөвхөн тусламж төдий зүйл. Гэвч шашнуудын тал хувьд нь бясалгалын арга байдаггүй, зөвхөн хагасыг л сонсдог тул ойлгож мэдсэн нь хангалтгүй.

Ногооны нэрийг унших нь ногоог идэхтэй адилгүй, ногооны нэрийг мэдээж унших хэрэгтэй. Гэвч бас ногоог нь заавал идэх хэрэгтэй, зөвхөн ногооны нэрийг унших нь шим тэжээлд хүрэлцэхгүй. Ном судар нь ногооны нэртэй адил учир тийм ч их ач тусгүй, шашин болгон бүгд сайн гэвч амьд сэрүүн байгаа Төгс Гэгээрсэн Их Багш байхгүй бол сайн биш.

**Асуулт:** -Заримдаа бидэнд ховдог, хилэн, мунхаг бодол үүсдэг, ийм бодол үүсэх үед Багшаас тусламж гуйвал тустай юү?

**Багш:** -Та юунд шунадаг вэ? (Эд мөнгөнд) Та нарт тарааж өгсөн бясалгалын өдрийн тэмдэглэл бол та нарыг өдөр бүр өөрийгөө хянан шалгаж, бясалгалаа сайжруул гэсний төлөө билээ. Багшаас тусламж гуйх нь бас ач тустай. Гэвч ховдог, хилэн, мунхаг бодол маргааш нь дахин гарч ирдэг. Учир нь ийм зүйлс бидний төрлөөс төрөлд ихээр нөлөөлсөн тул өдөр бүр бясалгалаа хийж жаахан өөрчлөх хэрэгтэй. Жишээлбэл: бидний ногооны хашаанд өвс их ургасан нь нэлээд атаршиж удсанаас болжээ. Иймээс зэрлэг өвс их, одоо бид өдөр бүр жаахан зулгаах хэрэгтэй. Харин ганцхан өдөрт бүхнийг арилгаж чадахгүй. Учир нь харагддаггүй маш олон нарийн үндэстэй, харахад цэвэрлэгдчихсэн юм шиг ч маргааш нь дахин урган гарч ирдэг. Өвс ургах нь хамаагүй, асуудал нь түүний хэдийд ургасныг мэдэхгүй бол яршигтай болно. Шуналтай болох нь хамаагүй, гэвч харин тэр даруйдаа сэрж мэдэхгүй бол

төвөгтэй болно, ойлгож байна уу? Хүн болгон цөм дутагдалтай, алгуурхнаар өөрчил!

**Асуулт:** -Багш аа! Бодьсадва хувилгаан биеэр хүнийг гэтэлгэхэд түүний махан бие нь бас нэг зүйлийн хувийн чанартай байдаг. Энэ нь түүний өнгөрсний дадал зуршлаас шалтгаалсан уу? Учир нь Бодьсадвад нэг зүйлийн тогтсон дадал зуршил гэж байдаггүй, гэтэл Их Багш Ингуан маш чанга хүн байсан, харин Багш та тун намуухан зөөлөн байдаг. Яагаад ийм ондоо байдаг юм бэ? Багш та, заавал ийм аргаар хамаг амьтдыг гэтэлгэвэл сая хамаг амьтдад ач тустай байдгаас болсон уу?

**Багш:** -Та нарт Багш чинь тийм ч хатуу чанга биш санагдаж байна уу? (Бүгд инээлдэв) зарим хүн Багшаас чинь тун айдаг байхад та яагаад Багш тийм хатуу чанга биш гэнэ ээ. (Миний хэлсэн санаа бол Бодьсадва хувилгаан биеэр хамаг төрөлтийг гэтэлгэхэд иймэрхүү зан чанар төлөвшил нь хамаг амьтанд ач тустай болохоор тийм янзтай болсон байх, тийм үү?) Тийм, тэр өнгөрсөн төрөлдөө ямар байсан нь хамаагүй, одоо бясалгал хийж өөрчлөх хэрэгтэй, энэ бол хамаг амьтны аяыг дагах гэгч болно.

(Бидний өнгөрсөн үеийн зан чанараас шалтгаалж энэ төрлийн маань зан араншин бүрэлддэг үү?) Та нарынх бол үйлийн үрээсээ болдог. Бурхан Бодьсадва адил бус цаг үед, адил бусын аргаар хамаг төрөлтийг гэтэлгэх хэрэгтэй. Цаг үе болгонд адил бусын төрөлтөн тун их. Төрөлтөн болгонд адилгүй арга хэрэглэдэг. Цаг үе болгонд бас адилхан аргыг хэрэглэж яаж болох вэ? Урьд цагийн хүмүүс ууланд суун бясалгаж, бурхныг дурсах завтай байж. Энэ цаг үед харин тун хүчир, хүмүүс завтай болохоороо зурагт харна, сонин уншина, машин жолоодож, зугаалахаар явна. Амралтын өдрүүдэд (бямба, ням гарагт) бас зоогийн газар хоол иднэ, бас цэцэрлэгээр зугаална, ийм байхад та түүнийг яаж өдөр бүр ууланд бясалгал хийлгэж чадах вэ? Одоо ууланд бясалгамаар газар олдохгүй, бүгдийг нь гадаа хооллож, буудалладаг хүмүүс эзэлчихжээ.

Одоо бол дээр үеийнхтэй адилгүй, цаг үе ондоо болсон тул хамаг төрөлтийг гэтэлгэх арга ч ондоо байх хэрэгтэй. Хэрвээ би одоо бас дээр үеийнхтэй адил өдөр бүр харааж, зодвол бүгдээрээ аль хэдийн зугтаж, энд ирж ном сонсох хүнгүй болно. Иймээс намуухан шиг байх хэрэгтэй. Үнэндээ Багш нь бас тун хатуу байдаг, хэн намайг хатуу биш гэж хэлсэн юм? (Бүгд инээлдэв.). Заримдаа би тун ч хатуу шиг санагддаг. Би ингэх дургүй. “Та тийм хатуу чанга байж болохгүй. Шавь нартаа арай зөөлөн байж болно.” гэж өөртөө хэлдэг. Би шавь нараа ихэд загнадаг байтал та яагаад

бас Багш тийм хатуу чанга биш гэж хэлнэ вэ? Үнэн шүү, би тун гайхаж байна! (Учир нь гаднах ихэнх Багш нар тун чанга, Багшид өчигдөр ярьсан номын багш хүн зоддог, аймаар сүртэй!) Би тийм дэсэд хүрэхгүй, би түүнээс ч доогуур дэстэй (Бүгд инээлдэв), энэ талаар би бас түүнд шавилах хэрэгтэй байх. Нэлээд хэдэн жил бясалгасны дараа л хүнийг бага зэрэг зодож чадаж магад.

(Багш аа: Хүн зоддог тэр номын багш шиг хүмүүс төгс гэгээрэлд хүрч чадах уу?) Хэрвээ тэр бясалгал хийвэл алдаагаа засах болно. Хүн алсан байтлаа бясалгаж болж байхад тийм хүн яагаад болохгүй гэж? Асуудал нь түүнд бясалгах цаг байхгүй. (Хүн алсан хүн гэмшсэнийхээ хойно, бясалгахаа өөрөө ойлгох боломжтой байдгаас болсон биш үү? Гэтэл тэр номын багш өөрийгөө тун өндөр дэсэд хүрч, хэдийн номын багш болчихсон болохоор бясалгах шаардлагагүй гэж боддог ч байж мэднэ.) Хэлж мэдэхгүй юм. Тэр нь түүний хувийн зан чанар. Үнэндээ тэр тийм бардам зангүй, өнгөн дээрээ тийм байдалтай байж чаддаг хэдий ч үнэндээ тийм биш. Гэхдээ түүнийгээ өөрчилж чадахгүй дээ биш, харин бясалгах цаг байхгүйгээс болсон байж мэднэ. Учир нь дэндүү их будилаантай хариуцлага үүрч байгаа болохоор бухимдаж, найдаж болмоор орон байгааг мэдэхгүй, бүгд түүнийг бухимдуулж, тайван сайхан бясалгах цаггүй болгодог. Бясалгахад ч гэсэн сэтгэл нь тайван болж чадахгүй, учир нь бухимдал нь дэндүү их болохоор уур хилэн нь дорхноо бадардаг. Тэгсээр зөв, бурууг ялгалгүй бүгдийг загнадаг, учир нь аливаа юм ондоо ондоо байдгийг харж чаддаггүй юм! Харин энэ хүн үнэхээр муу гэсэн хэрэг биш.





## ӨӨРИЙН БУРХАН ЧАНАРАА ТАНИХУЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Пү Хү  
1987 оны 2 дугаар сарын 13-ны өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Их Багш гэдэг нь ямар утгатай вэ? гэвэл бурхан Будда (Buddha) гэсэн утгатай, Buddha гэдэг нь самгарьд үг, ихэд билиг нээгдсэн хүн, гэрэл гялбаатай хүн, ухаарч сэхээрсэн хүнийг хэлж буй. Иймээс бид түүнийг Бурхан, Buddha, эсвэл номын Их Багш, жинхэнэ Багш, Их Багш, Гэгээнтэн, Их Бодьсадва гэх мэтээр хүндэтгэн нэрлэдэг, энэ нь бараг бүгд адил утгатай. Бид энэ орчлонгийн амь насны үзэгдлийг бүрмөсөн давчихсан хүнийг хүндэтгэдэг, тэрээр өөрийгөө хэн болохоо ойлгодог, хамаг амьтдын хэн болохыг ойлгодог, иймээс бид түүнийг Их Багш, эсвэл Бурхан гэж хүндлэн дууддаг.

Гэвч Бурхан хаанаас ирэв гэвэл бас л жирийн хүнээс гаралтай, бурхныг харахад бидэн шиг нүд, чих, ам, хамар болон бие махбодтой байдаг, эрэгтэй нь эр хүн шиг харагдаж магад. Гэтэл эмэгтэй бурхан ч бас байдаг, бурханд угаасаа эрэгтэй, эмэгтэйн ялгаа байхгүй, гадна төрх нь бурхан болохынхоо өмнөхтэй адил байдаг хэдий ч дотоодод нь харин хувиралт гардаг, сэтгэлээ хувируулахаас биш гадна төрхөө хувируулдаггүй. “Олонх бурханта судар”-т тэмдэглэснээр лусын охин найман настайдаа бурхан болсон гэдэг. Үнэндээ эрэгтэйчүүд л бурхан болж чаддаг гэж бид сонсож байсан. “Олонх бурханта судар”-т Шагжамуни Бурхан буруу үзлийг үгүйсгэн, хүмүүс ийм үзэлд хүлэгдэхээс сэргийлэхийг хичээж, лусын охины бурхан болсон түүхийг ярьсан

байна. Лусын охин бол далайд амьдардаг Тэнгэрийн найман лусын нэгэн төрөлтөн. Үнэндээ бид цөм хүн төрөлтөн л бурхан болж чаддаг, лус, тэнгэр, сахиус нь бурхан болох боломжгүй гэж ярьдаг, гэтэл “Олонх бурхант судар”-т лусын охин ч бурхан болдог, сонин биш үү? Тэр хүн төрөлтөн биш бөгөөд эрэгтэй ч биш байтал яагаад бурхан болж чадсан бэ? Энэ нь тун нууцлаг байдал болно, яагаад вэ? гэвэл Манзушир Бурхан лусын ордонд залран ном тайлж, Арьяабалын бясалгалын аргыг сургажээ. Ийм боломж их бий, хожим нь лус бурхан болсон байж мэднэ. Учир нь бурхны хүч хязгаарлашгүй, энэ орчлонг бүтээж чаддаг юм чинь лусыг яагаад хүн болгож чадахгүй байж болох вэ?

Иймээс “Олонх бурхант судар”-т бас хамаг бурхад илэрдэг нь хамаг амьтнаар бурхны билиг ухааныг ойлгуулахын төлөө гэж өгүүлсэн байна. Бурхны билиг ухааныг ойлгох гэдэг нь ямар утгатай вэ? гэвэл өөрсдөө бурхны билиг ухаантай байдаг гэдгээ ойлгох явдал болно, харин Шагжамуни Бурханы билиг ухааныг ойлгох биш, Шагжамуни Бурханы билиг ухааныг бишрэн шүтэх биш, учир нь бидэнд ч гэсэн тийм билиг ухаан байдаг. Иймээс Шагжамуни Бурхан энэ тоост хорвоод ирсэн нь биднээр бишрэн шүтүүлэх гэсэн биш, харин бидэнд тусалж өөрөө өөрийнхөө бурхны билиг ухаанаа нээхэд, өөрийн бурхан чанараа таньж Бурханы хутагт хүрэхэд л юм, ийм шалтгаанаас л Бурхан Бодьсадва энэ тоост хорвоод илрэн мэндэлдэг.

Өнөөдөр нэгэн хүн Багшид нь бурхан болно гэж бодож зүрхлэхгүй гэж хэлсэн, тэгвэл хожим бурхан болох уу, үгүй юү? гэж би асуухад тэр ингэж бодож зүрхлэхгүй гэв. Яагаад бодож зүрхлэхгүй гэж? Бурхан болохыг бодож зүрхлэхгүй юм бол чухам юу бодож зүрхлэх юм бэ? Хүн болох нь өдөр бүр унтана, иднэ, ажиллана, дахиад л ажиллана, иднэ, унтана, хүүхэдтэй болно, дараа нь хорвоогоос халина. Ингэж нэг насаа барж болохгүй, хамгийн дээд зорилготой байж гэмээнэ сая хүний биеийг олсны ач тус гарч, Их Эрийн хүсэлд нийцнэ.

Их Эр гэдэг нь эрэгтэй хүнийг хэлж байгаа биш. Их Эр гэдэг нь нэг зүйлийн намба төрх, нэг зүйлийн дэс, нэг зүйлийн чадвар, нэг зүйлийн билиг ухаан мөн бөгөөд учир ёсыг мэднэ, ухаарна, ойлгоно, тун өндөр дээд хүсэлтэй, сансрын хүрднээс гэтэлнэ, орчлонгийн жам ёсыг ойлгоно, их билиг ухаантай болно, “Мөр ёс”-ыг ойлгоно, ингэвэл л сая Их Эр мөн. Багш чинь та нарыг загнаагүй, Багшид нь ийм санаа байхгүй, Багш нь зөвхөн та нарыг битгий дэндүү сул дорой бай, тэгсний улмаас энэ нийгэмд бохирдон харлаж бараантана, бохирдохын эрхээр өөрийгөө хэн болохыг

бодож зүрхлэхгүй, бурхан болохыг бодож зүрхлэхгүй, өөрийн эрх чөлөөгөө дахин олохыг бодож зүрхлэхгүй байж болохгүй гэдгийг л хүсдэг! Жишээлбэл: нэгэн хаан, дайсны дайралттай учирч, улс гэр нь бусдад эзлэгдсэн тул эрхбиш нуун далдлах хэрэгтэй болов, ингэснээр хэдэн арван жил өнгөрч, түүнийг хаан гэдгийг мэдэх хүнгүй болжээ, тэр ядуучууд, тариачид, хотын борчуудтай хамт амьдарч, нэлээд удсаны сүүлээр амьдралын дадал зуршил, үзэл бодол нь улмаар тэдэнтэй адил болж, тэр ч байтугай эцэс сүүлдээ өөрийгөө хаан гэдгээ бодож ч зүрхлэхгүй, хааны ихэмсэг, эрхэмсэг төрх байдлаа илрүүлж чадахгүй болов. Хожим нь түүний танил нь: “Та үнэндээ хаан шүү, яагаад ийм болчихсон бэ? Бид бүгд өдөржин таныг хайж байгааг мэдэх үү? Бид маш хүчирхэг цэрэг олныг зохион байгуулж, таныг тэднийг удирдан дайсантай дайтахыг хүлээж байна, энэ улсаа дахин танаар удирдуулна, учир нь угаасаа таных мөн.” гэжээ. Тэр үед хаан ямар ч хүсэл мөрөөдөлгүй болж, горьдлого нь бүрмөсөн тасарч, итгэл алдан биедээ итгэлгүй болжээ, тэр: “Үгүй, үгүй, насаараа ингэж амьдрах нь хангалттай, идэх хоол, өмсөх хувцастай бол болчихно, харин бүр илүү өндөр дээдийн хүсэл байхгүй.” гэдэг. Үнэндээ тэр бол хаан хүн, цэцэн сэргэлэн, агуу их, эрх мэдэлтэй, гэтэл одоо юу ч бодож зүрхлэхгүй болжээ.

Бид ч бас ийм, нэлээд олон удаа хүний төрөл авснаас энэ нийгэмд бохирдож, өөрийгөө хэн болохоо бодож ч зүрхлэхээ больжээ. Ингэж элий балайгаар нэг насаа өнгөрөөх нь тун хөөрхийлөлтэй билээ. Ядуу хоосон, өдөр бүр гурван энгийн хоол, нэг солих жийнсэн өмд, цав цагаан хантаазтай, тийм их мөнгөгүй, өдөр бүр ядарч зүдэртэл ажиллан, хүнд дарамттай явна. Өөрийн биеэ авч явах нь нэгэнт тийм их төвөгтэй байхын дээр эр нөхөр, эхнэр хүүхдээ харж хандах хүнд дарамт үүрдэг нь, яг л хүнд ачаатай илжиг шиг, ачаа тээш улам хүндэрч, хожим нь тухтай амарч ч чадалгүй нэг насаараа зовж зүдэрнэ. Ингэх нь зөвхөн энэ зуун жилийн хүний амьдралын төлөө л ажээ.

Үнэнийг хэлбэл арай зуун жил ч амьдарч чаддаггүй, өнөөдрийн агаарын бохирдол ийм их, юм бүхэнд эм тариа, химийн эмийг ашиглана. Ийм зүйлийг зуун жил ч идэж чадалгүйгээр нас барна. Хэдэн аравхан жилийн төлөө тэгж ихээр зовж зүдэрнэ, үнэндээ бид юугаар ч дутахгүй, бүхий л орчлон бүгд биднийх мөн гэдгийг мартсан. Үүнд итгэхгүй бол битгий өглөө, орой ном гүрэм унш, номын утгыг ойлгохгүй бол уншсан ч нэмэргүй, судар ном уншин бурханд мөргөх ч хэрэггүй. Чухамдаа судар номд ярьсан ахуй ойлголтыг ойлгохгүй байж таарна, бурхан болбол л сая зөв,

бурхан гэж чухам хэн болохыг ч мэдэхгүй атлаа харин мухар сохроор бурханд мөргөх нь мухар сүсэг болохоос бурхныг таньж байгаа явдал биш. Яг л ирээдүйн бүсгүйгээ ерөөсөө хараагүйгээр харин өдөржин түүнийг дурсан санахтай адилхан, яаж ингэж дурсаж чадах вэ? Наад зах нь бүсгүйнхээ дүр төрхийг мэдвэл гэртээ хариад түүнийг санан дурсаж, бахдан биширч болно, хэрвээ мэдэхгүй бол яаж санах билээ? Хүн бүр бурхан мөн хэдий ч өөрөө харин мэдэхгүй бол яах билээ? Хэн нэгэн хүн: та нар бол бурхан мөн гэж хэлсэн ч та нар итгэхгүй, нэгдүгээрт, өөртөө ийм чадвар байдагт итгэхгүй, хоёрт тэр хүний ярьсанд нь ч итгэхгүй.

Багшийнх нь ярьсан нь бүгд үнэн, Багш нь та нарыг сургах гэж энд ирсэн биш, та нарын Багш болж, та нараар шүтэн тахиулж, хүндэтгэн бишрүүлж, ёслон мөргүүлэх гэсэн биш, ийм шаардлагагүй, тэгсэн ч болно, та нарын дур, энэ бол уламжлалт зан заншил төдий, бясалгалд үнэнхүү шаардлагатай зүйл биш. Багшийгаа хамгаас хүндэтгэх явдал бол өөрсдөө чармайн “бясалгаж”, Багш шигээ болох нь л хамгаас хүндэтгэж байгаа бурхны үр болно, “бурхан болох” нь бурхныг хамгаас илүү ойлгож байгаа хэрэг болно. Та нар бол бурхан мөн гэж би та нарт ярихаар барахгүй та нарт тусалж бурхан чанарыг чинь хайлгадаг. Энэ чимээ дамжуулагч нь бурхан биш байж мэднэ, тэр бол зөвхөн сайн мэдээ дамжуулагч төдий.

Яг л нэгэн шууданч та нарт сайн мэдээ дуулгасан шиг, гэвч тэр нь тийм ч сүрхий биш, тэр мөн л бидэнтэй адилхан хоол иднэ, унтана, эр нөхөр, эсвэл эхнэр хүүхэдтэй гэх мэтээр онцгой зүйл байхгүй, гол нь захидлын агуулга нь чухал, захидалд юу өгүүлж байгаа нь л бидэнд чухал, харин энэ шууданч чухал биш, иймээс шууданчид ёслон мөргөх шаардлагагүй. Үүнтэй адилаар Шагжамуни Бурханд ч ёслон мөргөх шаардлагагүй, мэдээж ёслон мөргөх нь ч нэг зүйлийн ёс зүй мөн, иймээс мөргөх нь бас буянгүй биш, учир нь ёс жаяг ийм юм чинь! Сайн үйл таривал сайн үр хураадаг гэдэг нь хэрвээ бид нэг хүнийг хүндэтгэвэл бусад хүн ч биднийг хүндэтгэдэг, ингэх нь буян мөн, тэрнээс биш тийм ч ач тусгүй.

Хамгийн чухал нь энэ хуудас захидлыг чимээ дамжуулагч бидэнд хүргэж ирэх хэрэгтэй. Иймээс Багш нь танд хүрч ном уламжлах нь маш олон шавь элсүүлэх юм уу, их үйлс бүтээх, эсвэл их сайндаа нэр алдаршихын төлөө биш, захидлыг үнэндээ та нар ойшоохгүй бол би ч аргагүй буцаагаад аваад л явна.

Зарим хүн энэ хуудас захидлыг үл тоож, захидал илгээгчийг танихгүй гэх буюу тиймэрхүү зүйлд дургүй, эсвэл эзэн нь

байхгүй, аль хэдийн өөр оронд нүүсэн гэж ярин өөрөө захидлыг дахин уг газар луу нь буцаачихсан ч байж мэднэ. Энэ бол та нарын хувийнх тул, тэр шууданчтай хамаагүй, тэр бол хүмүүст баярын мэдээ хүргэнэ, ирсэн захидлыг хураах эсэх нь та нарын асуудал.

Багш нь үнэн ёсыг үнэн бодитой ярих хэрэгтэй, эс бөгөөс та нар үхэл ирэхийн цагт үл мэдэхийн зовлонгоор шанална, эрих тоолон судар маанийн номд хүлэгдэж, номын хорхой ном дотроо үхдэгтэй адилхан хэрэгцээгүй болно. Өдөр бүр бусдын ахуй ойлголтыг уншаад ямар ач тустай байх вэ? Манзушир Бурхан бурхны хүчийг зээлэн аль аль түвшинд хүрсэн, Ананд Шагжамуни Бурхантай ямар ямар бурхны оронд очсоныг олж сонсон өдөр бүр ийм зүйлийг унших нь ямар ач тустай вэ? Шагжамуни Бурхан Бурханы хутагт хүрсэн нь түүний явдал, бидэнд хамаагүй, тэр хоёр мянга гаруй жилийн өмнө хэдийн бурхан болсон, энэ нь бидэнд ямар хамаа байх вэ?

Нэг хүн эмч болох нь бидэнд хамаатай юу? Бид эмч больё гэвэл анагаахын дээд сургуульд элсэн орж, өдөр бүр хичээн суралцаж, эмч болтлоо чармайх хэрэгтэй. Хэрвээ эмчид очоод ёслон мөргөж, эмчийн номыг уншвал эмч болж чадах уу, чадахгүй. Энэ ертөнцийн энгийн явдал бүгд ийм байдаг юм чинь бурхан болоход бусдын ахуй ойлголтыг л уншаад өөрөө яаж ахуй ойлголттой болж чадах вэ? Харин өөрөө ахуй ойлголттой болох хэрэгтэй, Ананд диваажинд хүрч чадсан бол бид бас хүрч болно. Молом тойн (Модгальяна) ид шидээр бурхны оронд очсон бол бид бас очиж болно. Шагжамуни Бурхан үй түмэн хувилгаан биетэй бол бид бас ийм байж болно. Арьяабалын бясалгалын аргыг бясалгаад хэсэг хугацаа өнгөрсний дараа бид юутай ч байж болно. Бясалгахгүй бол аргагүй, иймэрхүү чадвар нь бурханд мөргөвөл сая бий болдог юм биш.

Өчигдөр Багш нь бурханд мөргөх нь бурхны гутлыг арчиж, бурхны боол болдог явдал гэж ярьсан, бид өөрсдөө бурхан болох хэрэгтэй, харин бурхны боол болж болохгүй бөгөөд үргэлжид бурхны хүүхэд, жаахан хүүхэд хэвээр байгаад байж болдог юм биш! Бид аав, ээжээ хүндэтгэх нь зөв, гэвч бас хоол идэх хэрэгтэй, хоолоо өөрөө идэж, өөрөө том болж, дараа нь аав, ээж болно. Аав, ээж бол биднээс том, биднийг төрүүлсэн учраас өдөр бүр мөргөж, тэднийг хүндлээд хоол ч идэхгүй, сүү ч уухгүй, зөвхөн өдөр бүр түүний хүүхэд байх нь зүйтэй юу? Бидний аав, ээж ийм байдалд дуртай байх уу?

Бидний эгэл жирийн аав, ээж хүртэл биднийг өдөржин тэдэнд хичээнгүйлэн ёслон мөргөж, биеэ дааж чадахгүй, хэзээд

өсөн бойжихгүй байгаасай гэж хүсэхгүй байтал, бурхан ч хэрхэн биднийг өдөржин гагцхүү түүнд ёслон мөргөөсэй гэж хүснэ гэж үү? Ёслон мөргөх нь ч мөргөнө, гэвч өөрөө арга сүвэгчлэн бясалгавал сая зүйтэй, зуушны нэр уншаад хоол болдоггүй, зуушийг идвэл сая хоол болдог. Ном унших нь зуушны нэрийг уншихтай л адил.

Багш чинь өчигдөр “Очир огтлогч” судар нь Очир огтлогч судар биш учраас л сая “Очир огтлогч судар” мөн гэж ярьсан. Учир нь ном сударт зөвхөн Очир огтлогч судрыг л магтан сайшаасан. Жишээлбэл, та өвчлөөд эмчид очиход эмч оношилгооны хуудсандаа өдөр бүр хэдэн аспирын уувал толгой өвдөхөд хамгийн сайн байдаг гэж бичдэг, тэгвэл бас тифомицин (Typhomycine) болон тетрацилин (Tetracycline)-ийг танилцуулж, эмийн ач тусыг магтдаг. Гэвч та нар аспирын олж уувал сая толгой өвдөхийг засаж чадна. Аспирины жорын хуудсыг магтах нь аспиринтай хамаагүй, аспирин нь жорын хуудас биш, нэг зүйлийн эм, түүнийг уувал л сая ач тустай.

Үүнтэй адилаар Очир огтлогч судрыг магтах нь “Очир огтлогч судар” биш, “Очир огтлогч судар” бол өөр нэг зүйлийн судар, жинхэнэ Багшийг эрж олбол сая мэдэх болно. Тиймэрхүү жинхэнэ судар бол бидний дотоодод байдаг ч ярьж илэрхийлж чадахгүй. Баригддаггүй бөгөөд харагддаггүй, гэтэл юуг ч ойлгож, ямар ч билиг ухаан байдаг, энэ бол сая жинхэнэ “Очир огтлогч судар”, жинхэнэ судар мөн, гаднах ном судар бол бүгд л энэ жинхэнэ судрын тухай танилцуулга төдий билээ. Жишээлбэл, уржигдраас одоо болтол Багш нь үргэлж л Арьяабалын бясалгалын аргыг магтаж: “Хэрвээ зарим хүн энэ Арьяабалын бясалгалын аргыг олж чадвал маш сайн, үргэлжлүүлэн энэ аргаар бясалгавал үнэхээр туулан гэтэлж чадна.” гэж ярьсан билээ. Үүнийг зарим хүн сонсоод бүгдийг бичиж авч, Багшийнхаа Арьяабалын бясалгалын арга ямар ямар сайн гэж магтсаныг бүгдийг тэмдэглэн хожим нь нэг ном болгож найруулбал Арьяабал судар гэж нэрийддэг, учир нь Багш нь бүгдэд нь Арьяабалын бясалгалын аргыг ярьсан тул Арьяабал судар гэнэ.

Хоёр зуун жил, эсвэл хоёр мянган жилийн дараа ч юм уу, зарим хүн энэ боть судрыг уншаад: “Хэрвээ энэ Арьяабалыг олж сонсвол маш их ач буянтай болно, буян их хүн бол сая Арьяабалын бясалгалын аргыг бясалгаж чадна.” гэж тэмдэглэсэн байхыг олж харсан тул өдөр бүр тэр судрыг унших нь ямар ач тустай байх билээ? Учир нь Арьяабал бол энэхүү номын дотор байдаг биш, судар ном нь зөвхөн танилцуулга төдий. Яг л та нар одоо болтол

Арьяабалын бясалгалын арга гэдэг нь юу гэдгийг мэдээгүй байгаатай адил, тийм үү, үгүй юү?

Иймээс Шагжамуни Бурхан хаа очсон ч ерөөс адилхан учрыг ярьдаг, гэвч тэр адилгүй зүйрлэл, адилгүй аргаар тайлдаг. Багш чинь энд Арьяабалын бясалгалын аргыг тайлахад мөн маш олон зүйрлэлийг хэрэглэж, заримдаа цаг хомсдоод нэг газар очвол зөвхөн нэг л өдөр болдог, тэр үед Авид Бурханыг бясалгах дуртай хоёр, гурван хүнтэй тохиолдвол надад тийм их ярих цаг байхгүй тул тэдэнд Авид Бурханы судрыг ярьж, энэ бол цаглашгүй гэрэлт номын цогцос мөн, та үүнийг бясалгавал лавтай Төгс баясгалант оронд хүрч чадна гэж хэлснийг бусад хүн сонсвол Авид Бурханы номын цогцос нь юу болохыг мэдэхгүй тул энэхүү боть бурхны судар байвал даруй болчихно гэж боддог, яаж болох билээ?

Бас жишээлбэл, зарим хүн "Очир огтлогч судар"-т дуртай болохоор судрыг бүгдийг нь цээжилчихдэг, тэгвэл Багш чинь "Очир огтлогч судар"-ыг түүнд ярьж өгөөд дараа нь сая түүнд Арьяабалын бясалгалын аргыг уламжилдаг. Багш чинь зөвхөн Авид Бурханы судар, Очир огтлогч судрыг л тайлж чадах биш, Олонх бурхант судар, Лен Ян судрыг тайлж чадна, учир нь ерөөс адилхан номын цогцосыг тайлж байгаа бөгөөд зөвхөн адилгүй нэрээр л Арьяабалын бясалгалын аргыг тайлбарласан хэрэг.

Шагжамуни Бурхан ч адил, заримдаа тэр цаг завтай, нэлээд олон зүйл ярьснаас "Олонх бурхант судар" бий болжээ, зав байхгүйгээс түргэн шиг ярьснаас "Авид судар" бий болов, энэ бол адилхан утгатай, учир нь энэ бясалгалын арга тун сайн гэдгийг хамаг амьтанд ойлгуулахын төлөө ярьсан хэрэг. Гэвч Авид судар нь Авид бясалгалын арга биш, иймээс Авид судрыг хэдэн арван жил уншсан ч хариу мэдрэмжтэй болдоггүй, маш олон хүн ийм байдгийг би мэднэ. Гэтэл Багшаас нь сурвал дорхноо ахуй ойлголттой болдог. Учир нь урьд нь элс чанаж байсан тул будаа болж чадахгүй, одоо бол харин будаа чанасан тул мэдээж хоол болдог. Элсийг чанаад хэчнээн жил боллоо ч нэмэргүй, будаа чанавал дорхноо будаатай болно, учир нь будаа бол будаа, элс бол элс, элсийг удтал чанаснаас л будаа болдог биш билээ.

Багш чинь ном уламжлах үед та нарт мөн нэг сахилын дэвтэр өгдөг, энэ нь таван сахилыг жаахан дэлгэрэнгүй тайлбарласан зүйл, бараг бас Очир огтлогч судартай адилхан, өглөг үйлдэх, сахил баримтлах, доромжлолыг хүлцэх, хичээнгүйлэн бясалгах, даяанд битүүмжлэх, билиг ухаантай болох, энэ бүхэн бол бидний бясалгалын үндсэн сахил журам, үндсэн дүрэм горим мөн, "Очир огтлогч судар"-т зөвхөн зургаан гэтлэлтийг ярьж, бясалгалын



арга гэж дурдсангүй, Очирт бясалгалын аргыг ярьсангүй. Даяанд битүүмжлэх нь зөв, гэтэл сударт даяанд яаж битүүмжлэн явахыг бичсэнгүй, энэ нь даяанд битүүмжлэх нь өөр нэг зүйлийн сургаал ёсонд харьяалагдана. “Тус хувь хүнд сэтгэлээр сэтгэлд уламжлах” хэрэгтэй байдгаас ийм болдог, иймээс сая “Сэтгэлийн авшиг хүртээх” буюу “Ном уламжлах” гэж хэлдэг, энэ бол сургаалаас гадна ном уламжлах бясалгалын арга мөн, судар номд ярьж болохгүй бөгөөд бичиж тэмдэглэх аргагүй.

Өчигдөр Багш чинь та нарт ном уламжлах үед үг ярьдаггүй гэж хэлсэн, яримаар зүйл байхгүй, дүрсэлмээр “ном” ч алга, энэ номыг дүрсэлж чадахгүй, гэвч уламжлахгүй бол бас болохгүй, сэтгэлээр сэтгэлд уламжилдаг ч энэ сэтгэлээр нөгөө сэтгэлд уламжлах явдал биш. Хэдийгээр ийм боловч сэтгэлд уламжилж болно, уламжлах “ном” байхгүй хэдий ч та нар бүгд юм олдог, үг ярьдаггүй ч та нар ямар нэгэн юмыг олдог, үүнийг зөвхөн ном уламжлах үед л мэддэг, энэ бол сая жинхэнэ “Очир огтлогч судар”, жинхэнэ Очирт бясалгалын арга, жинхэнэ билиг барамидын зүрхний номын цогцос, жинхэнэ Арьяабалын бясалгалын арга мөн.

Багш нь ном уламжлах үед мөн та нарт нэг боть “Очир огтлогч судар”-ыг өгдөг, гэвч жаахан ондоо янзаар тайлбарладаг, энэ таван сахилыг тайлбарлаж, та нараар бас “өглөг” үйлдүүлдэг, гэвч “би” өглөг үйлддэг гэж бодож болохгүй, ингэх нь Очир огтлогч сударт ярьсантай адил болно. “Сахил баримтлах” нь өдөр бүр биеэ хянан шинжиж, таван сахилыг тодорхой сахих явдал. Дараа нь “доромжлолыг хүлцэх, жишээлбэл, ямар нэгэн бэрхшээл тулгарах буюу бусдад доромжлуулан загнуулах үед бид бурхныг “Санан дурсах” хэрэгтэй, бодол санаагаа бидний заасан бясалгалын арга дээрээ төвлөрүүлбэл зохино, бусад хүн юу ярьсан ч бид хариу хэлэхгүй, ингэх нь доромжлолыг хүлцэж байгаа явдал болно. Доромжлолыг хүлцээд л болчих биш, эрхбиш өдөр бүр чармайн бясалгах хэрэгтэй, ингэснээр “хичээнгүйлэн дэвших” болно. Багш нь та нарт бас яаж бясалгах, яаж бясалгаж суувал сая билиг ухаанаа нээж чадахыг заадаг, ингэх нь “Даяанд битүүмжлэх” явдал болно, хожим нь та нар “Билиг ухаан”-аа өөрсдөө нээнэ.

Энэ нь “Очир огтлогч судар”-т ярьсантай яг адил, гэвч эдгээр нь бүгд ёс журам төдий болохоос харин жинхэнэ “Очир огтлогч судар” биш. “Очир огтлогч судар” бол эрхбиш ном уламжлах үед сая байх болно, жинхэнэ “Очир огтлогч судар” бол өөр нэг зүйл, иймээс “Очир огтлогч судар” нь Очир огтлогч судар биш гэдэг,

ойлгож байна уу? Та нар бүгд толгой дохиж байхыг хараад би тун баярлаж байна, учир нь би ойлгомжтой ярьж чадахгүйгээсээ санаа зовж байлаа, чухам яаж тайлбарлавал сая та нарт ойлгуулж чадахаа мэдэхгүй, билиг ухаан минь хүрэлцэхгүйгээс санаа зовж байлаа, гэхдээ хятадаар ч урсам сайхан ярьж чадахгүй, хэрвээ бидний буян хишиг хангалтгүй, хувь барилдлага гүн биш байсан бол ярьж чадахгүй байсан байж мэднэ.

Миний бодоход: та нарт иймэрхүү өнгөрсөн түүх бий, заримдаа жирийн байдалд ч гэсэн өөрийн ойлголт төөрөгдлөө бусдад нэгмөсөн ярьж илтгэж чаддаггүй, иймээс нөхөр, гэргий хоорондоо заримдаа хэрүүл маргаан хийж, нөхөд зуураа эндүүрэл үүсэж, аав, ээж нь хүүхдэдээ уурладаг, учир нь өөрийн үзэл бодлоо илэрхийлж чадахгүй тул нөгөө этгээд нь буруугаар ойлгочихдог. Хэрвээ эгэл хүнд тохиолдсон жирийн байдлыг заримдаа ярьж илтгэхэд тун ч хүнд хүчир байхад бурхны билиг ухааныг хэлэх ямар байх билээ? Бурхны билиг ухааныг яаж эгэл хүний үг хэл болгож чадах вэ? Яаж ертөнцийн үг хэл болгож чадах вэ? Хялбар бус. Өөрөө “ойлгосон” нь хувь хүнийх болно, гэвч түүнийг бусдад ярих нь ондоо зүйл болчихдог, тун хялбар бус.

Иймээс гэгээрэх болон ном уламжлах хоёр нь ондоо учир ёс, билиг нээгдвэл ном уламжилж болно гэснийг илтгэж байгаа биш. Зарим хүн өөрийгөө ном уламжилж байна гэж хэлдэг. Гэвч түүний билиг нээгдээгүй. Багшийнх нь билиг нээгдээгүй, гэвч ном уламжилж чаддаг. Энэ нь тун сайн явдал болчихжээ. Та нар Багшийгаа дагаж бясалгавал өөрөө бас билиг нээгдэж болно. Багшийнх нь билиг нээгдэх эсэх нь хамаагүй, тэр бол зөвхөн нэгэн шууданч, захидлыг та нарт хүргэхийг л хариуцдаг төдий, ойлгож байна уу?

Гэгээрсэн хүн ч гэсэн өөрийн билиг ухаанаа нэгмөсөн ярьж илтгэж чаддаггүй гэж Багш нь саяхан ярьсан. Миний билиг нээгдээгүй хэдий ч та нарын билиг нээгдчихсэн тул тийм түргэн ойлгодог. Жаахан ярмагц ойлгочихдог. (Бүгдээрээ инээлдэв.) Энэ нь энд байгаа хүмүүс нэлээд билиг нээгдсэнийг харуулж байна. Ийм авшигтангай уулзсандаа би тун баяртай байна. Тун омогшиж байна. Аль хэдийн тийм ихээр гэгээрчихсэн байтлаа бурхан болж зүрхлэхгүй гэнэ. Бурхан болохоос зүрхшээх нь их харамсалтай хэрэг! Багш нь хэдийгээр билиг нээгдээгүй ч бурхан болж чадна. Тэгэх мөртөө үнэхээр энэ төрөлдөө бурхан болно. Учир нь би дараа төрөлдөө хүн болж төрөх эсэхээ мэдэхгүй. Дараа төрөлдөө хаана очихоо мэдэхгүй, хорхой, эсвэл чийгийн улаан хорхой болж ч мэднэ. Хэрвээ бид буян хишиггүй бол үхэр, морь, тахиа, хонь,

чийгийн улаан хорхой, хулгана гэх мэт болно гэж бурхны сударт бичсэн байна. Хоол хүнс олдохгүй тул бусдын юмыг хулгайлдаг юм чинь яаж ном сонсож чадах вэ? Яаж бясалгаж чадах билээ?

Гэвч Багш нь та нарт баталъя. Энэ төрөлдөө би лавтай бурхан болно. Батлахгүй ч лавтай бурхан болно, яагаад болохгүй гэж? Шагжамуни Бурхан бидэнтэй л адилхан. Хоёр мянга таван зуун жилийн өмнө бидний ертөнц тийм тав тухтай байгаагүй. Хүн ч тийм сэргэлэн биш, зурагт байгаагүй, утас байгаагүй, нисэх онгоц ч байгаагүй гэх мэт. Тухайн үеийн хүмүүс тийм бядуу, одоогийн хүмүүсээс ч бядуу байжээ. Бид одоо олон юмыг хийж бүтээж чаддаг тул чухамдаа түргэн шиг бурхан болбол зүйтэй. Яагаад бурхан болж чадахгүй гэж? Шагжамуни зургаан жил бясалгаад бурхан болсон. Бид зургаан сарын дотор бурхан болбол сая түргэнээр дэвшин хөгжиж байгаа одоогийн цаг үетэйгээ зохицож чадна. Бид өнөөдөр явган явах шаардлагагүй, дугуй, моторт дугуй унах нь дэндүү удаан, машин, галт тэргэнд суувал мөн л удаан. Одоо бүгд онгоцонд суух болжээ. Гэтэл одоогийн хүмүүст онгоц нь ч тийм түргэн биш шиг болов. Хожим тэд орчлонгийн нисэх онгоцоор биднийг саран дээр хүргэж болно. Учир нь энэ дэлхий дэндүү шахцалдаж, хүн ам улам олширч багтахаа больсон тул саран дээр амьдрахыг бодож олов.

Та нар хар л даа, одоогийн хүмүүс тийм эр зоригтой чадварлаг байхад, бид чухамдаа түргэн шиг бурхан болбол сая тэдэнтэй жаахан зохицож чадна. Та нар зургаан сарын дотор бурхан болох уу? Үгүй юү? Дуртай байна уу? Зургаан сарын дотор бурхан болох дуртай юу? Эсвэл зургаан минутад бурхан болох уу? Эсвэл агшин зуур бурхан болох уу? Зургаан сар дэндүү удаан байна. Энэ “Мөр”-ийг хайж олдог л юм бол дорхноо бурхан болно. Эрж олохгүй бол гадна нь эргэлдэх болно. Хаалганы дугаарыг нь эрээд олохгүй, “өрөө” нь хаана байгааг мэдэхгүй. Өөрөө хаалганы хавьд байсан ч өрөөг нь олж харахгүй бол бас нэмэргүй. Хэрвээ өрөөнийх нь хаалгыг эрж олбол маш түргэн гэгээрэх болно.

Авшиг хүртээх үед зарим хүн дорхноо архадын хутагт хүрч, Бодьсадва, буцашгүй Бодьсадвагийн хутагт хүрч, удалгүй Бурханы хутагт хүрнэ. Аль хэдийн бурхан болчихсон ч байж мэднэ. Зөвхөн өөрөө мэддэггүй. Үнэндээ одоо хэдийн бурхан болчихсон. Яагаад авшиг өгсний хойно л бурхан болдог вэ? гэвэл мэддэггүй учраас бурхан болдоггүй. Бурхан болон хамаг амьтан ялгаагүй, хэрвээ өөрийн бурхан чанараа танивал маш түргэн бурхан болно. Хэрвээ заавал бясалгал хийсний хойно сая бурхан болно гэвэл энэ бол жинхэнэ бурхан биш, харин хуурмаг бурхан. Бид угаас бурхан,

гэвч хараахан илрүүлээгүй байгаа тул бурхан гэдгээ мэддэггүй. Бясалгал хийх нь үүнийгээ “таних”-ын төлөө юм. Өөрөө угаас бурхан гэдгээ “ойлгох”-ын төлөө. Бясалгасны дараа сая бурхан болдог биш. Иймээс агшин зуур ч бурхан болж болно. Учир нь бурхан чанар бол угаас аль хэдийн байж байдаг, Багшийнхаа санааг ойлгож байна уу? Жишээлбэл, энэ чийдэнд цахилгаан хэдийнээ нэвтрээд ирчихсэн байвал товчлуурыг нь дармагц гэрэл асна. Хэрвээ товчлуур нь хаана байгааг мэдэхгүй бол эрхбиш эрж хайж олох хэрэгтэй. Гэвч товчлуурыг нь эрж олоод дармагц гэрэл дорхноо асна, маш түргэн. Та нар агшин зуурт бурхан болох уу?

Тиймээс Шагжамуни Бурханыг амьд сэрүүн байхад маш олон шавь нь Архадын хутгийг олсон. Бид судар ном уншвал ойлгож болно. Шагжамуни Бурхан ном тайлж дууссаны хойно хэчнээн хүн Архадын хутагт хүрч, хэчнээн хүн Бодьсадвагийн хутгийг олж, хэчнээн хүн Шюй түве хуан (Буддын шашны нэгэн зэрэг дэс) болсон гэх мэт, яагаад ийм байдаг вэ? гэвэл Бурхан Багшаас авшиг хүртсэний дараа бид өөрийн дэсээ дорхноо мэдэх болно. Бид аль хэдийн Архад болчихсон ч байж мэднэ. Зөвхөн өөрөө мэддэггүй. Энэ үед ямар нэгэн юмаар хэмжих юм бол дорхноо мэдчихдэг.

Жишээлбэл, өнөөдөр нэгэн эрэгтэй оройн долоон цагийн ном тайлахыг хүлээж чадалгүй үдээс хойш хоёр цагт Багшийг нь эрэхээр ирвэ. Багш чинь эндээс ер яваагүй. Гэтэл тэр эрж ололгүй буцсан. Буцсаны дараа мөн л хүлээж чадахгүй гурван цагт дахин ирсэн ч мөн л эрээд олсонгүй. Багш чинь эндээ л байж байсан хэдий ч тэр хоёр цаг гаруй хайж байж л сая Багшийг нь олсон биш. Багш нь угаас энд байсан. Харин тэр буруу замаар эрсэн байжээ. Энд маш олон өрөө бий. Аль нь Багшийн суудаг өрөө болохыг тэр мэдэхгүй. Багшийг танихгүй болохоороо олон газраар хайжээ. Хаалгыг нь эрж явсаар дорхноо олж харна. Гэвч хайж оллоо ч гэсэн Багшийг танихгүй болохоор дахиад л хайх хэрэг гарна.

(Багш тэр эрэгтэйгээс асуув) та өнөөдөр тэр хүн (Багш өөрийгөө заав)-ийг харсан бол хэн болохыг нь мэдэх үү? (Бүгд инээлдэв) мэдэхгүй, тийм үү? Та түүнээс Их Багш хаана сууж байна вэ? Сонсох нь ээ, энд нэгэн Чин Хай гэдэг Их Багш ирж ном тайлна гэсэн, та түүнийг таних уу? Тэр хаана суудаг вэ? Тэр унтаж байна уу? гэж асуусан бол би: “Үгүй, тэр бясалгаж байгаа.” гэж хэлнэ. (Бүгд инээлдэв.) Бид мөн л адилхан, бурхан бидний дотоодод байгаа хэдий ч харин эрээд олдоггүй. Учир нь түүнийг хаана байгааг мэдэхгүй. Бурхан чанар угаасаа байсан. Гэвч түүний хаана байгааг мэддэггүй болохоор эрээд олдоггүй. Авшиг хүртээх

үед өөрийн уг чанараа хардаг хэдий ч энэ нь юу болохыг мэдэхгүй байж магад. Билиг нээгдсэний дараа ч гэсэн мэдэхгүй байж мэднэ. Иймээс урьдын гэгээрэгсэд мөн л оройн дээд Төгс Гэгээрсэн Их Багшийг эрдэг. Тэрээр, Багш, эсвэл бусад Төгс Гэгээрсэн Их Багшийг эрж: “Миний энэ түвшний ахуй ойлголт нь чухам билиг нээгдсэнийг илтгэж байна уу, үгүй юү? Дээд түвшнийг төлөөлж байна уу, үгүй юү? Гурван ертөнцийг туулчихсан уу, үгүй юү?” гэдгээ гэрчлүүлдэг.

Өнөөдрийн тэр эрэгтэй, би бурхан болохыг бодож зүрхлэхгүй гэж хэлсэн. Энэ бол нэгэн зүйлийн гутрангуй зан юм. Учир нь бурхан болох сэтгэгдэшгүй явдлыг бодож зүрхлэхгүй учраас авшиг хүртээх үед билиг нээгдсэнээ өөрөө ч мэдэхгүй байдаг. Иймээс заавал гэрчлүүлэх хэрэгтэй. Энэ замаар аль хэдийн явж өнгөрсөн нэгэн хүн, энэ бол ямар дэс гэдгийг бидэнд хэлж өгвөл сая ойлгоно. Ийнхүү итгэл төрнө. Тэгээд ойлгох болж, улмаар “Ухамсар”-аа хөгжүүлдэг.

Энэ нь “Олонх бурхант судар” дахь зүйрлэлтэй адил. Нэгэн баян айлын хүү төөрснөөс болж алс газар явж, буцаж ирэхдээ аавыгаа танихаа больсон бөгөөд аав нь баян гэдгийг ч мэдэхээ больжээ. Аав нь түүнийг нааш ир гэж дуудахад тун айж, намайг хөнөөх гэж байна гэж бодоод зугтчихжээ. Иймээс тэр баян эрхбиш аажмаар түүгээр шал шүүрдүүлэх, жорлон угаалгах мэтийн жирийн ажлыг хийлгэж, би таныг амьдрах гэр, идэх хоол, өмсөх хувцсаар хангана шүү гэж ярьж, аажмаар орчин тойрондоо дасгах хэрэгтэй болдог. Баян, та бол миний хүү гэж шууд хэлж болохгүй. Учир нь тэр саяхан нэгэн ядуу орноос ирсэн тул өөрөө угаас том баяны хүү гэдгээ таниагүй, ойлгоогүй байдаг. Гэвч удаан амьдраад тэр итгэлтэй болдог. Учир нь баян түүнийг аажмаар чиглүүлж, эхлээд түүнийг боолоо болгож, дараа нь гэрийн даамал болгон дэвшүүлж, хамгийн сүүлд нь эд хөрөнгөө түүнд тушаан даатгаж, алгуураар эрхэмсэг хүн болгоод дараа нь дахин түүнд та бол миний хүү мөн гэж хэлнэ. Тэр чармайн ажилласнаас л боолын ажлаас гэрийн даамал болж, дахин баяны хүү болсон биш. Харин угаас баяны хүү, эдгээр эд хөрөнгө угаас бүгд түүнийх мөн. Гэвч тэр ядуу хүн болоод дэндүү удсан тул баяны хүү мөн гэдгээ бодож зүрхлэхгүй, итгэхгүй болсон байж.

Бясалгал хийх нь ч ийм, аль нэгэн өдөр Багш нь танд алгуураар та бол бурхан мөн гэж хэлэх болно. Тэр үед аль хэдийн бэлтгэчихсэн тул бурхан гэдгээ ойлгодог. Хэрвээ одоо та нар бол бурхан мөн гэж яривал хэчнээн хүн итгэхийг би мэдэхгүй. Ганцхан хүн итгэж мэднэ, ганц ч хүн итгэхгүй байж мэднэ. Учир

нь та нар өөрийгөө эгэл хүн гэж үздэг үзэл бодолдоо дэндүү их дасаж даджээ. “Би яаж бурхан байж болох вэ? Би бол эмэгтэй хүн, эрэгтэйчүүд л сая бурхан болох боломжтой. Би яаж бурхан болж чадах вэ? Миний үйл үр хүнд, би бол мунхаг харанхуй, тэнэг хүн мөн, би бол...” гэхчлэн боддог. Иймд, бид бол бүгд бурхан мөн. Үгүй бол Шагжамуни Бурхан худал ярьжээ, ганцхан Багш нь худал ярьсан төдий биш. Шагжамуни Бурхан бол хамгийн том худал яригч мөн болно. Тэрээр: “Хамаг төрөлтөн бүгд бурхан чанартай, бүгд надтай адилхан. Ялгаа байхгүй, яагаад өөрийгөө танихгүй байна вэ? Даанч хөөрхий! Даанч хөөрхий!” гэсэн байна.

Заримдаа Багш нь ч ингэж боддог. Би бурхан болоогүй ч аль хэдийн ингээд бодчихсон байна. Үнэн шүү, Багш нь та нарыг харахад бүгд л бурхан шиг. Ямар ч ялгаа байхгүй, бурхан болсны дараа ч бас адил байж мэднэ. Би Шагжамуни Бурханы үгэнд итгэнэ. Бид угаас адилхан, гэвч одоо бурхан биш, учир нь холбогдох утас тасарсан байна. Энэ бол бид өөрөө өөртөө хэрэм барьж, өөрийгөө хүрээлүүлснээс болжээ.

Ийм байдал нь тэр баяны хүүтэй адил, эцгийнхээ гэрт сууж байвч өөрийгөө угаас баян гэдгээ мэдэхгүй болжээ. Учир нь түүний урьдах үзэл бодол, дадал зуршил, байр суурь нь түүнийг халхалж, өөрийнх нь эд хөрөнгө нь үнэндээ түүнийх болохыг мэдүүлдэггүй. Угаас энэ боолын ажлыг хийж, өдөр бүр шал угааж, жорлон цэвэрлэх шаардлагагүй гэдгийг нь түүнд мэдрүүлэхгүй болгожээ. Тэр угаас энэ гэрийн эзэн байж таарна. Гэвч ойлгохгүй учраас өдөр бүр түүний буруу үзлийг жаахан огооруулж, харанхуй мунхаг бодлыг нь жаахан арилгаж байж л хожим нь хэн болохыг нь хэлж болно.

Үүнтэй адилаар, бид хэрвээ өөрийнхөө хэн болохоо танихгүй байсан ч, Арьяабалын бясалгалын аргаар чармайн бясалгадаг л юм бол нэлээд түргэнээр өөрийн уг чанараа таних болно. Учир нь авшиг хүртэх үед бид дорхноо ямар нэгэн зүйлийг олж, урьдахтайгаа адилгүй болдог. Яг л баяны хүү эцэгтэйгээ уулзах үед аавыгаа танихгүй байсан ч аавтайгаа уулзчихсан болохоор тэр тун аюулгүй сууж, хожим нь аажмаар өөрийгөө мэддэгтэй адил.

Арьяабалын бясалгалын аргаар бясалгаснаар энэ бурхны хүчтэй холбогдож, дараа нь таньдаг. Бид бол энэ бурхны хүч мөн. Бид бол бурхан мөн, үүнээс бусад өөр бясалгалын арга үүнийг бидэнд мэдрүүлж ойлгуулж чадахгүй. Яг тэр баяны хүү шиг өөрийн биеэ таних гэвэл эрхбиш урьдаар гэртээ сууж ажил хийх хэрэгтэй. Дараа нь алхам алхмаар дээш дэвшиж, аажмаар биеэ таньж чадах бөгөөд эцэг нь ч түүнд түшиг болдог. Хэрвээ

тэр нуун далдлах юм уу, салан одож, эцэгтэйгээ бүрмөсөн холбоо тасарвал эцэг нь тусалж чадахгүй. Угийн байр сууриндаа дадахыг сургаж чадахгүй, баяны хүү болохыг нь хэзээ нэгэн өдөр итгүүлж чадахгүй.

Иймээс Арьяабалын бясалгалын арга бол цорын ганц төгс төгөлдөр арга мөн. Биднийг өөрийн биеэ таньдаг болгоно. Том баяны хүү, үлэмж их эд хөрөнгөтэй гэдгээ сонссон байж мэднэ. Гэвч эцэгтэйгээ уулзахаасаа өмнө мэдэж чадахгүй. Өөрийн баян эрхэм байр сууриа ойлгоё гэвэл эрхбиш гэртээ сууж, эцэг нь түүнийг аажмаар чиглүүлэх хэрэгтэй. Энэ бол цорын ганц арга мөн. Энэ нь Арьяабалын бясалгалын аргатай адилхан. Иймээс арван зүг, гурван цагийн бурхан бүгд заавал Арьяабалын аргыг бясалгавал сая бурхан болж чаддаг.

Шагжамуни Бурхан аливаа сударт бүгдэд энэ бясалгалын арга, энэ дотоодын бясалгалын аялгууг сайшаан магтсан байна. “Олонх бурхант судар”-т ч энэ дотоодын аялгууг хэлсэн. Үүнээс гадна “Хотол зохилдогч зүйл”, “Баатар явагч их хөлгөн судар”, “Лэнгэ судар”-т бас дурдсан байдаг. Очир сударт ч танилцуулж, “Билиг барамидын зүрхэн судар”-т ч хэлсэн байна. Гэвч та нар заавал бясалгал хийсний дараа л сая ойлгоно. Багш чинь Арьяабалын бясалгалын аргыг бясалгахаас өмнө бас “Зүрхний тайлбар”-ын утгыг ойлгохгүй байсан. Юм бүхэн хоосон, дүрсгүй, мөхөхгүй, хиргүй, цэвэргүй, нэмэгдэхгүй, хорогдохгүй, хоосонд дүрсгүй, бодол явдал, мэдэл хүртэлгүй гэх мэт нь чухам юуг хэлж, ямар утгатайг ойлгохгүй байсан. Багш чинь бас Арьяабалын бясалгалын аргыг бясалгасны дараа л сая ойлгосон.

**Асуулт:** Хэрвээ бид энэ уг чанараа ойлгосны дараа явал сая туйлын амар амгалан түвшинд бүрмөсөн хүрч чадах вэ?

**Багш:** Уг чанараа мэдчихсэн бол үргэлжлэн бясалгаарай. Уг чанараа аль хэдийн мэдчихсэн бол хамгийн сайн, хиймээр зүйл юу байх вэ? (Бидэн шиг гэртээ сууж бясалгагчид бясалгахыг их санадаг ч тиймэрхүү туйлын амар амгалан түвшинд ер хүрч чадахгүй байдаг.) Тэрхүү хүрсэн туйлын амар амгалан дэс түвшинээ яаж хадгалах вэ?

**Багш:** Учир нь гэртээ сууж бясалгал хийгчид бол нэлээд яаруу байдгаас болдог, өглөөний цагийг ашиглаж болно. Жаахан эртхэн шиг босож, гурван цагаас зургаан цаг болтол бясалгаж сууж болно. Энэ үед хүүхэд чинь унтаж, эрэгтэй чинь бас их ядарсан байдаг. (Бүгд инээлдэв.) (Өдөр бүр энэ цагт бясалгах шаардлагатай юу?) Тогтсон цагтаа бясалгаж суух нь хамгийн сайн, үгүй бол ямар ч цагт сууж болно. (Тэгвэл суух хэлбэр нь?)



Хэлбэр байдал хамаагүй, та Багшийнхаа зааснаар суух хэлбэрээ сонго. Тэр танд завилахыг заасан уу? (Үгүй, яаж суувал таатай бол тэгж суу гэсэн), Тийм бол зүгээр, миний заадагтай адил юм. Тэр ямар бясалгалын аргыг заасан бэ? Амьсгалынх уу? (Бид заримдаа жирийн янзаар завилан сууж, заримдаа амьсгалаар бурхныг дурсдаг.) Зүгээр, үргэлжлүүлэн хийгээрэй танд таатай бол болчихно.

**Асуулт:** Багш аа, бурхныг дурсаж, бурханд мөргөх нь бурхан болгож чадахгүй гэж та хэлсэн, хэрвээ бид бурханд мөргөвөл яг л бурхны хувь барилдлагыг тарьсан шиг ирээдүйд бурхны үр хурааж, нас барсны хойноо бас баруун зүгийн Төгс баясгалант оронд мэндэлж, Авид бурхантай хамт байж болно гэж би нэг номоос уншсан. Энэ үнэн үү?

**Багш:** Таны баруун зүгийн Төгс баясгалант оронд төрөхийг хэн баталж чадах вэ? Тамга дарсан уу? (Бүгд инээлдлээ), (би номоос уншсан.) За, та түүнд итгэх нь мэдээж. Багшийнх нь ярьсан нь өөр нэг зүйл болно, (би ойлгохгүй л байна, ийм байдал нь жаахан зөрчилтэй шиг?) За, Багш нь чамд тайлбарлаж өгье. Бурханд мөргөж, бурхныг дурсвал бурхны үйлийг тарьж чадах нь буруугүй. Гэвч дахиад хэр удвал сая том болох билээ? Энэ бол нэгэн том асуудал мөн. Багш чинь жимсний модтой бөгөөд чамд жимс идүүлэх тул нэлээд түргэн. Хэрвээ заавал өдөр бүр услах хэрэгтэй бол чиний тарьсан энэ суулгац мод чинь бүдүүн болтол та аль хэдийн өлбөрөөд үхчихнэ. Үүнийг даяаны бүлэгтнийхэн “Аажмаар ухаарах” болон “Агшин зуур ухаарах” гэдэг. Аажмаар ухаарах нь маш удаан, хэзээ бурхан болж чадахыг мэдэхгүй. Энэ төрөлдөө бурхныг олж ч магад, дараа төрөлдөө ч магад, дараа, дараа, дараагийн... төрөлдөө ч байж мэднэ, асанги (阿僧只劫) хэдэн сая галавын дараа сая бурхан болж ч мэднэ. Агшин зуур ухаарах нь дорхноо ойлгож, дорхноо билиг нээгдэн дорхноо бурхантай холбогддог. Ингэх нь нэлээд хурдан байдаг. Бурхныг дурсаж, бурханд мөргөх нь нэмэргүй гэж Багшийн чинь хэлсэн санаа нь: тийм буян нь миний хувьд дэндүү бага байж, бараг байхгүйтэй адил. Жишээлбэл, нэгэн том баяны хувьд хоёр төгрөг болон зуун төгрөг нь нэг их ялгаатай биш. Энэ жаахан мөнгө нь түүнд тийм ч их чухал биш. Тэр баян танд: “Надад жаахан мөнгө шаардлагатай байна.” гэж яривал, та нэг, хоёр зуун төгрөг хэрэгтэй болов уу гэж бодоод: “Одоо надад нэг, хоёр зуун мянган төгрөг байна. Болох уу? гэвэл Тэр: “Хэрэггүй” гэж хэлнэ. Уг нь тэр, хоёр сая төгрөг авах гэсэн байна. Учир нь тэр мөнгийг нэг, эсвэл хоёр зуугаар хэрэглэх дадал зуршилгүй. Нэг, хоёр зуун

төгрөг нь түүний хувьд байхгүйтэй адил, ойлгож байна уу?

Та бурхны үйл, буян тарья гэвэл бурхныг дурсан бурханд мөргөвөл зохино. Гэвч би бол бурхан болно. Би буян тарихгүй, би ямар ч үр тарихгүй. Жишээлбэл, та өвчнөө эмнэх гэвэл эмчид үзүүлэх хэрэгтэй. Гэтэл би бол эмч. Иймээс адилгүй. Эмчид үзүүлэх нь ч ач тустай. Гэвч миний хувьд мөн л хангалттай биш. Би өөрийн өвчнөө эмнэхээр барахгүй бусдын өвчнийг ч эмнэнэ. Би бол эмч, зөвхөн эмчийг хүндэтгэн нэг, хоёр ширхэг аспириин авчраад толгой өвдөхөө эмнэх төдий биш.

Иймээс бурханд мөргөн бурхныг дурсах нь буянгүй биш, бас буян хураана. Та үргэлжлэн бурханд мөргөж, бурхныг дурс, ингэх нь тун сайн. Нэгэнт сайн барилдлагатай болсон. Ийм нас залуугаараа ч аль хэдийн бурхныг хүндэтгэн ёс суртахуунтай, мөр ёсыг хайх чин сэтгэлтэй болжээ. Энэ нь тун сайн, би тун бишрэн бахдаж байна, та үргэлжлэн бурханд мөргөж болно.

Багш нь энэ бүх учир ёсыг бурхан болох дуртай хүмүүс, өөрийгөө бурхан болж чадна гэж боддог хүмүүст ярьж байгаа юм. Багшийн ажил бол тэдэнд тусалж, хэн бурхан больё гэвэл түүнд яаж хийхийг сургадаг ажил. Бурхан болох дургүй ч гэсэн хамаагүй. Ном сонсохоор ирэгчдийг баярлан угтана. Аль нэгэн өдөр тэд бас бурхан болно. Угаасаа хэдийнээ бурхан болчихсон юм чинь! Гэвч зарим хүн бурхан болохыг тун яарч байгаа. Аажимхан, бурхны үйлийг тарих зав байхгүй тул тэд түргэн шиг бурхан болохыг бодож байна. Та бас завтай юм чинь аажмаар бурхны үйлийг тарьж болно, тэгээд хожим бурхны үртэй болж, хамгийн сүүлд бас адилхан бурхан болж болно.

Бурханы алдрыг огт үл сарних сэтгэлээр дурсан уншихад заавал нэгэн түших газар хэрэгтэй бөгөөд бүх анхаарал, бүх сэтгэл зүрхээ тэр газарт (Багш билгийн мэлмийгээ заав) төвлөрүүлбэл жинхэнэ үл сарних сэтгэлээр дурсан уншсан хэрэг болно. Зөвхөн амаар дурсан унших нь хангалтгүй юм. Бодлоороо бурхныг “Дурсдаг” гэж бид хэлдэг. Гэвч бидний бодол бас л төвлөрөхгүй байсаар байдаг. Учир нь итгэж найдмаар газар байхгүй, хэрвээ бид амаараа бурхныг дурсан “Наму Авид бурхан” гэж уншихын дагуу сонсох нь мөн л ертөнцийн үг хэл болно. Энэ мөнх бусын үг хэлэнд найдаад яаж бурхны мөнхийн хутгийг олж чадах билээ?

Энэ ертөнцийг туулан гэтэлье гэвэл заавал энэ ертөнцөөс хэтийдсэн нэг зүйлийн орон, нэг зүйлийн хүчинд найдахаас биш, харин өөрийн биедээ найдаж болохгүй. Биедээ найдах нь буруугүй ч, эрхбиш өөрөө чармайн бясалгах хэрэгтэй. Гэвч нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэлдээ найдаж болохгүй. Учир нь эдгээр нь бүгд мөнх

бус зүйлс. Хэрвээ иймэрхүү мөнх бус зургаан мэдрэхүүд найдвал, унтах үед найдах газар байхгүй болчих биш үү? Учир нь нүдээр харахгүй, чихээр сонсохгүй, яг л үхсэн хүн шиг, бодол сэтгэл ч хаана ч юм яваад муу зүүд, сайн зүүд, олон янзын явдлыг зүүдэлж байхыг ч үл мэддэг. Иймээс нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэлд найдах нь нэмэргүй. Бүгд л мөнх бусын байдал, энэ мөнхийн түвшнийг олж чадахгүй.

Бурханыг дурсах нь тустай. Учир нь самгарьд хэлээр Амиитаба (Amitabha) гэдэг нь “Цаглашгүй гэрэл” гэсэн утгатай. Цаглашгүй гэрэл бол бидний тухай нэг зүйлийн бэлгэдэл мөн. Бидний гэрэл гялбаат зан чанар, гэрэл гялбаат уг чанарыг бэлгэдэж буй юм. Иймээс дурсъя гэвэл тун олон нэрийг унших хэрэгтэй. Наму гэтэлгэгч Авид Бурхан, Наму гэтэлгэгч Арьяабал Бурхан, Наму гэтэлгэгч Очирваань Бурхан гэх мэтээр тун олон бурхныг дурсах хэрэгтэй.

Заримдаа бид наян найман бурхныг дурсаж, илүүхэн шунавал мянган бурхныг дурсдаг. Зарим хүн гурван мянган бурхныг дурсаж, зарим хүн арван мянган бурханд мөргөдөг. Бурхан нэг бүр нь бидний нэг зүйлийн зан чанарыг бэлгэддэг. Гэвч арван мянган бурхныг дурссан ч мөн л хангалтгүй. Учир нь түмэн бурхан нь ч зөвхөн түмэн зүйлийн зан чанарыг төлөөлдөг төдий. Гэтэл бид Ганга мөрний элс шиг олон зан чанартай, энэ мэтээр бол хэзээ нэг дурсаж дуусах вэ? Иймээс Авид Бурхан мөн л төгс төгөлдөр орон биш. Авид Бурханы сударт, дээд чанарын дээр мэндлэх гэж ярьсан нь ч тийм сүрхий зүйл биш. Төгс төгөлдөр биш болохыг та нар сайн мэднэ. Учир нь бурхныг дурсах нь зөвхөн бидний нэг зүйлийн зан чанарыг төлөөлдөг. Өөр бусад олон талын зан чанар нийлээд сая нэгэн бүрэн төгс бурхан болж чадна. Та нар одоо бүгд Авид Бурханд тун дуртай. Хэрвээ баруун зүгийн Төгс баясгалант оронд очъё гэвэл гагцхүү чин сэтгэлийг барих хэрэгтэй. Эрхбиш бидний бурхан чанар, билиг ухаандаа найдвал сая гагцхүү чин сэтгэлээр бясалгаж чадна. Тэгвэл сэтгэл огт самуурахгүй байж чадна. Харин энэ мөнх бусын үг хэлээр Наму Авид Бурхан гэж унших нь хангалттай гэж үзэж болохгүй, ойлгож байна уу?

Яг л машины цэнэгтэй адил, цэнэг нь дуусахаар заавал дахин цэнэглэх хэрэгтэй. Машинд цахилгаан цэнэглэгч байдаг. Хэсэг хэрэглэсний дараа дахин цэнэглэх хэрэгтэй. Бид бас тийм бурхан Бодьсадва байтлаа яагаад хамаг төрөлтөн болж хувирдаг вэ? гэвэл энэ дэлхийг дэндүү ихээр адисалснаас болж хүч чадлаа бардаг. Яг л дэндүү ихээр өглөг өгсний дараа мөнгө чинь дуусдагтай адил. Одоо аав, ээжээс бидэнд мөнгө өгвөл сая дахин бурхан

Бодьсадвагийн хүчтэй болж, энэ ертөнцийг дахин адисалж чадна. Тэгэхгүй бол гэрэл гэгээ улмаар бүдгэрч, эцэс сүүлдээ тамын орон болж, харанхуй орон болж, жаахан ч гэрэлгүй болно.

Сар гэрэлтэй, нар гэрэлтэй гэж та нар битгий бодоорой. Тэдний гэрэл нь нарны гэрлээс ирсэн биш. Бид дээд түвшинд хүрвэл тоост хорвоогийн гэрэл хаанаас ирснийг мэдэх болно. Энэ нь яг л чийдэнгийн гэрэл нь цахилгаан станцаас ирдэгтэй адил. Чийдэнгийн тус биед нь гэрэл байхгүй. Цахилгаан станцтай холбогдсоноос гэрэлтэй болдог. Бидний дэлхийн бөмбөрцөг гэрэлтэй бөгөөд бид өөрөө ч гэрэлтэй байх нь бүгд л бурхны гэрэлтэй холбогдсоноос болж байгаа хэрэг. Хэрвээ бурхны гэрэлтэй холбоо тасарвал бид гэрэлгүй болж, энэхүү ертөнц дорхноо харанхуй орон болно.

Иймээс Бурхан Бодьсадва энэ тоост ертөнцөд ирж, хамаг амьтдыг адисалж, тэдэнд дахин гэрэл бүтээж өгч, цахилгааны утсыг сэлбэн зассаны сүүлээр товчлуурыг нь дармагц дорхноо гэрэлтэнэ, ямар ч асуудалгүй. Үүнтэй адилаар, та нар бурхны гэрлийг алдсан тул одоо дахин гэрэл гийх болно, та нарын гэрэл чинь эвдэрч, утас чинь тасарчээ. Одоо нэвтрэлцдэг л юм бол дорхноо гэрэлтэй болно. Энэ бол адилхан санаа, тун шинжлэх ухаанч тайлбар, нууцлаг зүйлс биш.



## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ХАМАГ ТӨРӨЛТНИЙГ ГЭТЭЛГЭХИЙН ТӨЛӨӨ Л ЭНЭ ДЭЛХИЙД ИРДЭГ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэйн Шиндиан  
1987 оны 5 дугаар сарын 3  
(Эх нь хятад хэлээр)*

Ийм их салхи борооноор мөн л энд ном сонсохоор ирсэн та нарын үнэнийг хайх сэтгэл маш өндөр байна. Төгс Гэгээрэх гэдэг бол арга, билиг хоёр хэсгийг багтаана гэж Багш нь саяхан ярьсан. Бурхан бол “арга”-ын талд байж, цав цагаан байдаг. Бурхан бол жинхэнэ амьд сэрүүн байгаа Багш мөн. Иймээс зөвхөн Шагжамуни л Бурханы хутагт хүрсэн биш. Үүнийг Багш нь олонтоо ярьсан билээ. Адилхан учрыг байнга ярьдаг нь та нарт “Бурхан” гэгч хэн болохыг ойлгуулахын төлөө юм.

Бид хичээнгүйлэн бясалгавал өөрсдөө амьд бурхан мөн болохоо ойлгоно. Бясалгахгүй бол мэдээж ойлгож чадахгүй. Төрлөөс төрөлд зөвхөн Шагжамуни гэдэг ганцхан бурхан байсан биш гэж Багш нь хэлэхгүй бол, та нар тэндээ баригдаад өөрөө бясалгаж чадахгүй. Бурхан болж чадахгүй гэж бодно. Иймээс би: Шагжамуни бол Бурханы хутгийг олсон хүн хэдий ч ганцхан тэр л Бурханы хутагт хүрсэн биш. Бурхан хоёр мянган жил өнгөрөөд нэг удаа бууж ирдэг биш. Төрлөөс төрөл бүрийд Бурхан бас байсан гэдгийг байнга чухалчлан ярьдаг. Үүнийг би олонтоо ярьсан, одоо дахин ярьж байна. Өнөөдөр мөн бурхны тухай ярих болно.

Хамаг төрөлтөн бүгд бурхан чанартай гэж бид байнга ярьдаг.

Эсвэл ядаж хүнд л бурхан чанар байдаг гэж ярихыг сонсдог. Тэгвэл бид яагаад мэддэггүй, бас өөрийгөө амьд бурхан мөн гэдгээ таньдаггүй вэ? Яагаад бид бурхан болж чаддаггүй вэ? Бид бол амьд бурхан мөн. Сайтар бясалгавал ойлгох болно гэж Багш нь саяхан хэлсэн. Гэтэл бид одоо яагаад ойлгохгүй байгаад байна вэ? Учир нь мод хэдийгээр шатдаг боловч өөрөө гэнэт гал гарган шатаж чадахгүй. Ойлгож байна уу? Иймээс аль хэдийн асаж буй цог дээр уг модоо хийвэл сая гал асна. Эсвэл хоёр мод санаандгүй харилцан үрэлцвэл бас гэнэт гал гарч шатдаг.

Зуны улиралд ой дахь мод заримдаа бас харилцан үрэлцээд түймэр болдгийг бид бүгд мэддэг. Харин зориудаар гал тавьсан биш. Заримдаа, хэн нэг нь санамсаргүй тамхины унтраагаагүй ишээ тэнд хаявал бас галын аюул үүсдэг. Гэхдээ эрт дээр үед бидний өвөг дээдэс тамхи татдаггүй байсан ч бас уул, шугуйд гал гарч шатдаг байсан. Бясалгал хийхэд мөн адилхан. Хэрвээ бид энэ ертөнцөд байгаа Бурханы хутагт хүрсэн нэгэн оройн дээд Төгс Гэгээрсэн Их Багштай учрахгүй бол өөрөө үнэнийг олж чадахгүй. Иймээс Гэгээнтэн тун чухал. Бясалгахад багшаар жолоодуулах юм уу, хэн нэгэнтэй хамт бясалгах нь маш чухал. Гэхдээ хэн нэгэн хүн өөрөө Мөр ёсыг мэдчихсэн бол биднийг замчлан үнэнийг олж чадна, бидний замчлагч болж чадна. Эрхбиш замыг нь мэдвэл зочдоо дагуулан аялж чадна. Тийм биш үү? Хэрвээ хоёулаа зам мэдэхгүй бол төөрөлдөж, зүг чиггүй гүйлдэн, эцэс сүүлдээ бүгд ядарч цуцаад өлбөрч үхэхэд хүрнэ.

Үүнтэй адилаар, бид бол бүгд бурхан мөн. Бүгдээрээ бурхан чанартай. Гэвч амьд сэрүүн Бурхантай учрахгүй бол бид Бурхан болж чадахгүй. Төрөл болгонд Бурхан бууж ирэн хамаг төрөлтийг гэтэлгэдэг. Бид өөрөөсөө: “Бурхан хаанаас ирэв? Анх түүнийг сургасан хүн байгаагүй байтал яагаад Бурхан болов?” гэж асууж мэднэ.

Хоёр төрлийн Бурхан байдаг. Нэг төрөл нь жинхэнэ Их Бурхан. Жишээлбэл, Шагжамуни, Есүс Христ, Лууз, Бодьдармаа, Хүй Нэн (Hui Neng) гэх мэт. Тэд бол суралцсаны эцэст сая бурхан болжээ. Хоёрдугаарт, ерөөл барилдлагаар Гэгээрсэн Бурхан. Ерөөл барилдлагаар Гэгээрсэн Бурхан хэдийгээр төгс төгөлдөр биш хэдий ч билиг нээгдэж, үхэж төрөх сансрын хүрднээс чөлөөлөгдсөн байдаг. Тэр бол үхэж төрж, гурван ертөнцөд ээлжилдгийг өөрөө ойлгон шинжиж, гүн сэтгэж бодсоны дүнд өөрийн уг чанараа ухаарч ойлгосон байдаг.

Ерөөлөөрөө Гэгээрсэн Бурханд их хүч байхгүй. Бусдад ном уламжилж чадахгүй. Учир нь түүнд уламжилмаар ном байдаггүй.

Тэр нэгэн багшаас сурсан биш. Харин өөрөө билиг нээгдсэн тул түүнийг ерөөлөөрөө Гэгээрсэн Бурхан гэх буюу Өөрөө Гэгээрсэн Бурхан гэдэг. Тэр өөрөө бясалгаж өөрөө Бурханы хутагт хүрсэн байна. Бусад хүн түүнтэй ойртвол бас цэвэр цайлган уур амьсгал нь нөлөөлдөг. Гэвч тэр бусдыг сургадаггүй бөгөөд сургаж ч чадахгүй. Учир нь сургамаар “Ном” байдаггүй. Амьдрал угаас мөнх бус, аливаа зүйл бүгд мөнх бус гэдгийг өөрөө гэнэт ойлгож чадсан тийм хүн бол барилдлагаар Гэгээрсэн Бурхан болно. Мэдээж тэр бас жирийн хүн биш, харин “Мөр” доторх тэр цагаан хэсэгт багтана (зураг 1). Заримдаа тэр “Мөр”-ийн нөгөө хар хэсэгт очсон ч байж мэднэ. Учир нь тэрээр тэнд даанч харанхуй байхыг хараад цагаан талын хүчнээс жаахан өгөхийг боддог. Цагаан талын хүн энэ харанхуй газарт очдог нь харанхуй хэсэг дэх цагаан толбыг өргөтгөж, тэр орныг тийм их харанхуй болгохгүйн төлөө байдаг. Тэндэх хамаг төрөлтөн дэндүү харанхуй мунхаг, дэндүү зовлонтой байхыг хараад тэдэнд жаахан туслахыг боддог. Тийм хүн бол ерөөлөөрөө Гэгээрсэн Бурхан хэмээгч болдог. Түүнийг бас Бурханы хутагт хүрсэнд тооцож болно. Гэвч энгийн бурхны ажилтай адилгүй. Гэхдээ тэд хоёулаа цагаан талаас бууж иржээ.

Гэвч зарим хүн энэ цагаан орноос ер салдаггүй, хэзээд “Бурхан” хэвээр байдаг. Бид энэ дэлхийд ирээд тун удсан болохоор харанхуй муу зүйлсэд бохирдож, дээш гарахын аргагүй тун удсаныг цагаан талын хүн хараад: “Аяа! Юутай хөөрхийлөлтэй вэ! Тэд бүгд миний найз, дотно хүмүүс шүү дээ!” гэж боддог болохоор бууж ирээд биднийг татан гаргадаг. Энэ харанхуй оронд цагаан талын хүн бууж ирэхгүй бол бид зөвхөн өөрийн хүчиндээ найдаад дээш гарч чадахгүй.

Иймээс ерөөлөөр Гэгээрсэн Бурхан хэдий багшгүй боловч энгийн хүн биш бөгөөд үхэж төрөх сансрын хүрдэнд тэгж удаан эргэлддэггүй. Түүний ажил нь энэ харанхуй оронд бууж ирээд үлгэр жишээ болж, хүсэл зорилгоо тодруулж, энэ оронд тусалдаг. Тэрээр аль хэдийн үнэнийг олсон Бурхан мөн.

Ерөөлөөр Гэгээрсэн Бурхан хэдийгээр үнэнийг олдог хэдий ч хүч нь тун бага. Зөвхөн өөрөө гэрэл цацруулан энэ дэлхийд тусалдаг төдий. Гэтэл Бурхан жишээлбэл, Шагжамуни Бурхан, эсвэл бясалгал хийгээд Мөр бүтсэн Бурхан. Амьд сэрүүн байгаа Бурханы хүч нэлээд их байдаг. Яагаад вэ? гэвэл тэд хичээнгүйлэн бясалгадгаар барахгүй бясалгал хийгээд нэлээд удчихсан. Сургаж жолоодох Багштай. Нэгэн бясалгалын аргаар бусдыг алгуураар бясалгуулан дээш гаргаж чаддаг. Шинжлэх ухаантан ч ийм. Тэд бас ёс дүрэмтэй, өөрийн бүтээсэн, эсвэл бусадтай хамтарч



судалсан туршлагаа тэмдэглэн бичээд дахин бусадтай хуваалцдаг. Шагжамуни Бурхан, эсвэл бусад амьд сэрүүн Бурхан мөн л ийм туршлагатай.

Тиймээс Бурхан бүхэн бууж ирлээ гэхэд заавал нуун далдлах хэрэгтэй байдаг биш. Заримдаа Багш нь ном тайлахаар очиход зарим хүн: “Их бясалгалтан бүгдээр нуун далдалдаг байхад та гэлэнмаа байтлаа яагаад олон орноор явж ном тайлдаг юм бэ?” гэж асуудаг. Тэгэхэд нь би: “Хэрвээ тэд бүгд нуун далдалсан бол та яагаад бурхны ёсыг тэгж ихээр мэдэж чадсан байна вэ? Зургадугаар өвөг багш Хүй Нэн, Бодьдармаа, Шагжамуни Бурханыг яаж мэдэж аваа вэ?” гэж хариулдаг. Зарим бурхан яагаад гадна гарч ном тайлдаг вэ? гэвэл Нэгт, энэ бол түүний ажил. Хоёрт, хамаг төрөлтийг харш саад тун ихээс болдог. Жишээлбэл, хамаг төрөлтөн энэ харанхуй оронд хамт амьдарч, тэр Бурхан хараахан ирээгүй үед тухайн орон тун харанхуй байдаг. Зам харагдахгүй, үйл түйтгэр нь маш хүнд. Маш харанхуй, нэн бүдэг, яг л манан будан шиг бидний замыг хааж байдаг. Иймээс бурхныг эрж олоход хялбаргүй байдаг.

Гэтэл Бурхан хаана ч очсон тун гэрэл гялбаатай. Ямар ч саадгүйгээр чөлөөт орноос цааш зорчиж чаддаг. Иймээс тэр харанхуй орны зарим хүн бурхныг эрж олохыг тун их хүсэж байхыг хардаг (эсвэл сонсдог). Тэнд нь ганц, хоёр хүн, эсвэл гурав, тав, арван хүн, эсвэл нэг бүлгэм, хоёр бүлгэм байж ч мэднэ. Туулан гэтэлж, бурхныг харахыг туйлаас хүсдэг ч тэр орон харанхуй бүдэг. Хүмүүсийн үйлийн үр, нүгэл дэндүү хүндээс болж дэвшиж чадахгүй байгааг тэр мэддэг.

Иймээс Бурханд нигүүлсэнгүй сэтгэл төрж, танд хүрч тусалдаг. Тэгэхгүй бол эдгээр төрөлтөн өөрийн үйл түйтгэрээс гадна бас өвөг дээдсийн үйл түйтгэр, гэр бүлийн үйл үр, тухайн орны хамтын үйлийн үр, улс гэрийнхээ нийтийн үйлийн үр гэх мэтийг үүрч, бурхныг эрэхийн аргагүй байдаг. Ойлгож байна уу? Хэрвээ Бурхан бүгдээрээ нуугдан далдалчихдаг бол бид түүнийг хэрхэн эрж олох вэ? Тэгвэл даанч харамсалтай биш үү? Тиймээс ном тайлах хүн заавал байх хэрэгтэй. Тийм хүмүүс нь Шагжамуни Бурхан, Есүс Христ нар юм.

Мэдээж, хэрвээ нэгэн Бурхан дандаа л суугаад хамаг төрөлтийг ирэхийг хүлээвэл маш хялбар хэрэг. Түүний бие махбодод нь ч нэлээд сайн. Түүний оюун санаа нь ч бас тэгж их зүдрэхгүй. Гэвч нигүүлсэнгүй сэтгэлээсээ болж, зарим орны хүмүүсийн чин сэтгэлээсээ тасралтгүй гуйж байхыг хардаг. Иймээс тэдний бие махбодод нь ч хүрч, тэдэнд туслах хэрэгтэй.

Учир нь хэрвээ махан бие байхгүй бол хамаг төрөлтөн түүнийг таньж чадахгүй. Хэдийгээр гэрлээр танд хүрч болдог ч нөлөө үйлдэл нь нэлээд бага, хувилгаан биеэр танд хүрдэг ч та бас мэддэггүй, ойлгож байна уу? Жишээлбэл, нэгэн Бурхан хувилгаан биеэр танд хүрч, тэрхүү гуйсан хүний өмнө илрэн тун гэрэл гялбаатайгаар түүнд хариу хэлнэ. Хэрвээ тэр хүн тийм их хүчтэй, тийм өндөр дэстэй юм уу, тийм их буянтай бол бурхны зааврыг сонсож чаддаг. Тэгээд сонсож дууссан хойноо бас Бурхан хаана байгааг мэддэггүй.

Бурхан хувилгаан биеэр байнга тань дээр очих боломжгүй. Хувилгаан биеэр байнга илэрдэг хэдий ч гэсэн тухайн хүн тэр бүр мэдэрч чадахгүй. Учир нь та эрхбиш яг тэр дэсэд нь л байвал сая мэдэрч чадна. Яг л радиотой адил, хэрвээ радиог асаахгүй бол дуугарахгүй, зурагтыг нээхгүй бол дүрс гарахгүй, радио станц, эсвэл телевизийн станц өдөржин, шөнөжин ажилладаг ч бид гэртээ зурагтаа асаахгүй бол үзэж чадахгүй. Радио, зурагт эвдэрсэн байвал бас сонсож, үзэж чадахгүй.

Үүнтэй адил, зөвхөн ном тайлбал ном уламжилж чадахгүй. Ном уламжлахдаа сэтгэлээс сэтгэлд уламжлах хэрэгтэй. Зөвхөн хүнээс хүнд л уламжилж чадна. Гэхдээ энгийн хүн болон бурхан Бодьсадвагийн дэс ондоо болохоор эхлээд сэтгэлээр сэтгэлд уламжилж, дараа нь алгуурхан сургадаг. “Хүний сэтгэл”-д ном уламжилснаар жаахан хувирч, аажмаар улам их хувирч, дараа нь бурхан Бодьсадвагийн дэсэд хүрдэг. Тэр үед сая бурхан Бодьсадвагаас суралцаж болно. Одоо бол урьдаар хүн төрөлхтөн Их Багшаас суралцах хэрэгтэй байдаг.

Иймээс бие махбод тун чухал. Тийм биш сэн бол Шагжамуни Бурхан, Есүс Христ, эсвэл бусад Их Багш махан биеэр энд ирж хүмүүсийг сургах шаардлагагүй байх байсан. Тэд диваажингаас хувилгаан биеэрээ энд ирвэл л болчихно. Ойлгож байна уу? Шагжамуни Бурхан бидэнд Авид Бурханыг танилцуулахаас өмнө, Авид Бурхан аль хэдийн байсан байтал Авид Бурхан яагаад хүмүүсийг аварч туслаагүй вэ? Яагаад Шагжамуни Бурхан ирж танилцуулсны дараа бид Авид Бурхан байдгийг мэдсэн бэ? Яагаад Шагжамуни Бурхан ирж танилцуулсны дараа бид Арьяабал Бурхан байдгийг мэдэв ээ? Яагаад урьд нь Эзэн Бурхан, Эцэг тэнгэр хүмүүсийг авран тусалдаггүй байв? Заавал Есүс Христ ирж танилцуулсны хойно л Тэдний оршин байгааг мэдэв? Тэгээд сая л түүнд даатгах болов? Учир нь захидал дамжуулдаг элч байвал бидний үг хэлийг дамжуулж чадна. Ингэснээр хүний сэтгэлтэй холбогдож чаддаг.

Үүнтэй адил, хэрвээ нэгэн бурхан зөвхөн нэг л оронд саатаж, бусад оронд очиж ном тайлахгүй бол өөр орны төрөлтөн бурхныг эрэхэд тун хүнд хүчир. Тэр Багшийг эрэхэд маш хүнд бэрх болно. Иймээс тэр чармайн сурталчлах хэрэгтэй. Мэдээж энгийн их бясалгагч бол нууж бясалгадаг. Энэ нь бас буруу биш. Гэвч хэсэг хугацаа өнгөрөөд тэр мөн л хамаг төрөлтийг гэтэлгэхээр явах хэрэгтэй. Гэхдээ зарим хүн өөрийгөө нуун далдалдаг. Гуан Чин ахмад хувраг бараг олон оронд хүрч ном тайлаагүй шиг, хэрвээ тайлсан бол цөөхөн шиг байдаг. Тийм үү, үгүй юү? Тэгээд мөн л ном уламжилсангүй. Бусдад бясалгаж суухыг заасан ч байж мэднэ. Гэвч би бодвол тэр Арьяабалын бясалгалын аргыг заагаагүй. Учир нь бидний энд Гуан Чин ахмад хуушааны шавь нар тун олон байдаг ч бас Арьяабалын бясалгалын аргыг мэддэггүй. Энд ирж Багшаас чинь сурсны дараа сая мэдсэн байна. Иймээс би түүнийг Арьяабалын бясалгалын аргыг уламжлаагүй ажээ гэж боддог.

Үүнтэй адил, Энэтхэгт бас тун олон номын багш өөр орноор ном тайлах гэж очдоггүй. Харин хүмүүсийн ирэхийг хүлээдэг. Гэвч заримдаа тэд ахмад шавиа томилж ном тайлуулдаг. Энэтхэгт нэгэн том бясалгалтан байдаг. Нэр нь Шрирама Кришна (Sri-Rama Krishna) гэдэг. Тэр бол Энэтхэг шашны гэрээс гарагч юм. Шрирама Кришна тун олон аргаар бясалгаж байжээ. Учир нь тэр бурхны шашнаас сурвал чухам бурхан болж чадах уу, үгүй юү, амжилтад хүрч чадах уу, үгүй юү, Католик шашныг бясалгавал амжилтад хүрч чадах уу, Исламын шашныг бясалгавал амжилтад хүрч чадах нь уу гэдгийг мэдэх гэжээ. Иймээс бясалгалын арга болгоныг бүгдийг нь туршсан ажээ. Эцэс сүүлд нь бясалгалын арга болгон амжилтад хүрч болно. Гэвч заавал жинхэнэ бясалгалын аргаар бясалгах хэрэгтэй гэдгийг ойлгосон байна.

Аливаа бясалгалын арга нь бүгд л Арьяабалын бясалгалын арга мөн гэж Багш нь “Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр” номдоо бас ярьсан. Хэрвээ та нар Багшийнхаа номыг уншсан бол ойлгоно. Католик шашныхан ч ижилхэн аргаар бясалгаж, Есүс Христ ч адилхан бясалгалын аргыг уламжилж, Лууз мөн адилхан сургаал ёсыг ярьсан байна. Шагжамуни Бурхан, Мухамед (Тэрээр амгалан байг) зэрэг эртний Их Багш нар бүгд энэ бясалгалын аргыг бясалгах хэрэгтэй байжээ. Өнгөрсөн, одоо, эсвэл ирээдүйд бас адил. Зөвхөн энэ “Мөр”, энэ замаар л сая дээш гарч чадна. Ондоо зам байхгүй, бусад зам нь төгс төгөлдөр биш. Аль ч замыг сонгосон эцэстээ мөн л энэ замд дахин буцаж ирэх хэрэгтэй болдог.

Биднийг энэ замд хурдан замчлан дээш гарч чаддаг хүнтэй

тохиолдвол хамгийн сайн. Тэгэхгүй бол бид эргэж тойроод жинхэнэ замыг хэзээ ч олж чадахгүй. Арьяабалын бясалгалын арга бол гэртээ харих цорын ганц төгс төгөлдөр зам мөн. Жишээлбэл: та нар Багшийнхаа суугаа газарт ирэхэд хаанаас ирсэн ч бай, хамгийн сүүлд бүгд энэ замаар явбал сая Багшийгаа эрж олно.

За, одоо Энэтхэг үлгэрийг үргэлжлүүлье. Кришна бясалгаад нэлээд удсаны дараа эцэстээ Бурханы хутагт хүрч нэрд гарчээ. Гэвч тэр ном тайлахаар хаашаа ч яваагүй. Хүмүүс түүний байгаа газар очиж ном сонсдог. Тэр нэгэн Вивэкананда (Swami Vivekananda) гэдэг шавьтай. Хожим нь Вивэкананда Америкт хүрч, шашин дэлгэрүүлээд их алдаршсан. Swami гэдэг нь гэрээс гарагч гэсэн утгатай. Бидний эндхийн “хэнзол” (банди) гэдэгтэй адил утгатай байж магад. Учир нь Энэтхэг шашны гэрээс гарагч нь хоёр зуун тавин зүйлийн сахил мөрддөггүй. Харин зөвхөн арван сахилыг л мөрддөг. Иймээс бидний энэ дэх хэнзолтой (банди) бараг адилхан.

Гэвч бид энэ арван сахилаа тодорхой сайн сахивал бас хангалттай гэж би боддог. Энэ хоёр зуун тавин сахилыг тодорхой сахиж чадах хүн байх эсэхийг би мэдэхгүй. Энэ сахил нь сайн байлгахын төлөө л байдаг хэрэг. Өнөөдөр бид аравхан сахилыг ч сахиж мөрдөж чадахгүй болчихож. Тийм үү, үгүй юу? Учир нь сахилд тогтоосноор гэрээс гарагчид мөнгө авч болохгүй гэсэн. Гэвч зарим үед шавь маань мөнгө хандивладаг. Би хэдийгээр мөнгийг нь авч чихэр, жигнэмэг аваагүй ч бас мөнгөтэй нь холбоотой болчихдог. Мөн тэр мөнгийг хэрэглэн галт тэргэнд суудаг. Өнөөдөр галт тэргэнд суухад мөнгө хэрэгтэй. Мөнгөгүй бол таныг унаанд оруулахгүй. Ингэвэл яаж ном тайлахаар явах вэ? Онгоцонд суухад хамгийн хямдхан тасалбарыг худалдаж авахад бидэнд бас мөнгө хэрэгтэй. Ойлгож байна уу? Иймээс тэр сахилыг бид баримталж чадахгүй. Учир нь тэр сахилд тогтоосноор гэрээс гарагсад мөнгө авч болохгүй гэсэн. Үүнийг бид тодорхой баримталж чадаагүйдээ тун харамсаж байна! Одоо та бүхэнд гэмшиж наманчилж байна! (Бүгд инээлдэв.)

Vivekananda гэдэг нь ямар утгатай вэ? гэвэл vivek бол ялгах чадвар (discrimination), худал үнэн, сайн мууг ялгаж чаддаг. Ananda нь бол баясал юм. Бидний Бурханы шашинд бас нэгэн Ананд байдаг нь энэ үгнээс орчуулагджээ. Учир нь Анандыг самгарьядаар Ananda гэдэг. Vive болон Ananda гэх хоёр үг нийлбэл ялгах чадвартай, баярт сэтгэлтэй гэсэн утгатай болдог.

Вивэкананда Америкт тун нэрд гарсан тул багш нь ч дэлхийд алдаршив. Хэдийгээр Кришна өөрөө гарч ирээгүй ч шавь нараа ном уламжилж болохгүй гэсэнгүй.

Өөр бас нэгэн жишээ байдаг. Энэ Их Багшийн нэрийг та нар сонссон ч байж мэднэ. Түүнийг Бабажи (Babaji) гэдэг. Тэр бараг хэдэн мянган жил амьдарчээ. Гэвч хорин таван настай мэт залуу хэвээр харагддаг. Тэр өөрөө хаана ч очдоггүй. Зөвхөн Эхемали ууланд нуугдан бясалгаж, хэнд ч харагддаггүй. Дэлхийд зөвхөн хэдэн аравхан хүн түүнтэй уулзаж байсан ч байж магад. Гэхдээ бүгд санаандгүй уулзжээ. Тэр тантай уулзахыг хүсвэл сая уулзан учирч болно. Үгүй бол хэзээ ч уулзан учирч чадахгүй.

Тэр өөрөө ном уламжилдаггүй боловч шавь нь ном уламжилдаг. Түүний ахмад шавь нь Энэтхэгт тун алдартай. Нэр нь Лахиримахасаяа (LahiriMahasaya) гэдэг. Гэтэл Лахиримахасаяа гадаадад гарсангүй. Түүний ахмад шавь (Swamisri Yukteswar) нь ч гадаадад гарч ном уламжилсангүй. Гэтэл түүний нэгэн ахмад шавь дэлхийд алдартай Йогананда (Paramhansa Yogananda) нь харин тэднийг орлон өрнө дахинаар шашин дэлгэрүүлжээ. Та нар хэрвээ бясалгагчдын тухай номыг бага зэрэг уншсан бол үүнийг ойлгоно.

Йогананда мөн л Ananda юм. Энэтхэгт Ananda гэдэг бол маш түгээмэл байдаг нэр. Ананд нэртэй бясалгагч маш олон байдаг. Хаана ч очсон Ананд гэх нэрийг зөндөө сонсдог. Йогананда Америкт крия йогийг уламжлаад их нэрд гарчээ. Вивэкананда, Йогананда хоёр Америкт тун алдартай. Хэдийгээр хоёул нирваандаа буцсан хэдий ч одоо болтол дэлхийд алдартай байна. Нэгэн Их Багш хэрвээ өөрөө ном уламжлахгүй бол бас өөр хүнээр ном уламжлуулдаг. Хэрвээ ном уламжлаагүй бол бясалгалын аргыг хүмүүс яаж мэдэж чадах вэ? Хэрвээ ном уламжлахгүйгээр хэдийнээ мэдчихдэг бол бид аль хэдийн Бурханы хутагт хүрчихсэн байж таарна. Харин үхэж төрөх сансрын хүрдэнд эргэлдэж, тэгж ихээр зовлон амсах хэрэг юу билээ? Тиймээс нэгэн билиг нээгдэж гэгээрсэн хүн бидэнд ном уламжлах хэрэгтэй байдаг.

“Тэр яагаад тийм олон сайн шавьтай байдаг вэ? Эгэл хүн яаж тийм түргэн ахмад шавь болж чадах вэ?” гэж та нар бодож мэднэ. Тийм биш, тэр ахмад шавь нар нь үнэндээ эгэл хүн биш. Кришна мөн л эгэл хүн биш. Тэд бол цагаан талынхан. Би одоо цагаан талын хүнийг ярьж байна, та нар ойлгож байна уу? Бид бол одоо хар талд амьдарч байгаа, тэд бол цагаан талд байдаг. Ингэж яривал тайлбарлахад хялбар. Вивэкананда ч мөн цагаан талаас ирсэн байна.

Би одоо та нарт түүний түүхийг ярья, сонсох уу? Буруу номтны түүхийг сонсохоос айх уу? (Айхгүй гэж бүгдээр хариулав.) Учир нь тэр бол Бурханы (Buddha) шашинтан биш.

Энэтхэг шашинтан, гэхдээ би түүний тайлсан номын агуулгыг уншихад Шагжамунийг байнга магтдаг. Учир нь Энэтхэг шашинд Бурхан байдаггүй бөгөөд Эзэн Бурхан ч байдаггүй. Тэд Бурхан бол Эзэн Бурханаас бие хувиран тэднийг гэтэлгэдэг гэж ярьдаг. Тэд Buddha бол вишна (vishna)-гийн хувилгаан мөн гэж хэлдэг. Вишну бол Энэтхэг шашинтны хамгаас хүндэтгэн хайрладаг Эзэн Бурхан мөн.

Багш чинь Энэтхэгийн Бурхан багшийн гэгээрсэн газрыг сонирхон үзэх үед маш олон хинду шашинтан бас тэнд хүж өргөж байхыг харсан. Учир нь Бурхан бол тэдний Вишну болох тул тэд хүндэтгэн бишрэхгүй байж яаж болох вэ? Сүм хийдийг нь мөн Энэтхэг шашинтнууд барьсан. Хэрвээ та нар Багшийнхаа ярьж буй буруу номтны түүхийг сонсохоос айхгүй бол би үргэлжлүүлэн ярья.

Вивэкананда бол үнэндээ нэгэн Богд гэгээнтэн. Маш эрхэм дээд дэсэд бясалгадаг. Бидний энэ тоост хорвоод биш, харин цагаан талын оронд самадид ордог. Цагаан талыг бас тун олон дэсэд хуваадаг. Бид энд түүний аль дэсийн цагаан талд самадид орсныг оновчтой хэлж чадахгүй. Учир нь Кришна тун олон шашны бясалгалын аргаар бясалгаж байсан болохоор Бурханы хутгийг олох үед хэдийн нас ахисан байжээ. Гэхдээ олон хүн түүнийг хайж ирдэг тул тун яаруу бөгөөд бие махбод нь ч тааруухан. Сэтгэл нь тоост хорвоод байх үе тун цөөн байдаг. Хэрвээ хүн түүнтэй яривал зөвхөн: “Эн! Эн!Эн!” гэж хариулан сэтгэл нь аль хэдийн дээш гарчихсан байдаг. Иймээс түүнтэй ярилцахад хэцүү, бодол сэтгэл нь заавал энэ тоост ертөнцөд байх үед нь л ярилцаж чадна. Заримдаа тэр зургаан сар самадид байдаг тул түүнтэй уулзаж чаддаггүй. Тэр хоол ч идэлгүй, үг ч ярилгүй, ялаа шумуул хамарт нь үүр барьж, сүм хийд босгосон ч мэддэггүй. (Бүгд инээлдэв.)

Түүний хөрш нь мөн нэгэн бясалгагч, энэ байдлыг хараад маш чармайн бясалгаж байхыг нь ойшоож, энэ хүн самадигаасаа гарвал дэлхийд тун ач тус хүртээхийг мэджээ. Иймээс түүнийг өдөр бүр бүдүүн саваагаар зоддог. Тэгээд зодсоны дараа тэр жаахан сэргэдэг. Энэ үед даруй түргэн амыг нь хөшиж нээн хоол хийж өгдөг. Гэхдээ зөвхөн жаахан хоол л орж, ихэнх нь урсан гарч ирдэг. Гэвч ямар ч гэсэн тэр ингэж үргэлжлэн зургаан сар амьдардаг. Үгүй бол нас барчихна. Учир нь энэ бие махбодыг хэрвээ удаан хугацаагаар хэрэглэхгүй бол ялзарч муудна. Махан бие гэж эгэл ертөнцийн махан цогцос юм хойно.

Түүний амьдрал ихэнхдээ л самадид байдаг тул хүнийг гэтэлгэхэд амаргүй. Ном тайлахаар очиход дөхөмгүй, заримдаа

бас жаахан ном тайлдаг. Гэвч тун цөөн, учир нь сэтгэл нь энд тэр болгон байдаггүй. Иймээс тэр самадид орохдоо Эзэн Бурхан, эсвэл дотоод хүчнээсээ хамаг төрөлтнийг гэтэлгэх нэгэн хүн томилж, түүнд туслахыг гуйдаг. Учир нь тэр өөртөө тусалж чаддаггүй байжээ. Тэр үед Вивэкананда бясалгал хийж самадид орохдоо энэ байдлыг мэдээд бууж ирэн түүнээс суралцан шавь нь болжээ. Тэр бууж ирэх үедээ тэр дорхноо түүнээс сурсан биш. Тэр өөрийгөө хэн болох, ямар зорилгоор ирснээ мартчихдаг. Тэгээд бууж ирмэгц эгэл хүн болдог.

Иймээс Бурхан Бодьсадва бууж ирээд бидэнд тусалдаг нь нээрээ хамгийн их энэрэл нигүүлсэл болно. Учир нь бууж ирсний дараа зовлон зүдгүүр ихээр амсаж, дорхноо бурхан болдог биш. Шагжамуни Бурхан бууж ирэхэд бурхан гэдгээ санаж байсан. Долоон алхам алхаж, алхам бүрээс долоон бадамлянхуа цэцэг дэлгэрсэн хэдий ч хожим нь мөн л бурхан гэдгээ мартаж орхижээ. Тэгээд идэж ууж, жарган цэнгэж, гучин нас дөхөх шахаад сая ертөнцийн зовлонг ухаарч, сэргэжээ. Ихэнх хүн төрөөд хоёр насалтлаа өөрийнхөө хэн болох хийгээд ирсэн зорилгоо санаж байдаг ч тэр үеэ өнгөрөхөөр хэн болохоо мартчихдаг.

Бурхан байтал бүгд ийм юм чинь эгэл хүнийг хэлэх ямар байх билээ? Бид хар талд нэлээд удчихсан тул яаж тийм түргэн сэхээрч чадах вэ? Вивэкананда цагаан талаас бууж ирснийхээ хойно бас юу хийхээр ирснээ мартсан байна. Тэр нэг үе сонгодог зохиолоос эмх замбараагүй суралцан их сургууль төгссөний дараа бас шашны сонгодог зохиолыг суралцжээ. Тэрээр өөрөө бясалгаагүй, тийм их хүчгүй байсан бөгөөд хамаг л сонгодог зохиолыг суралцсан төдий байжээ. Тэр бидний энэ дэх даяаны бүлэгтэн шиг маргахдаа тун чадамгай, ном судар ихэд уншсаны дараа бусадтай маргадаг байж. Вивэкананда хорин таван насандаа мөн л тун омгорхог байв. Учир нь түүнтэй маргаж чаддаг хүн байсангүй. Тэр бол цагаан талаас ирсэн бөгөөд тун их хүчтэй. Хэдийгээр бясалгал хийгээгүй ч мөн л хүчтэй. Маргахдаа чадамгай, хүмүүс түүнтэй маргаад буцсаныхаа дараа хэд хоногоор зүрх нь эмзэглэж, хэвийн байдалдаа орж чадахгүй болдог байж. Хэл хурц, гэхдээ энгийн хурц биш. Та түүнийг маргаж дийлэхгүй бол зүгээр л байж байх биш. Харин харьсны дараа хэд хоногоор зүрх чинь шаналан эмзэглэдэг. Үүнийг би, тэдний түүхийг уншаад мэдсэн юм.

Нэгэн өдөр тэр бусдаас, Кришна бол угаас нэгэн хөдөөгийн хүн, мэдлэгээр хомс, эд хөрөнгө ч үгүй, юу ч үгүй, гэвч ном тайлах нь маш сайн. Маш олон хүн түүнтэй уулзахаар очдог гэхийг сонсмогц, надаас алдартай хүн бас байгаа юм уу гэж дургүй нь



хүрчээ. Үнэндээ тэр түүнтэй толгойг нь өвдтөл маргалдаж, унтаж чадахгүй хэмжээнд хүргэе гэж бодсон байна. Гэвч, Кришнагийн дэргэд очоод харин тэр “гэтлэгджээ”.

Вивэкананда үнэндээ Кришнаг дорд үзэн загнаж, ичээн гутаахыг бодож, уулзмагц зогсолтгүй ярьж гарчээ. Кришна юу ч ярилгүй тэндээ суун Вивэканандад гар хүрчээ. Зөвхөн ингэсэн төдийд Вивэкананда тэр дорхноо билиг нээгдсэн бөгөөд бас том гэрэл харжээ. Билиг нээгдэн жаахан юм ойлгох болсон тул тэр почирдон ухаарав. Их юм ярьсан нь бүгд хэрэгцээгүй байж. Энэ хүн лагшинд нь хүрмэгц яг л хүчит цахилгаанд цохиулсан шиг болсон тул Багшаараа залан шавь нь болов.

Шавь нь болсны дараа мөн л өдөржин маргах дуртай байв. Учир нь өөрийгөө мэдлэгтэй гэж үздэг омгорхог зангаа мөн л бүрмөсөн таягдан хаяагүй байж. Тэр ч байтугай заримдаа багшийнхаа нулимсыг мэлмэртэл маргадаг байв. Түүнтэй маргаж хүч хүрэхгүйгээс болж нулимс унагаадаг биш. Ингэж удтал сургасан байтал ухаардаггүй омгорхог шавьтайдаа сэтгэл нь шаналдаг байжээ. Мэдээж, тийм байж таарна! Хожим нь юутай ч гэсэн түүнийг бага зэрэг дэвшүүлжээ. Гэвч Багшдаа мөн л бүрмөсөн итгэдэггүй. Өөрийгөө хэн гэдгээ мөн л мэдэхгүй. Багшаа тийм сайн биш гэж үздэг байв.

Учир нь тухайн үеийн Энэтхэгт номын багш тун олон байж, зарим нь багшаас нь ч илүү нэрд гарсан байж мэднэ. Эхэндээ тэр гэрээс гарсангүй. Хожим нь гэрээс гарсан. Гэрээс гарсны дараа тэр таван жил Энэтхэгийг тойрон аялж, Багшийгаа чухамдаа сайн уу, үгүй юү гэдгийг нь гэрчлэхээр бусад Төгс Гэгээрсэн Их Багш хэмээгчдийг эрэв. Эцэст нь мэдээж эрж олсонгүй. Багшийнх нь дэсийг мэдэж чадах хүн байсангүй. Тэгээд тэр номын багш нарын ном тайлахыг сонсохын зэрэгцээ сургаал ёсыг нь дэнслэн бүрмөсөн хүлээн авч чадахгүй байв. Хамгийн сүүлд нь эзгүй оронд хүрч: “Би одоо хаана ч очихгүй эндээ сууж, гэгээрэхгүй бол буцахгүй. Одооноос эхлэн үхсэн ч мөн эндээ байна.” гээд суужээ. Тэгээд тэндээ суун юу ч бодохгүй, юу ч сурах санаагүй болсон бөгөөд маргахгүй, багш болохгүй, шавь ч болохгүй болов. Тэр үед гэгээрсэн байна. Эцэстээ цагаан талын хүн болохоо, ямар хувь барилдлагаар сая тоост ертөнцөд ирснээ ойлгож, өөрийн үүргээ мэдээд тэр дорхноо буцав. Учир нь тэр нэгэнт юу хийвэл зүйтэй вэ? гэдгээ мэдсэн байна. Энэ бол Вивэканандагийн түүх.

Та нар хар л даа! Нэгэн цагаан талын хүн тийм их хүчтэй байсан ч энэ тоост ертөнцөд ирвэл мөн л ихэд зовж, Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багшийг эрэхэд бас тун хялбаргүй ажээ. Эрж

оллоо ч мөн л өөрийнхөө дэсээр дэнсэлдэг байна. Иймээс та нар хэрвээ зарим хүн Багшид нь итгэхгүй, Багшийг нь гүтгэхийг сонсвол тэднийг уучилбал зохино. Тэр том бясалгагч байж ч магад. (Багш болон бүгд инээлдэв.) Бид түүнийг ийм байлгахыг хүснэ. Учир нь хүсэл байвал ер нь сайн байдаг. Хэрвээ хүсэл байвал бидний ирээдүй жаахан гэрэл гялбаатай болно. Хүсэл байхгүй бол муу болно. Нэгэн хүсэлгүй хүн бол өнөөдөртөө ч амьдарч чадахгүй юм чинь маргаашийг бүр ч ярих хэрэггүй. Иймээс “хүсэл” нь бидний хувьд хамгийн сайн, хамгийн ачтай нэгэн мөн. Хэрвээ Багшид нь итгэхгүй байгаа хүнийг харвал хайрын сэтгэлээр яривал зохино. Юу ярьж чадах байна, тэрийгээ л ярь, сонсохгүй бол орхичих. Тэднийг тоох хэрэггүй. Тэд өөрийн учир шалтгаантай, өөрийн үйл үртэй. Тийм хүн бол мөн бидний ачтан, мөн л Бурхан болно.

Эзэн бурхан бол Ханьцашгүй Үнэхээр Илтэд Туулсан Бодь Хутаг. Хайр энэрэлгүй мэт байна. Хэрэгцээгүй. Зөвхөн хүмүүн бид л хүнийг аварч чадна. Гэтэл бид: “Хүн бол эзэн бурхан, хүн бүхэн бурхан чанартай, диваажин бидний дотоодод буй” гэж үргэлж ярьдаг. Тийм бол хүмүүс бид ч бас хайр энэрэлгүй байх бус уу? Тийм биш. Эзэн бурхан ч хайр энэрэлгүй байхгүй. Ханьцашгүй Үнэхээр Илтэд Туулсан Бодь Хутаг хайр энэрэлгүй байхгүй, гэсэн ч Тэр яг л хайргүй энэрэлгүй мэт байдаг.

Багш чинь яагаад хосгүй Оройн Дээд бол бурхан биш гэдэг вэ? гэвэл бурхан бол зөвхөн нигүүлсэнгүй сэтгэлтэй. Зөвхөн хайрын сэтгэлтэй, зөвхөн гэрэл гялбаатай байдаг. Бурхан бол зөвхөн хосгүй Оройн Дээдийн нэг хэсэг. Зөвхөн түүний тал хувь нь болох цагаан талынх, харанхуй зан чанар байхгүй. Гэтэл Эзэн Бурханд бол хар ч, бас цагаан нь ч байдаг. Хэрвээ Шагжамуни Бурханыг их нигүүлсэнгүй сэтгэлтэн гэвэл Эзэн Бурхан (хэрвээ Эзэн Бурхан оршдог гэж үзвэл) бол хамгийн энэрэнгүй, хамгийн нигүүлсэнгүй, туйлын энэрэнгүй, нигүүлсэнгүй нь болно. Учир нь туйлын энэрэнгүй, туйлын нигүүлсэнгүй болохоор яг л нигүүлсэнгүй биш мэт байдаг. Яагаад вэ? гэвэл Эзэн Бурхан бол энэ “Мөр” мөн. Бурхан бол цагаан оронд харьяалагддаг. Хар орон бол тоост ертөнц, там гэх мэт нь юм. Тэр оронд жаахан ч гэрэл үгүй байдаг. Бурхан хүнийг шийтгэж чадахгүй. Та ямар үйл үйлдсэн ч хамаагүй. Түүний ажил нь таныг замчлан дээш гаргах төдий. Иймээс хэрвээ та сайн биш бол тэр бас хамаардаггүй. Гэтэл Эзэн Бурхан бол таныг тамд аваачаад угааж цэвэрлэн бэлэн болгосны дараа Бурхан бууж ирж авардаг. Ойлгож байна уу?

Эзэн Бурхан ажилдаа нэлээд чармайлттай. Учир нь тэр

хүнийг залхаан шийтгэдэг, бас шагнадаг. Ер нь л бид сайн явдал хийвэл Эзэн Бурхан сайн зүйл хүртээж, муу явдал хийвэл тамд унагаадаг гэж ярьдаг нь ийм утгатай. Энэ бол түүний ажил. Яг л бид нэгэн хүүхдийг эрх танхай болгож, буруу явдал хийсэн ч маш сайн гэж сайшаавал хожим муу болдогтой адил, тийм биз?

Эрт дээр үед нэгэн их түшмэл нэг орноор өнгөрөхөд нэгэн бяцхан хүүхэд модон дээрээс доош шээхдээ яг түүний толгой дээр нь шээчихжээ. Тэгэхэд тэр юу ч хэлсэнгүй дээш харж бяцхан хүүхдэд ёслол ер загнасангүй. Тиймээс тэр хүүхэд: “Аан за! Ингэх нь тун сайн юм байна.” гэж бодох болжээ.

Нэгэн өдөр өөр нэгэн их түшмэл явж өнгөрөхөд тэр бяцхан хүүхэд мөн л тэгж авирласанд их түшмэл ихэд уурлан тэр бяцхан хүүхдийг алчихжээ. Хэрвээ бяцхан хүүхэд анх муу хэрэг үйлдэхэд их түшмэл түүнийг загнасан бол хожим бяцхан хүүхэд дахин давтан үйлдэхгүй байх байсан. Гэвч тэр их түшмэл загнаагүй болохоор бяцхан хүүхэд ингэж хийх нь зөв юм байна гэж бодож, бусдыг элэг барьж зуршжээ. Ингэснээр үнэхээр амиа алджээ. Үүнтэй адил, Эзэн Бурхан, эсвэл Мөр ёс биднийг залхаан шийтгэдэг нь бүгд л бидний төлөө байдаг. Иймээс түүнийг хамгийн нигүүлсэнгүй гэдэг. Бурхан бол их нигүүлсэнгүй, Бурхан бол зөвхөн хамаг төрөлтнийг замчлан дээш гаргадаг. Учир нь Бурхан хамаг төрөлтнийг шийтгэж түвддэггүй. Жишээлбэл, заримдаа Багш нь ч шавиа сөгтгөдөг. Үнэндээ тэр гурван цаг сөгдөх байсан. Гэвч тавхан минут сөгдмөгц би хүлцэж чадалгүй хурдхан босгосон. Учир нь сөгдөхийг нь хараад өөрөө сөгдөх шиг болж, сэтгэл өвддөг. Тэгээд л “За, бос доо!” гэдэг. Хэдий чинээ удаан сөгдвөл би төдий чинээ зовно. Хэрвээ би хүлцэж чадвал илүүхэн сөгтгөнө. Гэвч би өөрөө хүлцэж чадахгүй тул босгох л хэрэг болдог. Энэ бол Багшийнх нь сэтгэл.

Хэрвээ та нар Багшийгаа нигүүлсэнгүй гэвэл тэр нь зөвхөн их нигүүлсэнгүй. Харин хамгийн их нигүүлсэнгүй биш. Хамгийн их нигүүлсэнгүй бол чухамдаа түүнийг илүүхэн сөгтгөхийн зэрэгцээ гэмших сэтгэлийг нь хүлцвэл зүйтэй. Учир нь тэр сөгдвөл би өөрөө сөгдөж байх шиг болдог бөгөөд сэтгэл ч шанална шүү дээ! “Бид бол Эзэн Бурханы хүү мөн.” гэхийг бид үргэлж сонсдог. Тэгвэл тэр хүүгээ шийтгэх үедээ өөрөө сэтгэл шаналахгүй юу? Шаналдаг, гэхдээ заавал ингэх хэрэгтэй. Иймээс тамын орон байх хэрэгтэй. Тэр бол хувцас угаах газар мөн. Хамгийн бохир хувцсаа тэнд аваачин хэдэнтээ угаасны дараа сая цэвэршиж, дараа нь дахин өмсөж болно.

Бурхан ч ийм, тэр ийм явдлыг хийж түвдэхгүй, хүлцэж

чаддаггүй. Учир нь түүний зан чанар нь цагаан байдаг. Тэр бол цул цагаан талын хүн. Харанхуй газар байхгүй. Тэр зөвхөн хүнд туслахаас биш, шийтгэж чаддаггүй. Иймээс Багш чинь Бурхан бол Төгс Гэгээрсэн биш, өөрөөр хэлбэл Эзэн Бурхан биш гэж хэлдэг. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Та нар урьд нь ийм явдлыг сонссон уу? (Багш ярьсан гэж нэг хүн хариулав.) Багш нь ярьснаас өөр ингэж хэлсэн хүн Тайваньд байна уу? (Байхгүй гэж бүгд хариулав), Бурхны шашинд Эзэн Бурхан гэх хэллэг байхгүй. Гэвч хамаагүй, бид Эзэн Бурханыг бас нэмж оруулъя. Үгүй бол өдөржин Бурхан Бурхан гэж яриад байвал Эзэн Бурхан маш ганцаардах болно. Энэ нь бид мөн л ялгаварлах сэтгэлтэй байгааг илтгэн харуулж байна. Иймээс Эзэн Бурханыг бас энд урьж залан хамтдаа ярилцъя!

Бид үргэлж хүн бол жижиг ертөнц, жижиг Эзэн Бурхан, эсвэл Эзэн Бурханы хүү гэж хэлдэг. Яагаад вэ? гэвэл Эзэн Бурхан бол сайнтай, муутай гэж Багш нь саяхан хэлсэн. Бид бас нэг хүнийг хайрлах үедээ бүх хөрөнгөө түүнд өгөхөд асуудалгүй. Нэг хүнийг хорсох үед түүнийг алах буюу хөрөнгийг нь завшдаг. Яагаад ийм байдаг вэ? гэвэл бид Эзэн Бурханы зан чанартай. Хэрвээ сайн газар хэрэглэвэл маш гүн хайрлаж, харанхуй мунхгаасаа болж муу газар хэрэглэвэл мөн маш гүн хорсож чаддаг.

Эзэн Бурханыг тийм сайн гэж та нар битгий бодоорой. Тэр бидэнтэй адил, зөвхөн жаахан том шиг л байдаг. Жишээлбэл, тэр ганц, хоёр хүн, нэг улс орон, тэр ч байтугай бүхий л орчлонг хайрлаж чаддаг. Гэтэл бид зөвхөн ганц, хоёр хүн, эсвэл нэг улс, нэг үндэстнийг л хайрлаж чаддаг. Жишээлбэл: зарим хүн хар арьстанд дургүй байдаг. Гэхдээ тэд бол зөвхөн энэ дэлхийн нэг бүлэг иргэд төдий билээ. Гэтэл Эзэн Бурхан хэрвээ ямар нэгэн улсыг хорсвол бүхнийг устгаж чадна. Маш олон улс байлаа ч гэсэн мөн бүхнийг устгаж чадна. Хэрвээ аль нэгэн өдөр тэр бидний дэлхийн бөмбөрцөгт дургүйцвэл бас бүхнийг устгаж болно. Тэр үе бол бидний хэлдэг дэлхийн мөхлийн өдөр болно. Ойлгож байна уу?

Үүнийг хэн үйлдсэн бэ? Ганц, хоёр хүн үйлдсэн үү? Биш, Эзэн Бурхан үйлдсэн. Тэр л угийн хүч, мөнх оршигч, нэг хэсэг нь хар, нөгөө хэсэг нь цагаан “Мөр” үйлдсэн хэрэг. Тэр үйлдээгүй бол тэгээд хэн үйлдэв? Тийм биш үү? Иймээс хамгаас муу нь тэр, бас хамгаас сайн нь мөн л тэр. Хамгаас нигүүлсэнгүй нь тэр, хамгаас хэрцгий нь мөн л тэр, ойлгож байна уу?

Бид ч ийм, хамгаас сайн нь бид, хамгаас муу нь ч бид. Та нар хар л даа, энэ дэлхийд бидэн шиг сайн төрөлтөн байна уу?





Бид ч бас бодьсатва байж мэднэ, Будда ч байж болзошгүй, өөрийгөө бүү доорд үз.

*“Төгс Гэгээрсэн Их Багшийг харахын төдийд туулан гэтэлнэ”  
айлдвараас.*



Их Багшийн Нэгдсэн Үндэстний Байгууллагад  
айлдсан хоёр дахь лекц



Багшийнх нь цорын ганц хүсэл найдвар бол аль болох олон сүнсийг  
гэтэлгэн чөлөөлөх явдал.

*“Бодьсадва Махасадвагийн ажил төрөл” айлдвараас.*

Бид бол мөн л нэг төрлийн амьтан мөн. Учир нь бид хөдөлж чадна, бас идэж, унтаж чадна, хүүхэд төрүүлж чаддаг болохоор амьтантай адил. Бидэнд, тэднээс ондоо сэргэлэн ухаан байгаа бөгөөд түүнийгээ хэрэглэхээс бусад нь бүгд адил. Иймээс бид бол амьтны хаан мөн. Учир нь бид тэднээс жаахан сэргэлэн ухаантай байдаг.

Энэ амьтны вант улсад аль амьтан нь бидэн шиг тийм сайн байдаг вэ? Бусад нь байх боломжгүй, тийм биш үү? Хамгаас сайн нь бид. Учир нь бид бусдыг тайтгаруулж чаддаг, дуу дуулж чаддаг, бусдыг баярлуулж чаддаг, ном тайлж чаддаг бөгөөд өглөг үйлдэж, сахил баримталж, доромжлолыг хүлцэж, хичээнгүйлэн дэвшиж, даяанд битүүмжилж, билиг ухаантай болж чаддаг. Эзэн Бурхан хайрын сэтгэлээсээ болж нар, мод мэтийг бүтээж, хүмүүст ашиглуулдаг. Гэхдээ ашиглахын аргагүй болох үед бас бүхнийг устгаж орхидог. Гэтэл бид хэрвээ хайрын сэтгэл байвал том эмнэлэг байгуулж, их өглөг үйлдэж, маш олон хүнд тусалдаг. Хорсвол бас маш олон хүнийг хорлон хөнөөдөг. Энэ бүхнийг бүгдийг хүн л хийж чадна. Бусад амьтан хийж чадахгүй.

Гэвч та нар хар, аль нэг зүйлийн амьтан бидэн шиг тийм хар сэтгэлтэй байдаг уу? Амьтан өөр амьтанд хорсвол зөвхөн ганц, хоёрхныг л хөнөөдөг. Тэд ямар нэгэн амьтныг хорссон ч хөнөөдөггүй. Ихэнх нь өлсөхийн эрхээр л бусад амьтныг хөнөөдөг. Хамгаас хэрцгий амьтан бол арслан, бар гэж ихэнх хүн боддог. Гэвч тэд өлсөх үедээ л бусад амьтныг барьж иддэг. Өлсөхгүй бол иддэггүй. Гэвч хүн төрөлхтөн бол өлсөхгүй ч гэсэн амь хороодог. Идэх дуршлынхаа л төлөө, хорслын төлөө, нэр ашгийн төлөө, эд хөрөнгийн төлөө тоолшгүй олон амь хороож, бүхий л улс орон, бүхий л гэр бүлийг устгаж орхидог.

Эрт дээр үед зарим нэгэн хүн хүнд ялд унавал хаан зарлиг буулган есөн үеэр нь хүйс тэмтэрдэг байжээ. Та нар хар, ганцхан хүн ял хийсэн байхад есөн үеэрээ хүйс тэмтрүүлдэг. Үүнээс үзвэл хүн төрөлхтний шийтгэх тогтолцоо хамгийн аймшигтай. Маш олон эрүүгийн хэргээр хүнийг шийтгэдэг. Эртнээс өдгөө болтол нэн олон хамгийн хэцүү шийтгэх тогтолцоог бүгдийг хүн л бодож гаргасан. Тамын оронд тийм “сайн” тогтолцоо байдаг эсэхийг би мэдэхгүй. Сонсох нь ээ, тамын орон нь хүнийг сүрхий шийтгэдэг гэсэн. Гэвч тоост ертөнц нь эртнээс өдгөө болтол бас хүнийг сүрхий шийтгэдгээрээ (Багш инээв) тамын оронтой нэг их зөрөөгүй. Зарим хүн урамгүй үедээ дайн дэгдээж, тоолшгүй олон амь насыг хөнөөдөг.

Иймээс хамгаас хэрцгий нь бид мөн. Хамгаас илүү хайрын



сэтгэлтэй нь мөн л бид. Ийм юм чинь бид Эзэн Бурхантай нэг их зөрүүгүй, тийм биш үү? Иймээс бид бас Эзэн Бурхан мөн гэдэг. Учир нь бид Эзэн Бурханыг дуурайж, Эзэн Бурханыг төлөөлдөг. Бид бол Эзэн Бурханы хүүхэд мөн. Эзэн Бурхан бол бүтээгч, хийж бүтээх чадвартай. Учир нь тэр бүхий л орчлон ертөнцийг бүтээсэн. Гэвч тэр бас алах дуртай. Үнэндээ алах дуртай гэж хэлж болохгүй. Учир нь зарим юм дэндүү муухай болж, ашиглахын аргагүй болбол тэр түүнийг устгаж орхидог. Энэ бол түүний туйлын их нигүүлсэнгүй тал болно. Жишээлбэл, машиныг сэлбэн засаж болдог л бол түүнийг худалдан авч сэлбэн засах хүнтэй, улаан, ногоон өнгөөр будаж, гялалзтал нь зүлгээд дахин хэрэглэдэг. Одоогоор төвд бидний ашиглаж байгаа эвдэрхий машин бол тав дахь гар дамжиж, олон удаа сэлбэн зассан нь. Учир нь тэр бол таван удаа гар дамжсан машин болохоор заавал байнга сэлбэн засаж байж сая ном тайлахаар жолоодоод явж чадна. Энэ таван гар дамжсан машин байхгүй бол бид явган явах болно. Гэвч одоо цагт машин байвал нэлээд цаг хэмнэх тул алхахыг машинаар орлуулжээ.

Учир нь өнөө машиныг сэлбэн засах боломжтой болохоор л зассан байна. Засахын аргагүй бол хаягдал төмрийн талбайд хүргэн төмөр хавтас болгон хавтгайлбал зохино. Та нар тиймэрхүү үйлдвэрийг харсан уу? Тэнд засахын аргагүй болсон машин, эсвэл хөргөгч гэх мэтийн зүйлийг хамт хавтгайлан хэсэг хэсэг төмөр хавтас болгодог. Тийм үү, үгүй юү? Тийм машин хэдий маш хямдхан боловч худалдан авах хүн байхгүй.

Бидний дэлхий ч ийм, эгэл хүний сэтгэлийн хувьд Эзэн Бурхан бол маш хэрцгий байдаг. Гэвч эвдрээд сэлбэн засахын аргагүй болбол тэр ингэх ёстой. Бурхан гэгч юу вэ? гэвэл тэр бол сэлбэн засах хариуцлагатан мөн. Цагаан талын хүн бол энэ ертөнцийг сэлбэн засахаар ирсэн. Тэр Эзэн Бурханд: “Хүлээж бай, хүний ертөнцийг битгий тийм түргэн устга. Би сэлбэн засъя, хэрвээ үнэхээр засахын аргагүй болсон бол дахин танд буцаан өгье.” гэж зөвшилцдөг.

Иймээс Бурхан Бодьсадва их бачимдаж, хамаг төрөлтийг зовнилтойгоор нулимс унаган гуйж, мацаг барьж, бурхныг дурсана хэмээн андгайлж, бүтэн шөнөөр сөгдөж, уул усанд мөргөх мэтийг хараад сэтгэл нь хөдөлдөг. Учир нь Бурхан Бодьсадва бол зөвхөн нигүүлсэнгүй сэтгэлтэй, түүний ажил бол хүнд туслахаас өөр юу ч байхгүй.

Эзэн Бурхан бол хоёр зүйлийн сэтгэлтэй, сайныг нь хайрлаж, мууг нь устгадаг. Яг л бидний хүн чанартай адил, хэн нэгэн

хүнийг хайрлах үед эрх танхил болгож, хайрлахгүй үедээ боломж эрж хорлодог, гүтгэдэг гэх мэт. Эзэн Бурхан бас тиймэрхүү зан чанартай. Учир нь хүүхэд нь үнэндээ аав, ээжтэйгээ адилаар байдаг. Тийм биш үү? Иймээс Шагжамуни Бурхан: “Нисваанис бол бодь мөр мөн.” гэжээ. Ховдог, хилэн, мунхаг бол мөн л бодь чанар мөн. Ховдог, хилэн, мунхаг байхгүй бол бурхан чанар оршиж чадахгүй. Ховдог, хилэн, мунхаг байхгүй бол бодь мөр байж чадахгүй.

Бид Эзэн Бурхантай адил муу чанар, сайн чанарыг бүрэлдүүлсэн байхад яагаад Бурхан Бодьсадва бас биднийг бясалгал хийлгэдэг вэ? Хэрвээ бид Эзэн Бурхантай адил юм бол үргэлжлүүлэн ингэж амьдарвал болчих бус уу? Юунд бас бясалгал хийнэ гэх вэ? Эзэн Бурхан бол мөнх оршдог. Бид ч түүнтэй адилаар мөнх оршин, сайнтай бөгөөд муутай байдаг. Тэгээд юунд бас бясалгах хэрэгтэй байдаг вэ? Та нар мэдэж байна уу? Хэн мэдэх вэ? Энэ бол нэгэн тун сайхан ном хаялцаан мөн. Урьд нь ийм ном хаялцаан байгаагүй. Бид энэ ном хаялцааныг нэмж болно. Хэрвээ, зуун ном хаялцаан байсан бол одоо нэгийг нэмбэл нэг зуун нэг болно.

Өнөөдөр Багш нь та нараар, бид яагаад бясалгал хийдэг вэ? гэдэг сэдвээр ном хаялцуулна. Сонсох нь ээ, бид угаасаа Төгс Гэгээрсэн, угаасаа л Эзэн Бурхан, Бурхан чанартай байдаг гэсэн. Тэгээд бас яагаад бясалгах хэрэгтэй вэ? Хэн мэдэх вэ? Та нар ийм сайхан ном хаялцаанд оролцохгүй, харин эмх замбараагүй ном хаялцаанд оролцдог. Бодьдармаа юунд Дундад улсад ирсэн бэ? гэх мэтийн ном хаялцаанд оролцох нь хэрэгцээгүй, ойлгож байна уу? (Бясалгах нь хамаг төрөлтийг сургаж, хамаг төрөлтийг дүрэм журамтай болгохын төлөө гэж нэг хүн хариулав.) Саяхан Багш нь хамаг төрөлтөн Эзэн Бурхантай адил гэж хэлсэн. Яагаад хамаг төрөлтийг сургах хэрэгтэй вэ? Амьтныг сурган хүн шиг тийм хэрцгий болгох уу? (Учир нь бид Бурхантай адил болохын төлөө. Эзэн Бурхан сайнтай муутай, гэвч бид муу чанарыг нь авахгүй, зөвхөн сайн чанарыг авна. Иймээс бясалгал хийдэг гэж нэг хүн хариулав.) Сайн, тэр гэгээрчихжээ. (Бүгд инээлдэв.) Түүний хариултыг та нар зөвшөөрөх үү? Ингэж ярих нь зөв үү? (Зөв гэж нэгэн хүн хариулав.) Үнэн үү? Хэдэн хүн зөвшөөрөх вэ? Гараа өргөөрэй! Хүмүүсийн тал нь зөв биш, тал хувь нь зөв гэж үзэж байна. Сайн, хэрвээ зөв бол бүгдээрээ Бурхан болсны дараа Эзэн Бурхан байхгүй болчих биш үү? Эзэн Бурхан хаана очих вэ? (Эзэн Бурхан ч Бурхан болно гэж нэг хүн хариулав.) Эзэн Бурхан Бурхан болох нь чухал уу? (Багш инээв.) Ингэвэл бид орших

ертөнцгүй болно. Ингэх нь ч сайн биш, бид бусдын үзэл ухамсарт хөндлөнгөөс оролцож болохгүй. Учир нь зарим хүн, энэ тоост ертөнцөд дуртай. Энэ тоост ертөнцөд дуртай төрөлтөн байдаг л бол бидэнд мөн л Эзэн Бурхан хэрэгтэй. Бүгд Бурхан болж чадахгүй. Бурхан гагцхүү нигүүлсэнгүй ариун тунгалаг л байдаг. Тэрээр хүнийг шийтгэж чадахгүй. Сэлбэн засахын аргагүй болсон машиныг дахин шинэчилж чадахгүй. Тэр зөвхөн машиныг сэлбэн засаж чадна. Харин ашиглахын аргагүй болсон машиныг яаж ч чаддаггүй.

Гэвч хаягдал төмөр авдаг үйлдвэр бол тиймэрхүү эвдэрснийг нь худалдаж аваад хэсэг хэсэг төмөр хавтас болгон хавтгайлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд худалдана. Тэдгээр үйлдвэр төмөр хавтсыг дахин галаар хайлуулан боловсруулж хэвд цутган хэрэгтэй бүтээгдэхүүн болгодог. Тэгээд нэг шинэ машин зохиож ч мэднэ. Эсвэл нэг шинэ нисэх онгоц, шинэ усан онгоц, эсвэл жижигхэн юмс, жишээлбэл, микрофон юм уу, бийр үзэг, өсгөгч гэж мэтийг зохион бүтээж болдог. Энэ бол бидний ярьдаг “үхэж төрөх сансрын хүрд” юм.

Бид амьтан болдог. Жишээлбэл, шар шумуул, могой, эсвэл бар болох нь бүгд л тэгж хавтгайлуулан гарч ирсний дараа дахин шинэ хэлбэртэй болсон байна. Ойлгож байна уу? Үнэндээ нэг машин, эсвэл нэг хөргөгч байснаа эвдэрсний дараа дахин өөр хэлбэртэй болсон байна. Хэрвээ бид үхэж төрөх сансрын хүрднээс айж байвал даруйхан бурхнаас суралцаж, бурхнаар засуулах хэрэгтэй. Битгий дэндүү муутган засахын аргагүй болоод хэсэг хэсэг болж хуваагдаарай!

Үхэж төрөх сансрын хүрд нь мөн л адилхан. Иймээс Эзэн Бурхан хэрэгтэй. Учир нь зарим төрөлтөн дээш гарах дургүй. Баяр хөөртэй байдалд дургүй, бурхан болох дургүй, сайнтай, муутай, зовлонтой, жаргалтай байх дуртай тул бид зөвшөөрөхгүй байж үл болно. Бидэнд өөрийн гэсэн сонголт байдаг тул бусад төрөлтнийг ч өөрийн гэсэн сонголттой байлгах хэрэгтэй. Эзэн Бурхан маш чөлөөтэй, Бурхан мөн л маш чөлөөтэй. Тэр мэдээж засах тун дуртай. Мөн л хамаг төрөлтнийг хамгаалах тун дуртай. Гэвч хамаг төрөлтөн түүгээр хамгаалуулахгүй бол бас аргагүй, тэр хөндлөнгөөс оролцохгүй.

Эзэн Бурхан ч ийм, тэр өөрийн ажлаа л хийдэг. Бурхан ч бас өөрийн ажлаа л хийдэг. Бид хэдийн Эзэн Бурхан болчихсон байхад яагаад бас бясалгал хийж, Эзэн Бурхан болох хэрэгтэй вэ? Бид бол сайнтай, муутай, Эзэн Бурхан ч мөн сайнтай, муутай. Гэвч бид яагаад Эзэн Бурхан бол хамгаас нигүүлсэнгүй, хамгаас

энэрэнгүй гэж магтаж, хүн төрөлхтөн бол харин сохор дүлий, харгис хэрцгий, нигүүлсэнгүй сэтгэлгүй гэж шүүмжилдэг вэ? гэвэл Эзэн Бурханы хийсэн бүхэн нь бүгд харанхуй мунхгаас болсон биш. Жишээлбэл, бид Пен Хү-д ном тайлахаар очихдоо машинаа нэг газар тавьсанд, нэг хүн тоглоом хийж, дугуйных нь хийг гарган шалчийлгасан тул бид унаагаар явж чадалгүй алхаж явах болов. Энэ машин муухайгаас болж тэр хүн эвдсэн биш. Харин тоглоом хийх гэсэн юм уу, машиныг тэнд тавиулах дургүйгээс тэгсэн байна. Энэ нь хаягдал төмрийн үйлдвэр машиныг эвдэх юм уу, юм сэлбэн засах үйлдвэр дугуйных нь хийг гарган шинээр сольдогтой адилгүй.

Эзэн Бурхан ямар нэгэн юмыг шийтгэх юм уу, устгах гэдэг нь бүгд л түүнийг сайн болгохын төлөө юм. Тэднийг шинэ төрөлтөн, хэрэгцээтэй амьтад болгохын төлөө билээ. Иймээс тэр хүнийг шийтгэдэг. Эсвэл хүний ертөнцийг устгадаг. Гэтэл бид нэг хүнийг хорлон хөнөөдөг нь бүгд л хорслын төлөө. Түүнийг хүлээн зөвшөөрч чадахгүйгээс арга сүвэгчлэн хорлодог. Эсвэл ямар нэгэн үйл үйлддэг нь бүгд л өөртөө баяр бахдал олохын төлөө байдаг. Иймээс бид хэдийгээр Эзэн Бурханы зан чанартай боловч, Эзэн Бурхантай адил гэж хэлж болохгүй, ойлгож байна уу?

Бид өөрийн сайн муу өчүүхэн чанараа хичээл зүтгэл гарган хөгжүүлж, Эзэн Бурханых шиг агуу сайн, агуу муу эсвэл хамгийн сайн, хамгийн муу болгон өөрчилбөл зохино. Тиймээс заавал бясалгах хэрэгтэй. Бясалгаад бурхны хутгийг бүтээх нь хамгийн зөв. Бид саар муу чанараа огоот дарж, сайн чанараа төгс хөгжүүлбэл энэ дэлхийд тусалж чадна. Өөрийн хүчээр бусад хүмүүсийг аварна. Улмаар тэр хүмүүс бясалгавал Ханьцашгүй Үнэхээр Илтгэд Туулсан Бодь Хутагт болж чадна. Эзэн Бурхан шиг сайныг хийхийн сацуу саарыг ч бас үйлддэг нэгэн болж чадна.

Үнэндээ “сайн” нь ч сайн биш, “муу” нь ч муу биш. Иймээс сонсох нь ээ, эртний хүмүүс гэгээрээд хамгийн дээд түвшинд хүрвэл сайн ч үгүй, муу ч үгүй, сайн, муу бүгд адилхан болдог гэсэн. Төгс төгөлдөр гүн билиг ухаан гэдэг бол гэгээн мэргэн намба төрх, гэгээн мэргэн билиг ухаан болно. Бид яагаад Бурхан болох хэрэгтэй вэ? гэвэл бидэнд энэ сайн, муу бүгд байхын төлөө, шийтгэх тогтолцооноос ангижрахын төлөө билээ. Бурхан болсны дараа, бүгд цагаан оронд байх тул залхаагдаж шийтгэгдэх ёсгүй. Энэ шийтгэх тогтолцооноос үүрд салдаг. Иймээс Бурхан бол үйл үрээс давж, сайн оронд сууж, сайн үйлийг л хийдэг гэж хэлдэг.

Бид энэ дэлхийд амьд байхдаа л бурхан болж чадна, бурханд тооцогддог. Учир нь энэ ертөнцөд мөн л хүнийг сургах хэрэгтэй.

Бас хэлбэр дүрстэй байж л бурхан болж чадна. Хэрвээ нирваанд залран төгс төгөлдөр гүн билиг ухаан болбол бурхан биш болчихно. Учир нь тэр үед хэлбэр дүрсгүй болж, энэ их хүчтэй нэгэн цогц болчихдог. Ойлгож байна уу? Иймээс Авид Бурхан бол төгс төгөлдөр гүн билиг ухаан биш. Тэр төгс төгөлдөр гүн билиг ухаан болж чадахгүй. Учир нь тэр төрөл төрөлдөө гэрэл цацруулан хүнийг гэтэлгэхээр андгайлсан байна. Хэрвээ мөн л нэгэн гэрэл цацруулан хүн гэтэлгэх “бодол” байвал, бас л Бурханы дэсэд байгааг нь илтгэнэ. Нэгэн Авид Бурханы дүртэй Бурхан мөн. Харин төгс төгөлдөр гүн билиг ухаан биш. Мөн л сайн үйл хийж, хүн аварна гэж бодох нь төгс төгөлдөр гүн билиг ухаан биш. Гэвч энэ бол түүний хүсэл, түүний ажил юм.

Зарим хүн Багшдаа: “Та яагаад Авид Бурханыг төгс төгөлдөр гүн билиг ухаан биш гэдэг вэ?” гэж хэлдэг. Одоо та нар миний санааг ойлгосон биз? Тэр бол төгс төгөлдөр гүн билиг ухаан биш. Төгс төгөлдөр гүн билиг ухаан бол эдгээр сайн, муу явдал үйлийг анхаардаггүй. Бурхан бол зөвхөн сайн үйл хийдэг. Учир нь Авид Бурхан мөн л гэрэл цацруулан хүнийг гэтэлгэж, мөн л сайн үйл хийдэг. Иймээс төгс төгөлдөр гүн билиг ухаан биш гэж хэлдэг. Ямарваа төрөлтөн түүний алдрыг дурсвал тэр ирж гэтэлгэдэг. Хамаг төрөлтнийг хэзээ ч гэтэлгэж дуусахгүй. Иймээс тэр хэзээ ч төгс төгөлдөр гүн билиг ухаан болж чадахгүй.

Газрын зүрхэн Бодьсадва мөн л ийм. Хэзээ ч Бурхан болоогүй. Учир нь тамын орон хоосордоггүй, ойлгож байна уу? (Ойлгож байна гэж нэг хүн хариулав.) Гэгээрчихжээ, баяр хүргэе! Багш чинь юу ч хэлсэн та нар ойлгодог. Ерөөсөө яриагүй ийм ёс учрыг ч дорхноо ойлгочихдог нь хялбар бус. Бараг бүхий л Тайваньчууд, энэ дэлхийн бурхны шашинтан бүгд л Бурхан бол төгс төгөлдөр гүн билиг ухаан мөн гэдэг. Тийм үү, үгүй юү? Тэд Бурхан бол хамгийн дээд мөн гэж үздэг. Бүгдээрээ Эзэн Бурхан бол хамгаас сайн гэж магтдаг.

Эзэн Бурхан тун сайн хэдий ч бас тун муу. Бид Эзэн Бурханыг сайшаан магтахдаа яагаад ингэж магтдагаа ойлгох хэрэгтэй. Эзэн Бурхан сайн гэх бусдын хэлэхийг сонсоод сохор мунхгаар сайн гэж ярьж болохгүй. Үнэндээ тэр яагаад сайн болох, ямар сайнтай болохыг ойлгодоггүй. Бурхан маш сайн гэхийг сонссон ч бурхан яагаад сайн байдаг вэ? Сайн тал нь хаана байгаа гэдгийг мэдэхгүй.

Багшийг нь буруу номтон гэж хэлдэг. Энэ бол мухраар биширч, сохор мунхгаар итгэж байгаа явдал юм.

Багшийнхаа ном тайлахыг сонсохын зорилго нь бид юуг итгэвэл зохих вэ? Яагаад үүнд итгэх ёстой вэ? гэдгийг ойлгохын

төлөө юм. Иймээс л Багш нь сая нэг ном тайлдаг. Тэгэхгүй бол та нар: “Би хэдийн бурхны шашинтан болчихсон байхад яримаар юу л байх вэ дээ?” гэх юм уу, “Би хэдийн католик шашинтан болчихсон, би Эзэн Бурханыг танина. Танд яримаар зүйл юу байх вэ?” гэдэг. Католик шашинтнууд Эзэн Бурхан ямар гэдгийг мэдэхгүй. Бурхны шашинтан ч Бурхан гэгч хэн болохыг мэдэхгүйгээр юуг шүтэх билээ? Ойлгож байна уу? Ойлгохгүйгээр яаж шүтэх вэ? Хэрвээ шинэ бэрээ хэн болохыг мэдэхгүй. Ямар янз төрхтэйг нь ч мэдэхгүйгээр яаж дурсах вэ? Яаж хайртай болох вэ? Яаж өдөр бүр түүнийг санан нулимс унагаах вэ? Ингэх боломжгүй. Иймээс учир ёсыг нь ойлгохгүй бол итгэж чадахгүй. Багш нь хүнийг сургахад ер нь урьдаар ойлгуулж, дараа нь итгүүлдэг. Гэтэл ихэнх хүн урьдаар итгүүлж, ойлгохгүй ч хамаагүй байдаг. Өөрөө ойлгохгүй байж бусдад яаж ойлгуулж чадах вэ? Энэ бол сая жинхэнэ буруу номтон болно. Гэвч тэд харин Багшийг нь буруу номтон гэж хэлдэг, тэднийг би бас буруу номтнууд гэж хэлнэ. Гэвч тэд бол энгийн буруу номтон, Багш нь хамгийн их, хамгийн сайн буруу номтон мөн. (Бүгд алга ташив.) Тэд бол буруу номтон, Багш нь ч буруу номтон. Харин ялгаварлах сэтгэл байхгүй. (Бүгд инээлдэв.)



(Зураг 1)



## **ХЭРХЭН ҮРГЭЛЖ БУЯНЫ ҮРИЙГ СУУЛГАЖ, НҮГЛИЙН ТҮЙТГЭРЭЭС АНГИД ЯВАХ ВЭ?**

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Ши ли соёлын төвд  
1988 оны 6 дугаар сарын 9-ний өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Энэ дэлхийд хайр байхгүй бол бид амьдрахын аргагүй болно. Бид балчир багаасаа эхлэн нэгэнт хайранд суралцсан. Нялх хүүхдэд аав, ээж нь хайраар хандахгүй бол өсөн бойжиж чадахгүй. Урьд цагт тун хэрцгий нэгэн хаан дөнгөж төрсөн нялх хүүхдийг аглаг ууланд орхиж, харж хандах хүнгүйгээр амьтантай хамт байлгажээ. Хүн очдог ч зөвхөн хоол унд хүргэж өгдөг төдий. Түүнд ойртохгүй, хайрлаж халамжлахгүй, тэврэх ч үгүй, өхөөрдөх ч үгүй. Хүн төрөлхтний хайр халамжийн харилцаа байхгүй нөхцөл байдалд том болсон хүүхэд ямаршуухан болохыг туршжээ. Эцэст нь тэр хүүхэд бие бялдрын хувьд тийм ч өндөр болж, өсөж бойжсонгүй, дөрвөн мөчөөрөө явж, амьтантай адил дуугарч, ааш зан нь тун хэрцгий, хүнтэй огт адилгүй болсныг мэджээ.

Зарим шинжлэх ухаанд бас туршсан байдаг. Бяцхан хүүхдийг багад нь аав, ээжээс нь салгаж, шинжлэх ухааны аргаар өсгөвөл үнэндээ тэрээр биеийн өсөлт хөгжилтөөр муу, эрч хүчгүй болдог байна. Иймээс хайр бол хамгаас чухал. Бид бусдыг хэдий чинээ их хайрлавал төдий чинээ сайн. Энэ дэлхийд хамгаас дутагдаж байгаа зүйл нь хайр энэрэл. Харин хоол унд биш. Заримдаа бид, хоёр, гурав хоног хоол идэхгүй ч байж болдог. Гэтэл нэгэн хүн биднийг хэдэн хоногоор занан хорсоход хүрвэл бидэнд маш зовууртай



санагддаг, тийм биш үү? Жишээлбэл, нөхөр, гэргий хоёр хоорондоо таарахгүй, муудалцаж, хэдэн өдрийн турш харилцан муухай харцаар бие биеэ харж, үг ярихгүй (бүгд инээлдэв) бол тэд ихэд сэтгэл шанална. Тэгэх үү, үгүй юу? Сэтгэл санаа нь тун зовниж, зарим хүн биеэ хорлож, зарим хүн архи уух юм уу, төвөг удаж мэднэ. Энэ бол бүгд хорсол гомдлын уур амьсгал, бие биеэ хүндэлж чаддаггүйгээс болжээ. Иймээс энэ дэлхийд бид хүн гэж явахын үүрэг хариуцлага гэвэл хайр энэрэлтэй байж, бусдыг ихэд доромжилж, шүүмжилж, гүтгэж болохгүй. Өдөржин бусдын муу талыг л харах биш, үнэндээ бүгд сайн талтай.

Бид өөрсдийгөө бурхны шашинтан, эсвэл католик шашинтан гэдэг бол, өөрийн шашны эздийнхээ хайр энэрлийн сэтгэл нь хэр зэрэг өндөр байдгийг харж, тэднийг даган дуурайх хэрэгтэй. Гэвч энэ аугаа их хайр энэрлийн сэтгэлийг цогцлоох хялбар биш. Аав, ээж нь хүүхдээ хайрлахад хялбар, нөхөр нь гэргийгээ хайрлахад бас тун хялбар. Гэтэл дайснаа хайрлахад маш төвөгтэй. Есүс Христ биднийг дайснаа хайрла гэсэн, Шагжамуни Бурхан бүгдээрээ Бурхан чанартай гэсэн. Энэ нь дайснаа уучлах гэсэн утгатай. Гэвч бид тэр дайснуудаа хайрлахад тийм хялбар биш. Хэрвээ бид хүндэтгэдэг хүнээ хайрлах гэвэл маш дуртай, маш амархан хайрладаг. Гэтэл дайснаа хайрлахад хялбар биш. Учир нь бидний хайрын хүч хязгаартай.

Бидний хайрын хүч яагаад хязгаартай байдаг вэ? гэвэл тэр аугаа их хайрын хүчтэйгээ нэвтрэлцээгүйгээс болдог юм. Арьяабалын аргаар бясалгагчид бол нэгэнт энэ их хайрын хүчтэйгээ холбогдчихсон. Ингэснээр сая жинхэнээсээ бусдыг илүү хайрлаж чаддаг. Иймээс бусдыг хайрлаж чадахгүй тэр хүмүүсийн хувьд ч бас тэдний буруу биш. Тэд тун хөөрхий, өөрийн аугаа их хайрын хүчтэйгээ холбоо тасарсан байна. Бид бүгдэд энэ “Бурхан чанар” байдаг. Энэ “Бурхан чанар”-ыг бас “Аугаа их хайрын хүч” гэж нэрлэж болно. Гэвч нэр нь адилгүйг сонсвол: “Бурхан чанар нь Аугаа их хайрын хүчтэй яаж холбоотой байж болох вэ? Хэн хэлсэн бэ?” гэж бүгдээрээ мэтгэлцэж мэднэ.

Багш нь яагаад бурхан чанар бол аугаа их хайрын хүч мөн гэж хэлдэг вэ? гэвэл бид бурхан чанарыг хайж олсны дараа аяндаа аугаа их хайрын хүчтэй болж, бүхий л орчлонгийн харилцаа холбоог нэвт харж, энэ хүн нь тэр хүнтэй холбоотой, тэр хүн надтай холбоотой, би үүнтэй ч холбоотой гэдгээ мэдэх болно. Тэр үед бид сая хүн бүхнийг Бурхан Бодьсатва цаанаас зохицуулж байгааг хардаг. Иймээс бид сая бүгдийг хайрлаж чаддаг, ойлгож байна уу?

Бид яагаад гэм буруугийн сэтгэлгээтэй байдаг вэ? гэвэл, аливааг бүгдийг нь бүтээгчээс зохиосон гэдгийг мэддэггүй, харин өөрийнхөө хүчээр зохиосон гэж үздэг. Иймээс сая үйлийн үртэй байдаг, ойлгож байна уу? Хэрвээ энэ харилцааг нэвт харсны дараа бид угаас гэм зэмгүй, гэмших сэтгэл хэрэггүй гэдгээ мэдчихдэг. Яг л хүүхэлдэй шиг, эрхбиш нэгэн хүн цаанаас нь хөдөлгөвөл янз янзаар хөдөлж чаддаг. Харин хүүхэлдэй өөрөө хөдөлж чаддаг биш. Үүнтэй адил, бидний махан бие ч тэр хүүхэлдэйтэй адилхан. Хэрвээ энэ аугаа их хайрын хүч байхгүй бол бид оршин тогтнож чадахгүй.

Бид бусдыг хайрлах тун дуртай бөгөөд дайснаа ч хайрлах дуртай. Эрх дураар байх дуртай бөгөөд бусдыг мөн ийм байлгах дуртай. Гэвч яагаад ингэж чаддаггүй вэ? гэвэл бүгд л өөрийн аугаа их хайрын хүчээр дутагдаж, өөрийн Бурхан чанараа таниагүй, өөрийн Бурхан чанартайгаа холбогдоогүйгээс болдог.

Бусдыг хайрлаж чаддаггүй тийм хүмүүс хэдийгээр тун хэрцгий хэдий ч бас маш хөөрхийлөлтэй билээ. Хүн болгоны дотоодод нь бурхан чанар байгааг нэвт харвал л сая бусдыг хайрлаж чаддаг. Үүнийг нэвт харахгүй бол бусдыг хайрлаж чадахгүй. Жинхэнэ нүдтэй болж, маш хатуужилтайгаар бясалгавал сая аливаа бүхэн Бурхан Бодьсадва, хэн ч гэсэн Бурхан Бодьсадва болохыг харж чаддаг. Иймэрхүү зүйлийг тайлбарлахын аргагүй. Гэвч та нар ойлгосон юм шиг байна. Тийм биш үү? (Бүгд инээлдэхийн зэрэгцээ халуунаар алга ташив.)

Даяан үг хэл хэрэглэдэггүй, нүдийг нь харангуут болчихдог. Багшийнхаа нүдийг харах нь маш “үнэтэй” шүү! (Бүгд инээлдэв) мөнгөний үнэ биш, би мөнгө авдаггүй. Багшийнхаа нүдийг харахад ямар ч үнэгүй. Гэтэл гагцхүү нүд харахад тун үнэтэй. Харсны дараа ухасхийн дахиж мах идэж чадахгүй. Тэр ч байтугай гэрээс гарахыг бодож, (Багш инээв) Арьяабалын аргаар бясалгахыг боддог. Авшиг өгсний дараа эр нөхөр, эсвэл эхнэртэйгээ үйл үрийн харилцаа тасарч, энэ ертөнцөд дахин ирж чадахгүй болдог. Иймээс ганцхан харах нь маш үнэтэй. Та нар айвал хамгийн сайн. Багшийнхаа нүдийг битгий хараарай! (Багш болон бүгд хамтдаа инээлдэв.)

Нүд бол хүмүүсийн хувьд маш их нөлөөтэй. Нэгэн дээд түвшний бясалгагчийн нүдийг харвал бидний амьдралыг өөрчлөн засна, үйл түйтгэрээр хүнд хүний нүдийг харвал бас бидний амьдралд харшилдаг. Гэвч нэг нь нэлээд сайн болгож, нөгөө нь тааламжгүй болгодог. Иймээс заримдаа бид нэгэн хэрцгий хүний нүдийг харвал бие хүйт даадаг. Гэтэл бясалгалаар маш сайн,

маш нигүүлсэнгүй бөгөөд хайр энэрэлтэй хүний нүдийг харвал маш таатай санагдаж, оршин байгаагаар мартах шахан, хамаг бие тавирч, аядуу зөөлнөөр амрах шиг болдог. (Бүгд инээлдэв.) Та нарт ийм зүйл тохиолдож байсан уу?

“Хотол зохилдогч зүйл”-д тэмдэглэсэнээр: Арьяабал Бурхан “Энэрэнгүй харцаар хамаг төрөлтнийг хардаг”. Тэр энэрэнгүй харцаар хамаг төрөлтнийг харах үед хамаг төрөлтөн маш их буян хурааж, цэлгэр их далайгаас ч их буянтай болдог гэсэн байна. Үүнийг “Хотол зохилдогч зүйл”-д маш тодорхой хэлсэн. Иймээс бид өндөр дээд бясалгагчийн мэлмийг харах дуртай. Үүнийг ном судар уншвал ойлгоно. Шагжамуни Бурханыг амьд сэрүүн байхад хүмүүс алга хавсран түүнийг ширтэж, нүд нь тогтчихоод хөдлөхөө больчихдог байжээ. Зарим хүн нэгэн амьд бурхныг харвал самадид ордог. Нүд рүү нь харсны дараа амьд бурхан харагдахаа больж, зөвхөн нэг хэсэг гэрэл л үлддэг. Маш таатай санагдаж, огт хөдөлж чадахгүй болдог. Тэр үед самадид орсон хэрэг юм.

Иймээс дээд дэсийн бясалгагчийг харсан хүн маш их ашиг тус хүртдэг. Заримдаа түүнийг хармагц тэр дорхноо билиг нээгдэж, гэгээрсэн ахуй ойлголттой болдог. Маш олон ном судрын утгыг ойлгож, угаас ухаараагүй байсан олон зүйлийг ухаарах юм уу, гэнэт самадид орж, тун таатай санагдан олон дахин харахыг боддог. Тэр дээд дэсийн бясалгагч биднийг харахыг хүсдэг биш. Харин бид түүнийг харахыг боддог.

Бидний бясалгал өндөрсөх тусам өөрийгөө итгүүлэхээр хэнийг ч албаддаггүй бөгөөд элдэв аргаар бусдын сүсэг бишрэлийг нь дорд үзэхгүй байвал зохино. Бид нэг зүйлийн үл харагдах хүчтэй. Юм ярихгүй ч хүмүүс бидэнд дуртай, биднийг хармагцаа дуртай болдог. Үнэндээ бид бусадтай маргах шаардлагагүй. Өдөржин ертөнцийн үг хэлээр маргаад хэзээ дуусах билээ? Учир нь даяан үг хэл хэрэглэдэггүй.

Багш нь байнга ном тайлдаг нь бүгд л та нарын тархи толгой дэндүү ихийг мэддэгээс болж байгаа юм. Иймээс Багш нь тайлбарлаж, та нарт ойлгуулбал сая тархи толгой чинь хоосон болдог. Тийм бишсэн бол ярих шаардлагагүй. Тархи толгой хов хоосон болсны дараа бид сая: “Даяан үг хэл хэрэглэдэггүй” гэдэг. Иймээс авшиг хүртээх үед Багш нь ямар ч үг хэлээр ном уламжилдаггүй. Зарим хүн Багшийг нь хармагц билиг нээгддэг. Харин заавал Багшийнх нь ном тайлахыг сонсвол сая ойлгодог биш.

Бидний хуврагуудын бүлгэмд нэгэн гэрээс гарагч байдаг.

Тэр жар насалтлаа амь хороосон. Өдөр бүр ан хийж, аглаг ууланд амьдардаг байжээ. Бусадтай уулздаггүй бөгөөд ямар ч хүний ном тайлахыг сонсоогүй. Ямар ч мэдлэггүй, хятадаар ч ярьж чаддаггүй. Тайвань хэлээр хагас дутуу ярьж, заримдаа хагас Тайвань хэл, хагас Япон хэлээр ярьдаг.

Багшийг нь голын эрэгт суудгийг тэр мэднэ. Тэр үед Багш нь Дайданд ном тайлахаар очиж, голын эрэгт майхан босгоод сууж байсан юм. Тэр мэдээд нэгэн өдөр яасныг бүү мэд хүрч ирээд Багшаар нь мэргэлүүлэх гэв. Би түүнд: “Би мэргэ төлөг тавьж чадахгүй, гэрээс гарагч хүний сахилд мэргэ үзэж болохгүй гэж тогтоосон байдаг.” гэв. Тэр сонсоод юу ч хэлсэнгүй, дуугаа хурааж, аман хуураа үлээн Багшид нь сонголоо. Тоглож дууссаных нь дараа би шавиараа хоол өгүүлж идүүлэв.

Түүнийг харахад тун ядуу байдалтай, зөвхөн нэг л солих хувцастай, нүд нь улайсан, авир байдал нь тун хэрцгий бөгөөд золгүй учралаа баахан тоочив. Түүний түүхийг сонссоны дараа би шавиараа жаахан мөнгө өгүүлж, харьсныхаа дараа эм авч уугаарай гэж захисан бөгөөд жаахан хоол өгч идүүлэв. Нэг их удалгүй тэр харьсан. Тухайн үед би түүнийг ургамал хоол идээрэй гэж ятгаагүй, амь хороож болохгүй гэж ч яриагүй. Сайн үйл үйлдэх хэрэгтэй ч гээгүй. Надаас суралцах талаар бүр ч ятгаагүй.

Түүний төрх байдлыг харвал хэн ч гэсэн айна. “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” (Тансан ламын үлгэр) дэх үсээ хусуулаагүй байх үеийн Шороо багш (3-р багш) шиг харагдан, үс нь өрвийсөн, нүд нь ув улаан, үг хэлэх нь маш хэрцгий. Би ерөөсөө ятгаагүй. Зөвхөн хоол идүүлээд гэр лүү нь буцаасан. Хэдэн цаг өнгөрөөд тэр дахин ирэв. Шавь минь түүнтэй юу ярьсныг би мэдэхгүй. Ямартаа ч би Тайвань хэлийг ойлгодоггүй байсан. Тэр буцахдаа бас: “Би үхсэн ч ургамал хоол идэж чадахгүй.” гэв. Тэр миний шавьд Багшаас нь сурч чадахгүй гэж хэлжээ. Тухайн үед би юу ч хэлээгүй.

Хэдэн цагийн дараа тэр дахин хүрч ирээд Их Багшийн хүчинд уяран хайлж, сэтгэл нь догдлоод одооноос эхлэн дахин амь хороохгүй, барьсан амьтдаа бүгдийг тавина, заавал Багшийг дагаж гэрээс гарна гэж хэлсэн билээ. Хэдхэн цагийн дотор өөр нэгэн болж хувирчээ. Та нар түүний урьдах байдлыг нь хараад одоогийнхтой нь харьцуулбал танихгүй байх байсан. Тэр гэртээ харих үед түүнтэй гучин жил хамт байсан найз нь хүртэл танихгүй болчихсон байжээ.

Бурхан Бодьсадвагийн хайрын хүч үг хэл хэрэглэдэггүй ч хүний сэтгэлийг зөөлрүүлж уяраадаг. Ерөөлтэй л бол хармагц

Мөр ёсыг ухаарч, хармагцаа л билиг нээгддэг. Харин заавал үг хэлэх ёстой биш. Их ярих хэрэгтэй байдаг нь бид мөн л “Агшин зуур Мөр ёсыг ухаарах” дэсийг олоогүйгээс болдог. Иймээс л их ярих шаардлагатай болдог. Зарим хүн Багшийнх нь ном тайлахыг их сонсож, Багшийнх нь номыг уншсан байдаг. Дууны хуурцгийг сонссон хэдий ч мөн л ойлгохгүй байдаг. Үүнээс та нар хүмүүсийн зэрэг дэсийн ялгаа зөрүүг ойлгож болно.

Өчигдөр нэг хүн Багшаас нь: “Хамаг төрөлтнийг гэтэлгэж дуусах уу?” гэсэнд би: “Дуусахгүй.” гэсэн. Учир нь энэ амьтдыг гэтэлгэж дуусвал бас чулуу бий. Тэдгээр чулуу дахин өвс мод болж, өвс мод дахин амьтан болно. Амьтан дахиад хүн болохыг хүлээнэ. Хүн болохдоо хэрвээ хэрцгий бол бас дорхноо бурхан болж чадахгүй. Дахин амьтан болно, чулуу болно, тэгээд маш олон удаа сансрын хүрдэнд эргэлдэх болно.

Бид одоо нэгэн Оройн Дээд Төгс Гэгээрсэн Багштай учирсан ч түүнээс суралцахгүй, сайхан учралыг алдвал эрхбиш хэдэн мянган сая жилээр хүлээсний эцэст сая түүнтэй нэг удаа учирч чадна. Олон мянган сая жил шүү дээ. Хэдэн мянган жил биш. Учир нь ном балрах үед олон мянган сая жилээр хүлээж байж л Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багштай учрах ерөөлтэй болдог. Иймээс хүн болгон буянтай байдаг биш. Одоогоор нэгэн Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багштай уулзаад алмайран өнгөрлөө ч гэсэн дараа төрөлдөө дахин түүнийг эрж олно гэж битгий бодоорой. Тийм хялбар биш.

Яагаад хялбар биш вэ? Багш нь тайлбарлаж өгье: бидний үйлийн үрд адил бус цаг мөч, адил бус дараалал гэж байдаг. Жишээлбэл, урьд төрөлдөө сайн үйл бүтээхийн хамт муу үйл ч үйлджээ. Одоо бид энэ сайн үйл үйлдсэн цагаа олж, Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багштай аяндаа учирдаг. Бид буянаа эдэлж, амьдрал маш чинээлэг, бие махбод чийрэг, өвчингүй, явдал мөр жаахан ч харш саадгүй гэх мэт байж болно. Хэрвээ энэ сайхан учирлаа эрхэмлэхгүй бол гэнэтхэн бидэнд харанхуй, эсвэл бүрхэг цаг ирвэл аварч нөхөж амжихгүй болно. Харанхуй мөч ирэх үед биднийг доош татаж, юм бүхэн урагшгүй болох бөгөөд олон үйл түйтгэр үүсгэж, дараа төрлийн буянаа эдэлж ч амжихгүй болж магад.

Багш нь бас нэг түүх ярья! Урьд цагт нэгэн хүн маш баян чинээлэг хэдий ч тун харамч хариг, харамч гэдэг бол хэнд ч хэзээ ч өглөг үйлддэггүй, нигүүлсэнгүй үйл үйлддэггүй, мөнгөө бүгдийг тэвэрчихээд өдөржин тоолж суухыг хэлнэ. Тэр гэрлэхээс ч айдаг. Учир нь эхнэр нь дэндүү их идэхээс айна. Хүүхэдтэй болбол бүр

ч яршигтай болохоос айдаг. Тэр бас найзлахаас айна, найз нар нь гэрт нь ирж ярилцан кофе, үнээний сүүг нь уухаас айдаг. (Бүгд инээлдэв.) Ямар ч хүний үдэшлэгт ерөөсөө очдоггүй. Тэднийг дахин урьж залахаас айдаг бөгөөд нааш цааш явах зардалд мөнгө хэрэглэхээс айдаг. Иймээс тун ганцаардангуй, найз гэх хэн ч байхгүй. Гэвч ганцаарддаггүй, учир нь өдөр бүр зоосоо тоолон цаг элээж, зоос нь найз нь мөн, эхнэр нь мөн, хүүхэд нь мөн, буян нь мөн л мөнгө, бясалгалын арга нь ч мөнгө байдаг. Иймээс наян дөрвөн мянган бясалгалын аргад бараг мөнгийг ч багтаадаг байх. (Бүгд инээлдэв.) Өчигдөр та нар наян дөрвөн мянган бясалгалын аргыг асуусан. Багш нь хариулахаасаа айдаг. Учир нь зарим арга нь сайн биш. Хамгийн сайн арга нь ганцхан байдаг. Тэр бол Арьяабалын бясалгалын арга мөн. Өөр бусад бясалгалын аргаар бясалгаж болдог ч тийм ч их ач тусгүй гэж Багш нь саяхан ярьсан билээ.

Нэгэн өдөр түүний хөрш нь нас барж, бүхий л хөрөнгийг нь бусдад өгнө, хэн ч авсан болно гэснийг тэр олж сонсжээ. Ямар ч нөхцөл болзолгүйгээр өгнө гэснийг тодорхой мэдээд тэр бас хөршийндөө очиж, хөрөнгөнөөс нь дургтайгаа авчээ. Тэгээд дэндүү ихийг авч, хүнд болсон тул ганцаараа авч явж чадахгүй болов. Гэхдээ ямар ч машин байхгүй, бас хүн дуудаж туслуулах дургүй. Өөрөө тэр эд зүйлсээ авч явахыг бодсон ч аваад явчихаж чадахгүй. Алийг нь ч орхиж чадахгүй ганцаараа тэнд гар мухардан гачигдаж байв.

Тэгж байтал түүний дэргэдэх нэгэн хүн: “Би танд тусалж гэрт чинь хүргэе, болох уу?” гэж асуув. Тэгэхэд тэр цочиж: “Та мөнгө горьдож байгаа биш үү? Би бусдаар туслуулахгүй, би хэнд ч мөнгө өгөхгүй.” гэв, “Үгүй, би мөнгө авахгүйгээр гэрт чинь хүргэнэ шүү!” гэж тэр хүн хэлэв. “Ийм сайхан сэтгэлтэн байна гэж үү? Үнэн юм уу?” гэж харамч асуув. “Үнэн шүү, би танаас ширхэг ч мөнгө авахгүй.” гэж тэр хүн хэлэв.

Харамч олон дахин асууж, тэр хүн нээрээ мөнгө авахгүйг мэдсэн хойноо сая туслуулахаар болов. “Гэвч надад нэгэн нөхцөл бий.” гэж өнөө хүн хэлэв. Харамч: “Та мөнгө горьдож байвал за боль оо.” гэв. (Бүгд инээлдэв.) Тэр хүн: “Үгүй, би мөнгө авахгүй, ямар ч юм авахгүй, гэвч эндээс гэрт чинь хүртэл та миний ном тайлахыг хоёр цаг сонсох хэрэгтэй. Ямартаа ч эндээс танайх хүртэл яг хоёр цаг явна гэж хэлснээ, цагаа харж, ийм л болзолтой, болох уу? гэв. “Болно, асуудалгүй! Та ном тайлж болно. Ингэвэл цаг түргэн өнгөрөх болно.” гэв. (Бүгд инээлдэв.)

Тэгээд хоёул хамт явжээ. Тэр хүн замын турш ном тайлж,

Эзэн Бурханы учир, эрхэм дээд хүсэл, Бурхан Бодьсадва, ёс суртахууны талаар, хамгийн дээд үнэн ёсны тухай магтаал зэргийг ярьжээ. Тэгээд гэртээ харьсан хойноо харамч: “За боллоо, би гэртээ ирлээ, би одоо дахин сонсохгүй. Та явж болно, юмыг маань тавь.” гэлээ.

Тэгээд хаалгаа бушуухан хааж, нөгөө хүнийг орж ирээд ус, эсвэл ямар нэгэн юм уухаас айв. (Бүгд инээлдэв.) Тэр хүн хаалганы гаднаас: “Би бас нэгэн учрыг чамд хэлье.” гэв. Харамч мөнгө авах, эсвэл ямар нэгэн юм авахаас болгоомжлон: “Бушуу ярь.” гэв. Тэр хүн: “Гурав хоногийн дараа та нас барах болно.” гэсэнд харамч: “Та тоглоом хийж байгаа биш үү, би яагаад үхнэ гэж?” гэжээ. (Бүгд инээлдэв.) Та надад итгэхгүй байж болно. Гэвч гурав хоногийн дараа та аяндаа итгэх болно. Учир нь би бясалгал хийсэн тул таны хэзээ нас барахыг чинь мэдэж чадна. Бид урьд төрлийн ерөөлтэй. Та надад жаахан тусалж байсан. Одоо би бясалгал хийгээд амжилтад хүрсэн болохоор сая танд туслахаар ирсэн юм. Би танд хэлье, гурав хоногийн дараа та энэ ертөнцөөс салж явах болно. Иймээс явах бэлтгэлээ амжих хийх хэрэгтэй. Би зөвхөн үүнийг хэлэхээр ирсэн юм. Юуг чинь ч авахгүй. Гэтэл та нас нөгчих үедээ жаахан ч буянгүй болохоор санаа зовсондоо л явал жаахан буян хураахыг хэлэхээр онцгойлон ирэв гэжээ.

“Та нас барсныхаа хойно танд унаж, Эрлэг хаантай уулзана. Эрлэг хаан таныг, буян хураасангүй, нигүүлсэнгүй үйл жаахан ч үйлдсэнгүй, өглөг үйлдсэнгүй, сахил баримталсангүй, хичээнгүйлэн дэвших, даяан агуулах, билиг ухаан гэмээр юу ч байхгүйг чинь харвал тун яршигтай болно. Гэтэл танд хамгийн сүүлчийн бөгөөд цорын ганц буян байна. Миний хоёр цагийн ном тайлсныг сонссон буян.” гэв. (Бүгд инээлдэв.)

“Эрлэг хаан хэрвээ танаас: “Та эхлээд буянаа эдлэх үү? Эсвэл үйлийн үрээ барах уу?” гэж асуувал, таны үйл нүгэл маш хүнд учраас хамгийн сайн нь: “Би урьдаар өөрийн хоёр цаг ном сонссон буянаа эдэлье.” гэж хэлээрэй, ингэвэл танд нэлээд сайн. Учир нь хэрвээ эхлээд үйл түйтгэрээс болсон гэсгээл шийтгэлээ эдэлбэл олон сая галавыг өнгөрүүлсэн ч тамын орноос салж чадахгүй болж магад. Тэгвэл би таныг аварч чадахгүй болно.” гэв. Тэгэхэд нь харамч: “Ингэх нь зөв юм бол би сайтар санаж явъя.” гэв. Тэгээд тэр хүн явж оджээ.

Гурав хоногийн дараа тэр үнэхээр нас барав. Мэдээж доош унаад Эрлэг хаантай уулзжээ. Эрлэг хаан түүний үйл нүгэл тун хүнд, бүгд үйл түйтгэр, хамгийн сүүлд л нэг юм хоёр цаг ном сонссон буян байхыг нь харав. Эрлэг хаан үнэхээр тэр хүний



ярьсан шиг: “Та эхлээд буянаа эдлэх үү, эсвэл үйл нүглээ хүлцэх үү?” гэж асуув. “Урьдаар буянаа эдэлье.” гэж тэр хариулжээ. (Бүгд инээлдэв.) Эрлэг хаан: “За, түүнийг диваажинд хүргэ.” гэв. Хоёр цаг Эзэн Бурханы алдрыг сонссоноор, бясалгал хийгээд амжилтад хүрсэн хүний ном тайлахыг сонссоны ачаар сая диваажинд очиж чаджээ. Тэр диваажинд хүрсэн даруй ном тайлж сонгосон тэр хүн бас тэнд тэнгэрийн төрөлтөнд ном тайлж байхыг хармагцаа: “Та юу?” гэж таньжээ. Тэр хүн: “Би мөн, одоо суугаад дахин ном сонс оо!” гэв. (Багш болон бүгд хамт инээлдэв, халуунаар алга ташив.) Тэгээд тэр дахин таван цаг ном сонсов. Таван цаг ном сонссоны ачаар буян нь нэмэгджээ. Хоёр цаг ном сонссоноор тэр диваажинд зуун жил сууж болно. Одоо дахин таван цаг ном сонсоод мянган жил болгож уртасгасан, цаг нь тулбал дахин тамд унах болно. Буян нь дуусвал заавал тамд унадаг. Тэр хүн: “Та тамд очвол Эрлэг хаанд мөн л би эхлээд таван цагийн буянаа эдэлнэ гэж хэлээрэй!” хэмээн түүнд захижээ. Энэ таван цагийн буянаа эдэлж дууссаны дараа Эрлэг хаан түүнд: “Чи Төгс Гэгээрсэн Багштай болохоор харин яах ч аргагүй, за! Та явж болно. Танд гэсгээл шийтгэл хэрэггүй.” гэжээ. (Бүгд халуунаар алга ташив.)

Бидэнд буян, нүгэл бүгд байдаг. Гэхдээ бид цэцэн мэргэн бол эхлээд буянаа эдлэх энэ хугацаандаа дахин өөр буян үйлдэж болно. Ингэвэл бидний буян тун их болж, хэрэглээд дуусахгүй. Үйл нүгэлтэй ч гэсэн түүнийг амсах шаардлагагүй. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Үүнтэй адил, бид одоо нэгэнт хүн болсон энэ зол завшаанаа дэмий үрэхгүй байх нь зүйтэй. Тэгэхгүй бол үйл түйтгэр ирэх үед амжихгүй болно. Учир нь үйл түйтгэр ирвэл заримдаа тамд унан, маш удтал салж чадахгүй. Аврах хүн ирэхгүй болно. Иймээс тамд унахаасаа өмнө хүн болсон, зургаан мэдрэхүй маш сэргэг байгаа байдлаа ашиглан бясалгал хийвэл бас амжих болно. Буянаа хэрэглэж дуусахгүйгээр дахин өөр нэгэн их буян хураавал хожим хэрэглээд барахгүй болдог. Тэгсээр үйл түйтгэрийг нэг их чухалчлалгүй, үйл түйтгэр бүгд буянд бүрхэгддэг.

Иймээс Эрлэг хаан Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багшаас тун айдаг. Тэр хэнээс ч айдаггүй ч Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багшаас л айдаг. Учир нь Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багш хүнийг аварч чаддагийг тэр мэднэ. Ямарваа хүн Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багшид харагдмагц аврагдаад Эрлэгийн эзэнтэй ямар ч холбоогүй болдог. Иймээс Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багшийг дайрч шүүмжилбэл тэр бол Эрлэг хааны албат мөн. Тэдний ажил бол хүмүүсийн бясалгал хийхийг саатуулж, өөрийнх

нь Оройн Дээд Төгс Гэгээрсэн Их Багшийг нь таниулдаггүй. Төрлөөс төрөлд сансрын хүрдэнд эргэлдүүлдэг. Ингэвэл л тэр сая тэр хүмүүсийг шийтгэх боломжтой болно.

Гэхдээ энэ нь мөн л нэгэн төрлийн шалгалт юм. Харин муу санаа биш, энэ бол орчлонгийн тогтолцоо мөн. Яг л улсын тогтолцоо шиг ерөнхийлөгчтэй, иргэдтэй, цагдаатай гэх мэт. Цагдаа бол тэр муу хүмүүсийг шийтгэн, улсын амар амгаланг хамгаалдаг. Цэрэг бол дайсныг устган, улс орныхоо энх тайвныг тогтоодог. Энэ нь муу санаанаас болсон биш, зөвхөн нэг зүйлийн тогтолцоо төдий билээ. Хэрвээ бид тэдгээр тогтолцооноос зайлсхийх гэвэл дээд дэсийн бясалгалын аргаар бясалгах хэрэгтэй. Гэхдээ тэр хүмүүсийг гүтгэх буюу доромжлон дайрахгүй, харин өөр нэгэн замыг хайх нь сайн. Хэрвээ бид цагдаатай холбоогүй, тэдэнд шийтгүүлэхгүй гэвэл хулгайлахгүй, хүн алахгүй, муу хэрэг үйлдэхгүй байж, нэгэн сайхан сэтгэлт иргэн болох хэрэгтэй.

Хэрвээ өндөр дээд мэдлэгтэй бол хэлтсийн дарга, ерөнхийлөгч, том цэргийн ноён болж болно. Эмч болж бусдад тусалж болно. Харин өдөржин цагдаа яагаад хүн шийтгэдэг вэ? гэж шүүмжилж болохгүй. Энэ бол тэдний ажил. Бид зөвхөн тэдэнтэй холбоогүй бол болчихно, ойлгож байна уу?

Үүнтэй адилаар энэ орчлонд чөтгөр, шулам, бурхан Бодьсадва байдаг. Бид чөтгөр шуламтай холбоогүй, зөвхөн бурхан Бодьсадватай холбоотой байвал зохино. Ад чөтгөр бас хамгийн сүүлд бясалгал хийгээд бурхан Бодьсадва болж болно. Зөвхөн одоогоор бясалгал хийх дургүй. Тиймэрхүү ажлыг хийх дуртай байгаа хэрэг.



## ГАЙ ГАМШИГ БҮХЭН БОДОЛ САНААНААС Л ҮҮСДЭГ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайнаны бясалгалын талбайд  
1988 оны 10 дугаар сарын 13-ны өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Багш, шавь бид ойрдоо гадна талын хатуу шалгалтыг тууллаа. Энэ нь бүгд бидэнд нөлөөтэй. Гэхдээ Багш нь ном дэлгэрүүлээд удаагүй. Урьд нь Тайваньд байхдаа бас нуугдан сууж байгаад таван жилийн дараа л сая ном дэлгэрүүлсэн. Тэгээд та нартай танилцаад жил гаруй л болж байна. Нэг жил болсон уу? (Тийм гэж дийлэнх нь хариулав, зарим хүн нэг жил, зарим нь арай болоогүй гэв.) Аливаа үйл хэргийн эхлэл нь бэрх байдаг. Үнэхээр тийм шүү, та нарт ч ийм сэтгэгдэл төрдөг үү? (Тийм гэж бүгд хариулав.) Дарамт маш их, тун хүнд байна. Тэд зөвхөн Багшийг нь шүүмжилсэн төдийгүй та нарыг бас шүүмжилдэг. Ингэхлээр заримдаа бидний толгой тархи төөрөлддөг. (Багш инээв.) Гэвч бас зүгээр, мөн л амь голтой, ой ухаан сэргэг хэвээр амьдарч байна. Яг л бидний төвдөө тарьсан нялх мод шиг. Тариад нэг их удалгүй хэдэнтээ салхинд үлээгдэн бороонд цохиулсан хэдий ч одоо бүр ч илүү “гялалзчихжээ”. Шинэ нахиа цухуйсныг та нар харсан уу? Маш гэгээлэг бөгөөд цул ногоон болов. Та нар санаж байна уу? Дөрөв хоногийн даяаны үед их бороо орж, та нарын майхан урагдаж, хүчтэй салхинд хийсэн газар ойчсон. Тэр шинэ нялх модод бороонд ихэд цохиулаад лав ойчсон юм уу, ургаж чадахаа больсон байх гэж би бодсон чинь харин бүр ч илүү ногоорч, сүрхий ургаж, одоо услахгүй ч гэсэн ургаж чадахаар

болжээ. Нээрээ гайхалтай. Тэр өдрийн салхи бороог туулсны дараа бүр ондоо болж, ширхэг навч ч унаагүй мөртлөө ногоон нахиа цухуйж, тэр мод арчилгаа шаардахгүйгээр, алгуурхан бүр ч сайн, түргэн ургажээ. Тийм биш үү?

Бид ч адилхан. Ноднин бусдад үнэхээр хэцүү шүүмжлүүлж, Багш, шавь бид бүгдээрээ маш олон шалгалт сорилт, маш олон дарамтыг туулав. Миний бодлоор энэ жил сайжирчээ. Ноднин жилийн сүүлээр Тайнанд анх илээр ном тайлав. Үүнээс өмнөх нь ил биш байсан, хэдийгээр илээр ном тайлдаг хэдий ч зохион байгуулалтгүй, шавь нар маань найз нөхөд, хамаатан саднаа дагуулж ирээд ном сонссон. Шавь нар зарлаж сурталчлаагүй, юу ч хийгээгүй. Анх удаа илээр ном тайлах үед үлгэр дэвтэр тараасан. Одоо нэг жил өнгөрчээ. Юм бүхэн ондоо болсон байна. Та нарт жаахан сэтгэл тайвширсан шиг санагдаж байна уу? Багшид нь тэгж санагдаж байна. Хэдийгээр бас гүтгэх хүн байгаа, бүр илүү тод, маш хэцүү байдаг хэдий ч бид угаасаа сэтгэл тайвширч, бүр ч илүү баяр баясгалантай байна. Тэдгээр гүтгэх хүнийг дагагсад үнэндээ бидний энд ирэхгүй бол зохилтой. Буян хариулал маш ихтэй хүн л Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж чаддаг.

Төрлөөс төрөлд маш олон Их Багш байсан гэж бид сонссон ч тэд чухам юу сургадаг байсныг нь мэддэггүй. Багш нь ярьсны дараа та нар сая, тэд уг нь бүгдээрээ Арьяабалын бясалгалын аргыг сургаж байсныг ойлгосон. Гэтэл уул нь мэдэх хүнгүй байв. Учир нь энэ бясалгалын аргаар бясалгаж чаддаг хүн тун цөөн. Хүн болгон чаддаг биш. Иймээс төрлөөс төрөлд бясалгагч тийм цөөн. Бурханы хутагт хүрэгсэд бүр ч цөөн. Яг л хөгжим сурахтай адил. Ихэнх хүн хөгжмийн сургууль, жишээлбэл, ятга сурдаг ч хүн болгон нэр алдаршдаг биш бөгөөд хүн болгон ятгын багш болж чаддаг биш. Ихэнх хүн ганц хоёр хоног сураад больчихдог. Над шиг хоёр, гурван долоо хоног сураад дахин сурахаа больдог. Учир нь дэндүү яаруу, эсвэл дур сонирхолгүйгээс болж байгаа хэрэг.

И Ланы нэг хүн тавхан жил сураад ятгын багш болов. Бусад хүн арав, хорин жил сурлаа ч бас нэрд гарахгүй байж магад. Миний хэдэн шавь түүнээс сурч байна. Тэр тавхан жил сураад ятгын багш болжээ. Энэ нь хялбар бус. Сонсоход тэр гоц сайхан хөгжимддөг гэсэн. Гэвч хүн болгон ингэж чадах биш. Учир нь тэр урьд төрөлдөө ятга сурсан байх. Эсвэл дээд түвшинд байхдаа хэдийн сурч гүйцээсэн байна. Бидний ихэнх нь бас дээд төвшнөөс бууж ирсэн. Бидний бясалгагчдын зарим нь эгэл хүн биш. Зарим нь Траястримса (Trayastrimsa) тэнгэр (гучин гурван тэнгэр). Зарим

нь дөрөвдүгээр ертөнц, зарим нь гуравдугаар ертөнц, зарим нь хоёрдугаар ертөнц, зарим нь Асурийн орноос ирсэн байна. (Бүгд инээлдэв.) Бид ааш араншин, эсвэл үзэл бодлоо ажвал хаанаас ирснээ мэдэж болно. Жишээлбэл, маш омгорхог, бусадтай маргах тун дуртай бөгөөд хөөрүү сэтгэлтэй байвал нэгдүгээр ертөнцөөс ирснээ мэдэж болно, “тамын орон” (地獄) биш. Харин “нэгдүгээр” (第一) ертөнц мөн. (Бүгд инээлдэв.) (тамын орон болон нэгдүгээр гэх ханз үсгийн дуудлага нэлээд адил төстэй болохоор Багш зориуд ингэж ярьжээ.) “Тамын орон” ч байж мэднэ. (Багш инээв.) Зарим хүн дөнгөж амьтны төрлөөс ирсэн гэх мэт янз байна. Иймээс тун ч ээдрээтэй. Гэхдээ Арьяабалын бясалгалын аргаар бясалгавал удалгүй маш түргэн хувирдаг. Бидний гэрээс гарагчдын дунд үлгэр жишээ тун олон. Нэг жилийн өмнө болон нэг жилийн дараа ер адилгүй болдог. Гэтэл тэр хүмүүсийг Багш нь эрхбиш маш хатуугаар дасгалжуулж, өдөр бүр шалтаг эрж загнадаг. Тэр алдаа гаргаагүй байж ч магад. Гэвч Багш чинь шалтаг эрж хараад үйл түйтгэрийг нь түргэн угаан цэвэрлэдэг.

Нэгэн хатуу чанга төгс гэгээрсэн багш болох нь маш зүдгүүртэй. Багш чинь Мял богдын түүхийг хэдэнтэй ярьсан. Мял богдын багш нь маш хатуугаар түүнийг сургахдаа байнга загнан зоддог. Гэтэл Мял богд түүнээс салж явах үед багшийнх нь сэтгэл тун шаналан сэмхэн нулимс унагадаг. Тэгээд шавийгаа түргэн буцааж ирүүлэхийг хамаг бурхдаас гуйдаг. Жинхэнэ багшийн сэтгэл гэгч ийм л байдаг.

Та нар найман сахиусны үлгэрийг уншсан уу? Хатны ах Цоо овогт уг нь их түшмэл байсан. Хожим нь сахиус болох үеэр өөр нэг сахиус түүнийг туршин шалгав. Цоо овогт завин дээр гармагц: “Хөөе, завьчаан, нааш ир! Сандаг авчирч намайг суулга.” гэжээ. (Хэ овогт эмэгтэй сахиус завьчин болж биеэ хувилгасан байжээ.) “Таныг суулгах сандал хаанаас байх вэ? Та зогсоогоороо яв!” гэж завьчин хэлэв. Тэгээд удтал шалгуулсны нь дараа сахиус түүнд сэтгэлийн авшиг хүртээв. Хатны ах Цоо овогт зориудаар бусдыг дээрэлхэн сандал авах гэсэн биш. Харин урьд өмнө нь их түшмэл байхдаа омгорхог зан сууснаас болжээ.

Зарим хүн урьд төрөлдөө дээрэмчний тэргүүн байсан бол энэ төрөлдөө мөн л болхидуу, омгорхог зантай. Жишээлбэл, дээд алба тушаалтан, дарга, эсвэл багш хүн бусдыг захирах дадалтай байвал, эсвэл гэр бүлээ дээрэлхэж заншвал хожим даруу болоход тун бэрх бөгөөд үнэнийг хайхад саад харштай болдог. Гэхдээ бас: мөр ёсыг хайх тун хялбар. Их Багшаас ном уламжлахыг гуйвал л болчихдог. Ямар төвөгтэй юм бэ? гэж бид боддог. Төвөгтэй

шүү! Учир нь бид өөрөө өөрийгөө төвөгтэй болгож, хана хэрэм босгож саатуулдаг. Иймээс хатуу багш болох нь хялбаргүй, “халтай багшаас галтай шавь” гэж хэлэхээр л болчих биш. Яаж тийм хялбар байж болох вэ? Үнэндээ ямар нэгэн явдал үйл хийсэн ч хялбар бус, хатуу багш болох нь бүр ч хялбар бус. Шавиа эрхбиш хатуужилтайгаар дасгалжуулах хэрэгтэй. Учир нь Багш нь Тайваньд ирээд тийм удаагүй бөгөөд хүмүүс Багшийг нь таньдаггүй. Гэтэл гадаадын хүн, хүмүүс бүгд өөрийнхөө улсын хүнд дуртай. Тийм үү? үгүй юу? “Дусал цус ер нь нэг сав уснаас сайн байдаг.” гэдэг нь цусан төрлийн харилцаатай хүн нь гаднах хүнээс сайн байдаг гэсэн утгатай.

Ер нь гадуурхах сэтгэлтэй болчихжээ. Ерөөсөө сонсоогүй гадаадын хүн бөгөөд тийм хатуу багшид шавилах хүн байх уу гэж тэд боддог. (Бүгд инээлдэв.) Тэгэхийн оронд сүмд очиж мөргөхийг хүснэ. Сүмд очиж улаан дугтуй (мөнгө) хандивлан, биднийг дараагийн байранд тавьдаг. Төгс Гэгээрсэн Чин Хай-д шавилбал өглөг өгсөн ч авдаггүй атлаа бас загнана. Гэвч энэ жил багш, шавь бидний сэтгэлийн дарамт нэлээд хөнгөрчээ гэж би боддог. Найман сарын тэргэл сарны баяр арван тавнаас хойш бид тун хөнгөрөв. Иймээс энэ сайн мэдээг дамжуулж, та нарыг жаахан баярлуулъя. Гэхдээ мөн л хичээн болгоомжлох хэрэгтэй. Жаргах үед сэрэмж хэрэгтэй гэдэг. Омогт хилэнтэй цэрэг болохоос хичээн сэрэмжлэх хэрэгтэй. Заримдаа дайтах болгонд ялаад байвал омогтой цэрэг болчихно. Иймээс Сүн Зи-гийн цэргийн аргад омогтой цэрэг дайнд үхэхэд хамгийн амархан гэж ярьсан байдаг. Тэр хичээн болгоомжлохгүй, дасгал сургуулилт хийхгүй, өөрийн чадвараа тоохгүй, өдөр бүр цэргийн бэлтгэл хийхгүй бол дайсан болгоомжгүй үед нь дайрч түүнийг ялдаг. Гэвч бид дотооддоо өдөр бүр дадуулж байгаа тул асуудалгүй.

Бусад хүн та нарт таван ариун нэрийг хэлэх юм уу, та нар бусдад хэлэх нь ямар ч хэрэгцээгүй гэж Багш нь хэлсэн. Багшийн зөвшөөрөлгүй бол энэ хүчийг хулгайлж болохгүй. Ойлгож байна уу? Энэ нь яг л бусдын банкны картыг хулгайлаад өөрийн нэрээ бичихтэй адил. Та банканд очвол тэд таныг баривчилна. Харин танд мөнгө өгөх боломж байхгүй. Иймээс тун аюултай. Багш чинь таван ариун нэрийг задруулж болохгүй гэж ярьдаг нь ийм санаа билээ. Учир нь таван ариун нэрийг задруулсан тэр хүнд муугаар нөлөөлнө. Харин надад ямар ч нөлөө болохгүй. Таван ариун нэрийг сургах нь зөвхөн анхан шат төдий. Хэрвээ энэ жаахан зүйлийг нууц болгож эс чадвал гүн нууцлаг аргад нэвтэрч чадахгүй. Яг л нэгэн сурагч эхлээд англи хэл сурахдаа дөнгөж

хорин зургаан авиаг мэдэнгүүт англи хэлний оньсыг мэдчихнэ гэж онгирохтой адил. Хэдийгээр англи хэлний бүх хэл зүйн дүрэм нь бүгд энэ 26 авиа үсгээс бий болсон хэдий ч маш удтал суралцаж байж сая яаж хэрэглэхийг нь мэддэг. Харин 26 авиа үсгийг мэдээд л болчих биш. Иймээс эртний үед бүгд нууцлаг сургаал ёсон гэж нэрлэдэг байсан нь ийм санаа билээ.

Бид бясалгал хийвэл бусад хүн хулгайлж чадахгүй. Та нарын дотоодын ахуй ойлголтыг хулгайлсан хүн байна уу? Дотоод дахь Багш чинь та нарт их юм сургадаг ч өөр хүн бичиж тэмдэглэж чадахгүй, сонсож чадах, харж чадах хүн байхгүй. Тийм биш үү? Таван ариун нэрийг задруулах нь зөвхөн инээдтэй өчүүхэн хэрэг. Санаа зовох хэрэг алга.

Багшийнх нь сургаал бол жинхэнэ нууц сургаал мөн. Учир нь дотоодоос чинь сургадаг. Таван ариун нэр нь тийм сүрхий юм биш. Багшийн зөвшөөрөлгүйгээр бусдад сургах, унших нь зөвхөн инээдтэй хэрэг. Жаахан ч хүчгүй, зөн билиг мэдрэгдэхгүй. Яг л бусдын банкны картыг хулгайлсан шиг. Харин өөрт нь мөнгө байхгүй. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Гадаа гарч дураараа таван ариун нэрийг задруулахын үйл түйтгэр маш хүнд. Учир нь энэ бол муу санаанаас үүсдэг. Муу санаа байвал муу үр нөлөөтэй болно. Хамгийн дээд Бурханыг гүтгэхийн уршиг тун их. Тэр хүмүүс дэндүү мунхаг байна.

Хэдийгээр харамсаж гэмшлээ ч тийм бодол санаа байхгүй гэдгийг илтгэж чадахгүй бөгөөд үйл үр оршихгүй гэсэн үг биш. Орчлон маш олон ертөнц, нэн олон дэстэй, бидний ертөнцийг материаллаг ертөнц гэдэг. Юм бүхэн нь харагддаг, тэмтрэгддэг бөгөөд гарт баригддаг. Үүнээс гадна бодлоор бүтээгдсэн ондоо нэг зүйлийн ертөнц байдаг. Эдгээрийн дунд Асурийн ертөнц нь бидэнд нэлээд ойр, ихэнхдээ бидний бодол нь доод дэсийн хэрцгий бодол, эсвэл эгэл ертөнцийн сайн бодол гэгчид харьяалагддаг. Тэр бодлууд хөвөн дэгдээд Асурийн оронд ойртдог бөгөөд бид түүнийг агаар мандлын их давхарга гэдэг.

Иймээс бид заримдаа ямар нэгэн өвчинд нэрвэгдэх юм уу, бусад хүн бидэнд өвчин халдаах, эсвэл ямар нэгэн гай гамшиг, дайн дажин, гаслан зовлон үүсэх нь бүгд л манай дэлхийн хүмүүсийн бодол маш хэрцгий байдгаас болдог. Би сайхан ээтгэлтэй, балчир багаасаа сайн үйл хийсэн байхад яагаад хүнд өвчинд нэрвэгдэв гэж гомдоллох хэрэггүй. Эсвэл миний улс орон тийм сайн, бүгдээр өмөржин бурхан шүтэн бурханд мөргөдөг байтал яагаад ийм их гай зовлон үүсэв? гэж эзмлэсний хэрэг алга. Юм бүхэн бүгд л шалтгаантай. Учир нь манай дэлхийн хүмүүс,



эсвэл манай улсын иргэд өнгөрсөнд юм уу, муу бодол өвөрлөсөн байна, Багшийнхаа санааг ойлгож байна уу? Бид бодсон даруй бодлоо таслаад бодитойгоор хийгээгүй ч энэ бодлын хүч нь мөн л оршиж байдаг. Гэхдээ яг л нэг зүйлийн мэдлэг, нэг зүйлийн цэцэн ухаан шиг. Бид түүнийг элемент гэж нэрийдэж болно. Түүнд сүнс байхгүй, бурхны чадвар байхгүй, зөвхөн тиймэрхүү мэдлэг төдий оршдог. Яг л компьютер шиг, сүнс байдаггүй ч тэр ажиллаж чаддаг.

Гэхдээ тэр хэрцгий, буруу үзэл бодол нь компьютероос бүр сүрхий байдаг, компьютерыг бид эвдэж болно. Гэвч тэр хэрцгий бодлыг харин амархан арилгаж чадахгүй. Хэчнээн устгасан ч гэсэн мөн л үргэлжлэн оршиж, өөртэй нь адил соронзон талбайтай бодлыг цуглуулан, хэзээ нэгэн өдөр үйлдэл болж, хүчээ гадагш гаргадаг. Гэхдээ тэр өөрөө устаж чаддаггүй. Компьютерыг ашиглахаа болих, эсвэл дэндүү удтал ашиглавал өөрөө эвдэрч мэднэ. Эсвэл аль нэг товчлуурыг нь дарснаар машин нь эвдрэн урьд нь хадгалсан бүх материал нь аяндаа алга болдог. Гэтэл тиймэрхүү хэрцгий бодол өөрөө арилж чадахгүй. Аль хэдийн шингэчихсэн байвал үргэлжлэн оршоор байна. Дараа нь нэг зүйлийн уур амьсгал болж бүрэлдээд биднийг хүрээлэх юм уу, манай дэлхий, улс орон, хот, хөдөө айлыг хүрээлж, маш олон үйл явдал, өвчин эмгэг, дайн дажин болж хувирдаг.

Өвчин гэгч юу вэ? гэвэл тэр уур амьсгал нь өөртэйгөө адил бодлоо хайж, соронзон талбайд нь нэвтэрдэг. Ижил чанар харилцан таталцдаг гэдэг нь үүнийг хэлдэг, ойлгож байна уу? Тэр таны тийм бодолтой болохыг хүлээх юм уу, байнга тийм бодол өвөрлөдөг хүнийг эрж хайн хаалгаар ордог шиг соронзон талбайд нь нэвтэрдэг.

Учир нь хоёр адил зүйл тун амархан хутгалддаг. Тэр бидний соронзон талбайд түрэмгийлэн орсноос хойш тархи, мэдрэлд нэвтэрч, өвчин эсэргүүцэх чадварыг эвдвэл бид хорт хавдар юм уу, ямар нэгэн мэдрэлийн өвчинтэй болдог, эсвэл ерөөсөө сонсоогүй өвчинд нэрвэгддэг. Байнга хэрцгий бодол өвөрлөдөг тэр хүмүүс урьд төрөлдөө муу уур амьсгал бүтээсэн байж мэднэ. Иймээс одоо дахин буцаж ирээд урьдын зохиосон муу уур амьсгалаа хурааж цуглуулах хэрэгтэй болно. Тийм болохоор бид хэн нэгнийг зэмлэхийн хэрэг алга. Аливаа бүгд бид өөрсдөө зохиосон байна. Гэхдээ бид түүнээс зайлсхийж чадна. Бие, хэл, сэтгэлээ хорин дөрвөн цагаар цэвэр байлгавал тэр нэвтэрч чадахгүй. Учир нь ондоо чанартай тул харилцан таталцахгүй. Тос, ус хоёр хэзээ ч уусдаггүй шиг ондоо чанартай хоёр юм ойртмогц тусгаарлагдсан

шиг болдог.

Бясалгагч маш олон үйл түйтгэрийг арилгаж чаддаг. Бид урьд нь хэрцгий бодол боддог байсан бол одоо цөөн шиг бодно. Жишээлбэл, тэр бодол бүхлээрээ нэвтрэх байсан бол одоо жаахан хэсэг нь нэвтэрнэ. Энд загатнах юм уу, тэнд өвдөх, эсвэл хоёр, гурван хоног халуурч мэднэ. Ингэвэл хорт хавдарг нэрвэгдэхгүй. Эсвэл машины осолд орж, машин нь эвдэрсэн ч хүн нь айлтгүй, зөвхөн арьс нь зулгарч магад. Иймээс тоост ертөнцөд байхдаа бид өөрийн бие, хэл, сэтгэлээ ариусгах хэрэгтэй. Учир нь өөрийн биеэ хамгаалах нь чухал. Хэрвээ гурван ертөнцийг давчихсан бол асуудалгүй. Тэнд муу уур амьсгал байхгүй, муу бодол өвөрлөдөг хүн байдаггүй. Зөвхөн цэвэр цайлган хүн л сая дээш гарч чаддаг.

Бясалгал хийхэд сахил сахиж, бие, хэл, сэтгэлээ цэвэршүүлэх шаардлагагүй гэж ярихыг сонсвол тэднийг тоглож шоглож байгаа, бясалгалдаа няхуур биш, бясалгал хийхийг хүүхдийн тоглоом шиг үздэгийг ойлгож болно. Томчуулын хувьд машин жолоодох нь маш няхуур, маш төвөгтэй хэрэг мөн. Гэхдээ бяцхан хүүхэд бас машин жолоодох дуртай. Машин жолоодож байна гэж дүрслэн бодож, “үүдн, үүдн” гэхийгээ маш сайхан гэж үздэг. Тиймээс машин жолоодох нь тун амархан гэдэг, тийм үү, үгүй юу? Эсвэл бид зүдэрч байж нэг давхар уужимхан байр барьж суухад, бяцхан хүүхэд харин гэр барих маш хялбар гэж хэлдэг. Тэд чулуу овоолж, энэ бол гэр мөн гэдэг. Гэхдээ бид бас тэднийг баярлуулахын төлөө “бүтээл”-ийг нь хүлээн зөвшөөрдөг. Эсвэл бид мөнгө төлж, жигнэмэг худалдан авдаг байхад тэд шавраар жигнэмэг хийж, модны навчийг мөнгө болгож наймаа хийдэг. Тэгээд гэртээ хариад маш хөгжилтэй, маш баяртайгаар модны навчаа тоолон: “Аан за! Их мөнгөтэй, баяжчихлаа.” гэж баярладаг.

Эртнээс нааш тийм хялбархнаар бясалгал хийсэн хүн байхгүй. Бясалгал хийгээд маш амархан амжилтад хүрдэг хүн бол лав гурван ертөнцөөс гаднах хүн болно. Түүнд харш саад гэж байдаггүй. Бясалгал хийхэд харш саад маш цөөн, байлаа ч гэсэн ад чөтгөр сэтгэлийг нь татах гэх мэт. Яг л Шагжамуни Бурханы хутагт хүрэх гэж байх үед адын эзэн түүний хатан нь, хүү нь, эсвэл маш гоё хүүхэнд хувилан түүний сэтгэлийг татах гэсэн байдалтай адил. Гэтэл Шагжамуни Бурхан: “Та нар бол бүгд хий бодол мөн.” гэсэн. Тэгээд тэднийг эрхшээн адын эзнийг ялав. Энэ бол харш саад, тэгэхгүй бол түүнд саад байдаггүй. Тэр зургаан жил бясалгал хийгээд Бурханы хутагт хүрсэн. Бид жаран жил, зургаан зуун жил бясалгасан ч мөн л амжилтад хүрч чадахгүй байж магад. Гэтэл Арьяабалын бясалгалын аргаар бясалгавал

лавтай амжилтад хүрнэ. Бусад бясалгалын аргаар бясалгавал зургаан зуун жил, зургаан зуун галав болсон ч амжилтад хүрэхгүй байж мэднэ. Учир нь элсийг чанаад хоол болдоггүй.

Бид гурван ертөнцийн гадна, эсвэл дотор байх эсэх хамаагүй. Бясалгахад бие, хэл, сэтгэл цэвэр байх хэрэгтэй. Гурван ертөнцийг туулчихсан гэж хэн нэгэн хүн ярихыг сонссон ч итгэж болохгүй. Урьдаар өөрийгөө чухам гурван ертөнцийн гадна, эсвэл дотор байна уу? гэдгээ харах хэрэгтэй. Бидний сэтгэл хаа нэг газарт хүлэгдэж байвал гурван ертөнцийн дотор байгааг илтгэж байгаа хэрэг. Урьд нь бид гурван ертөнцийн гадна байсан эсэх хамаагүй. Одоо гурван ертөнцийн дотор байх шиг байна. Учир нь энд хүлэгдэхгүй бол тэнд хүлэгдээд эрх дураар байж чадахгүй. Чөлөөтэй болж чадахгүй. Энэ нь бид мөн л гурван ертөнцийн дотор байгааг харуулж буй юм. Түргэн бясалгах хэрэгтэй. Удалгүй бид дахин гурван ертөнцийг даван туулж болно.

Бид бүгд сүнсний нутагтаа буцаж чадна. Гэвч бясалгал хийх хэрэгтэй. Бурхан Бодьсадва ч гэсэн маш хатуужилтайгаар бясалгах хэрэгтэй. Есүс Христ: “Би бол Эзэн Бурханы хүү мөн.” гэж хэлсэн. Гэтэл тэр элсэн цөлд бясалгаж байхад адын эзэн сэтгэлийг нь татжээ. Тэгэх нь бас ч тун төвөгтэй хэрэг билээ. Тэр Энэтхэгт хүрч 19 жил бясалгаад дараа нь элсэн цөлийн оронд дөч хоног бясалгаж суужээ. Тэгээд бурхан болох гэж байх үед нь адын эзэн хүрч ирээд: “Та надад мөргөвөл гурван ертөнц бүгд чинийх болно.” гэв. Тэгэхэд Есүс Христ: “Та дуугүй түргэн зайл!” гэжээ. Энэ нь түүнийг хол зайл! Би чамайг хармааргүй байна гэсэн санаа билээ.

Гурван ертөнцийн доторх Эсэрваа тэнгэр болох нь мөн л хялбар бус хэрэг. Америкт нэгэн бясалгалтан байдаг. Тэр бол Төвөд лам, тун алдартай. Тэр өөрийн номдоо би бол гурван ертөнцийн доторх хаан гэж бичсэн байна. Гэхдээ бид гурван ертөнцийн хаан болсон ч тийм сүрхий юм биш. Бидний зорилго бол гурван ертөнцийг даван туулах. Бясалгал хийхэд жаахан амжилтад хүрсэн ч баярлахгүй байвал зүйтэй. Гурван ертөнцийн гаднах зам уртаас урт. Гурван ертөнцийг давснаар лавтай гэгээрч чадна. Бид гурван ертөнцөд дахин ирэх дургүй л бол хэзээ ч ирэхгүй байж болно. Ийм л юм. Гурван ертөнцийг даван туулбал юм бүхэн дуусчих биш, дуусахгүй, хэдий удаан бясалгасан ч асуудалгүй. Та нарын ихэнх нь бясалгал хийж тавдугаар ертөнцөд хүрвэл юу болдог бол гэж санаа зовдог. Ингэх нь тун уйтгартай явдал биш үү? Хожим чухам юу хийх вэ гэж олон хүн надаас асуудаг. (Бүгд инээлдэв.) Энэ нь яг л бяцхан хүүхэд биднээс:

“Та гэрлэсний дараа юу хийх вэ? Хиймээр ажил байх уу?” гэж асуухтай адил. Гэрлэсний дараа сая жинхэнээр ажилтай болж, амьдрал шинээр эхэлдэг. Тэгээд хамтдаа байшин босгож, хамтдаа мөнгөө хэмнэж, хамтдаа хүүхэдтэй болж, хүүхдээ өсгөж, эцэг, эхийгээ харгалзан, өөрийн ажил үйлсээ цэгцэлдэг гэх мэт. Ийм биш үү? Харин гэрлэсний хойно юу ч хийхгүй болчих биш. Хоёр хүн олон жилээр янаглаж, зовж зүдэрч байж сая гэрлэж чаддаг. Тэгээд л сая жинхэнээр амьдарч эхэлсэнд тооцогддог.

Багш нь та нарыг ойлгоход хялбарыг бодож эгэл ертөнцийн учир явдлаар зүйрлэлээ. Хэрвээ дэндүү нууцлаг, дэндүү гүнзгий яривал дөнгөж бясалгаж байгаа хүмүүс амархан ойлгохгүй. Ойлгож байна уу? Иймээс бурхны номлол нь ертөнцийн ёс зүйгээс салангид биш гэдэг. Бид нэг талаар бясалган, нөгөө талаар ертөнцийн түүхийг ярьж болно. Ингэвэл ойлгоход нэлээд хялбар.

Гэтэл хамгийн сайн нь бодол санаагаа тэр хамгийн дээд хүчинд хандуулах хэрэгтэй. Түүнийг сэтгэлийн гүнээсээ санан дурсаж, нэгэн үзүүрт сэтгэлээр хамгийн дээд түвшинд хүрэхийг л бодно. Харин замын голоос буцаж болохгүй. Ингэвэл бид өөрийн биедээ нэн сайн, маш эрчтэй уур амьсгал бий болгож хэрэглэж чадна. Дараа нь бид өөрсдөө диваажинг бүтээнэ. Яг л та нар бясалгалын төвөө өөрсдөө барьдаг шиг. Эхлээд яаж барихаа төлөвлөж, дараа нь хамтаар барьж, бясалгалын төвтэй болжээ. Үүнтэй адилаар бид одооноос сайн төлөвлөгөө байхгүй бол хожим дээш гарсан ч юу ч эрж олохгүй. Бидний төсөв төлөвлөгөө хэдий чинээ өндөрт байвал түвшин маань төдий чинээ өндөр болохыг битгий март. Учир нь аливааг сэтгэлээр зохиосон. Бид диваажин, тамын орныг зохиоход маш хялбар. Иймээс өдөр бүр энэ бүхнийг чадагч хүчийг үл мартан “Надад зөвхөн та л хэрэгтэй. Бусад юмыг та надад өгсөн ч болно. Өгөхгүй байсан ч хамаагүй, хэрэглээд дууссан ч болно. Хэрэглээгүй байсан ч боллоо, түүнийг хамаарахгүй. Би нээрээ гэртээ л буцна. Зөвхөн хамгийн дээд хүчийг л гуйна. Би дахин тэнгэр, хүн, асури болох дургүй. Иймэрхүү үхэж, төрж эргэлдэх амьтад болох дургүй.” гэж чин сэтгэлээсээ тусламж гуйвал зохино.

Иймээс Багш нь та нарыг бие, хэл, сэтгэлээ цэвэр байлгах хэрэгтэй. Сахилаа заавал сайтар мөрдөх хэрэгтэй гэж шаарддаг. Гэтэл сайтар бясалгасны дараа аяндаа мөрдөх болно, тийм үү, үгүй юү? Багш чинь ийм туршлагатай, урьд нь би ургамал хоол идэж байхдаа бас сонгино, саримс иддэг байсан. Миний урьдын эр нөхөр маань ч ийм зүйлд тун дуртай. Хоолондоо хийвэл амттай санагддаг. Ингэхийг бид хоёул тун сүрхийд үздэг байжээ. Учир нь

бид “Ургамал хоолтон” шүү дээ!

Бараа худалдан авалт хийх бүрдээ сонгино, саримс ихээр авдаг байсан. Бид Италид байхдаа нэг хэлхээ саримсыг худалдан аваад хаалгандаа өлгөсөнд яг л чөтгөрийг хөөж байх шиг санагдсан. (Багш инээв.) Өрнө дахины хүмүүс саримсаар цус сорогч чөтгөрийг хөөж чаддаг гэдэгт итгэдэг. Бидний тэнд цус сорогч чөтгөр байхгүй, гэвч бид хоёулаа саримс идэх тун дуртай байсан. (Багш болон бүгд инээлдэв.) Зарим хүн бас саримс идвэл цус цэвэршин маш олон өвчнийг засдаг гэж үздэг. Өмнө нь би зуушиндаа сонгино, саримс хийвэл сая амттай, хийхгүй бол амтгүй гэж боддог байв. Гэтэл одоо идэх нь бүү хэл үнэртэх ч дургүй болов. Урьд нь би болон эр нөхөр маань өөрийгөө ургамал хоол идээд аль хэдийн маш цэвэр болсон гэж боддог байсан. Гэхдээ бүр ч илүү цэвэр байхыг бодож байгаагүй. Өмнө нь би өндөгний үнэрийг үнэртэх юм уу, бусдын өндөг идэхийг харвал тоохгүй, тэр үед би бас өндөг идэж болно гэж боддог, бас иддэг байжээ. Гэвч тун цөөн, бараг иддэггүйтэй адил, тэр бол би Арьяабалын бясалгалын аргыг бясалгахаас өмнөх явдал юм.

Нэгэн өдөр би өндөг идсэн чинь маш өмхий санагдан бөөлжиж гаргасан. Түүнээс хойш би өндөг идэхээ больж, дэс минь жаахан дээшилсэн шиг болж, аяндаа өндөг идэхээ болив. Тэр үед надад өндөг идэж болохгүй гэж хэлсэн хүн байхгүй. Учир нь урьд нь Багш нь үргэлж олон улсаар тойрон аялж, заримдаа ургамал хоол олдохгүйгээс болж өндөг идвэл уургаа жаахан нөхнө. Тэгэхгүй бол амьд явахын аргагүй гэж үздэг байв, ийм л байсан. Үнэндээ би өндөг идэх дургүй. Иддэг ч тун цөөн. Гэтэл нэгэн өдөр гэнэт идэж чадахаа больсон. Идмэгц зүйрлэхийн аргагүй өмхий санагдав. (Багш дотор муухайрах байдал үзүүлэв.) (Бүгд инээв.) Одоо чухам хэн өндөг идэж чаддаг эсэхийг би мэдэхгүй. Нээрээ тун өмхий, тиймэрхүү өмхийрсөн өндөгний муухай үнэр биш, харин булшны газрын муухай үнэр шиг. Ийм өмхий үнэрийг та нарт ярьж чадахгүй, тухайн үед би идмэгц тэр дорхноо дотор муухайрсан. Тэр өдрөөс эхлэн дахиж өндөг идээгүй.

Бясалгал хийсний дараа сонгино, саримсыг хүртэл идэх дургүй болов. Надад олон Багш байсан. Тэдний нэг нь Вьетнамын гэлэнмаа. Тэр одоо болтол хоолондоо мөн л сонгино хийдэг. Гэхдээ энгийн сонгино биш, харин франц сонгино. Жаахан ондоо. Өмнө нь би түүний хийсэн хоолыг идэх тун дуртай байв. Гэтэл гурван жилийн өмнө Германд очиж түүний бэлтгэсэн хоолыг үнэртмэгц толгой айхтар өвдөж, бөөлжих шахсан. Тийм үнэрийг хүлцэхийн аргагүй болж, өрөөгөө солихыг гуйсан. Тэгэхэд тэр: “Сонин юм

аа! Та яав? Урьд нь та үүнийг идэх тун дуртай болохоор бэлтгэсэн шүү дээ!” гэсэнд би инээгээд: “Урьдынх шиг дуртай хэвээр. Харин сонгино хийхгүй бол зүгээр юм!” гэв. Тэгэхэд тэр: “Та яасан сонин юм? Урьд нь сонгино идэхэд хамаагүй л байсан. Одоо яагаад идэхээ болив?” гэхэд нь би: “Зүгээр ээ, харин сонгинын үнэр үнэртмэгц толгой өвдөөд хэцүү байна.” гэв. Тэр үүнийг сонсмогц дахиад сонгино хийхээ больсон.

Иймээс бясалгал хийхэд нээрээ зэрэг дэсийн ялгаатай. Дэс дээшилбэл сахилаа аяндаа сахих болдог. Бид сайтар бясалгах тусам сахилаа төдий чинээ аяндаа сахих болдог. Тэр үед сахил, даяан, билиг ухаан гэж ярихгүй ч аяндаа сахил сахина. Аяндаа даяан агуулж, аяндаа билиг ухаантай болдог. Тэр бол сая жинхэнэ сахил, даяан, билиг ухаан юм.

Жинхэнэ сахил, даяан, билиг ухаан гэдэг нь яг сахил, даяан, билиг ухаан байхгүй шиг. Билиг ухаан байдаг ч байхгүйтэй адил. “Билиг ухаан” байдаг нь үнэн юм. Яг л амьсгал шиг тийм аяндаа байдаг. Бид өдөр бүр хэчнээн амьсгал авдгаа анзаардаггүй. Эсвэл яг гараа угаах, нүүрээ угаах, унтах шиг амархан байдаг. Жинхэнэ сахил, даяан, билиг ухаан бол ийм байдаг. Бид бясалгах тусам сайн болдог. Арьяабалын бясалгалын аргаар бясалгасны дараа явах тусам мэдрэмтгий болдог шиг санагддаг, тийм үү, үгүй юү? Урьд нь та нар бусадтай хамт ажиллахад хамаагүй байсан, одоо ажилдаа очвол заримдаа хүн тун өмхий санагддаг. Нэгэн авшигтан: “Багш аа! Би таныг дагаж гэрээс гарья гэж бодож байна. Учир нь гаднах хүмүүс даанч өмхий, тэвчиж чадахгүй байна.” гэж надад гомдоллосон. “Энэ бол гэрээс гарах хангалттай шалтгаан биш. Гэрээс гарахад эрхэм дээд хүсэлтэй байх хэрэгтэй. Бусдын өмхийгөөс зайлахын төлөө сая гэрээс гардаг биш.” гээд би зөвшөөрөөгүй. Хожим нь тэр тэсэж чадсангүй. Одоо Миаолид очиж, өөр ажил эрж хайжээ. Хэдийгээр гэрээс гараагүй ч Багштайгаа хамт бясалгалын төвд сууж байна. Миний бодоход, тэр мөн чин сэтгэлтэй юм байна.

Тэр хүмүүс үнэхээр маш өмхий болохоор тэр сая тийм эрс шийдвэр гаргажээ. Урьд нь тэдэнтэй арван хэдэн жил хамт ажиллаж байсан ч хамаагүй байдаг байж, бясалгаад удсаны хойно тэвчиж чадахгүй болсон байна.

Иймээс бид ертөнцийг огоорч хэрэггүй. Арьяабалын бясалгалын аргаар үргэлжлүүлэн бясалгадаг л бол хэзээ нэгэн өдөр энэ ертөнц биднийг аяндаа огоорно, ойлгож байна уу? Нээрээ тийм шүү, ертөнц биднийг огоорно. Бид түүнд тийм их хүлэгдэхээс айх хэрэггүй. Иймээс заримдаа Багш нь та нарт тун

хатуу хандаж, яагаад энэ ертөнцийг огоорч чадахгүй байдаг юм, яагаад бас энэ ертөнцөд хоргодоод байгаа юм гэж хэлдэгт минь та нар тэгж их сэтгэл шаналах хэрэггүй. Харин Багшийн ярьж байгаа нь зөв юм байна гэж гэмшин ухаарах хэрэгтэй. Үргэлжлүүлэн бясалгадаг л бол ухасхийгээд огоорч чадах болно. Нэр алдар, ашиг олз, эд мөнгө аливаа бүхэнд дургүй болдог. Дургүй гэдэг нь бид хэрэглэж болохгүй гэсэн үг биш. Харин тэдгээрийг бодохоо болино. Байвал хэрэглэнэ, байхгүй байсан ч гэсэн хамаагүй.

Саяхан нэгэн авшигтан Багшид нь маш үнэтэй бугуйн цаг бэлэглэсэн. Швейцар бугуйн цаг бол хамгийн үнэтэй. Хэдэн зуун мянган төгрөг гартаа зүүнэ. Гэтэл би зүүсэн биш, түүнд зүүлгэсэн. Гэрээс гарагсад түүнийг хэрэглээд яах билээ. Би бугуйн цаг зүүгээгүй нэлээд удаж байна. Одоо тэр үйл түйтгэрийг зүүгээд яах юм? Түүнийг зүүвэл бие загатнадаг. (Бүгд инээлдэв.) Тэгээд бас усанд орохдоо ч авах хэрэгтэй. Норговол эвдэрсэн эсэхийг нь шалгах хэрэгтэй. Ингэвэл нэн яршигтай болно. Иймээс би тэр үйл түйтгэрийг даруйхан түүнд бэлэглэсэн (Багш болон бүгд инээлдэв), маш баяртайгаар буцаасан. Гэвч Багш нь түүнд баярлаж талархахгүй гэсэн биш. Мөн сэтгэл догдлоогүй биш, хэдэн зуун мянган төгрөгийн бэлгийг бусдад хүргэх нь хялбар бус хэрэг. Уг нь би бүсгүй нь худалдаж авсан гэж бодсон. Санамсаргүй байдлаар Багш нь сонсох нь ээ, харин эр нөхөр нь өөрөө худалдан авсан байжээ.

Үнэндээ бүсгүйчүүд дураараа мөнгө үрж, тийм гялалзсан юмыг ихээр авдаг. Гэтэл энэ удаа харин түүний эр нөхөр нь худалдан авсан нь намайг тун цочоосон. Гэвч бас зүгээр, тэд хоёулаа Багшдаа итгэдэг, үгүй бол эхнэр нь атаархаж амиа алдахад хүрнэ. (Бүгд инээлдэв.) Нөхөр нь өөрийн эхнэртээ авсан биш. Гэхдээ эхнэрийнхээ цагаас хэдэн арав дахин үнэтэй Швейцар цагийг Багшид нь бэлэглэжээ. Үүнийг хэн тэвчиж чадах вэ? (Багш болон бүгд инээлдэв.) Гэвч бүсгүй нь бясалгалаар тун сайн, хувилгаан Багшийгаа байнга хардаг болохоор хоёуланд нь ямар ч асуудал үүсээгүй. Багш нь тийм үнэтэй эдийг зүүж болохгүй гэсэн биш. Харин надад зүүх шаардлага байхгүй, дур сонирхол ч алга, харахад ч дургүй байхад өдөр бүр гартаа зүүхийг бүр ч хэлэх хэрэггүй, гар загатнаж тавгүйтнэ. Тийм эд биднийг хүлнэ. Яг л үхрийг хамраас нь нүхэлж дөрлөвөл хаашаа ч амархан хөтлөн явж чадахтай адил.

Иймээс урьд цагт гэрлэхэд эр нөхөр нь маш олон алт, мөнгөн гоёл чимэглэл хүргэж эхнэрээ “ногтолдог”. Энэтхэгчүүд бүр ч хэцүү, хөлийн шилбэндээ хүртэл цагариг зүүдэг. Энд нь нэг, тэнд



нь нэг, зарим нь гартаа арван цагариг, хүзүүндээ хоёр гурвыг зүүж, чихэндээ ч зүүдэг, бас хамраа ч нүхэлдэг. Та нар Энэтхэгт очвол мэднэ. Тэд замаар явахад хангир жингэр гэж дуугардаг. Учир нь биеийнх нь ил хэсэгт бяцхан хонх байдаг. Хэрвээ хамартаа зүүж байвал чирч аваачин гэрлэхэд хамгийн амархан. Эртний эрэгтэйчүүд бүсгүйгээ өөрийн болгохын төлөө энэ аргыг бодож олсон байж магадгүй. Хамрын нүх бол маш мэдрэмтгий. Утсаар оосорловол барихад нэлээд хялбар. Хамрыг нь маш том нүхлээд дараа нь дээсээр сүвлэдэг. Ингэвэл гэртээ чирч аваачихад маш хялбар.

Иймээс Энэтхэг бүсгүйчүүд тун номхон. Гэрлэлтээ салгахыг ерөөсөө боддоггүй. Гэвч одоо цөөн тооны хүмүүс салж, эхэлж байх шиг байна. Энэ нь үйлийн үрийн нөлөөлөл мөн. Урьд нь гэрлэлт салах үзэгдэл байгаагүй. Энэтхэг бүсгүйчүүд эр нөхөр нь яаж ч муу хандсан салдаггүй байсан. Тэдний хувьд эр нөхөр нь эзэн бурхан. Тайваний эмэгтэйчүүд бол тун хэцүү. (Бүгд инээлдэв.) Бас зүгээр ээ, эрэгтэйчүүд тийм олон байхгүй. Гэвч бас ихэд хүлэгдчихжээ. Тийм биш үү? Ургамал хоол хийж идүүлэхгүй, долоо хоногийн даяан, гурав хоногийн даяан, дөрөв хоногийн даяанд та нарыг оролцуулахгүй байдаг.

Долоо хоногийн даяаны үеэр И Ланы авшигтны ярьсан түүхийг та нар сонссон уу? Бүсгүй нь долоо хоногийн даяанд явуулахгүй гэсэн бөгөөд түүнтэй хэл ам болж, хаалгаа цоожлон ерөөндөө оруулахгүй гэв. Тэгэхэд тэр хаалганы гаднаас таван ариун нэрээ уншжээ. Тавхан минут уншсанд бүсгүй нь тэсэж чадалгүй даруй хаалгаа онгойлгосон гэж тэр ярьсан. (Бүгд инээлдэв.) Дараа нь бүсгүй нь мөн л яриад байсан ч тэр хариу юу ч хэлээгүй. Зөвхөн таван ариун нэрээ уншихын зэрэгцээ бүсгүйнхээ билгийн мэлмийг ширтжээ. Тэгсэн чинь бүсгүй нь номхорч, хоёулаа амрахаар болжээ. Удалгүй бүсгүй нь: “За! Чамайг даяанд явуулья!” гэжээ. (Бүгд инээлдэв.) Иймээс та нар хамрын цагаригаар эр нөхөр юм уу, эхнэрээ захирах шаардлагагүй. Таван нэрээ хэрэглэвэл болчихно. (Багш инээв.) Таван нэр нь хамрын цагаригаас бүр ч хэцүү.

Тэр алт, мөнгөн гоёл чимэглэл нь бүгд л өөрийн биеэ хүлдэг эд. Хамаг оршихуй бий болохоос өмнө юу ч байгаагүй. Бид тэр юу ч байгаагүй үеийг бодвол зохино. Гэвч бас байхгүй биш, гэтэл хамаг оршихуй угаас хоосон. Цэцэг дэлгэрэхээс өмнө юу байв? Биднийг төрөхөөс өмнө юу байв? Уг нь юу ч байгаагүй. Бүгд л хувь барилдлага нийлснээс болсон. Иймээс бид тийм мөнхийн бус зүйлсэд хоргодож болохгүй. Бүгд хувь барилдлагаас л нийлж

бүтсэн. Хувь барилдлага дуусахаар салчихдаг. Гэвч энэ ёсыг жинхэнээр ойлгоход маш удаан бясалгах хэрэгтэй. Тэгээд хэзээ нэгэн өдөр нээрээ ийм байдгийг гэнэт ухаарсны дараа бид дахин мартахгүй болно.

Одоо ярьж байгаа нь ерөөсөө Багшийн чинь өв хөрөнгө. Та нарт харуулсан төдий хэрэг. Тэр мөн л минийх, та нар худалдан авч чадахгүй. Худалдан авч чадвал сая та нарынх болно. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Иймээс мөн л үргэлжлүүлэн бясалгах хэрэгтэй. Харин Багшийнхаа “Хамаг оршихуй бүгд хоосон, үйл түйтгэр угаас хоосон.” гэж ярихыг сонсоод бид тэгвэл бясалгах шаардлагагүй гэж бодож болохгүй, бясалгах шаардлагагүй бол маш сайн болчихно шүү! Гэхдээ Багшийн ярьсан бүгд зөв, Багшид итгэх нь бүрэн хангалттай гэж боддог хэр нь харин Багшийнхаа сургаал номлолыг бодитойгоор хэрэгжүүлэхгүй байж болохгүй.

Бидний бие, хэл, сэтгэл цэвэр байх хэрэгтэй, хэдий чинээ цэвэр бол гай барцад төдий чинээ бага, өвчин зовлон төдий их арилна. Бид төвөг бэрхшээл тохиолдвол бусдыг буруутгаж болохгүй. Тамын орныг буруутгаж болохгүй. Аливааг бүгд бид өөрсдөө үүтгэсэн. Тамын орныг ч бид өөрсдөө бий болгосон гэж Багш нь авшиг хүртээх үед ярьсан билээ. Одоо дахин тодорхой ярья. Тамын орон нь яг л эмнэлгийн мэс заслын өрөөтэй адил. Учир нь бид өвчтэй тул мэс засал хийлгэх хэрэгтэй, тийм зовуурьтай байдаг. Нэг гуурсыг хамарт нь, нөгөөг мөгөөрсөн хоолойд нь, бас нэг гуурсыг биед нь суулгадаг гэх мэт. Заримдаа та нар өвчтөнийг харахад тун зовуурьтай байдаг биш үү? Та нар эмнэлэгт очихдоо харсан уу? Олон янзын өвчнийг хүмүүс харин тэвчиж чаддаг. Тэнд ганц, хоёр хоног ч байж чадахааргүй байхад нэг хоёр сар, нэг хоёр жилийг хэлэх хэрэг юун? Тийм биш үү? Зарим хүн ямар өвчинд нэрвэгдсэнийг бүү мэд, биедээ савх шиг тийм нарийн гуурсыг эндээсээ тэндээ хүртэл суулгуулсан байхыг хардаг. Тэд маш зовуурьтай байдаг. Тийм үү, үгүй юү?

Эндхийн эмнэлгийн газар нь мөн тамын оронтой адилхан биш үү? Зарим орныг үнэхээр бодохын аргагүй. Зарим хүн авшиг авахгүйгээр харин Багшаасаа: “Намайг дагуулж тамын орныг харуулж болох уу?” гэж асуудаг. Тэгэхэд би: “Харуулж чадахгүй, тамын орныг хараад буцаж ирсний дараа бие махбод чинь тавгүй болж, мэдрэл чинь гэмтэнэ.” гэв. Нээрээ нэгмөсөн элий балай болж, нэгмөсөн өвчилж, мэдрэлийн өвчтэй болж, мэдрэл чинь гэмтэж мэднэ. Иймээс: Багш аа! Намайг дагуулж тамын орныг харуулна уу гэж байнга битгий асуу! “Та тамын орныг хараад яах гэсэн юм?” гэж би түүнээс асуухад (Бүгд инээлдэв) “Сонсоход

тамын орон тун аймшигтай гэнэ. Иймээс харъя гэж бодож байна.” гэв. Харж болно, гэвч хамгийн сайн нь Бурхан болсны дараа, Бодьсадва болсны дараа сая очвол дээр. Очсон ч хамаг төрөлтнийг гэтэлгэхийн төлөө очно. Тэр үед тамын оронд хүрвэл сая бидний мэдрэл гэмтэхгүй, хэрвээ хүч хүрэлцэхгүй бол тэнд очсоны дараа солиорч мэднэ.

Иймээс хүн болгон тамын оронд санаан зоргоор хүрч чаддаг биш, тамын орны маш олон байдал нь сэтгэшгүй муухай, муухай төдийгүй, тун аймшигтай, бид түүнийг ад чөтгөр, эсвэл ямар нэгэн жигтэй амьтан гэж хэлдэг. Үнэндээ тэд бол хүн мөн. Тэд бясалгал хийхээсээ өмнө өдөржин муу бодол өвөрлөж, тэр бодол нь их хэрцгий байдаг. Тэгээд өөрөө нэгэн ахуй орчин зохиож, тэр ахуй орчин нь төвлөрөөд нэгэн сүнсгүй бие цогцос болдог. Гэхдээ нэг зүйлийн хэлбэр дүрстэй, тэр “хэлбэр дүрс” нь биеэс нь саланги биш, харин биетэй нь хамт наалдаж байдаг, ойлгож байна уу? Маш олон тийм бие цогцос хамт цуглараад хачин жигтэй амьтан болдог. Иймээс ад чөтгөрийг харахад тийм аймшигтай. Учир нь тэдний бодол нь маш аймшигтай. Өөрийгөө чөтгөрийн дүртэй болгох юм уу, бодож гаргасан юмтайгаа адил болдог. Эсвэл өөрийн махаа өөрөө огтолж, тун муухай болгодог. Тэр хүмүүс туулан гэтэлж чадахгүй нь мэдээж. Учир нь тун олон өвчинтэй бие цогцос биед нь наалдаж байгаа болохоор тамын оронд очиж “гоо сайхан”-ы мэс засал хийлгэх хэрэгтэй.

Энэ дэлхийд бас гоо сайхны эмч байдаг. Миний урьдын эр нөхөр маань тийм эмч. Түүний нэг төрлийн ажил нь гоёж гоодох ажил (гоо сайхны эмч) болно. Гэхдээ гол ажил нь биш, гэтэл зарим хүн ямар нэг осолд орж, арьс булчин нь гэмтвэл, бусад газрын арьсыг нь огтлон авч тэр хэсгийг нь нөхдөг. Эсвэл шүд нь гэмтвэл сайхан засах хэрэгтэй. Эсвэл энд, тэнд нь нөхдөг гэх зэрэг нь мөн л нэг зүйлийн гоёлын засалт болно.

Тамын оронд бүр ч муухай байдалтай. Зарим ад чөтгөрийн байдал нь маш аймшигтай. Хүний дүр байдал жаахан ч үгүй, тэднийг хараад буцаж ирсний дараа амьдрахын аргагүй болно. Тэдний муухай царай нь хүнийг ингэтэл нь цочроодог. Иймээс ихэнх хүн чөтгөрийг гэнэт хараад, харьсныхаа дараа солиордгийг та нар мэдэх үү? Учир нь тийм муухай байдлыг тэвчиж чадахгүй. Муухай бөгөөд аймшигтай тийм уур амьсгал нь хүмүүсийг тэвчиж чадахгүй болгодог. Муухай төдий биш. Зарим үед хүмүүс маш аймшигтай баг зүүдэг. Бид харвал инээд хүрдэг, учир нь тийм аймшигт уур амьсгал байдаггүй.

Гэвч тэр жинхэнэ аймшигтай хүн бол нэг зүйлийн уур

амьсгал үүсгэдэг нь зэрэг дэс нь доор байдгаас болсон байна. Тэдний нүүрний арьс нь биднийхтэй адилгүй, шар юм уу, цагаан өнгөтэй. Зарим үед бор юм уу, бор хөх өнгөтэй, хөх биш харин бор хөх, яг л үхээд нэлээд удсан юм уу, усанд удтал дэвтээсэн шиг царай нь борлодог. Учир нь тэдний бодол нь зөв биш, санаа сэтгэл нь дэндүү аймшигтай байдаг тул гадна талын царай нь ч маш аймшигтай. Яг л бид хүнд өвчинд нэрвэгдвэл арьсны өнгө ч дагалдаад хувирдагтай адил. Энэ ертөнцөд байхдаа хэвийн бус бол нас барсны хойно мөн л тийм царайтай болдог. Иймээс Багш нь та нарт битгий уур уцаартай бурхан бол. Хэзээд баяртай, баясангуй ааш авиртай байх хэрэгтэй. Өөрийгөө албаар баясангуй болговол төд удалгүй үнэхээр баяр жаргалтай болдог гэж дахин дахин хэлдэг. Хэрвээ бид өөрийгөө албадахгүй бол хэн албадах билээ? Өөрөө чармайхгүй, өөрийгөө дээш татахгүй бол хэн ч тусалж чадахгүй, Багшийнхаа санааг ойлгосон уу?



## ОРЧЛОНГИЙН ОД ГАРАГИЙН ҮЛГЭР

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Миаоли Шихү бясалгалын төв  
1988 оны 10 дугаар сарын 15-ны өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Та нарын дунд даяаны бясалгалтан байна уу? Даяан (chan)-ыг жаахан бясалгасан учраас сая тийм “эмгэнэлтэй” (хятад хэлэнд даяан болон эмгэнэлтэй гэдэг үсгийн дуудлага ижил байдаг болохоор Багш зориудаар ингэж хэлжээ) байдаг. (Бүгд инээлдэв.) Та нар даяан бясалгаагүй бол Багш чинь тэгж зовж зүдрэхгүй. Учир нь ихэнх хүн өөр бясалгалын аргаар бясалгасны дараа дахин Багшаас чинь Арьяабалын номын цогцосыг сурсан. Гэхдээ Багшдаа мөн л бүрэн итгэдэггүй. Ихэнх хүн харш саадад ихэд автаж, урьдын бясалгалын аргаа огоорч чадахгүй байдаг.

Нэг хүн авшиг авсны дараа ямар ч ахуй ойлголт байхгүй байв. Иймээс чин сэтгэлээсээ Багшаасаа тусламж гуйжээ. Өдөр бүр бясалгахаасаа өмнө чин сэтгэлээсээ дотоодын багшаасаа тусламж гуйв. Гэхдээ маш хичээнгүйлэн бясалгаж гэнэ. Тэгээд хоёр долоо хоногт бясалгал нь маш түргэн дээшлэн бясалгаж суугаа үедээ самадид орох болсон бөгөөд сэтгэшгүй гэгээн гэрлийг харжээ. Гэхдээ дүрслэхийн аргагүй хурц. Түүний яс шөрмөс, дотор эрхтэн нь гэрэлтэж өөрт нь мэдрэгдэхээ болив. Энэ нь тийм гялбаат гэрэлтэй туйлын хүслэнт ахуй болно. Гэтэл самадид маш тааламжтай байхдаа гэнэт өмнөх багшийнхаа ярьсан: “Арга сахиус юм уу, билиг сахиус биеэс гарах нь маш аюултай, цаашилбал бясалгалын хэнээтэй болж мэднэ.” гэж хэлснийг санаад айжээ. Тиймэрхүү хурц гэрлийг харчихаад бас ад

наалдахаас айв. Ад яаж тийм гэрэлтэй байж болох вэ дээ? Ад бол гэрлийн эсрэг чанар болно. Хурц гэрэл харах нь яагаад адтай адил байж болох билээ. Яагаад тийм бядуу байдаг байна? Тэгээд өөрийн төөрөлдсөн мэдлэгээсээ болж тэр үзэл санаанд харшлагдаж, өөрийгөө албадан самадигаас гарчээ. Биеэ албадан самадигаас гарсан тул толгой нь их өвджээ. Гэхдээ толгой өвдсөн шалтгаанаа мэдэхгүйгээс болж бүр ч илүү айж, хожим нь бясалгаж суухдаа самадид орж түвдэхгүй, үргэлжлүүлэн бясалгаж ч зүрхлэхгүй, багшаасаа тусламж гуйж ч чадахгүй болов. Учир нь тусламж гуйвал самадид орно.

Тэр өдрөөс эхлэн бясалгалын дэс нь доошлон ахуй ойлголт жаахан ч үгүй болж, багшдаа захидал бичиж: “Урьд нь самадид орж, тийм сайхан байснаа одоо яагаад юу ч үгүй болов?” гэж гомдолложээ. Энэ бол өөрөө эрж олсон зовлон мөн. Өмнө нь бясалгаж суухдаа самадид ордог нь ад наалдсан явдал биш. Одоо бясалгаж зүрхлэхгүй болсон нь ад наалдсан явдал мөн юм. (Бүгд инээлдэв.) Ад наалдвал тэгж зовнидог. Самадид тийм таатай бөгөөд хурц гэрэл харсан байхад хэрхэн ад наалдаж чадах вэ? Адад гэрэл байдаггүй. “Бардо тойдол буюу Сонсгоод тонилгогч” сударт: “Хэрвээ туйлын хурц гэрэл харвал тэр бол Бурхны гэрэл, дагаж явбал зохино.” гэж хэлсэн байна. Тиймэрхүү туйлын хурц гэрэл нь ад биш.

Тэр үүнийг ойлгоогүй учраас багшдаа захидал илгээж: “Багш аа! Миний энэ байдал нь ад наалдсан байдал мөн үү, биш үү? Тийм гэрэл болон түвшнийг харах нь муу байдаг уу, үгүй юү? Арга сахиус юм уу, билиг сахиус биеэс гарах нь маш аюултай гэж миний өмнөх багш хэлсэн.” гэжээ. Тэр өмнөх багшийнхаа хэлсэнд итгэж, дахин бясалган сууж зүрхлэхгүй, Багшаасаа тусламж гуйж зүрхлэхгүй, юу ч хийж зүрхлэхгүй болжээ. Тэгээд одоо бясалгаж суулаа ч ахуй ойлголтгүй болсон бөгөөд Багшаасаа яавал зохихыг асуусан. Багш нь хэрхэн шийдвэрлэснийг та нар мэдмээр байна уу? Би уурласан (Багш инээв), тийм бядуу шавийг би адисалж чадахгүй. “За! Энэ асуудлыг тайлбарлахад маш амархан. Та бурхны гэрлийг харахгүй юм чинь тамд очоод хав харанхуй хүслэнт ахуйг үзээрэй! Та хэрвээ Багшдаа итгэхгүй бол хариад өмнөх багшаасаа сурвал болно!” гэж би хэлсэн.

Энэ чинь тун хялбар хэрэг биш үү? Гэрэл харах дургүй юм чинь харанхуйг хар! Одоо тамыг үзэхээр очоорой! Тэнд бүдэг харанхуй хүслэнт ахуй их байгаа. Тоост хорвоо ч мөн хав харанхуй. Дээд түвшинд хүрсний дараа л сая гэрэл хардаг. Та гэрэлд дургүй юм чинь харанхуй газар очвол болчихно. Асуух шаардлагагүй,

юунаас ч айх хэрэг алга. Багш нь чамайг заавал надаас сур гэж албадахгүй. Багшийнхаа бясалгалын аргад итгэхгүй бол урьдын багшаасаа суралц! Харин энэ аргаар бясалгаж байхдаа битгий өмнөх багшийнхаа ярьсныг санаад бай! Тэр юу ярьж хэлсэн ч бүгд хоосон, чамд юу ч өгөөгүй. Тэр авшиг авсны дараа Багш нь түүнийг гэрлийн ахуй ойлголттой болгосноос эхлэн айх болжээ. Өмнө нь ямар ч ахуй ойлголтгүй байсан болохоор сэжиг төрмөөр юмгүй байж. Багшаасаа сурсны дараа бага зэрэг билиг ухаантай болсноор “Миний өмнөх үзэл зөв юм болов уу?” гэж эргэлзэх болжээ. Урьд нь юу ч мэдэхгүй байхдаа ямар ч асуудалгүй байжээ.

Тиймээс бусдыг сургахад хялбар бус. Ахуй ойлголтгүй бол сэрдэж хардана. Ахуй ойлголттой болбол бас л хардаж сэрдэнэ. Бясалгалын зам маш урт, гэхдээ үнэнийг хайх сэтгэл бат гүн биш бол замын дундаас уруу татагдан явчихна. Тиймээс төрлөөс төрөлдөө Төгс Гэгээрсэн Их Багшийг олоход тун хялбаргүйг бод. Үгүй бол бясалгагч тийм их байхад амжилтад хүрэгсэд харин яагаад тун цөөн байдаг вэ? Төгс Гэгээрсэн Их Багш яагаад тийм цөөн байдаг вэ? Эгэл хүмүүсийн үйл хэрэг ч гэсэн бүгд ийм байдгийг та нар мэднэ. Хөгжим сурах хүсэлтэй хүмүүс их байдаг хэдий ч ганц, хоёр хоног сураад л больчихдог. Тиймээс мэдээжээр хожим амжилтад хүрч чадахгүй, эсвэл заримдаа баярлах үедээ бүжиг сурах хүсэл төрж суралцдаг. Гэвч эхлэн сураад шантарч, бүжиг сурах тэсвэр тэвчээр болон авьяас чадваргүй санагдан дахин сурахаа больдог. Та нар ер нь ямар нэгэн зүйл хийхдээ дөнгөж эхлүүлээд л эрч хүч чинь буурч, үргэлжлүүлэн хийхээ зогсоодог. Ингэвэл мэдээж амжилт гаргаж чадахгүй.

Багштай чинь уулзахаар, эсвэл ном сонсохоор ирдэг хүмүүс их байдгийг заримдаа та нар хардаг. Гэхдээ хүн болгоны итгэл хүсэл тийм бат биш. Зарим хүний сэжиг хардалтын сэтгэл тун хүнд, яагаад вэ? гэвэл бид төрлөөс төрөлдөө ад чөтгөртэй хамт байж, бурхантай ойр байх тохиолдол маш цөөн байсан болохоор толгой тархинд нь ад чөтгөрийн сэтгэгдэл нэлээд гүн суужээ. Яг л аав, ээж маань бидэнд балчир багаас юу идүүлнэ, түүнд нь дасаж, хожим том болоод хаана очсон ч түүнийгээ олж иддэг. Тиймээс хятадууд хаана очно, тэнд “хятад хот” бий болж, хятад хоол, хятад бараа худалдаж, хятад хэлээр ярьж, хятад хэлээр бичиж, хятад сонин уншдаг. Маш олон хятад хүн Америкт хэдэн арван жилийн турш амьдарсан байтал англи хэлээр ярьж чаддаггүй. Вьетнам (Ау Лак)-д бас “Хятад хот” байдаг. Бид түүнийг “cho lon” гэдэг, “том зах зээл” гэсэн утгатай. Хэн гэдэг вьетнам хүн ийм хошин нэрээр нэрлэснийг мэдэхгүй. “Хятад хот”-ыг “Их зах зээл”



гэснийг яана! Энэ нь арилжаа наймаа хийдэг том газар гэсэн үг.

Үнэндээ бас тийм. Та нар тэнд очвол бараа худалдаж байхыг зөндөө харна. Идээ, ундаа, тоглоомын зүйл гэх мэт зүйлс дүүрэн байгаа харагдана, Хятадууд хаана ч очсон зөвхөн наймаа л хийдэг. Үгүй бол оршин тогтнож чадахгүй юм шиг байдаг. Вьетнамын “Хятад хот”-д хятадууд дүүрэн амьдарч, хятад бараа худалдаж, хятадаар ярьдаг. Вьетнамд хэдэн арван жилээр амьдарсан байтлаа Вьетнам хэлээр жаахан ч ярьж чаддаггүй хүмүүс их байдаг. Үүнд би тун цочин гайхдаг. Гэхдээ энэ бол үнэн хэрэг. Энэ нь бүгд л бид хар багаасаа хэрхэн дадуулж өссөн гэдгээсээ хамаарч хэдэн арван жил өнгөрсөн ч ер нь өөрчлөхөд тун бэрх байдаг хэрэг.

Үүнтэй адилаар бясалгагч хүн Төгс Гэгээрсэн Их Багшид итгэхэд тун хялбаргүй байдаг нь адын саад тун хүнд байдгаас болжээ. Ад бол хий бодол мөн. Хий бодол дэндүү хүнд болохоор үнэн ёсыг сонсдоггүй. Ахуй ойлголтоор тун сайн авшигтан их байдгийг мэддэг бөгөөд бас ахуй ойлголттой хүмүүс өөрсдөө тун олон байгаа хэдий ч тэдний итгэл нь заримдаа мөн л гуйвдаг. Хэрвээ ийм биш бол Бурханы хутагт хүрэхэд маш хялбар. Хамгийн сайн бясалгалын аргыг нэгэнт олчихсон болохоор даруй түргэн бясалгаж Бурханы хутагт хүрэх нь зүйтэй байхад бид яагаад дорхноо тэгж чаддаггүй байна вэ? гэвэл тийм сэтгэгдлээ угааж цэвэрлэж чаддаггүйгээс болж байгаа юм.

Сэтгэгдлийг тийм түргэн арилгаж чадахгүй. Тиймээс өдөр бүр рашаан усаар угааж цэвэрлэх хэрэгтэй. Арьяабалын бясалгалын аргыг ашиглахгүй бол бид дотоодын тийм дуу хуурцгийг эвдэхийн аргагүй. Тэр өдөр бүр мэдээлэл шингээдэг. Бид өөр нэг төрлийн долгионоор түүний дуу үүсгэх системийг нь эвдэнэ. Яг л хоёр улс дайтаж байгаа үеэр нэг улс нь: бидний дайсан ямаршуухан муу санаатай гэхчилэн сурталчлахад нөгөө нэг улс нь бас: тэр улс ямаршуухан хар санаатай гэхчилэн ярьдагтай адил. Хоёр улс харилцан нөгөө этгээдийнхээ долгионыг харшилж, хашгирах дуу ч тод сонсогддоггүй, тэгээд дайсан этгээдийн гаргасан самууруулах дууны долгионд юм бүхэн эвдэгддэг. Үүнийг “самууруулах” гэж хэлдэг. Радио нэвтрүүлгийн долгионыг самууруулж, бид сонин мэдээг тод сонсохыг саатуулдаг. Үүнтэй адилаар бид ад чөтгөрийн дуу гаргах машиныг саатуулах гэвэл аялгуу ажих хэлбэлзлийг ашиглах хэрэгтэй. Тэгэхгүй бол угаан цэвэрлэж чадахгүй. Тиймээс заримдаа та нар дөнгөж эхлэн бясалгаж суухад сэтгэл тайвуу болж чаддаггүй. Есөн шидийн юм бодож, чухам хэзээ ийм олон бодол тархинд орж ирснийг бүү мэд. Угаас ийм олон бодол байсныг ч мэдээгүй. Гэтэл бид бясалгаж суух гэхээр бүгдээрээ

гарч ирээд амар мэндийг асуудаг, тийм үү, үгүй юү? Гэхдээ хүлцэнгүй байж үргэлжлүүлэн бясалгаж суувал төд удалгүй бүхнийг мартаж, саяхны ховдог, хилэн, мунхгийн нисваанист саатуулагдаж байсан маань бүгд алга болчихдог. Тиймээс хэдий ихээр бясалгаж суувал тийм их үр дүнтэй болно. Бясалгаж суух нь ач тустай. Хүлцэнгүй, хичээнгүй бясалгах хэрэгтэй. Гэхдээ ахуй ойлголтоо ярьж болохгүй. Багшийн зөвшөөрөл байвал сая ярьж болно. Багшийн зөвшөөрөлгүйгээр өөрөө яриад адын саадтай болбол Багш дээрээ ирж гомдоллож болохгүй, ойлгож байна уу? Эсвэл ярьсны дараа ямар ч ахуй ойлголгүй болбол бас Багшдаа гомдоллож болохгүй. Багшийн зөвшөөрөлгүйгээр ахуй ойлголтоо бусдад ярьж болохгүй гэж авшиг хүртээх үеэр Багш нь хэлсэн. Та нар Багшийнхаа өмнө ахуй ойлголтоо ярихад хамаагүй. Ямар нэгэн хэрэг гарвал Багш нь дор нь шийдвэрлэнэ. Учир нь Багш нь зөвшөөрсөн болохоор хариуцлагыг нь би үүрэх ёстой. Багш нь зөвшөөрөөгүй байхад та нар яривал хариуцлагаа өөрсдөө үүрэх хэрэгтэй. Заримдаа хариуцлага тун хүнд, хэрвээ үүрч дийлэхгүй бол яршиг төвөг их болно.

Одоо Багш нь бясалгалын тухай нэг түүх ярья! Нэгэн бясалгалтан урагдсан навсархай хувцастай явдаг байжээ. Эгч нь үүнийг хараад түүнд нэг баглаа даавуу хүргэж, өөрөө хувцас хийж өмсөөрэй гэж захижээ. Тэгээд арван гурван жилийн дараа эгч нь дүүгээ харахаар очсонд өнөөх даавуу нь яг тавьсан газартаа байж байх бөгөөд дүү нь тэр даавуунд огт гар хүрээгүй байжээ. Тэрээр хувцсандаа ер анхаардаггүй, сэтгэл зовнидоггүй, гэхдээ эгч нь авшиг хүртээгүй бөгөөд тэр авшиг хүртээгүй хүний өглөгийг авдаггүй байж ч мэднэ. (Бүгд инээлдэв.) Тэрээр чин сэтгэлтэй бөгөөд гагцхүү нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгадаг болохоор маш их зөн билигтэй. Уулан дээрээс маш олон газар тун түргэнээр нисэн хүрч чаддаг. Нэгэн өдөр хааны ээж таалал төгссөн тул хаан эзэн эхийгээ гэтэлгэхээр маш олон номын багшийг урьж залжээ. Гэвч бүгд л гэтэлгэж чадаагүй болохоор хаан олон газраар зар тарааж, гэгээнтэн лам хайжээ. Өнөө бясалгалтан бас хүрэлцэн ирж хааны эхийг гэтэлгэхийг бодов. Тэрээр бясалгалаар тун өндөр байтлаа бас бусдыг гэтэлгэх гэх нь чухам ямар учиртай вэ? Хааны охинтой хувь барилдлагатай байсан ч байж магад. Учир нь маш олон хүн ирээд бүгд л гэтэлгэж чадаагүй. Гэхдээ хаан эзэн гэтэлгэхээр ирсэн тэр хуврагуудыг харахад бүгд л амтат идээ ундаанд дурлаж ирсэн төдий бөгөөд чин сэтгэлээсээ гэтэлгэхийг бодоогүй. Тиймээс энэ удаа хаан эзэн нэлээд хичээн болгоомжилж, хэн нь чухам жинхэнэ зөн билигтэй, хүч чадалтай

болохыг туршин шалгажээ. Хаан, эхлээд нэг боть “Очир огтлогч судар”-ыг ордны хаалганы өмнө булж орхиод дараа нь номын багш нарыг ордондоо залжээ. Тэгсэнд бусад хүн бүгдээрээ шууд л орж, зөвхөн өнөө бясалгагч хаалгаар оролгүй, тэндээ сөхрөв. “Та яагаад ордонд орохгүй, харин тэнд сөхрөн сууна вэ?” гэж хаан асуусанд өнөө зөн билигтэй номын багш: “Тэр доор нэг боть “Очир огтлогч судар” тавиастан болохоор би судар дээгүүр алхан гарч зүрхлэхгүй байна.” гэж хариулжээ. Тэр үед хаанд жаахан итгэл төрж бусад номын багшийг хөөж явуулжээ.

Хаан эзэн өнөө бясалгагчаас, гэтэлгэх үеэр юу бэлтгэх хэрэгтэй вэ? Ховор нандин идээ ундаа хэрэг болох уу, эсвэл амтат жимс, шинэхэн цэцгээр тахил өргөх үү? гэхчилэн асуухад нэг тахилын ширээ, нэг гүлс (арц хүжний бойпор), нэг багц цэцэг, нэг жимс гэх мэтийг үзмэрийн төдий бэлтгээрэй гэжээ. Хаан эзэн сонсоод их л сэжиг төрж: “Үнэхээр иймхэн зүйлийг хэрэглэх үү?” гэж асуусанд тэр: “Тийм, эдгээрийг бэлтгэвэл хангалттай, болно.” гэжээ. Хаан эзэн түүнийг удтал ширтэв. (Сэжиг төрсөн тийм харцгыг та нар мэдэх үү?) Дээрээс нь доошоо, түүнийг үл тоомсорлосон харцаар ширтэв. Тэгээд түүний урагдаж навсайсан хувцас, удтал угаагаагүй ширэлдсэн урт үс, өмхийрсөн биеийг хараад, хаан түүнийг мэдрэлийн өвчтэй ч байж болзошгүй, гэхдээ Очир огтлогч судар булсныг тэр санаандгүй мэдсэн, харин жинхэнэ хүч чадалгүй байх гэж боджээ.

Хаан эзэн их л сэжиг төрсөн боловч бусад номын багшийг явуулж, зөвхөн тэр л үлдсэн болохоор одоо түүнийг хөөж явуулахын аргагүй болжээ. Тэгвэл дахин нүүрээ барах хэрэг гарна. Тиймээс хаан эзэн аргаа баран: “Зөвхөн энэ хэдхэн зүйлийг л хэрэглэх’ юм уу?” гэж дахиад асуухад: “Тиймээ, хаан эзэн та надад итгэвэл зохино.” гэжээ. Хаан эзэн аргагүйн эрхээр жаахан жимс болон хүж тавьжээ. Тэгэхэд өнөө бясалгалтан нэг гудас гуйж аваад ширээн дээр гарч хөдлөлгүй суужээ. Нэг ширхэг хүж асаж дуусах үеэр тэр самадигаасаа гарч: “Хаан танд баяр хүргэе! Хааны ээж гэтлэгдлээ.” гэж хэлэв. Хаан эзэн итгэж ядан түүнийг мэхэлж байна гэж бодон: “Би итгэхгүй байна.” гэж дөнгөж хэлж дуустал хааны эх асуурийн бие цогцосоороо илрэн: “Би нээрээ гэтлэгдчихлээ, та энэ гэгээнтэн ламд тэгж хандаж болохгүй.” гэж хэлжээ.

Хаан ихэд айн цочиж, энэ бясалгалтанг үнэхээр нээрэн хүч чадалтайг мэдээд түүнд биеэрээ сөхрөн мөргөж, их л баярлан талархжээ. Тэгээд ач хариулахын тулд түүнээс юу хүсэж буйг нь асуусанд өнөө бясалгагч хааны өмдийг хараад үүнийг чинь

авмаар байна гэжээ. (Бүгд инээлдэв.) Хөдөөгийн хувраг өмдгүй, эсвэл чухам юу авахаа мэдэхгүй байсан ч байж мэднэ. Учир нь хаан эзэн шахаад байхаар тэр арга буюу “Тэгвэл та өмдөө надад өгчих!” гэж хэлжээ. Тиймээс хаан эзэн түүнд Лүн кү (хааны өмд) хувраг гэх нэр хайрлажээ. Лүн шуу (лууны мод) биш, Лүн кү. Луу бол хаан суурийг төлөөлдөг. Тэр хааны өмдийг авсан болохоор Лүн кү хувраг гэж нэрлэжээ. Энэ үлгэрээс, бид ямар ёс зүйг сурч чадах вэ? гэвэл хэдий чинээ дээд зэргийн бясалгал бол төдий чинээ хялбар байдаг, ихэнх бясалгалын арга тун ээдрээтэй. Бурхны тахилын ширээ нь ч тун ээдрээтэй, хэд хэдэн шүтээн, хэд хэдэн Бодьсадваг тахин шүтэж, хооронд нь өрсөлдүүлэх нь хэцүү. Энэ хөрөгт нь мөргөвөл цаадах хөрөгт нь ч мөргөх хэрэгтэй. Зарим газар Арьяабал Бурханы хөрөг, Манзушир Бурханы хөрөг, газрын зүрхэн Бодьсадвагийн хөргөөс ондоо бас өөр шүтээний хөргийг тахидаг. Тиймээс бүгдэд нь мөргөх хэрэгтэй. Энэ хөрөгт нь мөргөөд нөгөө хөрөгт нь мөргөхгүй бол нөгөө хөрөг нь атаархахаас айна. (Бүгд инээлдэв.)

Төвөдийн бясалгалын арга бас тун ээдрээтэй. Тэд олон хэлбэрийн жигнэмэг хэрэглэдэг бөгөөд тийм жигнэмгийг манай энд хийж чадахгүй. Хийсэн ч тун ажиллагаатай бөгөөд адилхан хэлбэртэй хийж чаддаггүй. Түүнийг зөөхий болон арвайн гурилаар хийдэг. Төвөдүүд арвайн үрийг тээрэмдэх дуртай. Тэгээд арвайн гурилаа буцалсан усаар зуураад шууд л чимхээд идэцгээдэг. Тун тэжээлтэй.

Арвайн үр нь шим тэжээлээр тун сайн, арван гурван хувийн уурагтай, гахайн маханд арван дөрвөн хувийн уураг бий. Арвайн гурилаас ганц хувийн зөрүүтэй. Шар буурцаг бүр ч тэжээлтэй. Гучин зургаан хувийн уурагтай. Бүх махан төрөл (өндөг бас багтана)-өөс илүү тэжээлтэй. Бидний иддэг алаг будаа бас тун тэжээлтэй. Эрдэнэ шиш бас арван хувийн уурагтай. Тэр бол байгалийн идээ мөн. Ийн эдгээр нь уургаар маш баялаг байхад бид гахай, үхэр тэжээж, их зардал гарган, дараа нь тэдний махыг идэж, уургаа дам байдлаар нөхөхөө тун ухаантайд үздэг. Шууд уургийг ашиглахгүй, харин дам уургийг ашиглах нь нээрээ арга барагдам явдал.

Тонгоруу ертөнц гэж Багш нь аль хэдийн хэлсэн. Тиймээс сайн санаатай хүнийг тэд муу санаатан гэж, муу санаатныг харин сайн санаатай гэж ярьдаг. Бид жинхэнээр хичээнгүйлэн бясалгавал тэд шүүмжлэн дайрч, гаднах хүмүүс зөвхөн мөнгө олохыг л боддог төдий байхад тэд харин сайшаан магтдаг. Энэ ертөнц үнэхээр тонгоруу болчихжээ. Тэгвэл яавал зүйтэй вэ?

Хүмүүсийг гэтэлгэх энэ арилжааг хийхэд тун бэрх, мөнгөний алдагдал байнга гардаг гэж (Багш инээв) би та нарт хэдийн ярьсан. Тиймээс ийм “арилжаа” (Төгс Гэгээрсэн Их Багш болох)-г хийдэг хүн тун цөөн байдаг. Өөр хүмүүс хуурмаг арилжаа хийгээд харин их мөнгө хожиж, өөдөө эсрэг явдаг байхад жинхэнэ арилжааг хийхэд тун төвөгтэй бөгөөд мөнгө алдагдана.

Дээд түвшний ёслол нь тун хялбар дөхөм байдаг. Хэрвээ та дээд түвшинд аз таарч хүрч чадвал, өөрөөр хэлбэл өөр нэгэн дэлхий, жишээлбэл усан гараг, гал гараг, модон гараг зэрэг долоон гарагийн аль нэг гарагт очингуут ямаршуухан байдгийг мэдэх үү? Хүн ирж угтана, дараа нь таныг дагуулан маш олон төв, хот балгас, айл тосгоноор явж харуулна. Тэгээд зам дагуухыг, энэ бол хамгаас хөгжиж байгаа болхи бааз хэрэгсэл, нөгөө нь хамгийн боловсон, шинжлэх ухаанч бүтээл мөн. Гэхдээ та нарын дэлхийд ерөөсөө байхгүй шүү гэхчилэн тайлбарладаг.

Тэр багаж хэрэгсэл нь ямар үйлдэлд хэрэгцээтэй вэ? гэвэл тэр нь гэрлийг хуримтлуулж, дараа нь хэдий хэмжээний гэрлийг аль аль оронд хүргэхийг шийдэж, хэн нэгний өвчин, эсвэл зовлонг арилгадаг. Зарим хүн зовж шаналах үедээ залбирч даатгавал тэд гэрэл цацруулж, тэднийг авардаг. Эсвэл ямар нэгэн болхидуухан хэрэгслээр туйлын гэрэл цацруулж, үйл түйтгэрээр тун хүнд хүмүүсийг авардаг.

Эрхбиш тийм хэтийдсэн цацрагт хурц гэрлээр бидний бие махбодыг хэсэг хэсгээр тайрч байж л сая өвчнөөс аварч, үйл түйтгэрийг авч гаргаж чадна гэж хоёр хоногийн өмнө Багш нь Тайнанд ярьсан. Учир нь үйл түйтгэр бидний биеийн дотоодод муу систем болж хувирдаг болохоор заавал тийм гэрлээр хэсэг хэсэг болгон тайрдаг учраас өвчтөнд маш зовуурьтай санагддаг. Түүнийг тамын орон гэж хэлдэг.

Дээд түвшинд хүрч чаддаг хүмүүс бол лавтай тун сайн хүмүүс. Тиймээс тэд таныг урин залж, дээд түвшнээр зугаалуулдаг. Энгийн хүн тэнд хүрч чадахгүй, гэхдээ тэнд уригдаж очлоо гэхэд хөгжөөн наргиантайгаар угтаж авдаг юм биш. Бид дөнгөж тэнд хүрэх үед олон хүнтэй уулзаж, төв болгоноор нь хүрч чаддаг юм биш. Учир нь бидний хэлбэлзлийн хүч хангалттай сайн биш болохоор тэр оронтой амархан зохицож чадахгүй, зарим газрынх нь хэлбэлзэл нэлээд хурдан. Бид орохын аргагүй бөгөөд орвол тун зовуурьтай санагдана. Зарим газрынх нь хэлбэлзэл жаахан удаан. Эгэл хүмүүс дөнгөж хүрч очлоо ч бас зохицож чаддаг.

Бид хэдийгээр тэнд хүрч чаддаг боловч тэндхийн хүн болгонтой ярьж чадахгүй, бас харж чадахгүй. Зөвхөн бидэнтэй

холбоотой, биднийг дагуулж аялах хүнийг харж чадна. Гэхдээ тэд биднийг илүүхэн адислах хэрэгтэй болно. Ингэвэл сая бид тэндэх хүслэнт ахуйн давтамжтай зохицож чадна. Үгүй бол бид тэвчиж чадахгүй. Буцаж ирснийхээ дараа солиорч мэднэ. Мэдрэл хэвийн бус болж, бие махбод гэмтэж, юм бүхэн муу болно. Заримдаа бид бас тамын оронд очиж харж болохгүй. Учир нь очоод буцаж ирсний дараа нөлөөнд нь ихэд автаж, юмс муухай болно. Яг л атомын бөмбөгийн гэрэл харсан шиг бүх бие сул дорой болж, хурц гэрэлд нүд сохорч мэднэ.

Хэдий чинээ дээд зэргийн юм байна, төдий чинээ хялбар дөхөм байдаг. Гиймээс дээд түвшинд хүмүүсийг баярлан угтах үед пуужин тавьж хөл хөөрцөг болох юм уу, цэцэг жимс өргөх гэх мэтийн ёслол байдаггүй. Бүгд л маш уян зөөлөн, маш энгийн, маш хялбар дөхөм, цэцэг жимс мэтийн олон өнгийн юм ер харагдахгүй бөгөөд засал чимэглэл гэмээр зүйлс ч байдаггүй. Бидний эндхийнх шиг өнгөн талын материаллаг зүйлсээр зургаан мэдрэхүйгээ тайвшруулдаггүй. Харин хүмүүсийг хамгийн цэвэр цэмцгэр, энгийн эгэл хэлбэрээр угтдаг. Жишээлбэл, бидний бие, хэл, сэтгэл жаахан цэвэр болбол дээш гарч, харж болно. Гэхдээ тэндхийн иргэдийн хүн болгонтой ярьж чаддаг биш. Заавал нэлээд удаан хүлээж байж л сая ярьж чадна. Дараа нь бүр ч илүү удтал хүлээсний эцэст тэдэнтэй хамт амьдарч чадна. Үүнээс бүр ч илүү хугацаа өнгөрсний дараа тэднийг удирдан дагуулж чадна. Өөрөөр хэлбэл тэднийг заан сургаж, тэнгэрийн төрөлтний жолоодогч багш болно гэсэн утгатай, ойлгож байна уу?

Одоо бол бид хүн төрөлтнийг сургах боломжтой. Харин тэнгэрийн төрөлтнийг сургаж чадахгүй. Тэд билиг ухаанаар биднээс ч өндөр тул бид яаж дээш гарч тэднийг сургаж чадах билээ? Заавал эхлээд тэднээс суралцах хэрэгтэй. Дараа нь тэнд маш удтал дасгалжсаны дараа сая тэднийг сургаж чадна. Хэрвээ бид тэнд хүрч Есүс Христ, Шагжамуни Бурхан, Лууз, Күнз мэтийн Их Багш нар дээд түвшинд хэчнээн их агуу болохыг мэдвэл бид бүр ч илүү даруу болж, тэднийг бүр ч илүү хүндэтгэн хайрлаж, бишрэн шүтэх болно. Учир нь бид одоо хараахан мэдээгүй болохоор зөвхөн сайшаан магтахаас биш, жинхэнэ агуу ихийг нь мэддэггүй. Тэд энэ ертөнцөд амьдарч байхдаа яг л зарц шиг, хүмүүсийг жинхэнэ ёсоор асран халамжилж явсан. Гэхдээ тэднийг тоомсорлох хүн тун цөөн, хүмүүсийн тал хувь нь гүтгэн гүжирддэг. Бүхий л ертөнцийн хувьд тэд хэчнээн хүнийг гэтэлгэснийг та нар бүгд мэднэ. Тэд нирваандаа буцсаны дараа бид сая тэднийг дурсан санаж, сайшаан магтдаг. Гэхдээ тийм ч их

ач тусгүй. Бүгд л алдрыг нь дурсан унших төдий. Тэд чухам хэн болох, тэдний хэчнээн их агуу гэдэг үнэнийг мэддэггүй. Тэдний амьд сэрүүн байгаа үед бид бүрмөсөн итгэдэггүй. Эргэлзэн сэжиглэдэг юм чинь нирваандаа буцчихсаны хойно хэлэх хэрэг юун?

Тэдний зөн билгийг бид өөрсдөө хараагүй. Хүч чадлыг нь ойлгоогүй. Дээд зэргийн сургаал ёсыг нь сонсоогүй. Бүгд л бусдын тайлбарласнаар дамжуулан тэднийг ойлгодог. Гэхдээ тэр тайлбар нь хэдэн зуу, хэдэн зуун мянган хүний гар дамжсан тул бид тийм ч их итгэдэггүй билээ. Жишээлбэл, бид авшиг аваад дээш гарч тэдэнтэй уулзах үед тэд хэчнээн агуу их болох, тэнгэрийн төрөлтөн хэрхэн хүндэтгэж байхыг нь харвал тэд амьд сэрүүн байх үед бидний дэлхий үнэхээр азтай байсныг ойлгодог. Учир нь манай дэлхийгээс бүр илүү иргэншсэн тэдгээр гараг дэлхий, энэ дэлхийн хүмүүсээс боловсон иргэд одоо болтол мөн л тэднийг тэгж хүндэтгэж буй. Гэтэл бидний энэ дэлхийн бохир хүмүүс харин тэдэнтэй хамтдаа байж, адилхан агаараар амьсгалж, адилхан орон зайд оршин амьдарч, адилхан хэлээр ярилцаж байсан гэдэг нь нээрээ азтай хэрэг байжээ. Энэ үед бид сая л, тэдний алдрыг мэдэж чадсан аз завшаанаа ойлгож мэдрэх болно. Учир нь Бурхан, Бодьсадва энэ тоост хорвоод ирвэл бүгд л боол шиг болчихдог. Хамгийн эрхэмсэг, хамгийн гоц сайхан, хамгийн дээд дэсийн хүн энд ирвэл хамгийн доор дэсийн хүн болж, бүгдээрээ түүнийг гүтгэж, сэжиглэж, гутаан доромжилж, гутлын алчуур шиг дорд үздэг. Хүмүүс дур зоргоор тэднийг хорлон хөнөөдөг. Энэ дэлхийд байхдаа тэдний амь нас тун аюултай. Нэр алдар, эсвэл өнгө зүс нь гэгээн байр суурьтай болохыг нь бүр ч хэлэх юм биш. Учир нь тэдний амь насанд хэдийн аюултай байдаг болохоор нэрд гарахыг хүсэх хэрэг хаанаас байх вэ?

Ямар нэгэн шашинд итгэх нь бүгд сайн. Гэвч эхлээд Арьяабалын бясалгалын аргаар бясалган дээш гарч тэднийг харсны дараа сая нэн их итгэл төрж, бүр ч илүү хүндлэх болно гэж Багш нь үргэлж ярьдаг. Тэр үеийн даатгал нь жинхэнэ даатгал болно. Авид Бурханыг дурсвал түүний агуу ихийг жинхэнээр мэдэж, Есүс Христийг дурсвал яагаад тийм агуу их болохыг жинхэнээр ойлгодог. Энэ бол жинхэнэ даруу хичээнгүйгээр дурсаж байгаа болно, ойлгож байна уу? Одоо бид дээш гарч, урьдын нэгэн Төгс Гэгээрсэн Их Багштай уулзъя гэж бодъё! Жишээлбэл Лууз, урьд нь түүнд итгэдэг хүн тун цөөхөн байсан, тийм биш үү? Одоо ч мөн л ийм, зарим хүн итгэж, зарим хүн гүтгэдэг. Гэвч бид дээд түвшинд хүрвэл Лууз үнэнхүү агуу их болохыг хардаг. Гэхдээ



тэр тийм агуу их түвшиндээ байнга байдаг биш. Бусад түвшинд түүний байр суурь нь бүр ч агуу их болдог. Жишээлбэл, өмнө нь тэр бидний дэлхийн эдгээр бядуу иргэдийг сургахдаа тийм ч олныг сургаж амжилгүйгээр үүрэг нь дуусаж, дээд түвшинд буцсан. Учир нь тухайн үүрэг хариуцлагаа биелүүлсний дараа дэс нь дээшилдэг. Энэ дэлхийд түүний дэс нь хамгаас өндөр гэж бид бодож болохгүй. Хамгаас өндөр гэх нь бас зөв, гэхдээ дээд түвшинд бүр ч өндөр дэстэй болдог. Учир нь: “Оройн Дээд Төгс Төгөлдөр Гүн Билиг ухаан” болох тул дээшлэхгүй байхын аргагүй. Хэрвээ зах хязгаартай байвал “Оройн дээд” гэж хэлж болохгүй.

“Оройн дээд” гэдэг нь хамгийн дээд гэх нэгэн орон байдаггүй гэдгийг илтгэж буй. Иймээс бясалгахдаа ямар нэгэн түвшинд зогсчихож болохгүй, үргэлж тасралтгүй дээшлэн мөрийн хутагаа эгнэгт дээшлүүлэх хэрэгтэй. Бид Эзэн Бурханыг хамгийн дээд гэж хэлдэг. Тэр бол хамгийн дээд болох тул түүнд зах хязгаар гэж байдаггүй. Тэр бол хамгийн дээд нь бөгөөд хамгийн доод нь, тэр үүрд тасралтгүй дээшилж, ямар нэгэн түвшинд зогсчихож болохгүй. Зогсчихвол тэндээ ялзарч дуусна. Ойлгосон уу?

Лууз энэ дэлхийд байх үед бид үл тоомсорлож байв. Одоо ч гэсэн бас түүний сургаал ёсыг ойлгох хүмүүс тун цөөн. Зөвхөн түүнд дуртай байдаг төдий. Учир нь түүний ярьсан сургаал ёс нь маш гүн нууц. Гэхдээ жинхэнэ утгыг нь ойлгох хүмүүс маш цөөн, “бодь мөрийг ологсод” бүр ч цөөн. Жишээлбэл, тэр одоо бусад гарагийн төрөлтөн, биднээс бүр ч илүү иргэншсэн дээд дэсийн төрөлтөн. Дээд дэсийн судлаачид харьяалагдана. Тэднийг хэсэг хугацаанд сургасны дараа дэс нь улам дээшилж, хүч нь улам их болдог. Энэ үед өөр нэг бүр ч илүү иргэншсэн дээд дэсийн бөмбөрцгийнхөн түүнийг урьж багш болгодог. Тэр бол угаас нэгэн орны шашны тэргүүн, нэгэн гарагийн шашны тэргүүн байснаа одоо хамтад нь долоон улс, долоон гараг, тэр ч байтугай найман гарагийн шашны тэргүүн болчихож ч магад. Байр суурь нь улам дээшилбэл наймдугаар ертөнцийн дэсэд хүрч мэднэ. Харин зөвхөн нэг, хоёрдугаар ертөнц төдий биш. Жишээлбэл, Авид Бурхан зөвхөн баруун зүгийн Төгс баясгалант оронд шашны тэргүүн байсан бол хожим нь зүүн зүг, баруун зүг, эсвэл дөрвөн зүгийн шашны тэргүүн болж ч магад. Хэрвээ үнэхээр ийм болбол түүнийг угтах ёслол ямар байхыг та нар төсөөлж чадах уу? Манай дэлхийн угтах ёслолын ихэнх нь харанга хэнгэрэг дэлдэн, хөл хөөрцөг болдог. Тиймээс та нар дээд түвшний угтах ёслолыг төсөөлж чадахгүй. Гэхдээ үүнийг тийм амархан харж чадахгүй.

Нэг, хоёр зуун жил болж байж л нэг удаа, заримдаа хэдэн зуун мянган жилд нэг удаа ёслол үйлддэг. Гэхдээ тэнд хүрсэн болгон тийм ёслолыг хардаг биш. Би өөрөө ч гэсэн хараагүй шүү! Яасан бэ? (Багш инээв.) (Багш харсан гэж бүгдээр хариулав.) Би зөвхөн харсан хүн байдаг гэдгийг л сонссон төдий.

Урьд нь энэ дэлхийд шашны тэргүүн байсан нэг хүн, гэхдээ би нэрийг нь хэлэхгүй. Тэр дээш гарсны дараа нэгэн асар том шашны эзэн болов. Уг нь нэг л орныг хамаардаг байснаа одоо харин хэдэн гараг дэлхийг хамаарах болжээ. Сонсож байх нь ээ, түүнийг угтах ёслол нь ийм гэнэ: долоон гараг дэлхийгээс хамгийн дээдийг нь сонгодог. Хэдийгээр долоон гараг байлаа ч бүгдээр нэг цогц болж, долоо, эсвэл найман гараг дэлхий нэгдэж, иргэд нь ч нэгддэг. Дараа нь төв хэсэгт байгаа гарагт нэгэн маш том сүм босгодог. Тэндхийн сүм нь бидний эндхээс ондоо гэдгийг та нар төсөөлж чадахгүй. Төсөөлөхийн ч аргагүй. Тэдний сүм нь дээвэргүй, ханагүй, бидний майхан босгодог газартай төстэй. (Бүгдээр инээлдэв.) Гэхдээ бас тийм эзгүй хоосон биш, бүх сүм нь нэвт харагдан, яг л сүм гэмээргүй юм шиг, бүгд гэрлээр бүтээгдсэн юм шиг маш тунгалаг, мөн үзэсгэлэнтэй.

Сүмгүй гэсэн үг биш, байдаг ч нэвтэрч болно, харж чадна, яг л зах хязгааргүй юм шиг, дэндүү уужим. Хэрвээ адилтгаж болдог бол тэндхийн нэг сүм нь бидний эндхийн хэд хэдэн хотыг нийлүүлсэн гэмээр тийм том байдаг. Гэхдээ бид эндээс тэрийг хардаг шиг нэвт харж чадна. Тийм том байтлаа бас тийм жижигхэн, сүм хийд нь том байлаа ч харин зах хязгаар нь харагдахгүй том биш. Тэдний сүм нь маш олон хаалгатай. Жишээлбэл, найман бөмбөрцөг байвал найман хаалгатай, бөмбөрцөг бүр нь өөрийн гэсэн онцгой хаалгаараа нээгдэж, дараа нь нийлдэг. Төв хэсэгт нь нэгэн хоосон тавцантай, болор чулуу шиг гэрэлтэй, зөвхөн гэрэл төдий, үнэхээр бодитой гэмээр юм байдаггүй. Түүний дотор нь нэгэн маш өндөр тавцантай, тэд бүгд чимээгүй орж ирээд шинэ шашны тэргүүнээ угтан авдаг. Хоорондоо үг хэлээр ярьдаггүй, бүгдээрээ маш гоё, асар их гэрэл гялбаатай. Тэд орж ирмэгц сүм нэвт гэрэлтэж, төвд байгаа өндөр тавцанг гэрэлтүүлдэг. Төд удалгүй бүх гэрэл нь нийлж, маш том гал шиг болж хувирдаг. Маш гэрэлтэй, маш гялбаатай, дараа нь алгуураар тэр том гал шиг гэрлийн дотроос бидний сонсдог Арьяабалын номын цогцосын аялгуу шиг хөгжим цуурайтна. Гэхдээ зарим нь нэлээд өндөр дэсийнх бөгөөд гоц сайхан сонсогддог. Бүгдээр үргэлжлүүлэн хөгжим сонсож, ёслолын талбай нь нэн үзэсгэлэнтэй бөгөөд тун эерэг зөөлөн, заримдаа хөгжмийн дуу нь маш чанга сонсогддог,

эгэл хүний чихний сонор тэвчихийн аргагүй юм шиг. Гэхдээ гэмтээдэггүй, зөвхөн тэгж л санагддаг төдий. Дээд дэсийн хөгжмийг сонсох үед гол тавцангийн тэндэх гал шиг гэрэл нэг зүйлийн хэлбэр төрхтэй болдог. Дараа нь хүн болж хувирна. Хүн шиг боловч бас хүн биш, тэдний хувцас нь гэрэл, бие нь бас нэвт харагддаг гэрэл, тэр нь хүн мөн. Гэвч бас хүнтэй адилгүй, дараа нь алгуураар гар, хөл, толгой нь жаахан харагдана. Гэхдээ бүгд гэрэл гялбаатай, тэгээд хөгжим дуугарган гэрэл цацруулдаг. Ингэж жаахан үргэлжлүүлсний дараа өнөө шашны тэргүүн алга хавсран мэндчилж мэднэ. Тэр иргэд угтах ажиллагаагаа дуусгасны дараа хоёр гараа цээжиндээ солбицуулан тавьж, өнөөдрөөс эхлэн тэр хүн, өөрөөр хэлбэл шашны шинэ тэргүүнийг чин сэтгэлээсээ угтан авснаа, хүндэтгэн байгаагаа, шүтэн дагаснаа илэрхийлдэг. Тэд ийм хэлбэрээр нэгэн Их Бурханыг угтдаг. Угтаж авсны дараа гэрэл замхарч, хөгжим алгуураар суларч, бүгдээр гэртээ буцдаг. Цэцэггүй, жимсгүй, хэнгэрэггүй, хонхгүй, аливаа бүхэн нь маш энгийн байдаг. Дээд түвшинд ном тайлах нь ч бараг ийм байдаг.

Бид дээд дэсийн аргаар бясалгавал улам хялбар дөхөм байдаг. Гэхдээ миний саяхан ярьсан тэр орон бол бас хамгийн дээд дэс биш. Тэд зөвхөн тэр орныг төлөөлөн тэндхийн төрөлтнийг сургадаг төдий. Харин тэр гараг бол хамгийн дээд дэсийн гараг биш. Тэр газрын төрөлтөн үргэлжлүүлэн суралцдаг. Тэр бурхан тэнд хүрч тэднийг сургадаг. Яг л Шагжамуни Бурхан бидний дэлхийд ирээд хүмүүсийг сургадагтай адил. Гэхдээ цаашид үргэлжлүүлэн сургадаг бөгөөд хамаг төрөлтнийг сургах тусмаа дэс нь дээшилдэг. Бид энд түүнийг гүтгэх тусам түүний мөрийн хутаг нь дээшилдэг.

Иймээс Бурхан Бодьсадва бусдын гүтгэлгээс ердөө ч айдаггүй. (Багш инээв.) Харин хүмүүс хэрэгцээгүй зүйлсийн төлөө түүнд даатгаж, хүч тамирыг нь дэмий үрэхээс айдаг. Тэр ч байтугай зарим хүн зөвхөн нүүрэн дээрх батганыхаа төлөө залбирдаг. (Бүгдээр инээлдэв.) Бурхан Бодьсадва тэнсэлгүй дээд зам мөрийг бүтээхийн төлөө биш, харин өвчин зовлон, өчүүхэн бага ид шид, хөрөнгө мөнгө, алдар нэрийн төлөө л зорьж ирэх хүмүүсээс айна. Тиймээс тэд бүгд нуугдаж, гуйлгачин, ядарсан хүн, бядуу хүн, дүлий, хэлгүй, настай хүн болох, эсвэл маш хэрцгий, маш омгорхог хүн болж хувиран, хүнтэй уулзах дургүй байдаг. Эсвэл маш хэрцгий байдал үзүүлэн, тэр сургамаргүй хүмүүсийг хол зайлуулдаг. Яг л сарнай цэцэг шиг өргөс ихтэй, чин сэтгэлтэн биш бол цэцгээ таслуулдаггүй, нандигнахыг мэддэггүй нэгнээр гар хүргүүлдэггүй.

Өнгөн талын зүйлд битгий найдан бясалгаарай! Багшийгаа дагаж бясалгахад тун энгийн. Та нар хар л даа, бурхан ч үгүй, цэцэг ч үгүй, заримдаа та нар өглөг өгөхөөр л жигнэмэг, чихэртэй болдог. Гэхдээ та нар авчирсан болохоор хамтдаа хуваалцаж, бүгдээрээ бага зэрэг идсэний дараа харьцгаадаг. Бидэнд сүм хийд гэж байхгүй. Энэ бүх бөс даавуу шуувууг ер нь л салхи борооноос халхлахын төлөө ашиглаж байгаа. Энд гоё хээнцэр гэмээр зүйлс алга. Учир нь бидний хаант улс энд байдаггүй, дээд оронд бий. Тэнд маш гэрэл гялбаатай. Бид эндхийн хог новшинд шунадаггүй. Хэчнээн эгэл борог байлаа ч бүхнийг хүлээн авч, оршин амьдарч чадна. Учир нь хамгийн сайхан зүйлс дээд оронд биднийг хүлээж байгаа.



## БЯСАЛГАЛ ДЭВШИХ НУУЦ АРГА

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Миаоли Шихүгийн бясалгалын төв  
1988 оны 10 дугаар сарын 29-ний өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Багш нь та нарт нууц зүйл ярья! Яагаад зарим хүний бясалгал нь тун түргэн дэвшиж, зарим нь удаан байдаг вэ? Сонсох хүсэлтэй байна уу? (Хүсэж байна гэж бүгдээр хариулахын зэрэгцээ халуунаар алга ташив.) Та нар Мял богдын түүхийг мэдэх үү? Хэрвээ мэдэхгүй хүн байвал Багш нь маш хурдан дахин ярья!

Мял богдын эцэг нь нас барсны дараа хамаг хөрөнгийг нь аавынх нь эгч болон түүний нөхөр нь мэхлэн авчээ. Учир нь, эцэг нь эхнэр хүүгээ тэдэнд найдсан байтал Мял богдын хамаатан садан нь тэднийг сайн харж хандахгүйгээр үл барам зарцаа болгож, зовлон зүдгүүр ихэд амсуулжээ. Бүх зүйлээ өөрсдөө хийдэг, идэж өмсөх нь ч хүрэлцэхгүй, зарц шиг ханддаг болохоор тэд хорсол өвөрлөсөн байна.

Хожим нь Мял богдын ээж нь түүнийг хар шидэд суралцуулж, хар шидээр авга эгчийнхээ гэр бүлийн гуч гаруй хүнийг хөнөөжээ. Энэ үйл түйтгэрээс болж Мял богдын бясалгал сайжрахгүй байжээ. Тэр хүмүүсийг хөнөөсний дараа тэр гэмшин ухаарч тун ихээр айсан аж. Өнөө хар шид заасан багш нь ч: “Та Төгс Гэгээрсэн Их Багшийг нэн даруй хайж олбол сая өөрийгөө аварч чадна. Тэгээд хайж олсныхоо дараа намайг бас авар! Эс тэгвэл бид хоёулаа тамд унана. Учир нь хар шидээр хүн алсны үйл түйтгэр маш хүнд шүү!” гэжээ.

Мял богд энэ үгийг сонсоод мэдээжээр даруй түргэн төгс гэгээрсэн багшийг хайжээ. Хайж олсныхоо дараа Мял богд янз янзын арга хэрэглэсэн боловч багш нь түүнд юу ч сургаагүй, харин түүгээр өдөр бүр ядарч цуцтал нь хүнд ажил хийлгэсэн байна. Заримдаа том чулууг уулан дээр гаргасны дараа: “Болохгүй, дахин уг газарт нь аваачиж тавь.” гэнэ. Тэгээд буцааж авчирсны дараа дахин зөөлгөнө. Байшин бариулж, дараа нь нураалгана, дахиад л бариулна гэхчилэн долоон жил гаруй туршин шалгаад сая бясалгал хийхийг заасан байна.

Сонсох нь ээ, нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг хармагц чин сэтгэлтэй л бол бас сэтгэлийн авшиг хүртсэнд тооцогддог гэдэг. Гэтэл Мял богд долоон жил гаруй багштайгаа хамт байж, өдөр бүр шаргуу ажилласан байтал яагаад ямар ч үр дүнд хүрч чадаагүй бөгөөд багш нь ч жинхэнээр ном уламжилсангүй вэ? Та нар мэдэх үү? Учир нь тэр асар хүнд үйл түйтгэр үйлдсэн байна. Сонсож байхад хэчнээн хүнд үйл түйтгэр үйлдсэн ч бай, харамсан гэмших л юм бол арилчихдаг гэдэг. Яагаад Мял богд харамсан гэмшсэн мөртлөө бас долоон жилийг туулан байж, үйл түйтгэрээ арилгаж, төлж дуусгасан бэ? Та нар мэдэх үү? Тэр чин сэтгэлээсээ гэмшээгүйгээс болсон байж ч мэднэ. Бид гэмшлээ ч гэсэн энэ үйл түйтгэр мөн л оршсоор байдаг. Учир нь бидний гэмшлийн хүч хязгаартай. Туйлдаа тултал гэмшчихлээ гэж боддог ч мөн л тултал байж чаддаггүй.

Гэхдээ Мял богд багшийгаа мэхлэхийг санаархсан бөгөөд багш нь түүгээр ажил хийлгэх үед бас “Саяхан та надаар зөөлгөсөн юмаа дахиад л өргүүлж авчрууллаа. Та дураараа шийдвэр гаргаж байна.” гэж багшдаа гомдоллож байжээ. Багшдаа талархахгүй, харин маргалддаг. Багш нь түүний төлөө сэтгэлээ хэчнээн зүдрээж, өрөвдөх сэтгэлээ тэвчиж, хамгийн хатуу аргаар үйл түйтгэрийг нь арилгаж буйг тэр мэддэггүй байжээ. Та нар тодорхой харав уу? Хэрвээ тэр үнэнхүү гэмшсэн бол хэчнээн зовуурьтай байсан ч багшийнхаа сэтгэлийн зовлонг ойлгох байсан. “Миний үйл түйтгэр маш хүнд, хэдийгээр одоо ихээр зовж зүдрэн байгаа ч мөн л төлж дуусгахын аргагүй шүү дээ, миний алсан хүмүүсийн зовлонгийн дэргэд энэ бол юу ч биш, зовлон биш.” гэж бодвол сая зөв билээ.

Гэтэл тэр үед тийм бодол төрөөгүй аж. Өдөр бүр “Яагаад багш надад ном уламжлахгүй байна вэ? Багшид би тийм сайн хандаж байхад надад яагаад муугаар ханддаг байна.” гэж гомдоллодог байжээ. Хожим нь тэр бас далдуур багшийнхаа эхнэр болон шавиар нь ном уламжлуулахыг санаархжээ. “Надад ном уламжил

гэж багш чамд хэлүүлсэн шүү!” гэж шавийг нь мэхэлжээ. Энэ нь түүний би үзэл, багш нь “би”-д нь муу хандаж байна гэдгийг харуулж буй юм. Яагаад ийм байдаг вэ? гэвэл тэр амь хороодог хүмүүсийн сэтгэл маш хүйтэн бөгөөд амь хороосны дараа үйл түйтгэр нь маш хүнд гэдгийг мартчихдаг. Сэтгэл нь маш хүйтэн учраас сая тийм олон амийг хороожээ. Тэр хүмүүсийн бясалгал нь дэвшихэд маш хэцүү. Учир нь нэг зүйлийн хүйтэн уур амьсгал хажууд нь байж, харилцан таталддаг. Хэрвээ бид тун хүйтэн сэтгэлтэй бол халуун дулаан хайрын сэтгэлийг биед татаж чаддаггүй тул бясалгалын дэвшил тийм удаан байдаг. Тиймээс би: “Багшийнхаа хэлснийг нэгэн үзүүрт сэтгэлээр дагах, Багшийнхаа зааврыг нэгмөсөн хүлээн зөвшөөрөхөд тун бэрх.” гэж хэлдэг.

Багш нь юу ярина, түүнийг биелүүлдэг хүн маш ховор байдаг. Та нар гаднаа эргэлзэхгүй ч дотроо эргэлзэн: “Багш өдөр бүр ингэж ингэж ярих юм. Миний бодлоор зөв биш байхад мөн л надаар хийлгэдэг.” гэж боддог. Эсвэл: “Багш бол эмэгтэй хүн тэгээд нас залуу, мэргэжлийн хүн биш хойно тийм хэргийг яаж сайн ойлгох вэ?” гэж боддог. Та нарын ихэнх нь ингэж бодон сэтгэлдээ байнга эргэлздэг болохоор амархан дэвшдэггүй. Учир нь хүүхэд насандаа буцаж чаддаггүй. Хүүхэд шиг цэвэр цайлган болж чаддаггүй.

Библи сударт: “Бид хүүхэд шиг болбол сая диваажинд хүрч чадна.” гэж дурдсан. Лууз бас: “Бид хүүхэд насандаа буцвал сая бодь мөрийг олж чадна.” гэсэн. Хэлсэн нь адилгүй боловч санаа нь адилхан. Иймээс багш нь та нарт амь хороож болохгүй гэж хэлдэг. Хэвлий дэх хүүхдийг хороох тухай улсын хууль дүрэмд зөвшөөрсөн байлаа ч гэсэн тийм хэргийг хийж чаддаг хүн үнэхээр хар хортой. Хүйтэн сэтгэлтэн л хийж чадна. Бусад хүн бидэнд муугаар хандан биднийг шүүмжлэх буюу хорлох үед ихэд уурлаж, дэмий балайгаар түүнийг алдаг, эсвэл хорлодог. Энэ нь тухайн үед уурласнаас болоод өөрийгөө захирч чадаагүйгээс болжээ гэж хэлж болно. Гэтэл нэгэн сул дорой, ял гэмгүй хүүхдэд харин тэгж хүйтэн хандаж хөнөөх нь биднийг аврахын аргагүй болгоно. Дэндүү хүйтэн сэтгэлтэн гэдгийг илэрхийлж байгаа хэрэг. Ийм хүнийг хүн гэж хэлж болохгүй.

Иймээс Багш нь та нарт сахилаа заавал тодорхой сахих хэрэгтэй гэж хэлдэг. Бид өөрийн хүйтэн сэтгэлээ ойлгохын зэрэгцээ өөрийгөө хянан захирах хэрэгтэй. Хар сэтгэлийг туйлд нь хүргэх биш, бид хянан захирч болно. Хар сэтгэл байлаа ч гэсэн муу үйл үйлдэхгүй бол бидний соронзон талбай тийм хүйтэн болохгүй бөгөөд сэтгэлгүй, хүйтэн, саад бэрхшээл ихтэй,



саатуулах хүч ихтэй уур амьсгалыг татахгүй болно. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Бид ижил нь ижлээ харилцан татдаг ёсыг мэдэх хэрэгтэй. Хувийн чанар ижил бол харилцан таталцдаг.

Бид үйл түйтгэр үүтгэвэл харамсан гэмшингүүт арилчихна гэсэн үг биш. Учир нь бидний аливаа үйлдэл, үзэл бодол, сэтгэл хөдлөл, санаа сэтгэл бүгд соронзон талбайд наалдан бодол үүсгэмэгц буцаах аргагүй болж, хэзээ нэгэн өдөр тохиол эрж өргөжин хөгждөг. Иймээс бид шинэ үйл түйтгэр бүтээхгүй бол хамгаас сайн. Хуучин үйл түйтгэрийг Багш нь тусалж арилгаж болно. Шинэ үйл түйтгэр бүтээвэл та нар өөрсдөө төлөх хэрэгтэй болно. Учир нь нэгэнт мэдчихсэн байтлаа, дахин зориудаар үйлдсэн үйл түйтгэр нь урьдын харанхуй мунхгаас болж бүтээсэнтэй адилгүй байдаг. Иймээс сахилаа тодорхой сахиу хэрэгтэй. Бид ямар нэгэн төрөлтнийг хөнөөх буюу хэн нэгнийг хорлохыг хүсвэл энэ муу бодол хэзээ нэгэн өдөр буцан ирж биднийг хорлодог. Гэвч бид бас өөр аргаар алдаа буруугаа нөхөж, муу байдлыг сайжруулж болно. Жишээлбэл, өмнө нь бид амь хороосон бол одоо бусдад тусална. Эсвэл урьд нь хүүхдээ хайрлахгүй байсан бол одоо өрөөлийн хүүхдийг үрчлэн өсгөж болно. Ингэвэл урьдын алдаагаа жаахан нөхөж болно. Учир нь бидэнд гэмт сэтгэл бас л байсаар байгаа болохоор түүнийгээ бүрмөсөн арилтал гэмших боломжгүй. Хэчнээн харамсан гэмшсэн ч гэм буруут сэтгэл мөн л төрөх нь лавтай. Тэгээд соронзон талбайд наалдан түүнээс салахын аргагүй. Үүнийг үйл түйтгэр гэдэг. Тэр нь биднийг нас барах үед амгалан тайван явахын аргагүй болгодог. Учир нь бидний соронзон талбайд зохицсон ахуй орчныг татан авчирдаг болохоор зарим хүн тамд унаж, зарим хүн харин диваажинд очдог. Энэ бүхэн бол ижил чанар харилцан таталцдагаас болж байгаа юм.

Маш цагаан цайлган, эсвэл нинжин сэтгэлтний бясалгал нь яагаад тийм түргэн дэвшдэг вэ? гэвэл тэр (эвдрээгүй) хүн бол тийм ихээр маргадаггүй. Яаж маргахыг мэддэггүй. Тэр хүмүүсийн дэвшил нь маш түргэн, Багшдаа хүүхэд шиг бүрмөсөн итгэж, жаахан ч сэжиглэн харддаггүй. Бидний энд ийм хүн тун олон байдаг. Тиймээс дэвшил нь маш түргэн, гадна төрх нь энгийн байдаг ч Багшдаа хамгаас сайн, хамгаас итгэж, хамгаас хайрладаг. Багшдаа бүрмөсөн итгэж, дотроо сэжиглэдэггүй, гаднаа ч эсрэгцдэггүй. Та нар тийм хүмүүсийг харвал мэдчихнэ, дэвшил нь маш түргэн байдаг.

Зарим хүнийг гаднаас нь харахад тун ухаалаг бөгөөд Багшийгаа ч тун хүндэлдэг шиг боловч та түүнтэй жаахан

ярилцвал би гэх үзэл маш их, Багшдаа бүрмөсөн итгэдэггүйг мэдэх болно. Заримдаа тэр өөрөө ч ярьчихдаг. Та нар олон хүнтэй танилцахаар л сая хэн нь Багшийнхаа сургаал ёсыг жинхэнээр ойлгож, хэн нь Багшдаа үнэнхүү итгэдгийг мэдэх болно. Харин өнгөн талаас нь магадалж чадахгүй. Та нарын түргэн дэвших эсэх нь зөвхөн Багшдаа л бүрмөсөн найдах биш, бас Багшдаа яаж хандаж байгаагаас болдог. Багшдаа хэдий чинээ итгэнэ, хэдий чинээ хариу үйлдэлтэй байна, төдий чинээгээр дэвшдэг. Багш нь та нарт бясалгалд дэвших оньс хэлж өгье! Бусдад битгий яриарай! (Бүгдээрээ инээлдэн, алга ташив.)

Бидний бясалгал дэвших эсэх нь сэтгэл цагаан цайлган байх эсэхээс хамаардаг. Заримдаа цэвэр цайлган байх тун дуртай хэдий ч тийм байж чаддаггүй. Энэ нь бүгд л урьд нь тийм хүйтэн цэвдэг үйл түйтгэр бүтээснээс болж байгаа юм. Иймээс одоо энд ирэхдээ энэ хүйтэн хананд хашигдаад Багшдаа бүрмөсөн итгэж чадахгүй. Бие, хэл, сэтгэлээ бүрэн зориулж чадахгүй байдаг. Зарим хүн тун шаргуу бясалган, харахад тун чармайлттай, өдөр бүр дөрөв, таван цагаар бясалгаж суудаг ч мөн л энэ ертөнцөд хоргодон нэр ашгийг боддог тул тийм хүмүүс дэвшдэггүй бөгөөд дахин нэг удаа төрөл авах ч боломжтой. Учир нь мөн л энэ ертөнцийг бодож, энд хоцрохыг хүсдэг. Тийм хүмүүсийг Багш нь дахин нэг удаа ирэхээр зохицуулна, тэгээд өөр нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж байж л сая дэвшиж чадна. Эндхийн зарим авшигтан урьд төрөлдөө нэгэнт Арьяабалын бясалгалын аргаар бясалгачихсан байдаг. Гэвч бясалгалын дундаас ертөнцөд хоргодох буюу чин сэтгэлээр хангалтгүй, Багшийгаа сэжиглэснээс болоод дахин ирэх хэрэгтэй болжээ.

Энэ нь Багшийнх нь ярьсан үлгэртэй адил, нэг хүн нэг хуудас захидал бичээд Багшид нь өглөө. Тэр хэлэхдээ авшиг аваад харьсны дараа өдөр бүр чин сэтгэлээр Багшдаа даатгаж, Багшийн алдрыг уншин Багшдаа үнэнхүү итгэсэн байна. Тэгээд хоёрхон сар болсон төдий, маш түргэн дэвшин бясалгаж суухдаа хамгийн гэрэл гялбаатай оронд хүрч чаддаг болов. Үүний эцэст харин сэжиглэх бодол төржээ. Учир нь тэр урьдах багшийнхаа аргын сахиус, билгийн сахиус нь биеэсээ гарвал ад шүглэнэ гэж ярьсныг санаснаас багшийнхаа сургаал ёс, бясалгах арга нь буруу гэж бодох болов. Эцэстээ дэс нь дорхноо доошлон тэр өдрөөс эхлэн одоо болтол мөн л дээш гарч чадахгүй болжээ. Үүнээс адын саад биднийг ихэд саатуулдгийг мэдэж болно.

Зарим хүн дэндүү ихийг мэдэж, дэндүү олон бясалгалын аргад суралцвал бас дэвшихийн аргагүй болдог. Мэдлэг болон

билиг ухаан хоёр ер адилгүй, хэдий чинээ их мэдлэгтэй болбол билиг ухаанаар төдий чинээ бага байдаг. Иймээс хөдөөгийн бядуу цагаан цайлган хүний бясалгал нь нэлээд түргэн дэвшдэг. Гэвч дэвшсэний дараа бас хичээх хэрэгтэй. Битгий дахин саатуул, мөн бардамнаж болохгүй, бусдад ярьж бүр ч болохгүй. Яривал тэд таныг маш сүрхий гэж үзнэ. Ингэснээр танд төвөг бэрхшээл их болж, дэс чинь дорхноо доошлох болно. Ийм туршлагатай хүн байна уу? Лавтай байгаа, иймээс ахуй ойлголтоо ярихыг Багш нь тийм ч их зөвшөөрдөггүй. Учир нь яривал амархан бардамнаж, бүгдээрээ бишрэн магсаны дараа өөрийгөө тун сүрхийд үзэн бусдад тийм сайн ахуй ойлголт байхгүй гэж боддог. Тэгвэл маш яршигтай болно.

Багшийн хүчинд бүрмөсөн эрхшээгдэж, Багшдаа бүрмөсөн итгэвэл маш түргэн дэвшдэг. Энд тийм хүмүүс байна уу? Байвал тун азтай, бясалгал чинь маш түргэн дэвших болно. Зарим хүн Багштайгаа байнга уулздаг бөгөөд ном тайлахыг сонсохоор ирдэг. Хагас сайн, бүтэн сайн өдөр болгон бясалгалын газарт майхан босгож суудаг. Гэвч тэр хүмүүс Багшдаа жинхэнээр итгэдэггүй ч байж мэднэ. Итгэхгүй бол эвгүй гэж боддог байж ч мэднэ. Жишээлбэл, Багштай уулзахаар очихгүй бол эвгүй санагдаж, гэртээ байвал бас тун уйтгартай, эр нөхөр, эсвэл эхнэр маань эзгүй, ганцаар суух нь дэндүү уйтгартай гэж боддог тул даруй очдог.

Гэвч энэ нь бас ач тустай. Энд ирээд хэдэн үг сонсвол мөн л гэгээрч, алгуураар бусдынхаа нөлөөнд автах болно. Иймээс сая нийтийн бясалгал нь маш ач тустай гэдэг. Ганцаар бясалгахад тун бэрх, заримдаа урам хугардаг. Гэгээнтэн, найз нөхөд, авшигантай хамт байхгүй бол заримдаа яагаад ахуй ойлголт байхгүй байна вэ?, яагаад дэвшихгүй байна вэ? гэж боддог. Учир нь үйл түйтгэр нь маш хүнд гэдгээ мэддэггүй.

Эрт дээр үеийн Төгс Гэгээрсэн Их Багш бол тийм олон хүнийг илээр сургадаггүй. Учир нь харж хандах цаг зав байхгүйгээс эмээдэг. Одоогийн хүмүүс Багшийнхаа дуутай хуурцгийг тийм олон сонсож, бичлэгийг тийм олон хардаг хэдий ч Багшдаа итгэхэд тийм хялбар биш байгаа юм чинь урьдын хүмүүсийг хэлэх хэрэг юун билээ! Төгс Гэгээрсэн Их Багштай ганц хоёрхон удаа уулзаж, ном тайлахыг нь хоёр гуравхан удаа л сонсдог тул түүний ярьсныг тийм их шингээн авч чаддаггүй. Бичиж тэмдэглэлээ ч гэсэн эмх замбараагүй, заримдаа өөрөө ч ойлгохгүй, үсэг нь ч буруу ташаа, харьсны дараа хайнга уншиж, итгэл зоригоо эрчилдэггүй.

Иймээс Шагжамуни Бурхан урьд нь илээр ном уламжлах

үед таван мянган хүн номын талбайг орхин явсан байдаг. Учир нь хамгийн дээд номын цогцосыг тайлж байгаа гэдэгт итгээгүй. Бид бүгдийг ойлгочихсон, дахин суралцмаар хамгийн дээд номын цогцос байхгүй гэж тэд бодсон хэрэг. Тэр хүмүүс бол эрт дээр үеийн гэлэн, гэлэнмаа нар билээ. Харин гэртээ сууж бясалгадаг хүмүүс биш.

Иймээс аль ч цаг үед бүгд адилхан байдгийг мэдэж болно. Үнэн ёсыг ойлгоход тун бэрх. Учир нь уламжлалт зан заншил нь биднийг дэндүү чанга хүлж, хар багаасаа хэдэн арван жилээр ийм байдалд дадчихсан тул одоо Их Багштай уулзсан ч тийм амархан итгэдэггүй. Тиймээс та нар Багшаасаа салж яваагүй нь миний санаанаас гадуур болчихсон байна. Гэхдээ гүтгэхгүй байх нь нэлээд сайн болжээ. Ухамсаргүйгээр эр нөхөр буюу гэргийгээ дагаж ирээд авшиг авсан байлаа ч бас нэлээд сайн болов. Алгуураар илүүхэн бясалгавал сая ойлгож чадна. Тэгээд нас барах үед үр дүнтэй болж мэднэ. Одоо өдөр бүр жаахан усалж, заримдаа салхи, бороонд цохиулна. Заримдаа наранд шарагдана, заримдаа ундаалж, заримдаа гандуулж хайнга байдаг ч мөн л өсөж томордог. Миний ярьсан санаа бол нас барах үедээ ухаан суучихдаг гэсэн үг. Тэгээд тэр үед сая жаахан ухаарч сэхээрч ч мэднэ, ойлгож байна уу? Гэхдээ одооноос эхлэн өдөр бүр бага зэрэг бэлтгэл хийх хэрэгтэй, тэгэхгүй бол дээш гарч чадахгүй.

Та нар авшиг авахаас өмнө Багшийгаа ганц, хоёр удаа л харсан. Зарим хүн ганцхан удаа ном сонсоод дорхноо авшиг авдаг. Зарим нь ганцхан боть ном уншиж, зарим нь дууны хуурцгийг ганц удаа сонсож, бас зарим нь нэг лекц уншаад авшиг авдаг. Жишээлбэл, манай нэгэн гэрээс гарагчийн садан нь лекцийн эмхэтгэлийг түүнд уншуулсанд тэр “Авид Бурханы магтаалын жинхэнэ утга учир”-ыг уншиж дуусаад авшиг авсан. Урьд нь, Багшид нь дууны хуурцаг, бичлэг гэмээр юм байгаагүй бөгөөд ном ч хэвлээгүй, зөвхөн ганц, хоёрхон лекцийн эмхэтгэл л байв.

Бас нэгэн авшигтан бусдаас Багшийн тухай танилцуулгын хэдхэн үг л сонсоод даруй авшиг авав. Тайвань даяар номын багш тийм их байхад харин зөвхөн Багшийг нь сонгожээ. Тэр бас нэлээд олон газраар явсан, номын багш нарыг бүгдийг нь таньдаг. Урьд нь хамт ажиллаж байсан хүн нь түүнд ёс суртахууны тухай илүүхэн сургахын тулд байнга дагуулж номын багш нартай уулзуулдаг байжээ. Гэтэл тэр алианаас нь ч сураагүй, харьсныхаа дараа сэтгэл дундуур байжээ. Гэтэл Багшийг нь харсны дараа гэргийдээ: “Би нэгэнт хайгаад олчихжээ.” гэсэн байна. Гэргий нь сонсмогцоо: “Та хайж олчихсон байтлаа яагаад намайг дагуулж

очихгүй байна вэ?” гэж загнасан гэнэ. Тэр хоёр үнэхээр зугаатай, Багштайгаа учрахын төлөө л төрөл авсан юм шиг. Тиймээс Багштайгаа уулзсанаас хойш одоо болтол ер салдаггүй, итгэл найдлага нь огтхон ч гуйвдаггүй, зарим хүнийг Багшаасаа салж явахыг хардаг ч өөрсдөө дуурайдаггүй. Тухайн үед Багшид нь лекцийн товхимол гэмээр зүйл ч байсангүй. Тэр Багшийн чинь ном тайлахыг ганцхан удаа сонссон бөгөөд ном тайлж дуустал инээгээд л байсан. Үүнийг нь би хараад энэ хүн яагаад инээгээд байгаа юм бол гэж бодсон. Сүрхий их баярласан байдалтай, тэгээд харьсныхаа дараа гэргийгээ дагуулж ирээд Багшаас нь авшиг авахуулсан.

Зарим хүний хувь барилдлага маш гүн байдаг тул сая Багшийгаа тэгж удтал дагаж, тэгж гүн итгэж чаддаг. Бусад хүн хэдийгээр тун олон ном уншиж, их олон дууны бичлэг сонссон ч Багшийн сургаал ёсыг үнэндээ ойлгодоггүй. Үүнээс зэрэг дэсийн ялгаа зөрүү байдгийг ойлгож болно. Та нар ном сонсохоор очвол тэр дорхноо мэдчихнэ. Багш нь тийм тодорхой ярьсан байхад зарим нь хамгийн эцэст мөн л адилхан асуулт асуудаг. Тэр ч байтугай бусадтай яаж дайтах, католик шашнаас яаж өс хонзон нэхэх тухай Багшдаа заадаг. Энэ нь мөр ёсыг хайх сэтгэл байвал сая Багшийн сургаал ёсыг ойлгож чадна. Үгүй бол тийм ч амархан ойлгож чадахгүй гэдгийг илтгэж буй. Багш нь ном тайлах үед та нар тэнд суугаад маш тодорхой сонсдог хэдий ч зарим хүн ер ойлгодоггүй, Яг л дүлий хүн шиг, тэр ч байтугай та нарт ч гэсэн ийм байдал үүсдэг. Тэгээд харьсныхаа дараа дууны хуурцгийг дахин сонсох үед гэнэт ойлгочихдог. Тийм үү, үгүй юү?

Одоогийн цаг үе тун сайн. Багшийнх нь ном тайлсан дуун хуурцаг их байна. Бид алгуураар дахин нэг удаа сонсож болно. Өнөөдөр хэрвээ Багш нь дэндүү түргэн ярьсан, эсвэл Багшийнхаа нүд рүү хараад согтууран юу ч сонсоогүй бол харьсныхаа дараа дахин нэг удаа сонсож болно. Бид хүүхэд шиг цагаан цайлган, шуудхан хүлээн авч байх хэрэгтэй. Ингэж бясалгавал маш түргэн дэвшиж чадна. Үгүй бол Багш нь бас та нарыг шамдуулахын аргагүй. Зөвхөн хажууд чинь зогсоод хүлээх л хэрэг. Гэхдээ та нар Багшдаа итгэхгүй буюу тэгж чин сэтгэлээсээ гэмшихийн аргагүй байлаа ч гэсэн боломжийнхоо хэрээр, бүх хүч чадлаа шавхан байж бясалгалаа хийвэл аяндаа үр бүтээмжтэй болно. Яг л Мял богд шиг, тийм зөрүүд, тийм хар сэтгэлтэй байсан ч долоон жилийн дараа бас үр бүтээмжтэй болов. Бид түүнээс жаахан удаан, ихдээ арван жил байж мэднэ. Ингэж өөрийн биедээ цаг тогтоож болно. Алгуурхнаар бясалгаж хорин жил болсон ч яахав.

Үүрд үр дүнгүйгээс илүү дээр, тийм биш үү?

Зарим хүний дэвшил нь удаан, зарим хүний дэвшил нь түргэн байдаг хэдий ч бид боломжийнхоо хэрээр бясалгалаа хийх хэрэгтэй. Нэгэнт Багшдаа шавилчихсан юм чинь цаашид үргэлжлүүл. Ондoo бясалгалын арга хайсан ч мөн л ингэх хэрэгтэй. Хичээнгүйлэн бясалгахгүй бол дахиад хүн болж төрөөд Авид Бурханыг дурсах нь бас л тун яршигтай. Өглөө, оройн уншлага нь бас тийм сүрхий биш. Өглөө, орой ном унших шаардлагатай бол бас уншиж болно. Гэхдээ уншиж дууссаны дараа бясалгаж суух хэрэгтэй. Эсвэл модон бурханд мөргөх хэрэгтэй бол бас болно. Гэвч мөргөж дууссаны дараа бясалгаж суух хэрэгтэй.

Гэхдээ хамгаас сайн нь тийм зүйлийн хэлбэрдлээс салах явдал. Учир нь бид их сургуульд сурвал бага сургуульд сэтгэл татагдаж болохгүй. Багш чинь ийм зүйлсийг хэрэггүй гэсэн биш. Тэр нь нярай хүүхдэд тун хэрэгтэй. Жишээлбэл, угж нь бяцхан хүүхэд болон нялх хүүхдэд хэрэгтэй, харин хэрэгцээгүй гэж хэлж болохгүй. Хэрэгцээгүй гэдэг нь том хүний хувьд тийм. Ном уншиж, бурханд мөргөх шаардлагагүй юм бол тэгдэг хүмүүс яагаад тийм олон байдаг вэ? Хэрвээ угж хэрэггүй юм бол хүүхэд ихэд уйлаад байвал угж хөхүүлмэгц яагаад уйлахаа больдог вэ? Энэ нь тэдний хувьд эрхбиш шаардлагатай зүйл болохыг харуулж байна. Бид том болчихсон тул угж хэрэглэхгүй байх нь зохилтой биз дээ. Том болчихсон байтал бас л угжаа хөхсөөр байвал тун муухай, ойлгож байна уу?

Иймээс Багш нь сая та нарыг битгий модон бурханд мөргө, өнгөн талын хэлбэрдлээс хэдий чинээ түргэн салбал төдий чинээ түргэн дэвшинэ гэж хэлдэг. Үнэхээр огоорч чадахгүй бол бурханд мөргөхийн зэрэгцээ бясалгаж сууж болно. Гэвч хамаг байдаг цагаа бурханд мөргөж өнгөрөөгөөд бясалгаж суухгүй байж болохгүй. Тэгэх нь биднийг маш ихээр саатуулж, дээш гарч чадахгүй болгоно. Хүмүүс их сургуулиа төгсчихсөн байхад бид мөн л бага сургуульдаа сууж байх болно. Одоо их сургуульд орчихсон юм чинь их сургуулийн хичээлийг суралцаж, бага сургуульдаа хоргодож болохгүй.

Асуулт байна уу? Байхгүй бол хурдхан бясалгаж суу! Бидэнд хэрвээ асуудал тулгарвал илүүхэн бясалгаж суудаг л бол хариултыг нь үтэр түргэн өөрөө олчихно. Энэ бол хамгийн сайн хариулт мөн. Багшийн чинь ном хэдийгээр ганц, хоёрхон дэвтэр төдий ч олон удаа унших хэрэгтэй. Учир нь цаадах жинхэнэ утгыг нь бас бүрэн ойлгодоггүй, олон удаа уншвал ойлгоно. Дахин уншвал улам ойлгож, шинэ зүйлсийг улам их мэдэх болно.



## **ТӨВӨДИЙН НУУЦ БЯСАЛГАЛ, ХУВЦАС ХАТААХ НОМЫН ЁС**

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Миаоли Шихү бясалгалын төв  
1988 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Урьд нь Төвөдөд нэг бясалгагч байв. Гэхдээ хатуу аргаар бясалгадаг. Төвөдөд биеийн дулаанаараа нойтон даавууг хатаадаг нэг зүйлийн бясалгалын арга байдаг. Нойтон даавууг биедээ нөмөрвөл өөрөө хатчихдаг. Тэд наран сүлжээгээ бясалгаж, илчээр нь бүх биеэ дулаацуулдаг. Тэд ийм аргаар бясалган амжилтад хүрсний дараа тэсгим хүйтэн оронд амьдран их цас орсон ч зузаан хувцас өмсөх шаардлагагүй байдаг. Маш олон йогийн бясалгалтан хахир хүйтэн Хималай ууланд зөвхөн дотуур өмд хэмээгч нэг хэсэг жижигхэн даавуугаар нууц хэсгээ ороогоод цасан дээр хөл нүцгэн явж байхыг Багш нь нүдээрээ харсан. Гэхдээ бүх бие нь ув улаан, хүдэр чийрэг, үзэсгэлэнтэй харагдана. Энгийн хүн тэнд очвол маш зузаан арьсан хувцас буюу цасны нөмрөг мэтийн зузаан хувцас өмсөж, бүх биеэ ороовол сая тэсэж чадна. Гэтэл тэдгээр йогийн бясалгалтан харин нүцгэн чигээрээ хаа сайгүй явж байдаг. Тийм хүмүүс Энэтхэг болон Төвөдөд бий.

Урьд нэг Төвөд хүн ийм бясалгалын аргаар бясалгаад амжилтад хүрч, Төвөдөд тэргүүлжээ. Тэд ердөө хэсэгхэн хугацаагаар бясалгасны дараа уралдаан явуулдаг. Тэгээд хахир хүйтэн нэг оройг сонгон, шалгуулагсдаа голын хөвөөнд дагуулж очно. Голын ус нь хөлдчихсөн байдаг. Тэд даавуу, алчуур, эсвэл нимгэн даавууг мөстэй усанд дэвтээгээд нойтон даавуу буюу



алчуураар шалгуулагсдын биеийг ороодог. Тэд биеийнхээ илчээр тэр хэсэг даавууг хатаана. Өнөөх даавуу хатсаны дараа тэр даруй дахин өөр нэг мөстэй даавуугаар биеийг нь ороодог. Уралдагч хувцасгүй нүцгэн, тэгээд мөстэй усанд дэвтээсэн даавуугаар биеийг нь орооно. Хатсаны дараа дахиад л орооно. Ингэж шөнөжин үүр хаяартал хатааж, хамгаас олон даавуу хатаасан нэг нь тэргүүлдэг.

Багшийнх нь ярьж байгаа энэ түүхэнд гарч байгаа хүн бол тухайн үед уралдаанд тэргүүлсэн хүн юм. Энэ бол ойрхны хэрэг бус, бараг зуун жилийн өмнөх явдал билээ. Одоо ч гэсэн ийм аргаар бясалгаж байгаа хүн байдаг. Тэр Төвөдөд очиж, ийм бясалгалын аргыг олон газрын хүмүүст сургасан буюу бусадтай хувцас хатааж уралдан тун ихэд нэр алдаршжээ. Нэг өдөр нэгэн хүн түүнээс тун гүн утгатай асуулт асуужээ. Жишээлбэл: “Бурхан чанар хаана байдаг юм бэ?”, “Та хэн бэ?”, “Бодьдармаа яагаад Дундад улсад ирсэн бэ?” гэхчилэн асуусан ч байж мэднэ. Тэгэхэд тэр үл ойлгон өөрийгөө тун бядуу хэмээн бодож, хувцас хатаах эрдэм тийм ч сүрхий биш юм байна гэж боджээ. “Би хэн бэ?” гэдгээ ч мэддэггүй болохоор баахан бодоод мэргэжлээ солихоор шийдэж, дахин хувцас хатаахаа больж, Төгс Гэгээрсэн Их Багшийг хайжээ. Тэгээд олон газраар хайсны эцэст зарим нь ид шид сургаж, зарим нь огторгуйгаар нисэхийг зааж, бас зарим нь дүрэлзэн ноцох гал дээгүүр алхахыг сургасан байна. Гэхдээ тэр энэ бүх зүйлд сэтгэл дундуур явжээ. Зарим газарт ерэн доллар төлбөл ийм шидийг сурч чадна. Маш түргэн, зургаан цагийн дотор бүгдийг сайхан сурчихна. Би Америкт байхдаа бас сурах хүсэл төрсөн. (Бүгд инээлдэв.) Тэгээд сурсны дараа гал дээгүүр алхан: “Аяа! Би ид шидтэй шүү.” хэмээн Тайваньчуудад гайхуулахыг бодов. Гэвч хожим нь бодож үзээд сураагүй, ерэн доллар дэндүү үнэтэй санагдаад бас галын дундуур алхана, за больё гэлээ. Ойлгож байна уу? Гал дээгүүр алхах хэрэг юу билээ? Нээрээ инээдтэй, энэ бол хүүхдийн тоглоом.

Өнөө бясалгагч олон газраар явж салхи дуудаж, бороо урих гэх мэтийн эмх замбараагүй номын цогцосыг ихээр сурсан боловч тун уйтгартай санагджээ. Учир нь “Би хэн бэ” гэдгээ ч мэддэггүй, өдөр бүр Төгс Гэгээрсэн Их Багшийг хайлаа ч олж чадсангүй. Нэгэн өдөр тэр нэг хэсэг чулуун дээр сууж тун бухимдан: Төгс Гэгээрсэн Их Багшийг эрж олохгүй бол нээрээ зовууртай юм байна. Тэгэхийн оронд үхэх нь илүү дээр, өөрийгөө хэн болохыг хэдэн жилээр биеэсээ асуулаа ч ямар ч хариулт олоогүй нь үнэхээр гаслантай гэж бодон сууж байжээ. Юуны төлөө энэ дэлхийд

ирэв? Нас барсны дараа хаана очих вэ? гэдгийг удтал бодон, тэр ч байтугай амиа хорлох хэмжээнд хүрч гэнэ. Тэгээд яг голын хөвөөнд байсан тул гол руу шуудхан үсэрчихжээ.

Голын ус бургилан буцлах шиг догшин байсан ч тэр живэлгүй, харин маш хол голын эргийн элсэн дээр түлхэгдэн гарчээ. Гэхдээ ухаан алдаад хэвтэж байгаа байдал нь яг л хүн түүнийг голын хөвөөнд хаяснаас биш, харин голд урсгахгүй гэсэн шиг байв. Үнэндээ тиймгүй, голын ус түүнийг урсгасан. Хэсэг хугацаа өнгөрөөд тэр ухаан сэргэжээ. Тэгэхэд нэг хүн хажууд нь гал түлэн дулаацуулж байсан бөгөөд хувцас өмсгөсөн байжээ. Тэр би хувцас өмсөх дургүй байна гэв. Учир нь тэр хувцас хатааж уралдаад түрүүлсэн тул хувцас өмсөхгүй ч гэсэн даардаггүй байжээ. Дараа нь түүнийг аварсан бяцхан лам түүнийг дагуулж багштайгаа уулзуулав. Багш нь түүний нэр усыг ч асуугаагүй, зөвхөн: “За! мэдлээ, энд таныг хүлээгээд нэлээд удлаа. Та Төгс Гэгээрсэн Их Багшийг эрье гэж бодож байсан билүү?” гэсэнд тэр: “Та яаж мэдсэн юм бэ?” гэв. Тэгэхэд тэр багш: “Би бүгдийг мэднэ.” гэжээ.

Тэгээд өнөө хүнийг тулганы хажууд суулгаад өдөр бүр юу ч хийж болохгүй гэж захив. Ингэж гурван хоног суухаар тэр тэвчиж чадалгүй: “Би өвчтөн биш, бас зэрэмдэг ч биш, хувцас хатаах манлайлагч. Тулгын гал надад хэрэггүй.” гэв. Тэгэхэд тэр Багш: “Энд ажил гэмээр зүйл байхгүй, хувцас хатаах ч шаардлагагүй. Та тэнд тайван сууж амрахаас өөр юм хийх шаардлагагүй.” гэв.

Энэ багштай дөнгөж уулзсан, хэрүүл маргаан үүсгэх нь эвгүй болохоор хүлцэнгүй суух л хэрэгтэй болов. Тэгээд өдөр бүр тэндээ суун тав хоносны дараа дахин: “Багш аа! Би ажил хийхийг тун их хүсэж байна. Бусдад туслах хэрэгтэй, үгүй бол хэрэгцээгүй хүн болчихгүй юу?” гэв. Угаас нэгэн хэрэгцээтэй хүн байсныг тэнд очсоны дараа багш нь хэрэгцээгүй хүн шиг болгожээ. Тэр: “Надад гал хэрэггүй, урьд нь би хувцас хатааж манлайлсныг та бараг мэдэхгүй байж мэднэ.” гэж багшдаа ярьсанд: “Мэднэ, мэднэ.” гэж хариулжээ. Тэр хүн дахин: “Би энэ номын цогцосыг гурван жил гаруй бясалгасан, энгийн үед хувцас ч өмсдөггүй, өдөр бүр гадаа цасан дээр суудаг. Гурван жил гаруй ийм байсан тул гал надад хэрэггүй.” гэв. Тэгэхэд тэр Багш толгойгоо сэжин бяцхан ламд: энэ хүнийг тулгын хажууд аваач, гурван жилийн турш цас мөсөнд даарсан болохоор одоо бушуухан галд дулаацуул.” гэжээ. Өнөөх Багш түүний ярьсныг сайн ойлгосонгүй шиг, шавиараа галын дэргэд түүнийг хүргүүлэв. Тэр өдөр бүр Багшдаа тусалж, ус дамнах буюу бяцхан бандид тусалж мод тайрах, хоол хийхийг

гуйсанд Багш нь эс зөвшөөрч, шавь ламдаа: “Та найзыг маань өдөр бүр галын дэргэд суулган юу ч хийлгэж болохгүй. Хоолыг нь ч гэсэн хүргэж өг. Бие засахаас бусад цагт огт хөдөлгөж болохгүй. Хаашаа ч явуулж болохгүй. Ямар ч ажил хийлгүүлж болохгүй, хэрвээ үгэнд орохгүй бол эндээс зайлсан нь дээр гэж хэлээрэй!” гэж захив.

Энэ бол Багшийнх нь шийдвэр болохоор аргагүй эрхэнд өдөр бүр тэнд сууж, судар ном ч уншиж болохгүй, ажил хийж ч болохгүй. Байтлаа бүр хувцас хатаах номын ёсоо ч ашиглах аргагүй болов. Энд түүнийг сайшаан магтах хүнгүйн дээр харин галын дэргэд суулгав. Энэ нь түүний чадварыг бүрмөсөн зогсоов. Үнэндээ энд урьдахтайгаа адил байж чадна. Ядаж хувцас хатаах чадвараа хэрэглэх буюу гадаа гарч мод тайрах, эсвэл өөр ажил хийж болно гэж бодож байв. Тэр өөрийгөө тун хэрэгцээтэй гэж бодсон чинь харин ямар ч хэрэгцээгүй нэгэн болчихов.

Та нар сонсоод өнөөх багшийг солиорчихсон юм биш үү гэх байх. (Үгүй гэж бүгдээр хариулав.) Тэгвэл тэр чухам яаж байгаа нь энэ билээ? Яагаад ийм сонин зан гаргадаг байна вэ? гэвэл түүний би гэх үзлийг нь арилгахын төлөө байжээ. Тэр угаас бусдад туслахыг тун сүрхийд үздэг тул дандаа бусдад тусалж, өөрийгөө асар их хүч чадалтай, явдал хэргийг тун сайхан шийдвэрлэдэг гэдгээ мэдүүлэх гэсэн байна. Гэтэл өнөө Төгс Гэгээрсэн Их Багшийнд очсонд харин хэрэггүй хүн болов.

Тэр энд ирэхээс өмнө хийд барьсан бөгөөд Багш нь ч байсан. Идэх хоолтой, өмсөх хувцастай, хийх ажилтай, тэр жаахан ч туслах шаардлагагүй байсан. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Тэр бусдад тусалж, өөрийгөө тун ажилсаг гэж үздэг. Биеийнхээ илчээр хувцас хатааж, гурван жил дараалан манлайлсан тул хүмүүс түүнийг аугаа их гэж биширдэг бөгөөд өөрөө ч тэгж боддог. Гэтэл Багшийндаа очсон чинь харин бүрмөсөн ондоо болж, түүнийг зөвхөн галын дэргэд дулаан суулгах болжээ.

Тэр Багштайгаа анх уулзахдаа: “Надад бясалгалын арга сургах болов уу? Учир нь намайг шоолдог хүмүүс их байна. Урьд нь нэг шашны бүлгэмийнхэн надаас зөндөө олон асуулт асуухад нь би хариулж чадаагүй болохоор бусад шашны бүлгэмд хүрч хариултаа хайлаа. Тэгэхэд тэд намайг яасан бядуу юм бэ гэж шоолсон. Одоо та надад бушуухан номын цогцос сурга, тэднээс өс хонзонгоо авахыг хүсэж байна.” гэсэнд Багш нь зөвшөөрсөнгүй. Ингэж галын дэргэд гурван жил суусны дараа Багш нь: “За, одоо та юу хийсэн ч болно.” гэжээ. Гэтэл тэр өшөө авна гэлгүй, зөвхөн түүнд ном уламжилж, хэн болохыг нь таниулахыг гуйжээ.

Тэр тун даруу болж, дэлхий дахин угаас амгалан, өөрийнх нь хэрэг онц шаардлагатай зүйл ч алга. Хувцас хатаах чадвар угаас хэрэгцээгүй, хүдэр бадриун бие болон ажилсаг зан нь ч тийм сүрхий зүйл биш бөгөөд үүнийг хэрэгсэх хүнгүй юм байна гэдгийг ч ойлгожээ. Тэр галын дэргэд гурван жил гаруй суусны эцэст ухааран сэхээрчээ. Учир нь дэлхий ертөнц мөхөж сөнөөгүй хэвээр, хэн ч түүгээр дутаагүй, санаж дурссан хүн ч байхгүй бөгөөд дэлхий ертөнц юугаар ч дутаагүйг ойлгосон болохоор сая жаахан гэгээрчээ.

Түүний хүслийн хариуд Багш нь: “Би танд ном уламжилж чадахгүй, учир нь таны хүсэж буй номын цогцос зөвхөн миний номын ахад л байдаг.” гэжээ. Тиймээс Багш нь түүнд мөнгө төгрөг, хувцас хунар мэтийг өгч, шавь ламаараа өөр нэг хийдэд хүргүүлжээ. Тэр тэнд очсоны дараа маш шаргуугаар олон жил суралцаад амжилтад хүрчээ. Тэр биеэ далдалж чаддаг. Маш олон үйл хэргийг хувируулж чаддаг бөгөөд өөрийгөө хэн болохоо ойлгожээ. Түүний билиг нээгдэв. Нэгэн өдөр тэр бие далдалж өөр нэгэн газар хүрч, урьдын өшөөтнөө харав. Түүнийг шоолсон тэр хүмүүсийг огторгуйгаас ажихад үнэхээр өрөвдмөөр, мөн л урьдахтайгаа адил бядуу тэнэг хэвээр аж. Хэдийгээр жаахан шидтэй, жаахан сэргэлэн ухаантай хэдий ч тийм сүрхий биш тул шүүрс алдан нисэн буцжээ. Ихэнх хүн бүгд л ийм, сургахад тун төвөгтэй. Гэхдээ энэ дэлхий мөнх бус болохоор Багш чинь шавиа тэгж удтал хүлээлгэж түвдэхгүй. Хэдэн жилээр хүлээн байж л сая түүнд ном уламжлахад хүрвэл маргааш нь нас барчихвал яах вэ? Ойлгож байна уу?

Арьяабалын номын цогцосыг бясалгавал би гэх үзэл байлаа ч бас аюулгүй. Зөвхөн Багш нь жаахан ядардаг. Гэвч шавь нарын хувьд тун баталгаатай. Энэ дотоодын аялгуу байдаг л юм бол лавтай туулан гэтэлж чадна. Багшийн хамгаалах хүч байвал амьдрал чинь тийм аюултай болохгүй. Хэдийгээр би гэх үзэл байлаа ч алгуур бясалгаж болно. Зөвхөн жаахан ядрах бөгөөд олон эндүүрэл үүснэ. Эгэл хүмүүс бусдыг амархан буруугаар ойлгож, толгой тархиараа магадлах нь амархан эндүүрэл үүсгэдэг. Тиймээс бусдыг ойлгоход тун хэцүү. Багшийгаа ойлгохыг бүр ч ярих юм биш. Жишээлбэл, өчигдөр Багш нь та нартай ярилцахдаа юу хийдэг вэ? Ямар мэргэжлээр ажилладаг вэ? гэхчилэн асуусан. Бид аятайхан ярилцаж, Багш нь ч та нарт: “Би хожим дүүфүүний худалдаа эрхэлж байж ч магад. Бидний амьдрал энгийн, мөнгө төгрөг багатай ч амьдраад дөнгөчихнө.” гэсэн.

Багш маань ажил мэргэжлийн тухай ярьж яах гэсэн юм бол

гэж та нар боддог. Гэвч Багш нь ярьж дуусаад удаагүй байхад нэг шавь жижигхэн хуудас захидал дамжуулан, бусдад мэхлэгдэн, мөнгөө алдаж, оюун санаа нь сүйрэх дөхсөн болохоор Багш та сэтгэлийг минь тэгшлэхийг хүсэж байна гэж бичсэн байв. Багш нь сая та нартай ингэж ярилцаж байгаа нь бүгд л тэр хуудас захидлын төлөө ярьсан хэрэг билээ. Үнэндээ тэр хуудас захидлыг Багшдаа дахин уншуулах шаардлагагүй. Багш нь тэр захидлаас өмнө аль хэдийн ярьчихсан. Тэр чухамдаа ойлговол зохино. Багш нь шөнөжин ажил мэргэжлийн тухай ярьсан нь бүгд л оюун санаа нь сүйрэх шахсан тэр хүний төлөө ярьсан хэрэг.

Тэр бусдад мэхлэгдсэнээс арилжаа нь муудаж, мөнгөө дуусгажээ. Тэр захидлаа дамжуулахаас өмнө Багш нь нэгэнт: “Мөнгөгүй ч хамаагүй, ажлаа сольж болно. Нүүрээ барахаас битгий ай. Бид дүүфүүний худалдаа, бараа худалдаа гэх мэтийг хийн амьдарч болно. Гэхдээ хэр их мөнгөтэй болох талд хүлэгдэхгүй байвал зохино.” гэж хэлсэн. Манай Багш заримдаа бидэнтэй тун энгийн, эсвэл огт хэрэггүй зүйлийг ярилцдаг гэж та нар битгий бодоорой. Үнэндээ бүгд хэрэгтэй. Зарим хүнд тэр үе тун шаардлагатай байдаг. Тэр үе түүнд маш шаардлагатай бөгөөд сонсох дуртай. Та нар ч гэсэн заримдаа бас ийм байдаг. Жишээлбэл, Багш нь ганц хоёр түүх буюу бусад асуудлыг ярихад сонсогчид тийм сайн ойлгодоггүй. Зөвхөн та л маш тодорхой ойлгож, Багш маань зөвхөн миний төлөө ярьсан байна гэж хэлнэ. Учир нь та өнөөдөр яг үүнийг асууя гэж байсан хэрэг. Та нарт ийм туршлага байна уу? (Бүгдээр тийм гэж хариулав.)

Иймээс Багшийнх нь ярьсан бүхэн бүгд хэрэгтэй. Тэр өдөр танд шаардлагагүй байж магад ч хөршид чинь буюу ихэнх хүнд шаардлагатай байдаг. Заримдаа Багш нь шөнөжин зөвхөн ганцхан хүний төлөө ярьдаг. Эсвэл хэдэн долоон хоногоор зөвхөн ганц, хоёрхон хүний төлөө ярьдаг. Ийм боломж бас байж болно. Учир нь өөр хүмүүст тийм ч их шаардлагагүй атал түүнд төдий хэмжээний сургаал шаардлагатай байдаг.

Бид Багшийгаа маш амархан буруугаар ойлгодог. Урьд нь би нэлээд эртний сахил хүртсэн Багшийгаа буруугаар ойлгож байсан. Тэр Японд арван жил суралцсан түүхтэй, миний сахилын Багш бол тун залуу. Надаас ганцхан нас ах, одоо тэр Герман улсад их нэр алдаршин хаан шиг хүндлэгдсэн, түүнээс шилдэг хүн үгүй. Тэр тав, зургаан улсын хэлээр ярьж чаддаг бөгөөд маш залуу, арван насандаа гэрээс гарч, сахилаа ч маш тодорхой сахидаг. Гэхдээ би ч бас түүнийг тун хүндэтгэн биширдэг. Зан араншин нь цовоо сэргэлэн. Японд арван жил сурсан болохоор Япон хэлийг яг

л бид хятадаар бичдэг шиг тийм урсам бөгөөд тод бичдэг. Хятад хэлээр бас бичиж чаддаг, ойлгодог. Гэхдээ ярьж чаддаггүй, ярилаа ч хятад хэл болон вьетнам хэлийг хольдог, сонсоход нэг л сонин, та нар ч ойлгохгүй.

Миний сахилын багш Японд арван жил суралцаад, дараа нь Герман луу буцсан. Бид тэр үед танилцсан юм. Тухайн үед сахил хүртэх гэдэг юу болохыг ч мэдэхгүй байсан. Надад өөр хэд хэдэн буддын шашны багш бий. Тэд бол гэлэнмаа боловч жинхэнээр сахил хүртээгүй бөгөөд нэрд гараагүй. Тиймээс тэдэнд шавилбал надад муугаар нөлөөлөхөөс эмээж, өнөө залуу, ер танихгүй багшид хүргэж, түүнд шавилаарай гэжээ.

Энэ нь яг л та нар эр нөхөр, эсвэл эхнэрээ таньдаггүй байтал том болсны дараа аав, ээж чинь гэнэт: “За тэнд очиж түүнтэй хамт амьдар!” гэж хэлдэгтэй адил. Багаасаа аав, ээжийнхээ үгийг дагаж, хэзээ гэрлэхээ өөрөө ч мэддэггүй. “Сонин юм аа! Би түүнийг таних ч үгүй байж яаж шавилах билээ?” гэж намайг хэлэхэд миний эмэгтэй багш: “Би хараахан гэлэнмаагийн сахилыг хүртээгүй байгаа бөгөөд мөн л гадна төрхийг чухалд үздэг. Нөгөө багш маш залуу ч нэгэнт гэлэнмаагийн сахил хүртчихсэн. Бас олон хэлтэй, тун алдартай. Түүнд шавилбал нэр төртэй болно.” гэж хэлсэн. (Багш инээв.) Сахил хүртэхэд бас яагаад нэр төрд санаархах хэрэгтэй билээ? Гэхдээ тэр үед би тун бядуу байсан тул түүний үгийг дагаж, өнөөх багшид шавь орсон. Миний сахилын багш нэг өдөр миний эмэгтэй багшийнд очиж хоол идэхдээ нэг том хайрцагтай японы бэлэн гоймон авчирчээ. Би тэр үед ургамал хоол иддэг байсан тул англиар бичсэн найрлагыг нь сайтар ажигж, ямар найрлагатайг нь нарийн харж, цэвэр ургамал хоол болохыг тодруулсны дараа сая иддэг байсан.

Тэр өдөр багшийн маань авчирсан бэлэн гоймонгийн найрлагаас би нэг үгийг харлаа. Багш маань ярихдаа shrimp flavor гэсэн нь сам хорхойн амттай амтлагч гэсэн утгатай. Хийсэн явцыг нь англиар тийм тодорхой бичсэнгүй. Ямартаа ч сам хорхойн амттай. Энэ гоймон сам хорхойн найрлагатай, идэж болохгүй гэж би хэлсэнд багшийнд байсан хүмүүс сонсоод бүгдээрээ намайг хүрээлэн хамтаар найрлагыг нь харав. Нээрээ сам хорхойтой юм уу? гэж тэд асуусанд би тийм гэв. Англиар нээрээ тэгж бичсэн байна. Миний сахилын багш надад: “Үгүй, энэ бол жинхэнэ сам хорхой биш, зөвхөн тийм амт агуулж байх төдий. Би японд байхдаа хийх явцыг нь шалгаж үзсэн.” гэлээ. Тухайн үед би үл итгэн: “Сам хорхой ороогүй байтал сам хорхойн амттай идээг би ерөөс хараагүй.” гэв. Тэр үеэс би ихээр сэжиглэн: энэ багшийг би

таних ч үгүй, тэр сахилаа сайн сахидаггүй, ургамал хоол идэх нь ч цэвэр биш бөгөөтөл би албадлагын эрхээр түүнээс сахил хүртжээ гэж бодсон. Гэхдээ ихээр сэжиг төрсөн боловч тэгсхийгээд л өнгөрч, нэг их удалгүй мартаж орхив. Гэвч түүний хэлснийг зөв гэж бодоогүй.

Одоо Тайваньд ирээд зарим идээ үнэхээр шивтрийн үнэртэй байдгийг мэдлээ. Жишээлбэл, та нарын чанасан шөлөн дэх конзак (нэг төрлийн ногоо) нь хэдийгээр ногоо боловч маш их шивтрийн үнэртэй тул би бас иддэггүй. Тэд химийн аргаар нэг зүйлийн амтлагч хийж, дараа нь амтат мөөг буюу бусад зүйлийн эдтэй хамт холиод сам хорхой, эсвэл загасны үнэртэй болгодог байна.

Тэгээд л би сая сахилын багшийнхаа ярьсныг ойлгосон хэрэг. Гэхдээ би түүнийг тэгж удтал сэжиглээгүй. Зөвхөн одоо тийм амтлагчтай идээ идэж байхдаа л тэр явдлыг санасан хэрэг. Тухайн үед би түүний ярьсанд итгээгүй шалтгаан нь тэр үед ийм юмыг идэж байгаагүй бөгөөд японы үйлдвэрт очиж, бэлэн гоймонг яаж хийдгийг хараагүй тул түүнийг нэлээд хэдэн жил хилсдүүлж явжээ. Би хэрвээ Тайваньд ирээгүй бол одоо болтол түүнийг сэжиглэх байсан биз.

Тухайн үед тэр ч гэрчлэхийн аргагүй байсан. Би хэдийгээр хэсэг хугацаанд сэжиглэсэн боловч юу ч хэлээгүй. Зөвхөн өөрөө идээгүй бөгөөд веган (vegan) бүтээгдэхүүний найрлага тодорхой биш бол би иддэггүй гэж л хэлсэн. Энэ хэрэг өнгөрөөд нэлээд удсаны дараа би сая ойлгосон. Та нарт ийм явдал тохиолдож байв уу? Лавтай, заримдаа бид эхнэр буюу эр нөхөр, эсвэл аав ээж, найз нөхдөө нэлээд удтал буруугаар ойлгож, арван хэдэн жил, хорин жилийн дараа сая тэднийг үнэхээр хилсдүүлж байснаа гэнэт ойлгодог. Тийм үү, үгүй юү?

Иймээс Жон Шан Тан ордонд ном тайлах үед зарим хүн Багшаас нь хүнийг алах ялаар шийтгэх нь зохистой юу? гэж асуухад би зохисгүй гэсэн. Учир нь зарим үед бид буруугаар шийтгээд дараа нь харамсавч оройтчихдог. Бясалгагч хүн хамгийн сайн нь хичээн болгоомжилж, тодорхой мэдэх хэрэгтэй. Хэрвээ үнэхээр ойлгохгүй бол хамгийн сайн нь тийм их бодох шаардлагагүй. Хэд хоногийн дараа ойлгож мэднэ. Бид бусдыг маш амархан буруугаар ойлгодог. Тийм үү, үгүй юү? Бид бүгд ийм тохиолдолтой маш олон учир явдлыг тухайн үед нь ойлгохгүй байснаа хэзээ хойно ойлгодог. Энэ бүхэн нь бүгд л бидний би гэх үзлээс болдог. Тэр үзэл биднийг бат чанга хүрээлээд сайтар ойлгуулдаггүй. Жишээлбэл, Багшийнх нь саяхан ярьсан тэр хувцас хатаадаг хувраг шиг. Тулганы дэргэд гурван жил гаруй хүлцэнгүй



суугаагүй бол багшийнхаа сайн санааг ойлгож чадахгүй. Галын дэргэд гурван жил хүлцэнгүйгээр суух хүн байна уу? Хувцас хатааж манлайлсан хүн бусдын захиргаан доор өөрийнх нь чадвараас ондоо ажил хийлгэхээр мэдээж гомдоллоно. Багш маань нүд сохор (Бүгдээр инээлдэв) “Та яагаад намайг таньдаггүй юм бэ? Би бол хувцас хатааж манлайлсан хүн шүү! Өдөржин, шөнөжин унтах ч үгүй, нүцгэн биеэр цасан дунд суудаг байхад та харин намайг галын дэргэд дулаан суулгах юм. Энэ нь түүний нүд сохор гэдгийг илтгэж буй хэрэг. Би ондоо нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг хайхаар явна. Та бол миний Төгс Гэгээрсэн Их Багш биш. Ад чөтгөр л намайг саатуулж байна. Энд гурван жилийн турш суулгаж, цагийг минь талаар нэг үрэх нь. Өдөр бүр энд суун ажил ч хийж болдоггүй. Энэ чинь солиорсон багш биш үү?” гэж боддог. Лавтай ингэж зэмлэнэ, тийм биш үү? Миний бодоход Төвөдүүд л сая тийм хүлцэнгүй байдаг. Хятад хүмүүс бүгд түргэн бясалгаж, түргэн бодь мөр олохыг бодож, гурван жилийн турш суун, би гэх үзлээ арилгах хэрэг байдаггүй. Нэг хоног, нэг хэсэг арилгах нь тэдний хувьд дэндүү удаан болчихдог. Тиймээс Багш нь энд ирээд сургахад заримдаа ихэд зүдэрдэг. Дэндүү түргэн угаавал та нар хүлцэж чадахгүй, дэндүү удаан угаавал та нарын бясалгал маш удаан дэвшинэ. Чухам яавал зохихоо мэдэхгүй байна, та нарт аль нь зүйтэй вэ? Хэрвээ жаахан түргэн шиг арилгавал зугтах хүн их болно. (Бүгд инээлдэв.) Зарим нь жинхэнээр арилгаагүй байхад аль хэдийн зугтчихсан. Дөнгөж жаахан загнасан чинь харин зугтчихжээ. Дэндүү түргэн арилгавал үтэр түргэн хүний мөр, сүүдэр харагдахаа болино.

Багш хүмүүсийн би үзлийг арилгах үед маш тод харагддаг гэж та нар хэлдэг. Жишээлбэл, өнөөдөр Багш нь хэн нэгнийг туршин шалгавал та нар бүгд харж чаддаг. Гэхдээ үнэн бодитойгоор хардаг. Гэтэл өөрийг чинь шалгах үед тод харж чаддаггүй, тэвчиж чаддаггүй. Учир нь Багшийн шалгалт лавтай ийм, эсвэл тийм байж таарна гэж боддог. Үүний эцэст Багш нь та нарын бодсоноос огт ондоо зүйлийг хийлгэдэг. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Иймээс тун хялбаргүй, би зориудаар та нарыг туршин шалгаж байгаа юм биш. Энэ бол та нарын үйл түйтгэр ирэх буюу шалгалт тулгарах үед тийм байдал үүсдэг. Харин Багш нь өдөржин өнөөдөр энэ хүнийг ингэж туршин шалгана. Маргааш тэр хүнийг ч ингэж шалгана гэж төлөвлөгөө гаргадаг биш. Багш нь хэдэн мянга, хэдэн зуун мянган шавьтай. Өдөр бүр ингэж бодвол яаж шалгах вэ?

Үнэндээ дотоод дахь Багшийн хүч өөрөө эргэлдэж,

төлөвлөгөөгөө өөрөө зохицуулдаг. Гэхдээ маш тодорхой, заримдаа би өөрөө ч зогсоохын аргагүй болдог. (Бүгд инээлдэв.) Загнаж эхэлмэгц зогсчихож чаддаггүй. Иймээс та нар Багшийгаа уучлах хэрэгтэй. Багшид нь ямар ч арга алга. Энэ бол дотоодын хувилгаан Багшаас хийж байгаа зүйл. Бурхан Бодьсадвагийн хүч та нарыг шалгаж буй хэрэг, энэ нь “Чин Хай” надтай холбогдолгүй.

Заримдаа Багш нь хүртэл та нарт тусалж чадахгүй. Шалгалт тулгарах үеэр би ханцуй шамлавч хажуугаас чинь харахаас өөр аргагүй байдаг. Түүнийг тун хайрлаж, шалгуулж байхдаа ихэд зовж байхыг нь хардаг хэдий ч Багш нь зогсоож чадахгүй, үргэлжлүүлэн шалгах хэрэгтэй. Жишээлбэл, та шалгалтын хянагч болж, хүүхэд чинь танд шалгуулна. Хажууд нь бас өөр хянагч багш болон шалгуулагч тун олон байгаа бөгөөд бүгдээрээ эрх тэгш. Гэхдээ хүүхэд чинь тэнд тархиа гашилган арга барагдаж, шалгалтдаа хариулж чадахгүй байхыг хардаг болохоос тусалж чаддаггүй. “Хөөрхий та! Миний хүү, ингэж хариулна шүү!” гэж хэдэ болохгүй. Жаахан ч туслахын аргагүй. Туслахыг бодсон ч нэмэргүй. Шалгалтын сэдэв маш олон болохоор түүний өмнөөс шалгалтын сэдвийг хариулж чадахгүй, ойлгож байна уу? Та нар илүүхэн бясалгаж, илүүхэн хүлцэнгүй байх хэрэгтэй гэж Багш нь сануулья! Шалгалтын үеэр Багш нь ямар ч шударга бус ажиллагаа хийхгүй. Иймээс өөртөө найдан бясалгах хэрэгтэй. Өөртөө итгэж өөрийгөө сайтар ойлгосны дараа сая Багшийгаа ойлгож чадна. Үгүй бол ойлгож чадахгүй.

Одоо та нар галын дэргэд гурван жил хөдлөлгүй суух уу? (Бүгд инээлдэв.) Би та нараар ажил хийлгэх дургүй. Илүү ажил хийвэл та нарын үйл түйтгэрийг арилгадаг хэдий ч буруугаар ойлгохоос айдаг. Энд ирвэл Багш дандаа биднээр ажил хийлгэдэг гэж бодно. Тэгээд ажиллах тусмаа өөрийн бие сүрхийд үзэж, энд ирж Багшид тусалж байна гэж бодох болно. Үнэндээ ямар ч ажил хийсэн өөртөө тусалж байгаа хэрэг билээ. Би өөрөө хаана амьдарсан ч болно. Тийм уужим том өргөө байгуулан, зам тавих хэрэг юун? Аливаа бүгдийг та нар л хэрэглэдэг. Бидний гэрээс гарагчдад тийм ч хэрэггүй. Тэд хүн бүхэн нэг нэг майхантай бол тун баярладаг. Та нар тэдэнд зуун сая төгрөг өгөөд шинэхэн байшинд хамт сууя гэж хэлбэл: Үгүй, та нар өөрөө хэрэглээрэй! Бид майхандаа суувал болчихно гэж хэлэх болно.

Ганцаараа майханд суувал тун баяртай, тийм биш үү? Нэг долоо хоног, эсвэл нэг сарын дараа л нэг удаа цэвэрлэнэ. Бохирдлоо ч чамайг анзаарч хайхрах хүн үгүй. Цэвэрхэн байлаа ч тоох хүн үгүй. Майхандаа очоод зоргоороо хэвтэж, хөл гараа дураараа

сунгаж байхад хамаарах хүн байдаггүй, ёстой жаргалтай! Тэд энэ ертөнцөд сэтгэл татагдахгүй. Сүм хийдэд хүлэгдэхээ больж, зөвхөн майхандаа л хоргоддог. (Бүгд инээлдэв.) Гэхдээ цаг нь болохоор хоргодохоо болино. Яагаад вэ? гэвэл Багш нь тэднийг дасгалжуулаад маш удсан болохоор майханд суух дуртай болсон хэрэг. Харин гэрээс гарсан даруйдаа дуртай болчихсон юм биш.

Урьд нь бид Шин Диан (Xin Dian)-ы уулан дээрх нэг зусланд сууж байв. Гэхдээ тухайн үед би тэдэнд энд суух нь шоронд суухаас ялгаагүй гэж хэлсэн. Өдөр бүр маш их цэвэрлэгээ хийх хэрэгтэй. Тэгээд бас бүх бие засах газар нь муухай. Цонхыг нь хэчнээн зүлгэсэн ч бохир хэвээр гэж гомдоллодог. Нээрээ яршиг төвөг их бөгөөд бас Багшид загнуулна. Тэгэхийн оронд хамгийн сайн нь гадаа гарч хүн бүр нэг майханд суувал нэлээд амар. Ууланд дураараа нэг нүх малтан жорлон болгож, бие засчихвал болчихно.

Гэтэл миний нэг шавь: “Ингэснээр бид гивсай (gybsy) балар эртний хүнтэй адил болоод нэр төрөө барах биш үү?” гэлээ. (Бүгд инээлдэв.) Тэр: “Багш аа! Бушуухан газар худалдан авч, сүм байгуулья, үгүй бол гаднах хүмүүс надаас аль сүмд суудаг вэ? гэж асуувал би ичээд майханд суудаг гэж хэлж чадахгүй.” гэсэн. (Бүгдээр инээлдэв.) Тэгэхэд нь би: “За! Тэгье, дараа ярилцъя.” л гэсэн.

Хожим нь би майхны тухай дахин яриагүй. Тэгээд би өөрөө дөхөмхөн байшин барьж, тэднийг суулган, олуулаа нэг өрөөнд арван хэдүүлээ зэрэгцэн унтдаг. Дараа нь бас тэднийг дагуулж, олон газраар хэсүүчлэн, гурав, дөрвөн хүн нэг майханд, эсвэл тав зургаан хүн нэг өрөөнд суудаг болсон. Энэ мэтээр тэднийг алгуураар дасгалжуулсан хэрэг. Эхлээд зовлон зүдгүүр жаахан амсуулж, дараа нь хүн бүрд нэг майхан өгсөн. Ингэсэн чинь бүгд: “Багшдаа талархлаа!” гэж баярласан. (Бүгд инээлдэв.)

Одоо бүгдэд нь маш жаргалтай санагдан майханд суух тун дуртай болсон. Хэрвээ хоёр жилийн өмнө Багш нь хүн бүрийг нэг майханд суулгасан бол тэд дургүйцэн эсэргүүцэхэд хүрэх байсан. Тэгээд хүн болгон нэг том хуудас эсэргүүцлийн бичиг барьж: “Багш аа, би майханд суух дургүй. Бясалгалын төвийн гэрээс гарагч нар эсэргүүцэж байна.” гэх болно. (Бүгд инээлдэв.) Тэд лавтай Багшдаа эсэргүүцэл гаргана. Хоёр хоног өлсгөлөн зарлаж ч мэднэ.

Иймээс Багш нь эхлээд тэднийг их зовлон зүдгүүртэй амьдралд сургасан. Тэгээд хоёр жилийн дараа бүрмөсөн хувирч, урьдахтайгаа адилгүй болсон. Урьд нь та тэдний ярихыг сонссон

бол сэтгэл шаналж үхэхэд хүрэх байсан байх. Багш нь түүнийг сургах гэхэд харин: гивсай хүн шиг болно. Тайваньд ингэж болохгүй. Нэр төр барагдаж, хүмүүс элэглэнэ. Сүм хийдгүй бол ичмээр гэж ярьдаг. (Бүгд инээлдэв.) Түүний санаа нь Багшаасаа суралцвал ичнэ гэсэн үг. Та нар ийм шавийг сонссон уу? Бусдад хэний шавь, хаана сууж байгаа гэдгээ хэлэхээсээ ичдэг. Одоо бүгд өөр болсон.

Иймээс заримдаа маш удаж байж л сая өөрөө ямар чадвартай, ямар зөв ухагдахуунтай байгаагаа жинхэнээр нь ойлгодог. Үгүй бол бүгд буруугаар ойлгоод тэр ч байтугай, өөрөө буруу ухагдахуунтай байгаагаа ч мэддэггүй. Хэрвээ мэдчихвэл тун сайн болно. Та нар Багшийнхаа ахмад шавь гэгчдийг сайн ойлгохгүй. Тэдний тавцан дээр сууж байгааг та нар хараад бүгдээрээ тэдэнд итгэж найдан асуулт асуудаг. Та нарын бодлоор тэд хаанаас унаж ирсэн бэ? Түшээ тэнгэрийн орноос унаж ирсэн үү? Багш нь зүрхнийхээ дусал дусал цусаар сургаж дадуулсны ачаар, маш удтал туршин шалгасны эцэст сая ийм байдалтай болсон хэрэг шүү. Багш нь эрхбиш маш тэсвэр тэвчээртэй байвал л сая сургаж чаддаг.

Хэдийгээр ийм боловч багш нь бас л тэдэнтэй нэлээд хэдэн жил хамт амьдарч, өдийг хүртэл тултал дадуулж байж сая нэг юм нэлээд даруу болгодог. Өнгөрсөн хугацаанд бүгдээрээ Багшийгаа алгуур аажмаар ойлгох болжээ. Гэхдээ Багшийгаа бүрмөсөн ойлгох үед Багш чинь явчихна. Одоо хараахан ойлгож чадаагүй ч гэсэн хамаагүй. Гэхдээ заримдаа бид Багшийгаа буруугаар ойлгож, сайн санааг нь харин муугаар ойлгож, сургаж татах гэхэд нь тун ширүүн юм байна гэж боддогоо мэдэх хэрэгтэй. Та нарт лавтай ийм туршлага бий. Хэрвээ ийм байдал тохиолдвол Багшийнхаа өнөөдрийн ярьсныг санаж яваарай!



## АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА ИД ШИДЭЭС ЮУГААРАА ЯЛГААТАЙ ВЭ?

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Пин Тун Жүн жен урлагийн ордонд  
1988 оны 12 дугаар сарын 3-ны өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Өчигдөр нэг хүн маш сайхан асуулт асуусныг та нар санаж байна уу? Цаг тун давчуу байсан болохоор Багш нь дэлгэрэнгүй ярьж амжаагүй. “Багшийн уламжилдаг ном ба ид шид хоёр өөр үү?” гэж тэр асуухад би: “Өөр шүү.” гэж л хариулсан. Өнөөдөр Багш нь энэ тухай арья гэж бодож байна.

Ид шид нь бидний авшиг уламжлах номын цогцостой ер адилгүй. Ид шидийг зөвхөн хэсэгхэн хугацаанд ашиглаж болдгоос биш, харин үүрд мөнх хэрэглэж чадахгүй. Бидний уламжилдаг ном бол уламжилсны дараа хэзээ ч тасардаггүй мөртлөө үргэлжлэн хөгжиж байдаг. Ид шид бол та юу хийж чадна, зөвхөн түүнийгээ хийж чаддаг төдий зүйл. Цаашид хөгжин дэвшиж чаддаггүй. Жишээлбэл, та уулыг нүүлгэж, усыг юүлж чадвал зөвхөн тийм л чадварыг олно. Үүнээс өөр чадвар байхгүй.

Ид шид чиний билиг ухааныг нээж чадахгүй. Хэдий чи ид шидтэй болсон ч билиг ухаанаа уг түвшинд гацааж орхидог. Аливааг ухаарч ойлгосон хэр хэмжээ чинь ахицгүй болж, билиг ухаан чинь өдрөөс өдөрт нэмэгдэж чадахгүй. Түүнд хөгжлийн явц байдаггүй. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Бид авшиг хүртэж, Арьяабалын номын цогцосыг бясалгавал үүнтэй адилгүй. Багшаас ном уламжлах үед таны билиг нээгдэж, дараа нь

үргэлжлүүлэн хөгжүүлж болдог. Өдөр бүр багшийнхаа заавраар, хоёр цаг хагас бясалгаж суудаг л бол билиг ухаан чинь өдөр бүр бага багаар нэмэгдэж, улам өргөжин тэлнэ. Бясалгаж суудаг л бол өөрийн чадвараа өдөр бүр хөгжүүлж болно.

Гэхдээ бид ид шидгүй гэсэн хэрэг биш, ид шид байдаг. Гэвч аяндаа, харин хурай! хурай! Ум аа хум хэмээн тарни унших буюу ямар нэгэн хөдөлгөөн хийгээд зориудаар үүсгэдэг мөнх бусын ид шид биш. Зориудын ид шид, эсвэл өөрийн санаа бодлоороо санаачлан эзэмшсэн ид шид (англиар willpower or will) гэдэг нь зөвхөн хэсэг хугацаанд нь л ашиглаж болдог зүйл. Жишээлбэл, “Тансан ламын үлгэр” дэх Бичин багш бол далан хоёр зүйлд хувирч чаддаг. Гэхдээ та нар хараарай, тэр ид шидээ зөвхөн хэсэгхэн хугацаанд л ашиглаж чаддаг. Хэдийгээр тийм их ид шидтэй боловч мөн л Тансан лам багш нь шавиа болгох хэрэгтэй байжээ. Учир нь Тансан ламын хөөцөлддөг зүйл нь төгс төгөлдөр билиг ухаан, төгс төгөлдөр чадвар болно. Бичин багш бол харин хязгаартай чадварыг л хөөцөлддөг билээ.

Үүнээс бид хэчнээн их ид шидтэй байлаа ч гэсэн чадвар маань бас л хязгаартай байдгийг харж болно. Зөвхөн хамгийн дээд дэсийн билиг ухаан, жинхэнэ төгс төгөлдөр “Мөр”-ийг олбол бид сая аливаа бүхнийг олж чаддаг. Үгүй бол ид шидтэй ч гэсэн зөвхөн нэг л хэсэг нь энэ том хүч дотор байж чадна. Тэр бол бүх орчлонгийн том хүчний өчүүхэн хэсэг нь юм. Хэдийгээр өчүүхэн хэсэг гэж хэлдэг ч өчүүхэн хэсэгт нь тооцогдохгүй, яагаад гэвэл тэр нь мөн л хаалганы гадна нь байгаа. Жишээлбэл, бид ид шидээр уулыг нүүлгэн усыг шилжүүлэх, буурцаг цацаж цэрэгт хувиргаж чаддаг ч мөн л энэ толгой тархиа ашиглах хэрэгтэй. Толгой тархи бол билиг ухаан биш, чадвар нь хязгаартай машин төдий билээ. Толгой тархи, эсвэл бидний сэтгэл бүгд машин шиг нэг зүйлийн багаж хэрэгсэл л юм.

Зүрх бол бие махбодын нэг эрхтэн. Өдөр бүр түг түг цохилон ус татах буюу ус нэмэхэд хэрэглэдэг мотортой адил байдаг. Дотоод “хөөрөг” (зүрхийг хэлж байна) бол гадна байх мотортой адилхан, бүгд нэг зүйлийн багаж төхөөрөмж төдий билээ. Энэ махан биеийн зүрх нь ямар ч сэтгэлгүй. Хэрвээ нарийн ажвал мэдэж болно. “Миний зүрх сүрхий эмзэглэж байна!” гэх буюу “Бид хоёр зүрхний холбоотой” гэх нь тун инээдтэй явдал юм. Учир нь зүрх үнэндээ ямар ч сэтгэлгүй, юм боддоггүй. Хутгаар зүсэх үед л сая жинхэнээрээ өвдөнө. Үгүй бол түүнд юм ярьсан ч хэрэггүй бөгөөд сонсдоггүй.

Зүрх яагаад өвддөг вэ? гэвэл тэр нь нэг зүйлийн аяндаа

л гарч байдаг хариу мэдрэмж болно. Урьд нь тийм тавгүй байдал тохиолдсон, тиймээс одоо дахин тохиолдвол: “Энэ бол тавгүй байдал мөн байна.” гэж дорхноо мэддэг. Тэр үед аяндаа эсэргүүцдэг. Ийм байдлыг бид “зүрх өвдөх” гэж хэлдэг. Бүр тодорхой шиг ярья гэвэл “толгой өвдөх” гэх нь зүйтэй. (Бүгд алга ташив.) Гэвч энэ толгой тархи нь угаас өвдмөөр юм ч биш. Учир нь түүнд хайр байдаггүй, сэтгэл байдаггүй, яг л нэгэн дээд зэргийн компьютер шиг нэлээд маш нарийн, нэлээд олон мэдрэмжтэй, нэлээд сайн багаж төхөөрөмж төдий билээ.

Өнөөдрийн компьютерын хөгжил маш сайн. Зарим нь орчуулагчийн ажлыг гүйцэтгэж, англи хэлийг хятад хэлэнд, эсвэл хятад хэлийг герман хэлэнд орчуулах зэргийг гүйцэтгэж чаддаг. Хэрвээ бид компьютерыг дэндүү их ашиглавал толгой тархи алгуураар хоцрогдох уу? Хоцрогдохгүй юу? Тэгэхгүй, учир нь өнөөдрийн компьютер маш олон хэрэг явдлыг гүйцэтгэж чаддаг ч бидний толгой тархины чадвараас давж гарч чадахгүй. Бидний толгой тархи хэдийгээр тун сайн боловч бас тийм сүрхий ч биш. Учир нь бидэнд өөр нэг зүйлийн “юм” байдаг. Бид түүнийг “юм” гэж нэрлэвэл тэр нь толгой тархинаас бүр ч илүү сүрхий. Тэр байхгүй бол толгой тархи ажиллаж чадахгүй болно. Үүнийг бид “Уг чанар дүр” гэдэг. Тэр бол бидний эзэн, эсвэл уг дүр, аав, ээжээсээ төрөхөөс ч өмнө нэгэнт байсан уг чанар болно.

Энэ хүч, энэ эзэн бол бидний бүхнийг чадагч хүч мөн. Оройн дээд, сэтгэгдэшгүй, юугаар ч орлуулж боломгүй чадвар мөн. Зөвхөн тэр л сая бидний аливаа үйл ажиллагааг захирч чаддаг. Бидний толгой тархи, бидний зүрх, бие махбод болон бодол санаа бол бүгд түүнээс үүсэлтэй. Тэр байхгүй бол амь тасарч хэрэгцээгүй хүүр, бие төдий болно. Яг л машин шиг, жолоодох хүнгүй бол зүг чиггүй давхиж, тэгээд замаас гарч аюулд өртөх болно.

Хэрвээ дотоодын эзэн байхгүй бол энэ махан бие үнэндээ хэрэгцээгүй. Энэ гэрийн эзнийг бид хайх хэрэгтэй. Хайж олсны дараа юуг ч хийж чадах болно. Гэвч ихэнх хүн хайгаад олдоггүй. Учир нь нэгт, хүмүүсийн амьдрал дэндүү цаг завгүй, хоёрт, хайх дургүй, гуравт, тэр “эзэн”-ий оршин байгааг санаж мэддэггүй.

Бидэнд шашны төрөл зүйл тун олон байдаг ч дотоодын эзэн бол бурхан шашинтан биш, католик шашинтан биш, бумбын шашинтан биш, күнзийн сургаалтан ч биш. И Гуан До буюу Дао (нэг зүйлийн шашны урсгал бүлэг) бүр ч биш. Тэр юу ч биш боловч юм бүхэн тэр мөн. Тэр бясалгал хийдэггүй ч нэгэнт туулан гэтэлчихсэн. Тэр гэрээс гараагүй ч нэгэнт үйлийн үрээс



мултарчихсан гэдэг чухал зүйлийг ихэнх хүн санаж мэддэггүй.

Энэ дотоодын эзэн чиний ямар шашин шүтдэг гэдгийг хамаардаггүй бөгөөд шашинтай холбогдолгүй, гэхдээ бид түүнийгээ хайгаад олчихвол ямар ч шашинд итгэхгүй ч цэцэн мэргэн билиг ухаантай болж, агуу их хүн болж хувирдаг.

Тиймээс Багш нь зөвхөн шашныг мэддэг хүнд л ном тайлдаг төдий биш. Бүгдээрээ ирж ном сонсохыг баярлан угтана. Таван (五 wu) төрлийн шашин байж байж л сая нэг бүгдээрээ нэгдэнэ гэсэн хэрэг биш, шашин үгүй “无 wu” ч гэсэн бид нэгдэж болно. (Ханз үсгийн тав болон үгүй гэх үсгийн дуудлага ижилхэн байдаг болохоор Багш зориудаар ингэж хэлжээ.) Учир нь энэ “Мөр” нь бүх төрөлтнийг багтаадаг бөгөөд хүн бүхэнд шударга хандаж, ялгаварлах сэтгэл байдаггүй. Энэ “Мөр” нь хүн болгоны дотоодод байдаг. Махан бие цогцос нь эцсийн эцэст зөвхөн нэг солих хувцас төдий. Өнөөдөр ийм хувцас өмсөж, нөгөөдөр өөр хувцас сольж болно. Жишээлбэл, бид нас барсны дараа өөр нэг махан биеийн хувцас өмсөж ч мэднэ. Тэр үед хамаатан садан маань биднийг танихаа больдог. Энэ гадна талын хувцасны төлөө хүмүүс байнга бөөн маргаан үүсгэж, зарим нь дорно дахины хүн нэлээд сайн гэх буюу өрнө дахины хүн нэлээд сайн гэдэг. Бас зарим нь католик шашин нэлээд сайн, буддын шашин сайн биш гэж нэмж өгүүлнэ. Энэ бол маш төвөгтэй явдал билээ.

Тиймээс Багш нь ямар ч шашныг үүсгэн байгуулаагүй. Үргэлжлүүлээд өөр нэгэн шашныг үүсгээгүй. Учир нь нэгэнт тийм олон шашин байсаар байхад дахин өөр нэгийг нэмбэл бусдыг бүр ч илүү төөрөгдүүлэх болно. Зөвхөн зайлшгүй нөхцөл байдалд жишээлбэл, хийх ёстой үедээ л хийнэ. Өөрөө шийдэж чадах үед бол хийхгүй байвал зохино.

Ид шид хаанаас гаралтай вэ? Жишээлбэл, энгийн хүн дур зоргоороо бясалгавал өөр нэг ертөнцөд очдог. Ийм ертөнцтэй бид байшингийн шатаар мацвал тааралдчихдаг юм биш. Байгаа бүх түвшин бүгд энд (Багш билгийн мэлмийгээ заав) байдаг. Гэхдээ түвшин болгон нь өөр өөр зан чанартай. Үүнээс гадна бидэнд адил бусын багаж хэрэгсэл байдаг тул адил ижил бусын түвшнийг сонсдог, хардаг, мэдэрдэг. Жишээлбэл, эндэх агаар дотор ус байдгаас гадна бас жаахан хорт хий болон хүчилтөрөгч байдаг. Гэхдээ агаар дотор юу ч байлаа гэсэн бүгд л энэ ертөнцөд байгаа юм. Уушги нь гэмтсэн зарим хүнд өвчтөнд яг л агааргүй юм шиг санагддаг. Үнэндээ энд агаар байхаас гадна бас дэнгийн гэрэл байж, хамтдаа оршдог.

Үүнтэй адил, нэг газарт маш олон төрлийн зүйл хамт оршиж

байдаг. Гэхдээ сохор хүн нар байгааг мэддэггүй, сар, од, цэцгийг харж чаддаггүй, хүнийг ч харж чаддаггүй. Энэ нь хүнгүй, эсвэл нар, сар, од байдаггүй гэсэн хэрэг биш, ойлгож байна уу? Үүнтэй адил, бидний харагддаггүй нүд нээгдвэл өөр нэг түвшнийг харж чаддаг. Одоо бол бид сохор хүн шиг, зөвхөн энэ цэцэг, микрофон, ширээ, сандал мэтийн маш хатуу, хайргүй, сэтгэлгүй материаллаг зүйлсийг л хардаг. Хэрвээ бидний билгийн мэлмий нээгдвэл маш олон зүйлийн юм, бусад төрөлтөн болон түвшнийг харж чадна. Яг л сохор хүн мэс засал хийлгэсний дараа гэнэт нарыг харж: “Аяа! Нар байна.” гэж хэлдэгтэй адил. Үнэндээ нар угаасаа байсан, тэр харж чаддаггүй байсан болохоор л мэдээгүй байсан хэрэг.

Үүн шиг, бид байшингийн шатаар мацан дээш гарвал Бурханы орон, диваажинтай тохиолддог биш. Бодол санаагаа өөрчилж, билиг ухаанаа хувиргавал л болчихно. Үнэндээ хувиргах ч биш, билиг ухаанаа таньчихвал гэж хэлбэл зүйтэй. Бид энэ тэнгэрийн хаалгыг нээвэл өөр нэг түвшнийг харж, Багш нь та нарыг харах буюу та нар Багшийгаа харж байгаатай адил тийм тод харж чадна. Нээрээ үнэн, тэр үед бид өөр нэгэн дээд дэсийн түвшнийг хардаг. Тэгээд дахин энэ дэлхийг харах үед: “Уул нь тоост ертөнц гэдэг чинь хуурмаг юм байна, миний харсан нөгөө ертөнц сая жинхэнэ юм байна.” гэж хэлэх болно. Тиймээс: “Бүх үзэгдэл хөөс шиг.” гэж хэлдэг.

Бидний бясалгал дээшлэх тусам улам ихийг мэдэж, энэ дэлхий ертөнцийг улам чухалчлан үзэхээ больдог. Яг л кино үзэх шиг, бид кино театрт байхдаа жүжигчинтэй нь хамт уйлж, инээх юм уу, хамтдаа айн дагжиж, тун үнэн бодитой санагддаг. (кинодоо орчихдог) Гэвч кино дуусахаар сэтгэл эзгүйрч, тэр нь нэгэн зүйлийн жүжиглэлт байсныг сая санадаг. Тийм үү, үгүй юү?

Бид кино үзэхээр очихдоо үзэж дууссанаа дараа гэртээ харихаа мэдэж байдаг. Тэгээд гэртээ харих нийтийн унаа юм уу, таксинд суух мөнгөө бэлдэх хэрэгтэй бөгөөд харих гэр маань ч байх хэрэгтэй. Харин өдөржин тэнд хоргодон кино үзэж болохгүй. Үүнтэй адил, энэ ертөнц бол мөн л нэгэн том жүжгийн театр гэдгийг ойлгох хэрэгтэй. Хүн болгон ихдээ л зуун жил амьдраад нас барахаа мэддэг ч гэр лүүгээ буцаж харихаар бэлтгэдэг хүн харин байдаггүй нь нээрээ гайхмаар хэрэг билээ. Тийм үү, үгүй юү? (Тийм гэж бүгд хэлэхийн зэрэгцээ алга ташив.)

Хүмүүс энд оршин амьдарснаас болж буцаад харих гэр байдгаа мартжээ. Яг л бяцхан хүүхэд кино үзэхээр очоод кино театрт хөөрч, циркийн тоглолт үзэхээр очоод гэртээ харих дургүй болдогтой адил. Гэхдээ аав, ээж нь хүүхдээ, жүжиг, циркээ үзэж

дуусахаар нь дагуулж харина гэдгээ мэднэ. Заримдаа хүүхдийг дагуулж явахад тун хэцүү. Учир нь бяцхан хүүхэд байдлыг сайн ойлгохгүй болохоор цирк, театрт үргэлжлэн байхыг боддог. Өрнө дахинд хорин дөрвөн цагаар ажилладаг нэг зүйлийн кино театр байдаг, сонирхох дуртай бол үргэлжлүүлэн үзэж, гэртээ харих шаардлагагүй. Гэвч кино театрын цаг нь болохоор хаалгаа хаадаг. Хорин дөрвөн цаг болбол хэсэг хугацаагаар хаалгаа цоожилдог. Тэр үед бид гэртээ харихгүй гэсэн ч тэнд байж болохгүй.

Бидний ертөнц мөн л ийм. Багш нь та нарт ямар нэгэн сүрхий юм сургаагүй. Зөвхөн ачаагаа бэлтгэхийг сургадаг. Удалгүй явах үедээ айх юмгүй бөгөөд тав тухтай болно. Эргэлзэх, зовних, төөрөлдөх, юмаар хомсдох байдал үүсэхгүй. Гэвч бясалгал хийхгүй бол билиг ухаан, ёс суртахуун, тохиромжтой оюун санаа дутагддаг болохоор нас бараад өөр ертөнцөд хүрэх үед сая тэгж ихээр шаналан зовдог.

Учир нь та энэ ертөнцөд дуртай эсэх хамаагүй, хэзээ ч бай, эндээс явна. Гэхдээ та энэ ертөнцөд дуртай бол бас дахин ирж болно. Гэвч эхлээд гэртээ харьж мөнгө олж, хоол идэн, халуун усанд орж, хувцсаа сольж, жаахан тав тухтай болсны дараа маргааш нь дуртай бол дахин ирж, жүжиг сонирхож болно. Харин өдөржин тэнд үлдэн ажил ч хийхгүй, мөнгө ч үгүй байж болохгүй. Хэрвээ маргааш нь жүжгийн театрт нас барахад хүрвэл харж анхаарах хүнгүй болно, ойлгож байна уу?

Арьяабалын бясалгагч буцаж ирэх шаардлагагүй гэсэн биш. Хэрвээ энэ ертөнцөд ирэхийг хүсвэл бас болно. Гэхдээ ирэх үед маш эрх дураараа байх болно. Бурхан Бодьсадва, Төгс Гэгээрсэн Их Багш болж, энэ ертөнцийг адисалж, хамаг төрөлтнийг удирдан дагуулж, зовлонт хүмүүст болон шаардлагатай хүмүүст тусалдаг. Харин сохор мунхгаар буцан ирж, өөртөө ч тусалж чадахгүй, бусдад ч тусалж чадахгүй болчих юм биш.

Багшид нь шавилсан Арьяабалын бясалгагчид ид шид огт ашиглаж болохгүй гэдгийг мэддэг. Энэ бол авшиг хүртэхийн нэг нөхцөл билээ. Яагаад ид шидтэй байтлаа ашиглаж болохгүй вэ? гэвэл бид ид шид хэрэглэвэл бусдаас зээлсэн мөнгөтэй адил, тэр биднийх биш. Ид шид нь хэчнээн дээд дэсийн байлаа ч мөн л гурван ертөнцийн дотор байдаг. Тодорхойхон яривал нэгдүгээр ертөнцөд байдаг. Нэгдүгээр ертөнц нь бидний ертөнцөөс ганцхан дээсэр өндөр төдий. Мөн л гурван ертөнцөөс хэтийдээгүй байдаг.

Гурван ертөнц гэдэг нь юу вэ? гэвэл бидний энэ ертөнцөөс дээш бас гурван ертөнц байдаг. Тэр гурван ертөнц нь бидний ертөнцөөс жаахан дээд дэсийнх байж, дээшлэх тусам өндөр

болдог. Гэхдээ хэзээ нэгэн өдөр мөн л мөхөж сөнөх болно. Гурван ертөнцөөс гадна бас өөр нэг зүйлийн түвшин бий, хэзээ ч мөхөн сөнөдөггүй. Бид бясалгал хийх гэвэл эхлээд тэнд хүрэх хэрэгтэй. Тэгвэл сая туулан гэтэлсэнд тооцогдоно.

Багшийнх нь ярьсан “тэнд хүрэх” гэдэг нь бид гүйгээд хүрэхийг хэлж байгаа биш, бас сүнсээ гаргахтай ч адилгүй. Сүнсээ гаргах гэдэг нь эндээс сүнсэн биеэрээ Тайвань юм уу, Америкт хүрч очихыг хэлдэг. Бидний сүнс махан бие орхин өөр нэгэн биеийг дагуулж гардаг. Гэхдээ энэ махан бие дотор өөр бусад бие цогцос байдаг бөгөөд тэр бүхнээ дагуулж, Америкт очоод хүмүүс юу хийж байхыг харсны дараа дахин махан биедээ буцаж ирэхийг сүнсээ гаргах гэдэг.

Сүнсээ гаргадаг хүн бол хамгийн өндөртөө нэгдүгээр ертөнцөд хүрч чадсан байдаг. Тэр бол нэгэн ид шидтэй ертөнц. Хоёрдугаар ертөнцөд бас ид шид байдаг. Гэвч өөр нэг зүйлийн нэлээд мэдлэгтэй ид шид. Харин салхи дуудаж, бороо урих төдий тийм ид шид биш. Салхи дуудаж, бороо урих, уулыг нүүлгэн усыг юүлэх гэх зэрэг нь нэгдүгээр ертөнцийн ид шид болно. Хоёрдугаар ертөнцөд өөр нэг зүйлийн ид шид байж, өнгөрсөн, одоо болон ирээдүйг харж чаддаг. Гуравдугаар ертөнцөд хүрвэл материаллаг ид шид байдаггүй, харин нэг зүйлийн аяндаа байдаг ид шид болж хувирдаг.

Аяндаа гарч ирдэг ид шид гэдэг нь юу вэ гэвэл, жишээлбэл, бид ямар нэгэн хүний өнгөрсөн, одоо, ирээдүйг хараагүй ч таамаглах шаардлагагүйгээр түүнд яаж хандвал зөв болохыг аяндаа мэдэх юм уу, ямар нэг хэрэг явдлыг аяндаа хийдэг. Жишээлбэл, урьд нь түүнд таван зуун төгрөгийн өртэй байсан бол одоо аяндаа таван зуун төгрөгийн үнэтэй бэлэг хүргэдэг. Тэр үед бидний урьдах үйлийн үр аяндаа арилдаг.

Гуравдугаар ертөнцөөс дээших бол аяндаа ид шид болно. Яг л бид нэгэнт ахлах, дээд сургуулийн сурагч, эсвэл их сургуулийн оюутан болж, хүмүүс гурав дээр гурвыг нэмбэл хэд болохыг асуувал дорхноо зургаа гэж хариулдагтай адил. Харин гурав дээр гурвыг нэмж бодоход тархиа гашилган нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаа гэж дараалан бодож, хагас өдөр зарцуулж байж хариултыг нь бодож гаргахаа бас тун сүрхийд үздэг биш. Ийм байдал нь доод дэсийн ид шид болно. Ихэнх хүн хүүхэд насны тийм ид шид хэрэглэдэг.

Аяндаа гардаг ид шид нь та ахлах дээд сургуулийн сурагчид нэг багц цэцгийн үнэ гурван төгрөг гэж хэлбэл тэр хоёр багц цэцэг худалдан авахдаа тэр дороо зургаан төгрөг төлөхтэй яг адил.

Харин хоёр багц цэцэг нь хэдэн төгрөгийн үнэтэй билээ гэдгийг бодох шаардлагагүй. Учир нь нэгэнт сурчихсан болохоор бодох шаардлагагүй.

Аяндаа байдаг ид шидийн дэс нь зориудын ид шидээс өндөр байдаг. Тэр үед та ямар нэгэн хүнийг хармагц түүнд маш таатай санагддаг. Эсвэл та нэгэн өвчтөнийг эргэн харвал тэр маш түргэн эдгэрдэг. Харин “Ум ма ни бад мэ хум” гэж уншиж, (Бүгд инээлдэв) дараа нь дом шившлэг үйлдэж, галд шатаан усанд хийж, өвчтөнд уулгах гэх мэтээр будилуулах шаардлагагүй. Учир нь хүч чинь нэгэнт аяндаа байж байдаг болсон тул хэнийг бодно, тэр хүн аяндаа буянтай болно, хэнд сайн байна, тэр хүний ач буян нэмэгдэнэ. Хэн нэгэн таныг агшин зуур санан дурсмагц аяндаа ач тус хүртэж, таатай санагддаг. Бясалгахдаа эрхбиш ийм хэмжээнд хүрч байж л сая жинхэнэ мөр ёсыг бясалгаж байгаад тооцогддог. Арьяабалын номын цогцосоор бясалгавал ийм ид шидтэй болно. Харин гарын хөдөлгөөн хийх, “Ум аа хум” гэж унших мэтийн доод дэсийн ид шид биш. (Бүгд алга ташив.)

Иймээс та нар Багш бидний дэсийг мэдэхгүй гэж бодох хэрэггүй. Багш нь сайн мэддэг, гэвч мэдмээр юмгүй, учир нь энэ бүх юм аяндаа гарч ирдэг. Үнэндээ энэ бүх хариултыг би өөрөө бодсон биш, Багшийнх нь хувьд эдгээр зүйл нь аяндаа л болж байдаг. Гэхдээ хүмүүс асуусан болохоор хариулж, өөрийн мэддэг бүхнээ хүмүүсийн ойлгож чадах дэсэд тааруулж ярьдаг. Хэдийгээр үг хэлээр ярьж илтгэж чадахгүй ч гэсэн боломжийн хэрээр ярих хэрэгтэй тул сая тийм бэрх хэцүү байдаг. Хэрвээ бүгд Багштайгаа дэсээр адил бол юу ч ярих шаардлагагүй. Багшийгаа хармагц л аяндаа мэдэж, Багш нь юм ярих ч шаардлага байхгүй.

“Авид Бурханы судар” гэх нэгэн боть Буддын шашны судар байдаг. Түүнд баруун зүгийн Төгс баясгалант орныг дүрслэхдээ тэндхийн төрөлтөн уулзахдаа үг хэл хэрэглэдэггүй, та юу бодно, бусад нь тэр дорхноо ойлгодог буюу таны юу ярих гэж байгааг дорхноо ойлгодог гэсэн байдаг. Энэ нь бусдын бодлыг унших биш, харин бүгдээрээ нэгэн цогц болсон хэрэг юм. Бусдын сэтгэлийг унших болон тэнгэрийн нүд нь өөр нэг зүйлийн байдал юм. Зарим хүн, хэн хэн гэдэг номын багш юм уу, эрт дээр үеийн даяанч нар билиг нээгдэх үед өөрийн суугаа газраасаа өөр нэгэн газар ярилцаж байгаа хоёр хүнийг хардаг гэж хэлдэг. Энэ нь билиг нээгдсэн хэрэг биш, уучлаарай! Жишээлбэл, өнөөх номын багш өөрийн өрөөндөө бясалгаж суухдаа түүний багш нь хэн хэн гэдэг номын багштай Тайбэйд ярилцаж суухыг хараад харьсны дараа энэ ахуй ойлголтоо бичиж тэмдэглээд билиг нээгджээ гэж

хэлдэг. Та нар үзэж байгаагаар түүний байдал нь билиг нээгдсэн явдал мөн үү, үгүй юү? Энэ нь билиг нээгдсэн хэрэг биш, харин тэнгэрийн нүд болон тэнгэрийн чих нь нээгдсэн хэрэг юм.

Тэнгэрийн нүд гэдэг бол энгийн нүдээр, эсвэл нүдээ ашиглахгүйгээр маш холыг харж, харах гэсэн хүнийхээ Тайбэй буюу Гау Шөүнд юу хийж байхыг харж чаддаг явдал. Хэн нэгний өөр газар юу хийж байгааг харъя гэвэл тэнгэрийн нүдээрээ харна. Бичин багш бол мөн л ийм ид шидтэй болохоор тэр өндөрт нисэж үзэх юм уу өөрийн байгаа газраасаа хэн, хэн алс газар юу хийж байгааг хардаг. Үүнийг тэнгэрийн нүд гэдэг. Өөр нэг зүйлийн байдал нь бид чихээрээ Тайбэй болон Гау Шөүн дахь хоёр хүний ярилцахыг сонсдог. Энэ бол тэнгэрийн чих болно. Жишээлбэл, бид цаана суугаа тэр хүний юу бодож байгааг мэдэх нь бусдын бодлыг унших болно.

Энэ бүх ид шид нь Арьяабалын номын цогцостой холбогдолгүй. Бид хүүхдийн тоглодог тийм ид шидийг бясалгадаггүй. Та нар санаа зоволтгүй. Гэхдээ та нар зөвхөн ийм ид шидийн төлөө энд ирсэн бол урам тань хугарч мэднэ гэдгийг ойлгоорой! Учир нь тэр бүх ид шидийг үнэндээ тархиа гашилган бясалгах шаардлагагүй. Одоогийн цаг үед Багшийнхаа юу ярьсныг мэдье гэвэл утасдмагц болчихно. Тэр нь мөн л нэг зүйлийн тэнгэрийн чих болно.

Өнөөдөр бид ийм ид шидийг ашиглахгүй. Бясалгал хийдэг нь билиг ухаантай болохын төлөө билээ. Бясалгаж суухдаа ямар нэгэн түвшнийг харах нь муу биш. Энэ бол нэг зүйлийн маш сайн ахуй ойлголт. Үүгээр өөрийн дэсээ хэмжиж болно. Гэхдээ бас баярлахгүй байсан нь сайн. Учир нь Арьяабалын аргаар бясалгавал өөрийнхөө ямар түвшинд хүрч байгаагаа ойлгож, хэзээ ямар түвшинд хүрснээ маш тодорхой мэддэг бөгөөд өөрийн мөрийн хутагаа ч мэдчихдэг.

Хэдийгээр мэддэг хэдий ч нэг хүн бидний нэрийг бичиж тэмдэглээд: “Та сургуулиа төгсчихлөө шүү!” гэх шиг тийм тодорхой биш. Зөвхөн ойлгох төдий л байдаг. Гэхдээ бас: “Би нэгэнт архадын хутагт хүрчээ, би бол Бодьсадва, та мэдэж байна уу, үгүй юү?” гэхчилэн бусдад тодорхой ярьж чадахгүй. Тэр үед “би” маань ямар, ямар мөрийн хутагт хүрэв гэх бодол төрдөггүй болохоор ярихын аргагүй. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Тайбэйн нэг хүн Багшаас нь: “Та бурхны хутагт хүрсэн үү, үгүй юү? Гэхдээ хүн бүхэн бурхан мөн гэж хариулж болохгүй шүү!” гэж шамдуулан асуув. Тэр Багшийг нь шахаж бурхан мөн, эсвэл биш гэж хэлүүлэх гэсэн хэрэг. Тухайн үед би маш ичиж,

эвгүйрхсэн. (Бүгд халуунаар алга ташив.) Гэхдээ шамдуулан асууж байгаа болохоор түүнд хэлэх хэрэгтэй. Хэдийгээр “Би Бурханы хутагт хүрчихсэн.” гэж хариулсан боловч ямар ч Бурханы хутаг гэмээр юм байхгүй. Зөвхөн та нарын урмыг хугалахгүйн тулд л тэгж хэлсэн хэрэг.

Багшийнх нь хувьд Бурханы хутагт хүрэх нь тийм ч сүрхий хэрэг биш. Учир нь Бурханы хутгийг олох нь маш аяндаа болдог явдал. Жишээлбэл, та олон жилээр багшийнхаа ажилд тусалсны дараа “би” бол англи хэлний гарамгай багш мөн гэж боддоггүй. Яг л хооллох, унтах шиг нэг зүйлийн аяндаа болдог ажиллагаа болчихдог. Зарим хүн таныг: “Энэ бол англи хэлний гарамгай багш мөн.” гэж бусдад танилцуулбал та бүр ч ихээр ичих болно, тийм биз? Үүнтэй адил, Бурханы хутагт хүрсэн хүн өөрийгөө бурхан болчихлоо гэж сэрж мэддэггүй. Гэхдээ ертөнцийн үг хэлээр ярьж илтгэхийн тулд, эртний судар ном, өөрийнх нь ахуй ойлголт болон өөрийнх нь цацруулж байгаа хүчийг үндэслэж байж, сая түүнийг бурхан гэж хэлдэг. Гэвч түүний хувьд бурхан байдаггүй бөгөөд хамаг төрөлтөн ч байдаггүй. Бүгдээрээ эрх тэгш, иймээс тэр бол бурхан мөн. Гэвч бас бурхан биш. Бурхан мөн гэдэг нь хамаг төрөлтөн түүнийг бурхан гэж үздэгээс болжээ. Гэтэл тэр өөрийгөө бурхан биш гэж үздэг. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Үүнийг ярьж илэрхийлэхэд тун амаргүй, гэхдээ та нар ойлгосон бол билиг нээгдсэнийг тань харуулж байгаа хэрэг.

Арьяабалын номын цогцос болон ид шид нь өөр байдгийг ойлгохгүй хүн байвал дараа Багшаасаа дахин дэлгэрэнгүй асууж болно. Ингэвэл сая та нарын хувийн эргэлзээ мэдлэгийг тайлж чадна. Та нарын асуултад хариулах маш дуртай. Багшийнх нь хувьд аливаа бүхэн аяндаа болдог, надад таны юу бодож байгааг мэдэх, бусдын бодлыг унших чадвар байхгүй байж мэднэ. Энд олон хүн байна, хэрвээ би бусдын бодлыг уншвал маш яршигтай болно. Энэ хүн ингэж бодож байна, тэр хүн тэгж бодож байна гэхчилэн уншиж, ихэд яарч, толгой тархи маань тасралтгүй сэтгэн бодож, удалгүй ном тайлж чадахаа болино.

Багш нь яагаад Арьяабалын номын цогцосыг бясалгавал ид шид хэрэглэж болохгүй гэж хэлдэг вэ? гэвэл бид гурван ертөнцөөс салж, гурван ертөнцийг туулан гэтлэх гэж байгаа билээ. Гурван ертөнцийг туулан гэтлэх гэвэл энэхүү гурван ертөнцөд хамаарах зүйлсийг хэрэглэж болохгүй. Жишээлбэл, та зочид буудалд хоноглоод явахдаа мөнгөө төлснийхөө дараа явах хэрэгтэй. Гэхдээ тэндхийн цэцэг болон гэрлийг авч явж болохгүй. Хэрвээ тэндээс явах гэж байгаа бол ингэж болохгүй. Хананых нь



нэг хэсгийг ч хэлтэлж болохгүй. Усны цоргыг нь авч болохгүй. Ор, сандлыг нь бүр ч авч болохгүй. Та бол зочид буудалд түр зуур буудалласан төдий билээ.

Үүнтэй адил, ид шид нь бидний ертөнц дэх харагддаг материал шиг мөн л нэг зүйлийн хэлбэр дүрсгүй материал болно. Жишээлбэл, би хэн нэгний байшинг зээлдээд сууж болдог ч юмыг нь авч болохгүй. Зочид буудлын эд зүйлсийг бас авч болохгүй. Үүний адилаар гурван ертөнцийн дотор бас харагддаггүй материал байдаг. Бид харагддаггүй зүйлсийг дур тааваараа хэрэглэж болохгүй. Учир нь гурван ертөнцийн доторх бүх зүйл бол адын эзний эд хөрөнгө юм.

Ад гэдэг нь толгойдоо хоёр эвэртэй, урт хоёр соёотой маш хэрцгий нэг хүнийг хэлж байгаа биш. Ад гэдэг нь нэг зүйлийн хий бодол, хуурмаг хий хүслийн түвшинд харьяалагдана. Хэрвээ бид түүнд мэхлэгдвэл зүүднээсээ хэзээ ч сэргж чадахгүй болно. Адыг самгарьдаар “Маа” гэдэг. “Хий бодол, хий сэтгэгдэл, зөв бус түвшин” гэсэн утгатай. Түүнд мэхлэгдэн түүнтэй тогловол үүрд тэнд амьдарч, салж чадахгүй болно. Яг л багадаа шавраар жигнэмэг хийж тоглодог, эсвэл угж хөхдөгтэй адил. Хэрвээ том болчихоод мөн л түүнийг хэрэглэвэл хүмүүс биднийг мэдрэл нь мууджээ гэх бөгөөд бидэнтэй жаахан ч харилцах дургүй болно. Тийм үү, үгүй юү? Үүнтэй адилаар гурван ертөнцийн дотор гурван ертөнцийн л тоглоом байдаг. Бид мөн л тэнд төөрөлдөж, тэдэнтэй тогловол Бурхан Бодьсадва тоохоо больдог. Учир нь тэр хүн мөн л хүүхэд хэвээрээ, хэдийгээр бие нь томорсон боловч мөн л “угж”-аа хөхсөн хэвээрээ.

Дээд түвшний хууль дүрэм нь доод түвшнийхтэй адил байдаг. Тиймээс бясалгах нь ид шидийн төлөө биш, харин хамгийн дээд дэсийн чадвартай болж, хамгийн төгс төгөлдөр билиг ухаанаа нээж, өөртөө болон бусдад ач тус хүртээх явдал юм. Хэчнээн хүнд тусалсан ч асуудалгүй. Диваажинд хүрэх, эсвэл тамын оронд очъё гэвэл хоромхон зуур хүрч чадахын төлөө гэдгийг ойлговол зохино. Ямар нэгэн хүн хэрвээ тамын орноос бидэнд даатгавал түүнд тусалж чаддаг. Гэтэл тамын орны ихэнх хүн биднээс тусламж гуйж чаддаггүй, яагаад гэдгийг та нар мэдэх үү? Учир нь тэд бидэнтэй харилцаа холбоотой байдаггүй. Ойлголцдоггүй, бидний нэрийг сонсдоггүй, сонслоо ч гэсэн бид бас туслах эрх байхгүй. Жишээлбэл, нэгэн хуульч өөрөө шоронд очиж: “Би түүнд тусална. Шоронд хоригдсон ялтан болгонд тусална.” гэж ярьж болохгүй. Тэр хуульч хууль дүрмийг ойлгодог, эрх мэдэлтэй, маргах чадвар сайтай байлаа ч өөрөө тэгж болохгүй. Нэгэн ялтны хамаатан

садан нь хуульчид найдан туслуулах гэвэл сая тэнд очиж, тэр бүх ялтанд тусалж болно. Тиймээс бясалгах хэрэгтэй. Учир нь бясалгал хийвэл өвөг дээдэстээ тусалж чадна. Авшиг хүртэгсэд бол хамгийн ачлалтай хүүхэд мөн. Бид өвөг дээдэстээ хэчнээн мөргөлөө ч Багшаасаа “Авшиг” хүртсэн хоромхон зууртай чинь тэнцэхгүй. Та авшиг хүртвэл таван үе, зургаан үе, есөн үеийн өвөг дээдэс чинь бүгдээрээ төрөл дэвшинэ. Та хэчнээн жилийн турш мөргөлөө ч тэдэндээ тусалж чадахгүй. Тамын оронд мөн л ихэд зовж, хэчнээн хоол ундаар тахисан ч идэж чаддаггүй. Ачлалын сэтгэл чинь сүмбэр уул мэт өндөр байлаа ч тэд сэрж мэдэхийн аргагүй.

Багш нь хүмүүсийн маш зовуурьтай байхыг харсан ч тусалж чаддаггүй. Гэхдээ өрөвдөхгүй, сэтгэл зовнидоггүй гэсэн үг биш. Бусдын зовохыг харахаар Багшийнх нь сэтгэл бас ихэд шаналдаг. Гэвч тийм ч их тусалж чадахгүй. Хэрвээ шавь нар минь гэж зовж шаналбал л би яаж хийхийг зааварлаж чадна. Тэгээд багшийнхаа заавар ёсоор хийх л юм бол дорхноо сайн болно. Жишээлбэл, миний шавийн өвчин нь эдгэрсний дараа Багшийнхаа заасан аргыг хөршдөө ярьж, ингэж хийвэл өвчин чинь эдгэрнэ шүү гэж хэлнэ. Гэхдээ хөрш чинь сонсонгуут: “Ингэж яаж болох вэ? Үүнийг идвэл ходоод гэмтээнэ.” гэж хэлж мэднэ. Хүн болгон Багшийнх нь үгийг дагадаг биш гэдгийг бас ойлго. Багшид нь хэдийгээр эм байдаг боловч хүн болгон уух дуртай биш. Үүнтэй адил, Багшийнх нь энэ туулан гэтлэх тасалбар үнэгүй бөгөөд ямар ч нөхцөл болзол байдаггүй ч харин хүлээн авдаг хүн тун цөөн. Тиймээс та нар: “Бясалгалтан ганц хоёрхон, хамаг төрөлтөн тийм олон, чухам хэзээ гэтэлгэж дуусах билээ?” гэж битгий бодоорой! Хамаг төрөлтнийг хамаарах хэрэггүй. Эндээс салж явах, эсвэл энд хоцрохоо өөрөө л шийд! Бүгдээрээ чөлөөтэй юм хойно.

Халуурах томуу (тахал) нь зөвхөн ариун цэврийн асуудлаас болсон төдий биш. Тайваний эрүүл ахуй угаас ийм байсан, харин саяхны явдал биш. Үнэндээ одоогийн Тайвань өмнөхөө бодвол бүр ч илүү ариун цэвэрч болжээ. Гэтэл харин өвчтөн улам нэмэгдэж байна. (Халуурах томуу уг нь халуурах, хавдан чинэрэх төдий байсан, одоо эдгээрээс гадна бас цус гарах болов.) Бид шар шумуулыг устгалаа ч нэмэргүй. Энэ өвчнийг арилгая гэвэл амь хороохоо больж, яргачны мэсээ хаяж, чин сэтгэлээр харамсан гэмшиж, Эзэн Бурхан, Бурхан Бодьсадвад илүүхэн даатгах хэрэгтэй. Харин шар шумуулыг устгачихвал асуудал шийдэгдчих биш.

Яагаад гэвэл энэ бол хувь хүн болон улс орны нийтийн үйл

үр юм. Манай улсын үйл түйтгэр бусад улсынхтай адилгүй. Аль ч орон, аль ч улсад ч гэсэн шар шумуултай. Гэтэл бусад улсад ийм халуурах томуу дэлгэрснийг маш цөөн сонссон. Тайваньд урьд нь бас шар шумуул байсан. Харин одоо л байгаа юм биш, тэгвэл яагаад одоо долоон сая халуун хижиг гарах болов? Тийм үү, үгүй юү? Хүмүүсийн ёс суртахуун улам улам уруудан дордож байгааг ажвал яагаад өвчин дэлгэрдэг шалтгааныг мэдэж болно.

Одоо улам ихээр амь хороох болжээ. Урьд нь хятадууд амь голтойг тун хайрлаж, хааяа зочин ирэхээр л нэг тахиа гаргадаг байв. Одоо өдөр бүр хаана ч очсон мах харагдаж, амь хороох нь улам нэмэгджээ. Тиймээс “өвчин амаар ордог” гэж хэлдэг. Хэрвээ амаар орж амжихгүй бол хамраар ч орж мэднэ. Одоогийн өвчин биеийн гаднаас дотогшоо орсон байдаг. Багшийнх нь ярьсан бүхэн үнэн. Энэ өвчин бол бидний ёс суртахуунтай холбоотой болохыг та нар харж чадна. Одоо ойлгосон биз дээ? Та нар хариад хөршдөө амь хороохоо боливол шар шумуул аяндаа цөөн болно гэж хэлээрэй! Үнэхээр ийм болохыг Багш нь батална. Багш нь хийж болох боломж байвал халуурах томууг арилгах дуртай байна. Гэвч маргааш, нөгөөдөр дахин өөр нэг зүйлийн бүр ч хүнд өвчин үүсэж мэдэх болохоор ямар ч нэмэргүй. Бид өөрийн бие, хэл, сэтгэлээ ариусгах хэрэгтэй. Ямар арилжаа хийсэн ч бай, бусад төрөлтнийг хорлохгүй бол байгалийн үйл үрийн хууль биднийг хорлохгүй, үнэхээр ийм юм шүү.

Ертөнцийн хууль дүрэм мөн л ийм. Та ямар нэгэн хүнийг хөнөөвөл хамаатан садан нь таныг хөнөөнө. Ингэж харилцан хөнөөж, өс хонзон хэзээ ч тасардаггүй. Араатан амьтныг хөнөөх нь хүн алах шиг тийм хүнд ноцтой биш байлаа ч дэндүү ихээр хөнөөвөл хүн алсантай адил болно. Үүний үйл түйтгэр маш хүнд. Ёс суртахуунаар дэндүү дор, муу үйлийн үр дэндүү их болохоор тэнцвэрээ алддаг. Амь хороох үйл дэндүү их, дэндүү хэтэрвэл маш олон гай гамшиг болж хувирдаг. Засгийн газар бидэнд туслахыг бодовч туслахын аргагүй. Богд гэгээнтнүүд, бясалгагчид бидэнд туслахыг хүсдэг ч зөвхөн хэсэг хүнд л тусалж, их олонд туслахын аргагүй. Тиймээс бид өөрөө өөрийгөө аврах хэрэгтэй. Амь хороох үйл нь аливаа гай гамшигийн үндэс мөн гэдгийг тодорхой ойлгох хэрэгтэй. Ингэвэл сая гай гамшиг устана. Харин шар шумуулыг устгачихаар сайн болчих биш.





Сэтгэл зүрх маань хүүхэд мэт гэнэн цагахан, аливааг тун амар хялбар хүлээн авдаг болсон цагт бид маш хурдан дэвшинэ.

*“Бясалгал дэвших нууц арга” айлдвараас.*





Илүү өндөр дэсийн бясалгал бол илүү хялбар дөхөм байдаг.  
*“Орчлонгийн од гарагийн үлгэр” айлдвараас.*



Их Багш Коста-Рика дахь ашрамын өмнөх тариан талбайд тааваараа зургаа зурж байгаа нь.



## ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШИЙГ ХАРАХЫН ТӨДИЙД ТУУЛАН ГЭТЭЛНЭ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Пин Туны Жүн жен урлагийн ордонд  
1990 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Өнөөдөр Багш нь дахиад энд ирсэн байна. Тэгээд нийтийн бясалгалд оролцохын сацуу Пин Туны ахан дүүст, сайн үйл хийхийг битгий март, угаас өөртөө байдаг хайр энэрлийн сэтгэлээ битгий март гэдгийг сануулах гэсэн билээ. Ном судар олон унших нь мөн л ач тустай. Заримдаа ховдог, хилэн, мунхгаа амархан захирч чаддаггүй. Уурлах, эсвэл хэн нэгэн хүнд хорсох үед ном судар илүүхэн уншвал нэмэр болох шиг санагддаг. Учир нь ном сударт цэцэн мэргэн сургаалыг номлож, сайн үйл хийхийг сургадаг. Хэрэгцээгүй ном судар гэж байдаггүй.

Бид судар ном уншдаг нь өөрийгөө ариусгаж, өөртөө тусалж, энэ дэлхийд амар тайван оршин амьдарч, сайхан ааш араншинтай болохын төлөө билээ. Харин ном судар уншвал Бурханы хутагт хүрчихдэг юм биш. Хэрвээ ингэж ойлгож чадвал судар ном уншихад асуудалгүй. Гэтэл судар ном уншвал Бурханы хутагт хүрч чадна гэж үзвэл энэ нь элсийг чанаад хоол болдоггүйтэй адил зүйл.

Учир нь эртнээс нааш ном уншвал бурхан болно гэж ярьсан Төгс Гэгээрсэн Их Багш, Бурхан Бодьсадва ер байгаагүй. Тэд бүгд л сургаал ёсноос ангид ном уламжилдаг. Шагжамуни Бурхан нирваандаа буцах үедээ залгамжлуулахаар шавь Маха Гашибыг



сонгон түүний өмнөөс ном дэлгэрүүлжээ. Гэхдээ Маха Гашибаар ном судар уншуулаагүй. Маха Гашибыг Шагжамуни Бурханыг залгамжилж, тусгайлан уулын агуйд очин бясалган суулгажээ. Тухайн үед Шагжамуни Бурханд эмхэтгэн найруулсан ном судар гэмээр юм байгаагүй, тийм биз?

Шагжамуни Бурхан таалал төгсөөд маш удсаны дараа шавь нар нь ном судрыг нь эмхэтгэсэн билээ. Тэгвэл Маха Гашиб яаж Бурханы хутагт хүрсэн бэ? Тэр өдөр бүр ном уншиж, цээжлээгүй бөгөөд Шагжамуни Бурхантай ч байнга шадарлаагүй. Учир нь Шагжамуни Бурхан нирваандаа буцах үед зөвхөн Ананд л дэргэд нь байжээ. Үүнээс гадна нэгэн өдөр Маха Гашиб алс холоос Бурхан Багштай уулзахаар ирэхэд хувцсанд нь тоос шороо дүүрэн наалдсан байв. Энэ нь тэр саяхан уулын агуйд хатуу бясалгал хийж байсныг гэрчилнэ. Ингээд түүний судар ном уншаагүй гэдгийг мэдсэн байна. Ном судар, маани тарни хэчнээн уншлаа ч ойлгохгүй зүйл бас л байдаг. Учир нь бидний түвшин өндөр биш, билиг ухаан нээгдээгүй байдаг.

Багш нь ном тайлах болгондоо: Өнөөдрөөс эхлэн бүхнийг шинээр эхлүүлж болно. Урьд нь хэчнээн их үйл түйтгэр бүтээж, хэчнээн харанхуй мунхаг явсан нь хамаагүй. Бид энэ төрөлдөө туулан гэтэлж чадах бөгөөд өнөөдөр, эсвэл маргааш билиг нээгдэж чадна гэж сануулдаг. Ял гэмийг толгой тархи үйлдсэн, бие махбод үйлдсэн. Харин бидний сүнсэн бие үйлдээгүй. Сүнсэн бие бол угаас байсан уг чанар, эсвэл эзэн хэмээгч мөн. Тэр нь энэ бие махбодыг ашиглаж байж л материал, туршлага, бусад төрөлтөнтэй холбоо харилцаатай туршлагыг хуримтлуулж чаддаг. Гэхдээ заримдаа төхөөрөмж эвдэрч мэднэ. Жишээлбэл, толгой бол зөвхөн нэг зүйлийн багаж мөн. Бид түүнийг ашиглавал сая бусадтай харилцаж, бусадтай туршлагаа солилцон, сурч боловсорч хүмүүжиж чадна. Гэвч энэ толгой тархи бол тийм цэцэн сэргэлэн биш. Тэр бол нэгэн машин мөн. Яг л компьютер шиг. Гэхдээ нэлээд сайн компьютер төдий. Бид юу хуримтлуулна, тэр бүгдийг тогтоон авч, бид ямар нэгэн товчлуурыг нь дармагц тогтоосон зүйлээ гадагшаа гаргадаг. Жишээлбэл, тэр угаас хэн нэгнийг загнаж зодож чаддаггүй. Гэтэл нэгэн өдөр хоёр хүний хооронд үл ойлголцол үүсэж, загнаж зодохыг харвал даруй тогтоож авдаг. Дараа нь нэг хүн түүнд буруу үг хэлбэл толгой тархи гарыг нь цохих юм уу түүнийг зоддог. Учир нь тэр нэгэнт сурчихсан байна. Гэхдээ бусдаас сурсан бөгөөд сайныг, эсвэл мууг сурсан эсэхээ мэддэггүй. Зөвхөн тийм туршлагын дагуу л хийдэг. Тэр аль нь сайн, аль нь муу гэдгийг ялгадаггүй.

Бидний дотоодын эзэн сэрээд түүнд хэлэх юм уу, өөр нэгэн сэрсэн сүнс түүнд хэлбэл ойлгож мэддэг. Гэхдээ тийм түргэн биш, тийм ч хялбар биш. Учир нь дэндүү олон үзэгдэл, дэндүү олон асуудлыг тогтоож бүртгэгчигсэн болохоор дорхноо бүхнийг тийм хялбархан угаан цэвэрлэж чадахгүй. Тиймээс хувь хүний зан араншинг өөрчлөхөд тун бэрх. Заримдаа бясалгалтнууд бас хувийн зан араншинтай байдаг. Эрхбиш Бурханы хутагт хүртэл бясалган, “би” үгүй дэсэд хүрч байж л хувийн зан араншинг арилгаж чадна, тэр үеэр яг л толь шиг, өмнө чинь юу байна, түүнийг тэр янзаар нь тусгаж, хэлбэр төрхийг нь ч хувиргадаггүй.

Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш, эсвэл Бурханы хутагт хүрсэн хүнийг харахаар бидний сүнс яагаад туулан гэтэлж чаддаг вэ? Яагаад хармагцаа туулан гэтэлдэг вэ? Нэр алдрыг нь сонсвол яагаад туулан гэтэлж чаддаг вэ? Гэхдээ тэр өөрөө бясалгаж Бурханы хутагт хүрсэн, харин бид бясалгаагүй байхад яагаад туулан гэтэлж чаддаг вэ? Та нар нэлээд сайн ойлгох боломжтой шүү! Мэдэх хүн байна уу? Мэдэх хүн байвал шагнал олгоно. Нээрээ мэдэхгүй юу? (Багш адисалснаас болов гэж нэг хүн хариулав.) Энэ хариулт дэндүү хялбар байна. (Хүсэн мөрөөдөх болон даруу хичээнгүйгээс болов гэж нэг хүн хариулав.) Хэлж мэдэхгүй юм даа, зарим хүн Багшийг нь гүтгэсэн байтлаа бас туулан гэтэлгүүлдэг. Гэхдээ нэлээд удаан. (Билиг ихээр нээгдсэн хүн биднийг харсны дараа бидний билгийн мэлмийг нээгдүүлж, биднийг адисалдаг. Гэхдээ бид харж чаддаггүй гэж нэг хүн хариулав.) Ийм боломж байж мэднэ. (Тэр нэгэнт багшид итгэгчигсэн байна гэж бас нэг хүн хариулав.) Багшдаа итгэгчигсэн тэр хүмүүсийг би яриагүй шүү! (Дотоодын эзэн Багшид итгэдгээс болжээ гэж нэг хүн хариулав.) Та нарын ярьсан нь бүгд зүйтэй.

Бидний дотоодын эзэн үүрд цэцэн сэргэлэн хэвээр байдаг. Төрөхгүй, мөхөхгүй, бохиртохгүй, цэвэршихгүй, нэмэгдэхгүй, хорогдохгүй, хэзээ ч гэсэн билиг ухаантай хэвээрээ байдаг. Юуг ч ойлгож, юуг ч мэддэг. Зөвхөн түүнд үүнийгээ санаж олох зол завшаан байдаггүй. Учир нь тэр энэ толгой тархийг ашиглаад дэндүү дадчихсан болохоор үргэлжлүүлэн ашиглаж, өөр зүйлийг хийж, билиг ухаанаа ашиглах хэрэгтэй гэж үздэггүй. Харин энэ толгой тархиа хэрэглэвэл болчихно гэж боддог.

Өөр нэгэн сүнс нэгэнт туулан гэтэлчихсэн байдаг. Тэр нь ямар байдалтай вэ? гэвэл тэр өөрийн дотоодын эзэн болон толгой тархи хоёроо (салгаж) тусгаарласан байдаг. Тэр толгой тархиа хэрэглэдэг боловч толгой тархиндаа харьяалагддаггүй. Хэрвээ нэгэн сүнс тэр туулан гэтэлчихсэн сүнс ингэж хийхийг харвал

дорхноо: Аан за! Уул нь түүнтэй адилхан хийвэл зүйтэй юм байна гэдгийг мэддэг. Тэр агшинд даруй ойлгочихдог. Учир нь тэр угаас маш цэцэн сэргэлэн билээ. Жишээлбэл, хоёр хүн хамт гүн далайгаас сувд эрж хайхдаа биедээ хүчилтөрөгчийн сав, нүдний шилгэх мэтийг авч явдаг бөгөөд шумбалтын хувцас өмсдөг. Далайд орсны дараа хоёулаа салж ажиллан, нэг нь дорхноо далайгаас гарч, гадуурх хувцасаа тайлж эхэлжээ. Нөгөө нэг нь далайгаас гарсны дараа үнэндээ ингэж тайлдгийг мартаад мэлхийн хөл шиг хоёр хөлөөрөө, шумбалтын багаж зүүсэн хэвээрээ нааш цааш алхахад маш төвөгтэй санагдана. Гартаа бээлий өмссөн болохоор чөлөөтэй хөдөлгөж чадахгүй. Толгойдоо хүчилтөрөгчийн баг өмссөн тул амьсгаа авахад хэцүү. Ингэсээр явал түргэн шиг явж чадах бол, яаж ажиллавал арай сайн бол гэдгийг мэдэхгүй аргаа барж суудаг. Тэр хажуу дахь хүнийг шумбалтын хувцсаа эхлэн тайлж, биедээ байгаа тэр төхөөрөмжөө бүгдийг нь орхин маш чөлөөтэй болсныг хараад: “Аан за! Уг нь ингэх ёстой юм байна.” гэдэг. Тиймээс тэр бусдыг дуурайж хийдэг.

Учир нь тэд хоёулаа угаас адилхан болохоор нэгнийхээ хийхийг хармагц тэр даруй яаж хийвэл зохихоо мэдчихдэг. Бид бол зөвхөн мартчихсан төдий юм. Харин мэддэггүй биш, ойлгож байна уу? (Бүгд алга ташив.) Заримдаа нэгэн зүйлийн нөхцөл байдал байдгийг та нар мэдэх үү? Бид бээлий өмсөөд дэндүү удвал гэртээ харьсны дараа мөн л бээлийтэйгээ хоол идэх юм уу, ямар нэг ажил хийгээд авахаа мартдаг. Иймээс ажиллахад маш төвөгтэй болж, арга барагддаг.

Тэр үед нэгэн хүн хажуугаас нь: “Та бээлийгээ тайлаач.” гэж хэлэх хэрэгтэй. Эсвэл заримдаа бид малгай өмсөх юм уу, ямар нэгэн юм зүүгээд авахаа мартвал хүмүүс хажуугаас нь: “Та үүнийгээ тайлаач.” гэж хэлэх хэрэгтэй. Үүнтэй адил, нэгэн билиг нээгдсэн хүн бол үйл түйтгэр, толгой тархи буюу аливаа эгэл хүний ойлголтоосоо салчихсан байдаг. Тэр мөн л эгэл хүний бие цогцостой. Эгэл хүний толгой тархитай ч энэ нь өөрийнх нь бие биш гэдгийг маш тодорхой ойлгож, маш тодорхой салгаж тусгаарладаг. Иймээс өөр нэгэн сүнс хажууд нь ингэж хийхийг харвал тэр бас дуурайн тэгж хийдэг. Үнэндээ тэд угаас адилхан байдаг болохоор “агшин зуур билиг нээгдэж, энэ төрөлдөө туулан гэтэлдэг”. (Бүгд алга ташив.) Тиймээс бид бурхныг хармагц туулан гэтэлж чаддаг нь ийм санаа билээ.

Тэгвэл нэр алдрыг нь сонссон төдийд бас яагаад туулан гэтэлдэг вэ? Энэ нь мөн л маш хялбархан. Бид ямар нэгэн хүний нэрийг сонсвол тэр хүнд нөлөөлөгдөж, хувийн чанар, эрдэм

мэдлэг, аливаа авьяас чадвар нь бүгд бидэнтэй холбогддог. Багшийнхаа санааг ойлгож байна уу? (лавтай) нөлөөлнө. Учир нь бидний дотоодын эзэн, эсвэл бидний уг дүр маш чөлөөтэйгөөр аливаа орныг харж байдаг. Бидний толгой тархи мэдэхгүй байлаа ч бидний сүнс мэдэж чаддаг. Тиймээс бидний сүнс нэгэн хүний алдрыг сонсмогц сонирхолтой санагдан толгой тархинаасаа энэ хүн хэн бэ? гэж асуудаг. Дараа нь л толгой тархи анхаарлаа түүн лүү хандуулдаг.

Тэр хүн биднийг заавал таних шаардлагагүй. Гэхдээ түүний алдар нэрийг дуудах буюу түүний нэрийг бодвол тэр билиг нээгдсэн хүн бас мэдэж чаддаг. Учир нь тэр биднээс бүр ч илүү мэдрэмтгий, юуг ч мэддэг. Хаа сайгүй оршдог, бүхнийг чадагч, аливаа хязгаарлалтаас давчихсан болохоор түүний бүх зан чанар нь бидэнд дамжигдан хүрч ирдэг. Учир нь хамаг оршихуй нэг цогц мөн гэдгийг та нар битгий мартаарай!

Гэхдээ бид түүнтэй адилхан ертөнцөд амьдран, адилхан агаар амьсгалж, адилхан хоол идэж, адилхан хувцас өмсдөг тул түүнийг дурсмагц холбогддог. Тэр билиг нээгдсэн хүний нэрийг сонсвол бидний оюун сүнс ч ойлгож эхлэн сэрж эхэлдэг байна. Ингэснээр алс холыг харж чадаж, тэр билиг нээгдсэн хүнийг анхаарч эхэлдэг. Тэр бол билиг нээгдсэн хүн мөн гэдгийг ойлгоод түүнийг дуурайдаг бөгөөд туулан гэтэлж чаддаг. Тиймээс “Даяан үг хэл хэрэглэдэггүй.” гэдэг билээ.

Энэ үед бидний өвчин зовлон, нисваанис, харанхуй мунхаг багасаж эхэлдэг. Төрөл төрөлдөө дэндүү олон нисваанис, үйл түйтгэр, харанхуй мунхгийн мэдээлэл хуримтлуулсан тул алгуураар, бага багаар багасдаг. Тиймээс яг л дорхноо бурхан болоогүй юм шиг. Үнэндээ дорхноо бурхан болчихдог. Тэр билиг нээгдсэн хүнтэй адил. Билиг нээгдсэн хүн бол аливаа харанхуй мунхаг, нисваанис, үйл түйтгэрээ бүгдийг нь цэвэрлэн устгачихсан байдаг. Харин нөгөө хүн дөнгөж арилгаж цэвэрлэж эхэлж байгаа болохоор харахад маш удаан мэт байдаг. Гэвч жаахан удвал хоёулаа адил болно. Эрт билиг нээгдэх, эсвэл хожуу нээгдэх бүгд адилхан. Зөвхөн цагийн асуудал төдий. Усанд шумбах хоёр хүн шиг, нэг нь нэгэнт шумбалтын хувцсаа тайлан чөлөөтэй нааш цааш явахыг нөгөө нэг нь хараад дуурайж, удалгүй шумбалтын хувцсаа тайлбал хоёулаа адил болно, ойлгож байна уу? Энэ нь зөвхөн цаг хугацааны асуудал юм. (Бүгдээр алга ташив.)

Тиймээс Бурхан Багш яагаад хамаг төрөлтнийг бурхан мөн гэж үздэг вэ? гэвэл хамаг төрөлтөн хэзээ нэг өдөр Бурханы хутагт хүрнэ гэдгийг тэр мэднэ. Тэрээр аль нэгэн шавиа харах,

эсвэл хэн нэгэнтэй уулзах гэж яардаггүй. Хэдхэн хүнийг сургавал хангалттай болно. Дараа нь шавь нар нь түүний алдрыг уламжлан тархааж, шавьтай нь холбоотой л бол түүнтэй холбоотой болчихно. Харин айл болгоны хаалгыг тогших шаардлагагүй. Эсвэл хамаг төрөлтнийг гэтэлгэхээр цаг завгүй яаралтай явах ёстой биш. Тэр нигүүлсэнгүй сэтгэлгүйдээ биш, харин яаж хийхээ маш тодорхой ойлгодгоос тэр.

Түүний хийх арга нь эгэл хүмүүсийнхтэй адилгүй. Эгэл хүмүүс бол шавь хайж яарч, олон хүн дээр очиж, сургаал ёсыг ихэд ярьж, үгэндээ оруулан авшиг авхуулдаг. Бурхан Бодьсадва угаас тийм олон шавь сургах шаардлагагүй. Зөвхөн хэдхэн шавь сургавал болчихно. Шавь нар нь цаашид уламжилдаг, шавь нь хаана хүрнэ, Багш нь тэнд байдаг болохоор дэлхий дахин угаас амгалан, тун аюулгүй санагддаг. Жишээлбэл, та Бурханы хутагт хүрээгүй байгаа бол хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр танд тусалж Бурханы хутагт хүргэдэг. (Бүгд алга ташив.) Гэтэл хүмүүс заримдаа: “Бид маш зовууртай байна, өөрийн бурхнаа хаана байгааг мэдэхгүй байна, та ярихдаа бид бүгд бурхан мөн гэсэн, гэтэл би өчүүхэн ч мэдэхгүй байна.” гэж даатгадаг.

Хүмүүс бас бурхны өмхий арьсан тулам, хүний ертөнц дэх “ажлын өрөө” (бие цогцосыг хэлж буй)-нөөс зууралдан ийш тийш олон орноор явуулж, ном тайлуулдаг. Нэг удаа тайлахад ойлгохгүй бол маргааш нь дахин тайлж ойлгуулдаг. Ном тайлахаар л бид ойлгочихдог биш. Харин цаг нь болохоор аяндаа ойлгодог. Үнэндээ тайлах, эс тайлах нь адилхан. Гэхдээ ном тайлахгүй бол хүмүүс энэ хэсэг хугацаанд сэтгэл тэгшлэх хүнгүй, урамшуулах хүнгүй, тайлбарлах хүнгүй болж тун уйтгартай болно. Тиймээс мөн л энд ирж ном тайлуулдаг. Үнэндээ ном тайлах эсэх нь хамаагүй, хожим та нар бүгд Бурханы хутагт хүрэх болно.

Бурхан Бодьсадвагийн үйл ажиллагаа нь эгэл хүнийхтэй адилгүй. Жишээлбэл, эмч өвчтөнийг аврах юм уу, шидийн хүчээр өвчтөнийг авардаг хүнийг харвал бид маш сүрхийд үзэн тэдэнд ихээр талархдаг. Гэхдээ удалгүй бас өвчилнө гэдгээ мэддэггүй. Бурхан Бодьсадва хэдийгээр илээр бусдыг өвчнөөс нь авардаггүй ч хэн хүн алдрыг нь сонсмогц, түүнд даатгамагц төрөл төрөлдөө дахин өвчлөхгүй болдог. Өвчиллөө ч гэсэн ганц энэ төрөлдөө л өвчилдөг. (Бүгд алга ташив.)

Тиймээс Бурхан Бодьсадва эгэл хүмүүс шиг тэгж яаралтай ажиллагаа хийдэггүй. Гэрт чинь хүрч хэвлийн мэс засал хийх юм уу, танд тусалж өвчнийг чинь эмнэхгүй байлаа ч харин өөрийн гэрээсээ адилхан хийж чаддаг. Гэхдээ нэг удаа аварвал дахин

хэзээ ч өвчлөхөө больж, үхэж төрөх сансрын хүрдэнд дахин эргэлдэхгүй болдог. Энэ бол сая жинхэнээр өвчнөөс аварч байгаа явдал болно, ойлгож байна уу? (Бүгд алга ташив.)

Бид энэ ертөнцөд төрөх, өглөх, өвдөх, үхэхээс зугтахын аргагүй. Учир нь үйлээ нэгэнт тарьчихсан. Одоо үр жимс чинь боловсорчихсон тул аяндаа газар унадаг. Гэхдээ ирээдүй, маргааш бол хамгаас чухал. Бурхан Бодьсадва энэ суурь модны үндсийг бүхлээр нь тайрч, дахиад үр жимс ургахаа больдог. Иймээс бид урьдын тарьсан үйлээ дахин амсахгүй болно. Ингэвэл сая үйлийн үрээс мултарч чадна. Гэтэл одоо бол нэгэнт үр жимс боловсорч гүйцсэн болохоор өөр газар шилжүүлж болохгүй. Нэгэнт жимс ургачихсаныг бүгд харна. Гэвч хожим дахин жимс ургахаа болино.

Бурхан Бодьсадва эгэл хүмүүс шиг тэгж яаруу давчуу ажиллах шаардлагагүй. Харин амгалан тайван хийдэг. Яг л юу ч хийгээгүй шиг боловч шаргуу ажилладаг. Гэвч бас ажиллаагүй. Тиймээс Лууз “Хийдэг, гэвч бас хийдэггүй.” гэжээ. Ийм дэсэд хүрэхэд Бурханы хутгийг олох хэрэгтэй, “би”-гүй болох хэрэгтэй.

Бурханы хутгийг ологсон үй түмэн хувилгаан биетэй болж чаддаг. Гэвч хаана ч очдоггүй. Иймээс түүнийг “Түүнчлэн ирсэн” гэж нэрлэдэг. Түүнчлэн ирсэн гэдэг бол ирдэггүй бөгөөд очдоггүй. Гэвч түүнийг хаана ч харж чадна. Нэг хүнийг хаана ч харж чадвал бид түүнийг Түүнчлэн ирсэн гэж хэлдэг. Учир нь нэг адилхан цагт хаана ч байж чадна. Гэвч хаана ч очдоггүй. Иймээс Түүнчлэн ирсэн гэдэг.

Маш олон хүн бясалгал хийдэг боловч энэ санааг үл ойлгон зөвхөн Шагжамуни Бурханыг л сая Түүнчлэн ирсэн мөн гэж үздэг. Ингэж бодох нь өөрийгөө дэндүү голдгоос болжээ. Хүн бүхэн Түүнчлэн ирсэн болж болно. Бид хэрвээ хамаг төрөлтнийг гэтэлгэх заяа буянтай бол Түүнчлэн ирсэн болж болно. Тийм заяа буянгүй ч гэсэн Бурханы хутгийг олж болно. Гэхдээ өөрийгөө Бурхан Бодьсадва мөн болохыг ойлгодог хүн маш цөөн. Ойлгохгүй бол хамгаас сайн. Учир нь бурхан болох нь маш зовуурьтай, бурханд зовуурь гэж байдаггүй ч хүмүүс түүнд авчирдаг.

Бид эгэл хүн болохдоо нэгэнт хэлэхийн аргагүй зовуурьтай болчихдог. Ганцхан хүний зовуурь нэгэнт тийм их болчихдог. Тэгвэл хамаг төрөлтөн болон ертөнцийн хамаг оршихуйн зовлон бүгд чиний зовлон болох тийм байдлыг та төсөөлж чадах уу? Энэ нь тоглоом мөн гэж үү? Биш шүү дээ! Тиймээс Бурханы хутагт хүрэгсдийн ихэнх нь чимээгүйхэн хүрдэг. Үүнийг бид бас буруушааж болохгүй. Шагжамуни Бурхан шиг тийм агуу их хүн Бурханы хутагт хүрснийхээ дараа: “Хамаг төрөлтнийг битгий

гэтэлгээрэй! Дэндүү бэрх ажээ.” гэж толгой сэгсэрсэн гэдэг. Тэр толгой сэгсэрсэн нь нирваандаа буцах гэснийг илтгэж буй хэрэг. Самади дахь амар амгаландаа цэнгэж, амарлингуй тайвуу нирваандаа жаргах гэсэн утгатай.

Нас барсныхаа дараа л сая нирваандаа буцдаг биш. Нирваан гэдгийн утга нь самадид орох үеэр нисваанис арилж, зөвхөн дээд дэсийн түвшиндээ жаргадаг. Үүнийг бага нирваан гэдэг. Их нирваан гэдэг бол тоост хорвоотой холбоотой хувь барилдлагаа үүрд тасдан энэ ертөнцөөс салах утгыг хэлнэ. Өөрөөр хэлбэл дахин буцаж ирэхгүй гэсэн утгатай. Гэхдээ буцаж ирсэн ч болно.

Тиймээс Шагжамуни Бурхан нигүүлсэнгүй сэтгэлгүйдээ биш, хамаг төрөлтнийг гэтэлгэх дургүйдээ ч биш, харин даанч хүнд хэцүү байдгийг тэр ойлгосон. Тухайн үед энэтхэгчүүд маш цэвэр ариун байв. Энэтхэг бол төрлөөс төрөлд бүгд бясалгасан ариун дагшин орон. Ихэнх хүн нь ургамал хоолтон. Яаж бясалгахыг багаасаа мэддэг. Маани тарни унших, бурхныг дурсах, бурханд мөргөх гэх мэтийн үйл бүгд байдаг. Тэд бол тусгайлан бясалгал хийдэг улс мөн бөгөөд Бурхан Багшийн тэр цаг үеийг зөв номтны цаг үе гэж, харин одоог ном балрах цаг үе гэж хэлдэг.

Зөв номтны цаг үед хүмүүсийн сэтгэл цэвэр ариун, материаллаг зүйлсийн талд тийм элбэг баялаг биш ч нийгмийн байдал, байгаль орчин нь одоогийнх шиг бохирдоогүй байсан. Иймээс хүмүүсийн сэтгэл мөн л маш цэвэр цайлган, оюун санаа нь маш тайван байжээ. Гэхдээ Бурхан Багш Энэтхэгт байсан бөгөөд тэндхийн хүмүүсийг гэтэлгэхэд тун хялбар байв. Тийм байтлаа мөн л толгой сэгсэрч байсан юм чинь одоо үед Бурханы хутагт хүрэгсэд яаж өөрийгөө бурхан мөн гэж ярьж зүрхлэх вэ? Бядуу бурхан л тэгдэг. (Бүгдээр алга ташив.) Өмнө нь Багш нь бас гадагш гарч өөрийгөө сурталчлаагүй. Хувь барилдлага бүрэлдэхийн эрхээр хүмүүс Багшийг нь татсаар байгаад л гаргачихсан. Та нар бол Эсэрваа тэнгэр, Архад, Ном хамгаалагч мөн. Бүгд Багшаасаа байнга гуйж, улмаар ямар дэстэй, хэн болохыг минь задруулсан. Гэхдээ энэ бүхэн нь миний хувьд шинэхэн мэдээлэл байсан, ийм гэдгээ мэдээгүй явсан ажээ.

Би бол угаас энгийн нэг хүн. Миний аливаа алдар цолыг та нар хүндлэн нэрлэсэн. Гэхдээ нэгэнт ийм болчихсон юм чинь би энэ байр суурийг хүлээж авах л хэрэгтэй болж байна. (Бүгд алга ташив.) Яг л ерөнхийлөгчийг сонгохтой адил, бүгдээрээ зөвшөөрвөл ерөнхийлөгч болчихдог. (Багш инээж, бүгд алга ташив.) Та нар ач тус хүртэж, баяр жаргалтай болж, аврал, тусламж, хамгаалал хүртэж чаддаг л юм бол Багш нь юу хийсэн ч



дуртай хийнэ. Бурхан болсон ч бай, ад болсон ч бай, та нар ач тус хүртдэг л бол боллоо. (Бүгд алга ташив.)

Та нар бол бурхан байж мэднэ. Зөвхөн хамаг төрөлтнийг гэтэлгэх ерөөл барилдлагагүй болохоор чимээгүй л Бурханы хутгийг олдог гэж багш чинь саяхан ярьсан. Чимээгүйхэн бурхан болох нь хамгаас сайн. Бидэнд ямар эрдэм гавьяа, ямар хүч, ямар ёс суртахуун байлаа ч бүгдийг нь нууцалж, гайхуулж ярихгүй бол хамгаас сайн. Гайхуулж ярьдаг хүн бурхан биш болчихно. Бид дув дуугүй л, эсвэл санамсаргүй үед ямар нэгэн хүч, ямар нэгэн чадвартай байдгаа мэдлээ ч гэсэн бусдад мэдэгдэж болохгүй. Эртнээс нааш богд гэгээнтнүүд маш даруу, өөрийгөө ёс суртахуунтай гэж үздэггүй, өөрийгөө ёс суртахуунтай, бурхан мөн гэж үздэг хүн бол бурхан биш. Сонин биш үү! Тун зөрчилдөөнтэй хэрэг юмаа. Гэхдээ та хамаг төрөлтнийг гэтэлгэх ерөөл барилдлагатай бол хүмүүс таныг олонд таниулдаг. Хааж далдалсан ч нэмэргүй. Дараа нь түмэнд танигдаж, хүндлэгдэн өргөмжлөгдөж, сайшаан магтагдаж, энхрийлэн хайрлагддаг. Гэхдээ жинхэнэ Бурханы хутагт хүрэгч л ингэж чаддаг. Хараахан Бурханы хутгийг олоогүй бол тийм боломжгүй. Жишээлбэл, та их сургуулиа төгсөөгүй, мэдлэггүй бол хэчнээн хүнд танилцуулж, хэчнээн хүн сайшаан магтлаа гээд ямар ч нэмэр болдоггүйг та өөрөө мэднэ. Хэсэг хугацаанд мэхэлж чадлаа ч удалгүй баригддаг. Бурхан биш хойно үүрд хуурч чаддаггүй.

Энэ бүх зүйл хүслийн чинь дагуу бүтдэг юм биш. Эсвэл ямар нэгэн бүлгэмийн сурталчилгаанд найдан бүтээдэг юм биш. Эрхбиш орчлонгийн бүтээгчийн зохицуулалтаар сая болдог хэрэг. Бүх орчлонд зөвшөөрөгдвөл болно, ойлгож байна уу? (Бүгд алга ташив.) Гэхдээ сонгогдсоны дараа баларсан явдал болж гэдгийг мэдээрэй! (Багш болон бүгд инээлдэв.) Танд өөрийн гэсэн цаг зав, санал шаардлага, ажил төрөл, хайр, сэтгэл гэж үгүй болдог. Бүх орчлон таных болдог хэдий ч хэн нэгэн таных биш. Бүх орчлонд та туслах хэрэгтэй боловч танд тусалчих хүн орчлонд ганц ч байдаггүй. Энэ бол маш аймшигтай байр суурь юм. Нэг хүн тэгж өнчрөн ганцаардах байдлыг та нар төсөөлж чадах уу? Үүнийг л Бурхан гэдэг.

Тиймээс бид иймэрхүү ил тод харагдан Бурхан болдог хүнийг өрөвдөх хэрэгтэй. Бахархмаар хэрэг биш. Өнчрөн ганцаардах зовлонг амсахаас гадна бас олон хүний бишрэл, жөтөөрхөл, гүтгэлт, эндүүрэл, үл ойлголцлыг хүлээн авдаг болохоор ажлыг нь саатуулдаг. Нэг талаар ажиллан, нөгөө талаар гүтгэлгийг нь сонсох хэрэгтэй. Хэн ч таныг ойлгодоггүй хэдий ч мөн л

үргэлжлүүлэн ажиллах хэрэгтэй. Гэхдээ бас тийм зовуурьтай биш. Би бас тэвчиж дөнгөнө. Ингэж ярьж байгаа нь зөвхөн та нарт бурхан болох байдлыг жаахан мэдүүлж, дэмий битгий хий бодоорой гэж сануулах гэсэн хэрэг. Мэдээж дээд дэсийн хүслэнт оронд тэр бол хамгаас шилдэг нь байдаг. Гэвч энэ дэлхийд амьдарч, энэ дэлхийтэй харилцаа холбоотой, махан цогцостой байдаг л юм бол тоолшгүй олон зовлон зүдгүүр амсдаг. Гэхдээ мөн л хүлцэн тэвчиж чаддаг. Нэгэн эгэл хүн ийм ажлыг хийж, тийм их зовуурийг амсахад хүрвэл дорхноо тоос тортог болж замхрахад хүрнэ. Гэхдээ алгуурхнаар ч биш, анхны өдөр эхэлж зовлон амсангуут тоос тортог болчихно.

Та нар Мял богдын түүхийг санаж байна уу? Түүнийг нас барах үеэр (хүн түүнд атаархаж хор уулгасан) хор уулгасан тэр хүн дахин ирж, маш даруу, тун хуурамч нигүүлсэнгүйгээр: “Багш аа, та агуу их хүн, яасан ч нас барж болохгүй, өвчин зовлонгоо шавьдаа өгөөрэй!” гэж уйлан хэлжээ. Энэ нь зовлонг чинь би үүрч, таны өмнөөс үхье гэсэн утгатай.

Тэгэхэд Мял богд: “Болохгүй, та тэвчихийн аргагүй, та ингэж чадахгүй.” гэжээ. Тэр хүн мөн л гуйгаад л байв. Учир нь тэр Мял богдыг хуурмаглаж байна, өвчнөө түүнд дамжуулж чадахгүй байж магад (шид байхгүй гэсэн санаа) гэж бодсон байна. Тэр удтал гуйгаад байхлаар Мял богд туршиж үзэхээр урьдаар зовуурьт байдлаа хаалганд дамжуулсанд хаалга дорхноо үнс болжээ. Тэр хүн мөн л эс үнэмшиж: “Хаалганд битгий дамжуул, надад дамжуул. Ингэвэл таны зовлон арилах болно.” гэв. Мял богд арга буюу түүнд өвчнөө жаахан дамжуулав. Бага зэрэг л дамжуулсан байтал тэр газар өнхрөн унаж, яахын аргагүй өвдөж, хүлцэн тэвчиж чадахаа болив. Тэгээд сая Мял богд жинхэнээр зовлон амсан, тоглоом хийгээгүйг тэр ойлгосон аж.

Бурханы хутагт хүрэгсэд, эсвэл Төгс Гэгээрсэн Их Багш нарын ихэнх нь эмгэнэл зовлонгоо үргэлж ярьдаггүй. Ярилаа ч гэсэн маш хошигнох дүр үзүүлж тийм ч их дарамтгүй шиг санагдуулдаг. Тэдэнд гашуун зовуурь байхгүй биш. Бидний зовлон, бидний үйл түйтгэр бол зөвхөн өөрийн чинь ганцхан хүнийх болно. Гэтэл нэгэн Бурханы хутагт хүрсэн хүн бол өөрийгөө золиосолж, бүх ертөнцийн хэцүү зовуурийг өөрийн болгох хэрэгтэй. Ингэснээр л дэлхий ертөнц сая өсөн дэвшиж, хөгжин бадарч чадна. Хамаг төрөлтний үйл түйтгэрийг тэр үүрэх хэрэгтэй. Үйл байвал үртэй, нэгэнт тарьчихсан үйл юм хойно үүрэхгүй байхын аргагүй. Гэхдээ хэний тарьсан үйл ч бай, үрийг нь тэр амсах хэрэгтэй. Ойлгож байна уу? Үүнийг л Бурхан гэдэг.

Бурхад маш олон зэрэг дэсийн ялгаатай. Харин бүгд яг адил байдаг биш. Гэвч тэд бол нэг цогц. Бурханы хутагт хүрэгсэд хоорондоо дээд, доод гэж ялгаварладаггүй хэдий ч бас ялгаа зөрүүтэй. Яг л их сургуульд профессор их байдаг ч зарим нь нас ахиж үлэмж туршлага суусан, зарим нь дөнгөж сургуулиа төгсөж багш болсон байдаг, тийм биз дээ? Зарим нь сургуулийн захирал болно.

Бурхан Бодьсадва мөн л ийм. Хэдийгээр түвшнээр нь ялгаварладаггүй гэж хэлдэг боловч үнэндээ өөр өөрийн гэсэн түвшинтэй. Гэхдээ үүнийг эгэл хүмүүсийн үзэл бодолд хандаж ярьсан хэрэг. Бурхан Бодьсадва нарын хувьд: “Би Бурханы хутгийг олоод нэлээд уджээ, та бол дөнгөж олсон байна.” гэж ялгаварладаггүй бөгөөд: “Надад туршлага их байна, төрөл төрөлдөө маш олон хүнийг сургасан. Та бол дөнгөж Бурханы хутагт хүрсэн болохоор шавь гэмээр хүн ганц, хоёрхноос хэтрэхгүй шүү!” гэж хэлдэггүй.

Тэд заримдаа бас хоорондоо байр сууриа солилцдог. Тиймээс судар ном уншвал Манзушир Бурхан бол үнэндээ арван зүг, гурван цагийн бурхдын багш мөн. Гэтэл Шагжамуни Бурхан энэ дэлхийд буун ирж ном дэлгэрүүлэх үеэр тэр харин Шагжамуни Бурханы шавь нь болж хувираад ном хамгаалагч Бодьсадва болж, хаана очсон ч Шагжамуни Бурханд тусалж ном дэлгэрүүлснийг мэдэж болно. Тиймээс жинхэнэ байдлыг нь бид яаж мэдэж чадах билээ? Харанхуй мунхаг гэгч үнэхээр аймшигтай, ялгаварлах сэтгэл гэж бас л “агуу их” гэдэг нь аргагүй. (бүгд инээлдэн алга ташив.)

Бурхан Бодьсадва яагаад ингэж байраа солих хэрэг гардаг гэвэл тэдэнд хиймээр ажил төрөл гэж байхгүй, тун уйтгартай (Бүгд инээлдэв.) байдаг болохоор юу хүснэ, түүнийгээ хийдэг. Тэдний хувьд байр суурь гэх ухагдахуун байдаггүй тул сонголт хийдэггүй. Бидэн шиг хаа сайгүй очиж, сонгуулийн хүн хайдаггүй. Хэн нь нэлээд сайн, хэн нь сайн биш гэдгийг анхаарч тоодоггүй. Энэ ертөнцөд ирж, хамаг төрөлтнийг гэтэлгэдэг л бол арван зүг, гурван цагийн бурхад бүгдээрээ таныг дэмжин тусалж, шавь чинь, туслагч чинь, бядуу шадарлагч чинь, эсвэл гэрээс гараагүй ахмад шавь чинь, гэрээс гараагүй шавь чинь, ном хамгаалагч гэхчилэн болдог. Тэд зар сурталчилгаа хийж, ном тайлж, ном дэлгэрүүлэхэд чинь тусалдаг. Ингэх нь Бурхан Бодьсадвагийн хувьд тун энгийн хэрэг билээ. “Гэхдээ эцсийн эцэст түүнийг Бурхан гэдгийг нь хүн болгон мэдэх болно.”

Бид маш олон төрөлтөнд туслах шаардлагатай. Гэхдээ биднийг дасгалжуулж бурхны дэсэд хүргэх гэх нь бас л тун хялбар бус хэрэг мөн. Учир нь бид энэ ертөнцөд маш удтал амьдарсан

болохоор өөрийн байр сууриа мартчихжээ. Төрөл төрөлдөө эгэл хүн болж дадчихсан тул гэнэт дахин бурхны байрандаа буцахад тун бэрх, ойлгож байна уу? Бэрх гэдэг нь бид өөрийгөө хүлээн авч чадахгүй болохоор л бэрх байдаг хэрэг. Харин бид бурхан бус гэсэн биш, харин мартчихжээ.

Дөнгөж сэрсэн тэр эгэл хүмүүс, жишээлбэл, саяхан авшиг авсан хүмүүст найдвал тэдний бодол санаа нь мөн л хувирч амжаагүй бөгөөд биедээ итгэлгүй болохоор хамаг төрөлтнийг яаж гэтэлгэж чадах билээ? Иймээс бурхан бүхэн бууж ирэхдээ бүгд л өөрийн хүмүүсээ дагуулж ирдэг. Хэн ч бай, Төгс Гэгээрсэн Их Багшийг ихэд дэмжиж, сургаал ёсыг нь гүнзгий ойлгож, бясалгалын аргад нь гүн итгэдэг бол тэр хүмүүс Бодьсадва мөн. Эртний Богд Гэгээнтэн буюу эртний Бодьсадва нар мөн л ийм. Ондоо зүйл биш, ойлгож байна уу?

Тиймээс та нар хар, Шагжамуни Бурханы шавь нар нь ихэд билиг нээгдэн авшиг авмагц Архад болж, Бодьсадва болж, тэр даруйхан түүнийг дэмжин тусалж, олон газарт очиж, жинхэнэ сургаал ёсыг нь уламжлан дэлгэрүүлжээ. Учир нь тэд аль хэдийн хийж чадсан байдаг. Бид бас Бодьсадва ч байж мэднэ. Бурхан ч байж магад, өөрийгөө битгий дорд үз. Та нар Багшийнхаа ярьсанд итгэхгүй байж мэднэ. Гэхдээ бас туршаад үзэж болно. Хэрвээ бид нээрээ Бурхан Бодьсадва мөн бол, хэрвээ Багшийнх нь ярьсан үнэхээр зөв бөгөөд үнэн бол (Бүгд алга ташив.) өөрийгөө хэн болохоо мэдэх аз завшааныг алдчих нь даанч харамсмаар хэрэг биш үү?



## БОДСАДВА МАХАСАДВАГИЙН АЖИЛ ТӨРӨЛ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар  
Тайваний Тайбэй  
1986 оны 10 дугаар сарын 4-ний өдөр  
(Эх нь хятад хэлээр)*

Буддын шашинд та нар “Махасадва”, “буддын шашны Махасадва” гэж дуудахыг байнга сонсдог. Үүнийг бумбын шашин болон католик шашинд “Богд гэгээнтэн” гэж нэрлэдэг. Махасадва гэж чухам юуг хэлдэг вэ? Махасадва бол самгарьд хэлнээс гаралтай үг. Их бодсадва, Их богд гэсэн утгатай. Бодсадва гэдэг нь бодь садва гэх самгарьд хэлнээс шууд орчуулагдсан үг юм. Бодь гэх үгийн утга нь Гэгээрсэн, билиг нээгдсэн хүнийг хэлдэг. Са гэдэг нь хамаг төрөлтнийг заадаг болохоор садва гэдэг нь нэгэн билиг нээгдсэн агуу их хүн гэсэн утгатай. “Mahanta”-г хятад хэл рүү хөрвүүлбэл “mo he sa 摩訶薩” гэж бичнэ. Маш их гэсэн утгатай. Maha гэдэг нь самгарьд хэлэнд агуу их гэсэн утгатай. Жишээлбэл, Mahatama, Maharish, Mahabuddhi гэх мэт.

Шагжамуни Бурхан Бурханы хутгийг олсон газрыг бид Mahabuddhi гэж нэрлэдэг. Хятад хэл рүү орчуулбал бодь бясалгалын газар болно. Энэ бол маш том газар, нэгэн билиг нээгдсэн газрыг заадаг. Бүхий л Maha гэх үгэнд их, агуу их гэх санаа агуулагддаг. Иймээс Mahatma нь Maha болон Atma-аас нийлэн бүтжээ. Maha бол их, Atma бол сүнс гэсэн утгатай, нийлбэл “их сүнс” гэсэн утгатай үг болно. Нэгэн том бясалгалтны сүнс нь хөгжин дэвшээд маш өндөр түвшинд хүрч, энгийн хүнтэй адилгүй болно. Иймээс түүнийг Mahatma гэж нэрлэдэг.

Энэтхэгт богд гэгээнтэн Гандийг Mahatma Gandhi гэж хүндэтгэн дууддаг. Тэд агуу их хүний нэрийнх нь өмнө Mahatma гэдэг үг нэмж хүндэтгэн дууддаг. Үүнээс бусад Maharishi гэх дуудлага нь мөн л Mahatma-аас үүсэлтэй. Maha гэдэг бол том юм, Rishi бол харж чаддаг хүн гэдэг утгатай. Гэхдээ энгийн нүдээр харах биш, хэтийдсэн чадвараар хардаг болохоор “тэнгэрийн нүд” гэж нэрлэж болдог бөгөөд өнгөрсөн, одоо, ирээдүйг харж чаддаг. Хэрвээ нэгэн Rishi нь ийм агуу их чадвартай бол Энэтхэгчүүд хамгийн дээд Rishi-г Maharishi гэж нэрлэдэг. Энэ нь миний саяхан ярьсан Maha, Atma хоёрын байдалтай адил.

За одоо, Бодьсадва Махасадва өөрөөр хэлбэл “Их Бодьсадва” гэсэн утгатай үгийн тухай ярья! Бид магтаал дуу дуулахдаа үргэлж “Наму хомшим (Арьяабал) Бодьсадва Махасадва”, “Маха билиг барамид” гэх мэтээр нэрлэдэг. Одоо би үүнийг та нарт тайлбарлаж өгье!

Маха билиг барамидыг самгарьд хэлээр Mahaprajna Paramita гэдэг. Хятад хэлэнд орчуулахдаа авиаг нь орчуулаад утгыг нь орчуулдаггүй тул маха билиг барамид болов. Түүний утга нь “Гүн билиг ухаан” буюу “Их хүчин” “Их мөр” гэх санааг илтгэдэг. Барамид гэдэг нь “тэртээ эрэгт хүрэх”, “биелүүлэх”, энэ үйл хэрэг буюу энэ юмыг хамгийн дээд хүчинд хариулах гэсэн утгатай. Энэ нь цаглашгүй сэтгэлээ хөгжүүлэх гэсэн санаатай адил.

Махасадва бол дээд дэсийн Бодьсадваг хэлнэ. Тэгвэл түүний ажил төрөл нь юу байдаг вэ? гэвэл саяхан би маха билиг барамид гэдэг нь хамгийн их, хамгийн дээд билиг ухаан, хамгийн их хүч, их мөрийг заадаг гэж ярьсан. Тийм их билиг ухааныг яаж олдог вэ? гэвэл эрхбиш нэгэн Махасадваг хайж олох хэрэгтэй. Энэ Махасадва нь дээд дэсийн Бодьсадва. Түүний ажил нь эгэл хүний хардаг юм уу шүүмжилдэг шиг тийм байдалтай биш бөгөөд тэд чухам хэн болохыг нь таньж чадахгүй. Ийм Махасадваг хайж олоход тун бэрх. Өдөр бүр уулзаж, замд тааралддаг ч биш, эсвэл зах зээлээс худалдан авч чадах биш. Түүний ажил нь маш онцгой. Ямар онцгой тал байдаг бол?

Тэр энэ ертөнцөд ирэхдээ нуун далдалдаг. Ихэнх бясалгагчтай адилгүй. Бусад хүн бол үйл ажиллагаа ихтэй. Торго дурдангаар хувцаслаж, том сүм хийд байгуулдаг бөгөөд бас машин жолоодож, их мөнгөтэй, олон шавьтай байдаг ч байж мэднэ. Гэтэл Махасадва тийм биш, харахад тун энгийн, эгэл жирийн, тэр ч байтугай тэж ийх нэрд гараагүй байж мэднэ. Яагаад гэвэл түүний ажил нь бусад их багш буюу номын багш нарынхаас өөр. Энэ ертөнцөд ирээд хөгшин сүнсийг дагуулан дээш явдаг. “Хөгшин сүнс” гэдэг нь урт

сахалтай, эсвэл бууралтсан үстэй хүн биш, нэгэнт гэртээ харихаар бэлтгэчихсэн сүнсийг хэлж байгаа юм.

Бэлтгэх гэдэг нь юуг хэлдэг вэ? Ачаагаа янзалж, онгоцны тасалбараа худалдан авахыг бэлтгэх гэх үү? Тийм биш, гэртээ харихаар бэлтгэх гэдэг нь чин сэтгэлээсээ харихыг хүснэ. Хаашаа харих вэ? “Эх нутаг”-таа харина. “Эх нутаг”-ийг католик шашинд “Диваажин” гэж, бурхны шашинд “Нирваан”, эсвэл баруун зүгийн Төгс баясгалант орон гэх мэтээр нэрлэдэг. “Эх нутаг”-аа дурсан санаж, нэгэн үзүүрт сэтгэлээр эх нутагтаа буцахыг хүснэ. Хөгшин сүнс нь тун залуу, хар үстэй харагдаж ч мэднэ. Харин нэгэн өндөр настны сүнс нь маш залуу байж мэднэ.

Сүнс бол жинхэнэ билиг барамид мөн. Сүнс нь угаас билиг барамидтай адилхан. Өөр зүйл байхгүй. Тэр бол их билиг ухаан, их мөр, уг дүр, бурхан чанар мөн. Гэвч энэ ертөнцөд ирэхдээ олон давхар хувцсаар хучигдсан болохоор уг дүрээ мартчихдаг. Нэгэн сүнсээр жишээлбэл, нэгэн сүнс гэж яривал та харин нэгэн төрөлтөн гэж бодож мэднэ. Үнэндээ адилхан утгатай. Энэ Махасадва, энэ дээд дэсийн төрөлтөн бол маш өндөр түвшнээс нэлээд доогуур түвшинд ирсэн байна. Жишээлбэл, энэ ертөнцөд ирэхдээ эрхбиш өөр нэгэн бие цогцосын хувцас өмсөх хэрэгтэй. Яг л бид биедээ хувцас өмсдөгтэй адилхан. Жишээлбэл, Тайвань бол бүгчим халуун орон, гэтэл Герман улсад очихдоо зузаан хувцас өмсөх хэрэгтэй. Герман улсын төв хэсэг рүү ойртох тусам хувцсаа зузаалах хэрэгтэй. Багш чинь Германд очвол та нар намайг харж чадахгүй байж мэднэ. Учир нь биедээ зузаан хувцас өмсөж, гадуур нь дахин цув нөмрөн, малгай өмсөж, зөвхөн хоёр нүдээ л ил гаргадаг. Ингэснээр бусад хүн намайг таньдаггүй бөгөөд өөрөө өөрийгөө ч харж чадахгүй болно. Бүх биеэ хувцсаар ороосон болохоор толинд хараад өөрийгөө танихгүй болдог. Тэгээд гадаа гарвал бас салхинд цохиулна. Цасан шуургатай өдөр гадуур гарвал хацар улайн нулимс урсдаг. Гадаа дэндүү хүйтэн болохоор гараад ирэхэд царай төрх ондоо болчихдог. Хэрвээ үсээ гоё сайхан янзалж гарсан бол цасанд бороод өөр хэн нэгэн хүн болчихсон мэт харагдана. Эр нөхөр чинь ч танихгүй байж мэднэ.

Үүнтэй адил, нэгэн цэвэр цайлган сүнс дээд түвшнээс бууж ирэхдээ маш олон хувцас өмсөх хэрэгтэй болдог. Тиймэрхүү хувцсыг өмссөний дараа бид одоогийн ийм байдалтай болдог. (Багш биеэ заав.) Хамгийн дотоод дахь хувцас нэлээд нарийн байж мэднэ. Гэвч гадагшлах тусам зузаан хувцас өмсөж, энэ ертөнцөд ирвэл одоогийнх мэт хав хатуу байдалтай болж, толгой тархи сэргэг бус, бие махбод ч хав хатуу болдог. Дараа нь энэ



хувцсаа өдөр бүр өмсөх хэрэгтэй бөгөөд дэндүү удтал өмссөнөөс болж өөрийн уг дүрээ мартан хувцас бол өөрийн бие минь мөн гэж үздэг болно. Гэхдээ нэгэн Махасадва бидэнд тусалснаар, биедээ өмссөн зузаан хувцсыг алгуураар нэг нэгээр нь тайлж чадна. Ингэснээр бид өөрийн уг дүрээ харж чадна. Махасадва бидэнд туслан гадуур хувцсыг тайлж хаясны дараа тэр бүх хувцсыг дахин өмсөх дургүй болдог. Жишээлбэл, Герман дахь миний байшин халаалттай. Дулааны хэмжээг Тайваньтай адил дулаан болтол зохицуулж болно. Маш тав тухтай, зузаан хувцас өмсөх шаардлагагүй. Харин гадаа гарахдаа зузаан хувцас өмсөх хэрэгтэй.

Махасадва ч ийм, энэ ертөнцөд ирэхдээ бас бидэнтэй адил хувцас өмсөх хэрэгтэй. Гэхдээ өөрийн өрөөндөө зузаан хувцас өмсөх шаардлагагүй. Учир нь халаалттай тул өрөөндөө байхдаа хувцасгүй байсан ч хамаагүй. Гэтэл ажиллахаар гадаа гарах хэрэгтэй учраас мөн л хувцас өмсөх хэрэгтэй. Энгийн хүний өрөөнд халаалт байхгүй бол өрөөндөө байсан ч зузаан хувцаслах хэрэгтэй. Тэгээд удаан өмссөний дараа дадал болж, эсрэгээрээ харин өөрийнхөө хэн болохоо мэдэхээ больдог. Өдөржин энэ гадна талын харанхуй бүдэг хувцсаа хараад энэ бол миний уг дүр мөн гэж боддог. Үүнтэй адилаар нэгэн сүнс энэ ертөнцөд ирэхдээ маш олон хувцас өмссөний дараа хаяж түвдэхээ больж, нэгмөсөн дадаж, энэ “хувцас”-ндаа хүлэгдэж, “бие цогцос”-тоо бүр ч ихээр хүлэгдэж, салж түвдэхгүй болохоор дээш гарч чаддаггүй. Сүнсний эх нутагтаа буцаж чадахгүй болдог.

Саяхан би Махасадвагийн ажил нь маш онцгой гэж ярьсан. Тэр ямар ажил хийдэг вэ? гэвэл бид хэзээ нэгэн өдөр энэ зузаан, хав хар хувцаснаас үнэхээр залхаж, ядаргаатай санагдахаар: “Ийм олон хувцсаа явал орхиж чадах билээ? Энэ бүхнийг өмсмөөргүй байна, тайлах арга байгаа болов уу? Яасан хүнд юм? Муухай мөртлөө юу хийсэн ч амар хялбаргүй, эрх дураар явж чадахгүй, явал сая нэг эрх дураараа болж чадах бол?” гэж өөртөө хэлж, хүн хайж хувцсаа тайлуулахаар яардаг. Энэ үеэр Махасадва илрэн бидэнд тусалж, энэ бүх хувцсыг тайлах боломжтой болдог. Гэхдээ энэ ертөнцөд амьдрахад заавал өмсөх хэрэгтэй бөгөөд өмсөх ёстой. Гэтэл Махасадва хувцас өмсдөг ч бусадтай адилгүй. Хувцсандаа хүлэгддэггүй, тайлах гэвэл тайлж, огоорно гэвэл огоорч чаддаг бөгөөд тайлсан хувцсаа дахин өмсөж болдог. Гэтэл ихэнх хүн хувцаснаасаа салах дургүй байдаг. Энэ бол Махасадва болон эгэл хүн хоорондын хамгийн их ялгаа зөрүү болно.

Нэгэн Махасадвагаас суралцсаны дараа бид бие махбодоо

нэг нэгээр нь орхисоор “Эх нутаг”-руугаа буцахад хүрдэг. Сүнсний эх нутагт энэ бие махбодыг хэрэглэдэггүй бөгөөд тийм их төвөг бэрхшээл байдаггүй. Идэх уух, бие засах мэтийн асуудал байдаггүй, юуг ч хэрэгсдэггүй. Гэхдээ маш баяр жаргалтай. Ийм баяр жаргал нь кино үзэх, бүжиг бүжиглэх, ховор нандин амтат идээ идэх юм уу нөхөр, гэргийн хоорондох баяр жаргалтай адилгүй. Эгэл ертөнцийн баяр жаргал нь тийм сайн биш, бүгд л биднийг хүлээсэлж, биднийг мэхлэн бидэнд жинхэнэ баяр жаргалыг ойлгож таних завшаан олгодоггүй. Тиймээс энэ ертөнцийн баяр жаргалд найдаж болохгүй. Энэ ертөнцийн баяр жаргалыг баруун зүгийн Төгс баясгалант орон буюу диваажингийн баяр жаргалтай адилтгахын аргагүй бөгөөд огт ондоо. Эгэл хүний бодлоор тэндхийн баяр жаргалыг төсөөлөхийн аргагүй.

Гэхдээ нэгэн Махасадвагаас суралцсаны дараа тийм баяр жаргалыг жаахан амталж болно. Түүнээс суралцан үгийг нь дагаж, зааврыг нь мөрдвөл баяр бахдалт рашаан усыг ч жаахан ууж болно. Ингэснээр сая “аюулгүй” болно. Гэвч аюулгүй гэдэг нь зорьсон газартаа хүрснийг илтгэж байгаа биш. Мөн л илүүхэн бясалгах хэрэгтэй, улам их бясалгавал улам сайн, энэ бол сая бидний амьдралын жинхэнэ зорилго болно. Гэтэл ихэнх хүн амьдралын зорилгоо мартан, цаг заваар дэндүү давчуу болжээ гэж ярин, мөнгө олохоор ихэд яардаг. Энэ ертөнц янз янзын аргаар биднийг хүлээсэлдэг. Заримдаа ямар ч аргагүй болгодог. Мөнгө олохоо больж, бясалгал хийх гэхээр эхнэр, хүүхдээ яах билээ. Угаас борог бааздуухан хувцастай явахыг боддог ч хөршүүд нь хээнцэр ганган хувцасладаг болохоор биедээ элэгдэж хуучирсан хувцас өмсвөл санаа зовох болно. Хүүгээ их сургуульд сургахгүй бол бас л болохгүй. Учир нь хөршийн чинь хүү их сургууль төгссөн болохоор хүү маань ч адилхан байх хэрэгтэй гэж бодно.

Энэ нийгмийн аливаа бүхэн нь биднийг өөрийн эрхгүй бусадтай өрсөлдөхөд хүргэж, өрсөлдөөн ч их, улам төвөгтэй, улам л ээдрээтэй болдог. Тэд зурагттай, тиймээс бидэнд ч бас байх хэрэгтэй. Үгүй бол хүүхэд чинь гэртээ хариад: “Нөгөө айлын хүү том зурагт худалдан авсан байхад манайд яагаад байхгүй байна.” гэж гомдоллох болно. Нээрээ бухимдалтай хэрэг! Тиймээс аав нь мөнгө олохоор арга бодож, хулгайлах, эсвэл зээлэх гэх мэтийн аргаар зурагт худалдан авдаг. Аав нь хүүгээ дэндүү хайрладаг болохоор хөршийнх нь зурагттай байхад өөрийнд нь байхгүй бол ихэд зовнино. Хөршийнх нь хүүхэд их сургуульд сурдаг байхад өөрийнх нь хүү сурахгүй бол мөн л сэтгэл шанална.

Тиймээс энэ ертөнц нь биднийг албадаж, биднийг хүлээсэлж,

салахын аргагүй болгож, мөнгө төгрөгийг тоохгүй байхын аргагүй болгодог. Өөрт нь угаас тийм ч их мөнгө хэрэггүй. Гурван удаагийн хоол, хэдхэн солих хувцас байхад болчихно. Ялангуяа эрчүүдэд олон хувцас хэрэггүй, бүсгүйчүүд бол арай олон хувцас шаардлагатай бөгөөд будаж шунхдах буюу заримдаа бас үсээ буржийлгах хэрэгтэй. Гэтэл эрчүүд бол маш амархан, хоёр гурван солих хувцастай бол болчихдог. Зарим хүнийг харахад ганцхан жийнсэн өмдтэй ийш тийш явж, олон хоног ер сольдоггүй. Нэг хүний жинхэнэ зардал маш хязгаартай. Тийм үү, үгүй юү?

Гэтэл хүн болгон тун завгүй, өдөржин ийш тийш явж мөнгө олдог нь юуны төлөө гэвэл гэр бүлтэй, эхнэр, хүүхэдтэй болохоор нэр ашгийн асуудал үүсдэг. Хэрвээ өөрийнхөө төлөө биш бол бас эхнэр, хүү, эцэг, эх, хамаатан садан, найз нөхдийнхөө төлөө өдөр бүр ийм тийм юманд яаран сүнсний эх нутаг руугаа буцна гэдгээ мартдаг. Тэд бясалгах зав байдаггүйн шалтгаан нь зөвхөн ийм л төдий байдаг.

Тиймээс эгэл ертөнцийн баяр жаргал нь диваажингийнхтай адилгүй. Ертөнцийн баяр жаргал нь жинхэнэ үйл түйтгэр мөн. Харин жинхэнэ баяр жаргал биш. Биднийг энэ ертөнцөд хүлээсэлж, биднийг завгүй болгож, жинхэнэ үнэ цэнтэй асуудал, энэ ертөнцөөс гаднах учир явдлыг бодох цаг хоромхон ч олгодоггүй.

Урьд нь би зарим орноор явсан, тэд ардчилсан засгийг хэрэгжүүлдэггүй. Багш нь улс төрийн хэргийг шүүмжилж байгаа биш. Би энэ ертөнцийн улс төрийг хамаардаггүй, ардчилалтай эсэхийг нь бүр ч хамаардаггүй. Хүн төрөлтөн өдөр бүр ийш тийш яаран энэ жижигхэн ертөнцдөө дайтдаг. Үүнийг харахаар надад яг л хүүхдийн тоглоом шиг ямар ч хэрэгцээгүй санагддаг. Гэхдээ би та нарт эдгээр улсын түүхийг ярьж байгаа нь жаахан харьцуулсан төдий л зүйл. Би ямар ч улсад харьяалагдахгүй. Энэ ертөнцийн хувьд би бол дэлхийн нэг иргэн. Харин аль нэгэн улсын иргэн биш, тиймээс Багш нь өнөөдөр улс төрийн хэргийг ярихгүй. Та нарт зөвхөн түүх ярих гэснийг минь ойлгох хэрэгтэй.

Би тэр улсад очиход тэнд маш хүйтэн байсан. Дараа нь дэлгүүрээр нь хэсэв. Тэр нь тусгайлан жимс, чихэр болон архи зардаг дэлгүүр байлаа. Хэчнээн архи, хэчнээн жимс, чихэр, жигнэмэг зарагдаагүйг яг тодорхой бичиж тэмдэглэдэг. Жишээлбэл, нэг эмэгтэй өглөө ажиллаж, нөгөө нэг нь үдээс хойш ажилладаг гэж бодъё. Өглөө ажилладаг хүн ажиллаж дуусаад буцахдаа үлдэж байгаа архиа хэмжиж, хэдэн хундага архи зарагдаагүйг тодорхой бичиж тэмдэглэх хэрэгтэй. Жишээлбэл,

энэ лонхонд хоёр хундага, нөгөө лонх нь хагас хундага архитай. Өөр нэгэн лонхонд гурван хундага гэх мэтээр бичиж тэмдэглэдэг. Чихэр болон жимсийг мөн л тэгнэ, энэ саванд хэчнээн шоколад байгаа, тэр саванд хэдэн тоор зарагдаагүй, сав болгонд зарагдаагүй чихэр, жимс, жигнэмэг хэчнээн байгааг бүгдийг нь бичиж тэмдэглэдэг. Дараа нь үдээс хойшхи ээлжийн хүн ажилдаа орохдоо сав болгон дахь зарагдаагүй үлдсэн архи, шоколад, чихэр, жимс хэд хэчнээн байгааг дахин нягталж, тэмдэглэлийн дэвтэр дээрхтэй тулган шалгадаг. Хэрвээ өглөөний ээлжийн хүний бүртгээн тоо нь бүгд зөв байвал тэрээр сая харьж болдог. Үдээс хойшхи ээлжийн хүн дахин хэчнээн бараа зарснаа мөн л бүгдийг тэмдэглэх ёстой. Өдөр бүр ийм, зочин байхгүй ч гэсэн тоо хэмжээг нь бүртгэн хулгайд алдахаас эмээдэг. Тиймээс заавал тодорхой шалган тэмдэглэх хэрэгтэй.

Ингэх нь таныг завгүй болгоно, юм бодох завгүй болгоно. Дэндүү завгүй болгоно, үнэхээр төвөгтэй. Тийм олон чихэр, жимс, шоколад, архийг эрхбиш бүртгэх хэрэгтэй болохоор Авид Бурханыг дурсахыг бодовч завгүй. Ум ма ни бад ми хум гэж уншихыг хүсдэг ч зав олдохгүй. Бодол тархинд нь нэг, хоёр, гурав гэх тоо л эргэлдэнэ. Энэ нь тэдний бясалгалын арга байж ч мэднэ. (Бүгд инээв.) Өдөр бүр нэг чихэр, хоёр чихэр, гурван чихэр гэхчилэн тоолох нь нээрээ тун яаруу. Иймээс тэдгээр улсад хувьсгал тун бага үүсдэг. Учир нь хувьсгал хийх завгүй, бүх цагаараа жимс, чихэр, шоколад тоолдог. Энэ арга маш сүрхий, цэцэн мэргэн арга. Нэг хүн нь хоёр хүнийг хариуцан хоёр хүн нь дахин өөр хүнийг хариуцаж, харилцан бие биеэ хариуцан захирдаг болохоор засгийн газарт хиймээр ажил үгүй, ямар ч хэрэг үүсдэггүй. Гэхдээ та нар бол өөрөө өөрийгөө хариуцан захирч, өөрийгөө өөрийн биедээ мэдүүлж, хэнд ч итгэж болохгүй. Найздаа ч итгэж болохгүй, хамаатан садандаа ч итгэж болохгүй.

Энэ ертөнцөд бид мөн л ийм биш үү? Аль ч нийгэмд гэсэн бүгд ийм, өндөр байр суурьтай болох гэвэл заавал бусадтай өрсөлдөх хэрэгтэй. Зарим хүн даргадаа тал засаж, өөрийгөө хамгийн үнэнч ажилтан мөн гэж магтуулахын төлөө даргадаа бусдын хов живийг ярьж, зөвхөн би бол хамгаас үнэнч, хамгаас хурдан ажилладаг, хамгийн сайн зүтгэдэг гэж хэлдэг. Ингэх нь мөн л ахан дүүсээ худалдаж байгаатай адил биш үү? Гэвч энэ ертөнц бол ийм, та өндөр тушаалд мацах гэвэл эрхбиш бусдыг хорлох хэрэгтэй. Учир нь ихэнх хүний баяр жаргал нь бусдын зовууриар золиослогддог. Заримдаа бусдыг зориудаар хорлохгүй ч нөхцөл байдлын улмаас өөрийн эрхгүй болдог. Учир нь энэ ертөнцийн

байдал ийм юм хойно.

Ингэж харилцан хорлож, угаас маш ариун, буянтай, ёс суртахуунтай байдлаа мартан, нэр ашгийн өмнө юуг ч танихаа больдог. Адын эзний хүч маш их, тэр янз янзын нэр ашиг, жаргал цэнгэлээр биднийг энд хүлдэг болохоор салж чаддаггүй. Тийм нэгэн Махасадва байхгүй бол бид гурван ертөнцөөс салж чадахгүй. Махасадва энэ ертөнцөд ирвэл бид түүнийг таних арга бий. Тэр өөрөө би бол Махасадва мөн гэж тунхагладаггүй. Эсвэл хармагц таних ямар нэгэн онцгой тэмдэг байхгүй. Байвч эгэл хүний нүдээр таньж чадахгүй.

Сонсож байх нь ээ, Шагжамуни Бурхан гучин хоёр лагшин дүр юм уу, наян сайхан лагшин дүртэй гэдэг. Гэвч энгийн хүн харж чадахгүй. Учир нь сайхан лагшин дүрийг гаднаас нь харж чадахгүй. Сайхан дүр нь түүний хувилгаан биед нь байдаг. Хувилгаан бие нь илрэх үед л сая харагдана, махан цогцосоос нь харахын аргагүй. Үгүй бол яагаад зургадугаар үеийн өвөг багш Хүй Нэн-д тийм сайхан царай төрх байгаагүй вэ? Сонсоход, түүний царай төрх нь тийм сайхан биш, нуруу намхан, хав хар царайтай гэсэн. Тавдугаар үеийн өвөг багш Хун Рэнь анх уулзахдаа бас: “Та бол нан ман (вьетнам) хүн, яаж Бурханы хутагт хүрч чадах вэ?” гэж загнасанд Хүй Нэн нэн даруй: “Яагаад хүрч чадахгүй байх вэ? Миний бурхан чанар таны бурхан чанартай яг л адилхан.” гэж хариулсан гэдэг. Иймээс гаднах байдал болон бурхан чанар нь харилцаа холбоогүй, тийм биз?

Гуан Чин ахмад хувраг мөн л ийм. Хэрвээ сайхан лагшин дүртэй байх хэрэгтэй юм бол Гуан Чин ахмад хуврагийн дүр байдал нь бас тийм онцгой биш. Намхан биетэй, Багшийнх нь биеэс тийм ч зөрүүгүй. Тэр ч байтугай надаас ч туранхай бөгөөд намхан. Ихэд бясалгал хийж, тун бага иддэгээс болсон байж мэднэ. Иймээс сайхан лагшин дүрийг эгэл хүмүүс харж чадахгүй.

Гэхдээ нэгэн Махасадваг таньж болно. Яавал сая түүнийг таньж чадах вэ? Нэгэн Махасадва бусдыг сургахдаа хамгийн дээд бясалгалын аргыг заадаг. Тэр таны буян хураасан эсэх, ач буян үйлдсэн эсэх, түүнийг тахиж шүтэх эсэхийг хамаардаггүй бөгөөд үргэлж сүм хийдэд очиж мөргөдөг эсэх, буддын шашин, эсвэл католик шашныг ойлгох эсэх, мөнгөтэй эсэхийг хамаардаггүй. Их сургууль, эсвэл бага сургууль төгсгөсөн гэдгийг ч хамаардаггүй. Учир нь энэ бүхэн нь түүнтэй холбогдолгүй, зөвхөн бясалгал хийж туулан гэтлэхийг боддог л бол бүгдийг нь шавиа болгодог.

Шавиа болгох гэдэг нь танд сахилын нэр хайрлан шүтэн дагуулах явдал биш, ингэх шаардлагагүй, шүтэн дагах бясалгалын

аргыг нас барах үед хэрэглэж чадахгүй. Авид Бурхан танаас сахилын нэртэй эсэхийг чинь асуухгүй. Нас барах үед гэм зэмтэй бол Эрлэг хаан мөн л таныг аваад явна, мөн л тамд унана. Амьддаа сайн үйл хийсэн нь муу үйл хийснээсээ их бол диваажинд очиж болно. Диваажин нь баруун зүгийн Төгс баясгалант орон биш, Төгс баясгалант орон бол бурхны ариун орон, диваажинтай ямар ч хамаагүй. Бидний эндхийн хоосон огторгуйг туулбал диваажинд очиж болно. Тийм диваажин нь жинхэнэ диваажин биш, харин Асурийн ертөнц болно. Гэхдээ маш гоё байдаг, жаахан буянтай бол тэнд хүрч, нэлээд удтал амьдарч, цаашилбал яг л мөнхрөх шиг санагдуулдаг. Гэвч мөн л хамгийн дээд нь биш, хожим энэ ертөнц мөн л мөхөн сөнөж, бид дахин унаж хүн, чөтгөр, амьтан, өвс мод гэх мэт болдог.

Нэгэн Махасадва бусдаар хүндлүүлж мөргүүлдэггүй. Эсвэл ач буян үйлдэх, сүм хийд, эмнэлэг байгуулах юм уу, дэлхийн энх тайвныг хамгаалах, нийгмийн журам дэглэмийг эмхлэн цэгцлэх, эсвэл ном дэлгэрүүлэх гэх мэтийг хийлгэдэггүй. Энэ бүхнийг хамаардаггүй, зөвхөн таныг дагуулан жинхэнээр диваажинд хүргэдэг. Учир нь тэр бол энэ нийгэмтэй харилцаагүй, энэ нийгэм төрөл төрөлдөө ийм байдалтай. Хамаг төрөлтөн төрөл төрөлдөө ийм байсан. Зарим хүн энэ ертөнцөд ирэхдээ бусдыг өглөг үйлдэх, сайн үйл үйлдэх, сүм хийд байгуулах, судар ном унших, маани тарни унших хэрэгтэй, ингэвэл ач буянтай болно гэж ятгадаг. Үнэндээ энэ бүхэн нь бүгд л биднийг завгүй болгохоос хэтрэхгүй. Харин төгс төгөлдөр зүйлс биш.

Өөрөө бясалгаж энэ замаар сүнсний эх нутаг руугаа буцах нь төгс төгөлдөр зүйл болно. Энэ замыг бид “Мөр” гэж хэлдэг. “Мөр” нь ганцхан байдаг, бусад нь чухал биш зүйл. Өглөг үйлдэх нь энгийн хэрэг, зарим хүн өлсөж байгаа болохоор бид хоол өгч идүүлдэг. Энэ нь бидний хүүхэд өлсвөл хоол идүүлдэгтэй адилхан, тийм ч сүрхий хэрэг биш. Иймээс Бурхан Багш Очирт сударт: “Өглөг үйлдэнэ, гэвч үйлддэггүй, ингэх нь сая жинхэнэ өглөг үйлдэх болно. Хамаг төрөлтнийг гэтэлгэдэг, гэвч гэтэлгэгдэх төрөлтөн байхгүй. Энэ нь сая жинхэнэ гэтэлгэж байгаа хэрэг болно.” гэж хэлсэн. Учир нь “би гэж байдаггүй болохоор “би” хийж байна гэх бодол төрөхгүйгээр өглөг үйлдэж, хамаг төрөлтнийг гэтэлгэж чаддаг. Жишээлбэл, хоол идэхдээ “би” үнэхээр сайн хүн, “би”-д хоол идүүлж байна гэж бид боддоггүй, тийм үү, үгүй юү? Энэ нь үнэндээ энгийн хэрэг мөн.

Тиймээс “өглөг үйлдэх”-ийг угаас онцгой сурталчлах шаардлагагүй. Угаасаа тийм сүрхий явдал алга. Хүн өлсвөл

бид хоол идүүлдэгтэй адил болохоор тийм ч сүрхий хэрэг биш. Эмнэлэг байгуулах нь мөн л адилхан, католик шашинтнууд олон эмнэлэг байгуулж, Америкчууд маш олон улс оронд эмнэлэг байгуулсан. Харь гүрэнд бас эмнэлэг байгуулж, Герман улс, Швейцар улсын улаан загалмайн нийгэмлэгт их өглөг өгсөн... Гэхдээ тэд бясалгал хийдэггүй. Мөнгөтэй л бол өглөг үйлдэж чадна. Сонинд нийтлэх юм уу, зар сурталчилгаа хийж, өглөг үйлдэх, хайр түгээх, энэрэн нигүүлсэнгүй сэтгэлтэй байгаарай гэж бусдыг уриалах шаардлагагүй. Нигүүлсэнгүй сэтгэл, хайр түгээх нь угаас байх ёстой хүн хоорондын нэг зүйлийн харилцаа юм. Үүнийг бид бага сургуульдаа нэгэнт сурчихсан болохоор том болсны дараа сүм хийдээр явж дахин сурах шаардлагагүй.

Нигүүлсэнгүй, түгээмэл хайр бол энгийн ёс суртахуун мөн. Хөршийнхөн ядарсан байвал бид тусална, яг л өөртөө туслах болон эр нөхөр нь эхнэр, хүүхдэдээ тусалдаг шиг, тийм ч сүрхий явдал биш. Өглөг үйлдэх юм уу, сүм хийд байгуулах, эсвэл ямар нэгэн ёс суртахуунтай үйл хийх нь хамгийн их шилдэг зүйл биш бөгөөд тэр бүхэнд найдвал диваажин луугаа буцаж чадахгүй. Учир нь хамгийн дээд, хамгийн төгс төгөлдөр түвшинд сайн, муу зүйлс байдаггүй, буян гэж байдаггүй бөгөөд үйл түйтгэр ч байдаггүй. Бидний ямар буян үйлдсэн, хэддүгээр түвшинд хүрсэн гэдгийг тэр хамаардаггүй. Хэчнээн үйл түйтгэр бүтээгээд тэнд очсоныг ч хамаардаггүй. Үнэндээ бидэнд үйл түйтгэр байдаггүй бөгөөд буян ч байдаггүй. Энэ ертөнц бүрэлдэн тогтохоос өмнө үйл түйтгэр гэж хэрхэн үүссэн байж болох вэ дээ? Тэр үе бол сая бидний “Уг дүр” мөн.

Нэгэн Махасадва, Их Жолоодогч Багш энэ ертөнцөд ирвэл тиймэрхүү өчүүхэн ёс суртахууны үйлийг дэндүү чухалчилдаггүй. Гэхдээ хүмүүст ёс суртахуунтай үйлийг битгий хий гэж сургадаггүй. Гэвч энэ бүхэн нь хамгийн чухал зүйл биш гэдгийг тэр мэддэг. Өдөр бүр сүм хийд, эмнэлэг байгуулах юм уу, ямар нэгэн өглөг үйлдэх гэх мэтээр цагаа дэндүү битгий үр, ийм хэргийг аялдан дагаж, хувь барилдлагын дагуу хийвэл зүйтэй. Харин буян юм уу, нэр алдрын төлөө зориудаар хийх биш. Учир нь энэ бүхэн бол төгс төгөлдөр зүйл биш. “Төгс төгөлдөр” гэдэг нь бясалгал хийж, туулан гэтэлж, хожим асар их хүчтэй болж, хамаг төрөлтнийг гэтэлгэнэ. Юугаар ч дутахгүй бөгөөд хамаг төрөлтөн юу хүснэ, түүнийг нь өгнө. Өгч чадахгүй зүйл гэж байдаггүй.

Махасадвагаас суралцвал нээрээ төвөг бэрхшээл тулгарах юм бол чин сэтгэлээсээ тэднээс тусламж хүсвэл дорхноо зөн совинтой болдог. Учир нь тэр үед Махасадвагийн бясалгал



нэгэнт ихэд дэвшиж, нэн их буянтай болсон тул хүссэн бүхнийг чинь өгч чадна. Гэхдээ бид шунахай сэтгэлийнхээ төлөө даатгаж огт болохгүй. Ингэвэл Бурхан ч танд туслах боломжгүй. Махасадвагийн ажил нь бидэнд тусалж, өөр нэгэн Махасадва, тийм нэгэн агуу их төрөлтөн болгож, хожим бид юугаар ч дутахгүй болдог. Хамаг төрөлтөнд юуг ч өгч чаддаг. “Бурхан болж, хамаг төрөлтнийг гэтэлгэх” гэдэг нь ийм санаа билээ.

Бурханы хутагт хүрэхээс өмнө хамаг төрөлтнийг гэтэлгэж чадахгүй бөгөөд гэтэлгэмээр төрөлтөн ч байхгүй. Хамаг төрөлтөнд өглөг үйлддэг ч үнэндээ үйлдсэн өглөг гэхээр юм байдаггүй. Бид хаанаас ирэв? Хамаг төрөлтөнд юугаараа өглөг үйлдэх вэ? Угаас гар хоосон ирж, гар хоосон буцдаг байхад юугаараа хамаг төрөлтөнд өглөг үйлдэх вэ? Гар хоосон ирж, гар хоосон буцдаг юм чинь ямар билиг ухаанаар хамаг төрөлтнийг гэтэлгэх вэ? Аливаа бүхэн угаас “Билиг барамид”-аас үүсэлтэй, “Их мөр”-өөс үүсэлтэй, Эзэн Бурхан, эсвэл өвөг Бурхан бүгд л энэ хамгийн дээд, хамгийн их хүч, хамгийн уугуул орноос үүсэлтэй гэж бид хэлдэг. Өөрөө юу ч үгүй болохоор өглөг үйлдмээр юм гэж алга. Зөвхөн бусдад түгээн тархааж байгаа төдий билээ. Жишээлбэл, би сав дүүрэн устай бол унд хүссэн хүнд жаахан уулгаж болно. Гэхдээ ус нь үнэндээ минийх биш, ус хаанаас ирсэн бэ? Нэгэн Эзэн Бурхан үнэхээр байгаа гэж үзвэл Эзэн Бурханаас үүсэлтэй. Хэрвээ нээрээ нэгэн өвөг Бурхан байгаа гэвэл тэр нь мөн л өвөг Бурханаас үүсэлтэй. Хэрвээ нэгэн хамгийн их хүчний бүтээгч байгаа гэвэл мөн л түүнээс үүсэлтэй. Ус бол минийх биш хойно “би” түүнд өгсөн гэж ярьж яаж болох вэ? Тийм үү, үгүй юү?

Надад ус байгаа гэж бодъё, тэгвэл агаарыг хэн надад өгсөн бэ? Агааргүй бол мөнгө төгрөг, эр нөхөр юм уу, эхнэр, хүүхэд, эд зүйлсээ бодохын завгүй дорхноо үхэхэд хүрнэ. Агааргүй болмогц даруй амиа алдана. Агаар бол хамгийн ховор нандин. Тийм үү, үгүй юү? Гэтэл агаар, хүчилтөрөгч биднээс огт мөнгө авдаггүй. Аливаа бүхэн агаарыг түшдэг. Нар бас хамгаас чухал байдаг, тэр аугаа их хүчтэй, наргүй бол хамаг оршихуй үүсэж төлжиж чадахгүй. Гэхдээ нарны гэрэл нь мөн л үнэгүй, тийм чухал, тийм дутагдаж боломгүй юмс бүгд үнэгүй юм чинь бид хүмүүст юу өгч чадах вэ? Агаар, наргүй болмогц бид дорхноо амиа алдана. Тиймээс бусдад өглөг үйлдсэн гэж өөрийгөө үзэж болохгүй.

Махасадваг танья гэвэл сургаал ёсноос нь таньж болно. Тэр бол энгийн хүнтэй адил зүйлсийг сургадаггүй. Ам нээмэгц: “Та өглөг үйлд, сүм хийд байгуул, гурван эрдэнэд бишир, гэрээс гарагч, эсвэл гэрээс гараагүй бясалгалтанг хүндэтгэх хэрэгтэй.”

гэх мэтээр ярьдаггүй. Тийм өчүүхэн хэргийг ярьдаггүй, ёс суртахууны тухай зүйлсийг үнэндээ хүн бүхэн мэдэх ёстой. Дахин ярих шаардлагагүй. Бага сургуульд байхад багш бидэнд сургачихсан. Тийм үү, үгүй юү? Хайрын сэтгэлтэй, нигүүлсэнгүй сэтгэлтэй байгаарай! Настнууд, сул дорой, тусламж хэрэгтэй нэгэнд тусал, цангасан хүнд ус ойртуул, өлсөж ядарсан нэгэнд хоол хүргэ гэхчилэн сургадаг. Эдгээр нь бүгд энгийн хэрэг, тийм ч сүрхий биш.

Тиймээс сургаал ёсноос нь энэ Махасадваг таньж болно. Түүний сургаал нь бусадтай адилгүй, биднийг түргэн бясалгах хэрэгтэй гэж сургадаг. Ном уламжлан, яаж бясалгах, яаж бясалгавал сая хамгийн дээд түвшинд хүрч, хамгийн түргэн дэвшиж, хүчээ талаар үрэхгүй байх талаар сургадаг. Учир нь цаг бол туйлын ховор нандин зүйл, маргааш нас барчихвал яах вэ? Өглөг үйлдэхэд найдах нь онгоцны тасалбар худалдан аваад диваажинд очиж чадахгүйтэй адил. Хайр энэрэлтэй байх нь тун сайн. Гэвч мөн л төгс төгөлдөр биш, мөн л онгоцны тасалбар худалдан авч диваажинд хүрэхэд тусалж чадахгүй. Иймээс хамгаас чухал нь нэгэн эрхэм Махасадвагай уулзаж, түүнээс энэ номын цогцосыг суралцан ямар “Мөр”, ямар “Зам” -аар явбал сая буцаж чадах, гурван ертөнцийг туулж чадах, үхэж төрөх сансрын хүрднээс мултарч чадахыг түүгээр заалгах хэрэгтэй. Махасадва биднийг дагуулан гурван ертөнцийг туулан, үхэж төрөхөөс гэтэлгэх болно. Энэ бол түүний цорын ганц ажил юм.

Та мөнгөтэй байгаад өглөг үйлдэх, эсвэл үйлдэхгүй байхыг тэр анхаардаггүй. Өглөг үйлдсэн, эсэх нь хамаагүй, тэр таныг дагуулж буцна. Урьд нь та үйл түйтгэр ихээр үйлдсэн байвал одоо харамсан гэмшиж, туулан гэтлэхийг хүсвэл тэр мөн л таныг дагуулан буцдаг. Өмнө нь та хүн алсан, садарласан юм уу, хулгай дээрэм хийж, маш олон муу хэрэг үйлдсэн бол, одоо дахин яасан ч хийхгүй гэж бодол шулуудвал тэр бүхнийг мартан уучлан өршөөж, тэр ч байтугай төрөл төрлийн чинь үйл түйтгэрийг угаан цэвэрлэдэг. Ингэх нь сая жинхэнэ Махасадва мөн. Бид түүнийг таньж суралцаж болно. Үгүй бол бясалгал хийхийг сургадаг “багш” их байдаг болохоор аль нь жинхэнэ багш, жинхэнэ Махасадва болохыг яаж мэдэх билээ?

Энгийн үед зарим хүн ихээр өглөг үйлдэх юм уу, ямар нэгэн сайн үйл хийдэг. Жишээлбэл, өвчтөн, ядарсан хүмүүст туслах гэх мэтийг харвал бид түүнийг Бодьсадва мөн гэж хэлдэг. Бодьсадва маш олон зэрэг дэстэй, Бодьсадва гэх нь бас буруугүй, учир нь хүн бүхэнд “Бодьсадвагийн сэтгэл” байдаг. Сэтгэлгүй хүн гэж

байхгүй. Хүн алсан нэгэн ялтны сэтгэлд бас “Бодьсадвагийн сэтгэл” нуугдан байж, өөрийн хүүгээ хайрлан санадаг. Хүүгээ энхрийлэн тэврэх үед хүн алсан ялтан биш, харин нэгэн сайн эцэг болчихдог. Энхэрээ энхрийлэн тэврэх үед ч хүн алсан ялтан биш, тэр үед нинжин сайхан сэтгэлтэй сайн эрэгтэй болдог. Гэвч гаднах муу нөлөөнд автсан юм уу, орчин тойрны нөлөөллөөс болж хүн алах, эсвэл хулгай хийдэг. Тэр бол угаас сайн хүн, найз нөхдөдөө маш нөхөрсөг, хамтдаа хоол идэж, ундаа ууж, наргиж цэнгэдэг. Тэр үед муу хүн биш. Ихэнх хүн “харанхуй мунхаг”-аасаа болж буруу хэрэг хийснээ мэддэггүй, хүн ер нь алдаа гаргадаг.

Тиймээс нэгэн Махасадвагийн хувьд хамгийн муу хүн, эсвэл уучилж болшгүй хүнд гэм хийсэн хүн байдаггүй. Тэр хүн болгоныг агуу их төрөлтөн, маш ариун сүнс гэж үздэг тул хэн ч бай түүнд шавилж болдог. Шавилах гэдэг нь зөвхөн яриад л болчих биш, харин шавийнхаа үйл түйтгэрийг ч хүлээн авч, үйл түйтгэрийг нь үүрч, төрлөөс төрөл дэх үйл түйтгэрийг нь угаан цэвэрлэдэг. Дараа нь өдөр бүр алгуураар дээш дагуулж гардаг. Ном уламжлах үед шавь нь дорхноо ахуй ойлголттой болж чаддаг. Жаахан билиг нээгдсэн ахуй ойлголттой болгож, жаахан итгэл төрүүлдэг. Үгүй бол Махасадва, эсвэл энгийн нэгэн Бодьсадва гэдгийг хэрхэн мэдэж чадах билээ?

Гадна бусдыг сургадаг багш их байдаг бөгөөд номын багш ч их байдаг. Гэхдээ үсээ хусуулчихаар л номын багш болчихдог биш. Номын багш гэдэг нь ном уламжилдаг багшийг хэлдэг болохоор “номын багш” гэж нэрлэдэг. Ихэнх хүн: “Энэ бол номын багш, тэр бол их номын багш” гэж байнга хэлдэг хэдий ч чухам хэн болохыг мэддэггүй. Гэтэл нэгэн Махасадвагай уулзвал дорхноо билиг нээгдэн гэрэл гялбаатай ахуй ойлголттой болж, биднийг Авид Бурхан (Amitabha)-ы цаглашгүй гэрэлтэй холбодог. Ингэснээр түүнийг Махасадва гэж ярьж болно. Тэрээр цаглашгүй гэрэлтэй, гэхдээ өөрийнх нь. Үгүй бол бидэнд дамжуулж чадахгүй. Учир нь Amitabha гэдэг нь цаглашгүй гэрэл гэсэн утгатай. Харин нэг хүнийг зааж байгаа биш. Хэрвээ тэр Махасадвагийн дотоодод энэ цаглашгүй гэрэл байвал бусдад дамжуулж болно. Хэнд ч бай жаахан гэрэл дамжуулж чаддаг. Тийм биш бол цаглашгүй гэрэлтэй гэж ярьж болохгүй. Учир нь “Цаглашгүй” болохоор хэчнээн дамжуулсан ч болно, ойлгож байна уу?

Ийм цаглашгүй гэрэлтэй бөгөөд бидэнд жаахан гэрэл харуулж чадах юм уу, бурхны аялгууг жаахан ч гэсэн сонсгож чаддаг л бол Махасадва мөн. Энэ “Бурхны аялгуу” нь мөн л гэрэлтэй адил, уг чанар нь ижилхэн, зөвхөн шинж чанар нь жаахан ондоо байдаг.

Яг л агаар болон ус шиг, жишээлбэл адилхан H<sub>2</sub>O боловч, ус бол харагддаг, агаар харин харагддаггүй. Гэхдээ хоёулаа бүтэц нь ижил, хэрвээ химийн явцыг нь мэдвэл агаарыг ус болгож, усыг агаар болгон хувиргаж болдог.

Тиймээс “гэрэл” үнэндээ хоёр зүйлийн агуулгатай, нэг нь “Аялгуу”, нөгөө нь “Гэрэл” болно. Энэ гэрэл нь цаглашгүй гэрэл гэсэн утгатай. Авид Бурхан бол бидний хардаг хээнцэр хувцас өмсчихсөн өнгөн талын тийм байдал төрхтэй биш шүү! Цаглашгүй гэрэл бол сая Авид Бурхан мөн. Нэгэн Махасадва нь бидэнд тиймэрхүү гэрлийг жаахан олгож чаддаг. Тэр нь аялгуунаас үүсэлтэй гэрэл, эсвэл гялбаат гэрлийн аль нь ч бай бүгд л гэрэл мөн. Тиймэрхүү гэрлийг харвал бага зэрэг билиг нээгдчихлээ гэж хэлж болно.

“Гэгээрэх” гэдэг нь ойлгох гэсэн утгатай. Ойлгох (明) гэдэг үг нь нар (日) болон сар (月) гэсэн хоёр үгнээс нийлж бүтсэн. Энэ нь бидний дотоодод гэрэл байгааг илтгэж буй. Энэ дэлхийд байхдаа Авид Бурханыг хараагүй, цаглашгүй гэрлийг хараагүй бол нас барах үед ч харж чадахгүй. Яагаад ийм байдгийг Багш нь ярьж өгье!

Энэ ертөнцөд байхдаа эмч болж чадаагүй бол нас барсны дараа яаж эмч болж чадах вэ? Тийм биш үү? Амьддаа юу ч сураагүй бол нас барсны дараа багш болох боломж байхгүй. Иймээс Шагжамуни Бурхан: “Хүний бие маш ховор нандин” гэсэн байна. Учир нь хүний биетэй байж л сая бясалгал хийж Бодьсадва болж чадна, гэгээрнэ, Махасадва болж чадна. Хэрэв ийм биш бол Шагжамуни Бурхан: “Хүний бие маш ховор нандин” гэж ярихгүй, харин нас барсны дараа ховор нандин болдог гэж хэлэх байсан. Учир нь нас барсны дараа Төгс баясгалант оронд очиж чадна, ойлгож байна уу? Тийм биш бол ад чөтгөр, тэнгэрийн элч, тэнгэрийн төрөлтөн ч бясалгал хийдэг. Яагаад зөвхөн хүн төрөлтөн л бясалгаж чаддаг вэ? Маш олон ад чөтгөр, тэнгэр элч, луун сахиус нар хүний төрөл авах маш дуртай. Хүн болбол бясалгал хийж чадна. Дараа нь туулан гэтэлж чаддаг бөгөөд үүрд туулан гэтэлдэг. Тэд сахиус, тэнгэрийн төрөлтөн болж, ид шид ихтэй, энгийн хүнээс жаахан чөлөөтэй, буянтай, зөн билигтэй байдаг хэдий ч үхэж төрөхөөс мултарч чадахгүй. Гурван ертөнцийг даван туулж чадахгүй. Иймээс тэд хэвлийгээр дамжин хүн болох маш дуртай. Ингэвэл хожим бясалгал хийж, үүрд туулан гэтэлж чадна.

Зарим хүн Багшаас нь үүрд туулан гэтлэх гэдэг нь ямар утгатай вэ? Яагаад туулан гэтлэх вэ? гэж асуудаг, яагаад гэдгийг

та нар мэдэх үү? Туулан гэтэлсний дараа юу хийх вэ? Зарим хүн энэ ертөнцийг маш гоё сайхан гэж үздэг, хэрвээ дахин буцан ирж чадахгүй бол яана аа гэнэ. Буцан ирж болно, ирэхдээ нэгэн Махасадва болно.

Эрх чөлөөтэй, буянтай, асар их хүчтэй хүн болж, хамаг төрөлтийг дагуулан, хамаг төрөлтнийг удирдан чиглүүлж, ядарсан хүмүүст тусалж, туулан гэтлэхийг хүсэх хүн байвал тусална. Энэ бол бидний амьдралын зорилго мөн.

Харин идэх, унтах, ажиллах, хүүхэд төрүүлэх, өтлөх, өвдөх, нас барах гэхчилэн нэг насаа элээх биш. Ингэх нь тун уйтгартай, хүний амьдрал ихдээ л зуун жил, гэхдээ ийм удаан жил амьдарч чадах хүн маш цөөн, наяд наслаад нас барах нь нэгэнт урт насалсанд тооцогддог. Зарим хүн хорь, гуч наслаад ертөнцөөс салж оддог. Иймээс “хүний бие” бол маш эрхэм нандин байдаг. Бие цогцосоо ашиглан бясалгал хийвэл нэгмөсөн туулан гэтэлж чадна. Нэгэн Махасадва хүнийг гэтэлгэхээр ирэхдээ хүний биеийг ашиглаж болох бөгөөд бусад бие цогцосыг ашиглан хүнийг гэтэлгэж болно. Та нар одоо ойлгосон биз дээ?

Лууз: “Мөрийг ярьж болдог бол тэр нь мөнхийн бус мөр мөн, нэрийг дуудаж болох бол тэр нь мөнхийн бус нэр болно.” гэж хэлсэн байна. Зарим үнэн ёсыг үг хэлээр ярьж илтгэж чадахгүй. Нэгэн өдөр миний өвөг Багш: “Үнэхээр тийм, би ярьж илтгэж чадахгүй.” гэжээ. Тухайн үед олон хүн “Гүн билиг ухаан”-ыг сонсохоор хүлээж байв. Гэтэл өвөг Багш маань яаж ярихаа мэдэхгүй байв. Учир нь дотоод дахь дэндүү олон зүйлийг хэчнээн жил ярьсан ч дуусдаггүй. Ярилаа ч гэсэн яримаар юм байдаггүй. Хүмүүс өөрөө бясалган өөрөө бодитойгоор ойлгох л учиртай. Бясалгагчид маш олон зэрэг дэстэй, хамгийн муу нь нэгдүгээр дэсийн хүн болно. Тийм хүн бол өөрөө бясалгал хийдэггүй, зөвхөн сониуч сэтгэлээсээ үүдэж, Махасадвагийн ном тайлах нь ямар онцгой бол, ямар агуулгатай юм ярьдаг бол гэж бодон бусдыг дагаж очдог.

Дараа нь хоёрдугаар дэсийн хүн, ийм төрлийн хүн дэсээр жаахан өндөр, Махасадватай байнга уулзаж, бясалгалын арга юм уу, сургаал ёсыг нь ахиухан шиг ойлгосны дараа дахин түүнд шавилж, ном уламжлуулж авшиг хүртэхийг боддог. Нэгдүгээр төрөл болон хоёрдугаар төрлийн хүний дэс нь тийм ч зөрүүгүй, гэвч хоёрдугаар төрлийн хүний дэс нь жаахан өндөр, учир нь нэгдүгээр дэсээсээ дэвшсэн бөгөөд Махасадвагийн ном тайлахыг сонсчихсон, номыг нь ч уншчихсан болохоор дотооддоо Махасадвагийн сургаал ёсны нөлөөг жаахан хүртсэн байдаг.

Үүнийг тэр өөрөө мэддэггүй байж мэднэ. Гэвч Махасадвагийн ярьсан сургаал номлол буюу бичсэн номын агуулга нь түүний оюун санааг бага зэрэг гэгээрүүлсэн байдаг. Энэ нь авшиг хүртэхээс өмнөх бэлтгэлээ нэгэнт хийсэнтэй тэнцдэг. Тиймээс авшиг хүртэх үед санаа сэтгэл нь тайвширч, Махасадвагийн номын цогцос болон сургаал ёсонд эргэлздэггүй.

Махасадва заримдаа дэндүү нигүүлсэнгүй байдгаас болж, эхлээд ном сонсоогүй, сургаал онолыг нь ч ойлгоогүй тэр хүмүүст мөн л авшиг хүртээн, үйл түйтгэрийг нь үүрдэг. Ингэх нь тэдэнд эхлээд бясалгал хийж, туулан гэтлэх завшаан олгож, дараа нь алгуураар энэ дотоодынхоо сэтгэгдэшгүй хүчээрээ, өөрийнхөө сэтгэлийн харанхуй бохир талаа угаан цэвэрлэхийг хүсдэгээс болж байгаа хэрэг.

Шавь нь авшиг хүртсэнийхээ дараа дахин ирэхээ больдог ч Махасадва хувилгаан биеэрээ шавьдаа очин зааварлан сургаж, муу зан чанарыг нь ариусган цэвэрлэдэг. Үүнийг шавь нь өөрөө ч мэддэггүй. Зөвхөн санаа сэтгэл нь улмаар саруулшин, сэргэлэн ухаантай, дотоодод нь ямар нэгэн хувирал гарсан шиг санагддаг. Энэ нь тэр нэгэнт хоёрдугаар дэсэд хүрснийг илтгэж байгаа юм. Урьд нь авшиг хүртсэн хэдий ч дэс нь өндөр биш, эрхиш хэсэг хугацаа өнгөрч байж, Махасадвагийн хүчээр дотоодоо өөрчилбөл сая дэс нь дэвшиж чадна.

Үүнээс гадна гуравдугаар дэс гэж байдаг. Гуравдугаар дэсэд өөрийн бие хэл сэтгэлээ өөрөө арчилж цэвэрлэдэг. Өөрийгөө нэгэн хоолой болгодог, ийм хоолой нь яг л усны хоолой шиг усыг дамжуулан бусад газарт хүргэдэг. “Хоолой” болох гэдэг нь ямар утгатай гэвэл тэр өөрөө бас ус болж хувирч чаддаг бөгөөд бусдад дамжуулж чаддаг.

Мэдээж тэр бол их далай биш, гэхдээ өөрт нь ус байдаг бөгөөд тэр нь гүн далайгаас эхтэй болохоор доторх ус нь их далайтай яг адил. Ус энэ хоолойгоор дамжин хаашаа ч урсан хүрч, тэр ч байтугай хэчнээн хол газар байлаа ч хүмүүст уулгаж чаддаг. Энэ бол гуравдугаар дэс болно. Ийм дэсэд хүрвэл бид түүнийг аравдугаар дэсийн Бодьсадва, хамгийн дээд Бодьсадва гэж нэрлэдэг. Нэр дэвшигч махасадва гэж ч ярьж болно. Нэгэн жинхэнэ Махасадва харахан болоогүй ч нэгэнт махасадвагийн хүчтэй болчихсон байдаг.

Иймээс нэгэн Махасадвагаас суралцвал хожим бид бас махасадва болж болно. Тийм агуу их, тийм хүчтэй болж болно. Харин зөвхөн Махасадвад л сая тийм хүч байдаг биш. Бид бас түүний хүчийг дамжуулах хоолой болж болно. Тэгвэл биднээр

дамжиж бусад төрөлтөнд тусалж болно. Учир нь Махасадва ганцаараа тийм олон газарт хүрч чаддаггүй болохоор түүний гар нь болж, олон хүнийг татаж, нэг доор байлгаж болно. Ингэснээр бид түүний хүмүүсийг гэтэлгэх багаж болдог. Гэхдээ Махасадва биднийг ашиглах, эсвэл эзэмдэн захирч ямар нэг хэрэг үйлдэхийг бодоогүй, огт ийм биш.

Махасадвагийн зам мөр маш чөлөөтэй, бид үнэндээ өөрийн дур хүслийнхээ дагуу хийж болно. Түүнээс суралцах эсэх, авшиг авах эсэх, хүн гэтэлгэх багаж болох эсэхийг бид өөрсдөө шийднэ. Махасадва бусдад хүчээр өөрийн сургаал ёсоо сонсгох юм уу, хүлээн авхуулах боломж огт байдаггүй.

Зарим доод дэсийн шашны бүлгийнхэн бол тэдэнд шавилмагц нэгмөсөн хүлэгдэж, салахад тун бэрх болдог. Байнга утасдаж, таныг асууна, шавиа томилон таныг эрнэ. Долоо хоногийн дөрөв, тав хоногоор хаалгыг чинь тогшиж үймүүлнэ. Салахыг бодовч нэмэргүй, заавал маш удтал хүлээж байж л салж чадах боломжтой. Үүнээс гадна бас танд ямар ямар ач буянтай хэрэг үйлдэх ёстой, хэд хэчнээн өргөл өгөх ёстой, долоо хоног бүрд хэчнээн хүнийг эрж олж, шашиндаа оруулж, тэднээс суралцах хэрэгтэй гэх юм уу, ямар ямар зүйл хийж, ямар ямар андгай тангараг тавих хэрэгтэй гэх мэтээр захидаг. Ингэж үүрэг хариуцлага ихээр үүрүүлэх нь үнэхээр төвөгтэй.

Энэ ертөнцөд ирмэгц бид эрх чөлөөгүй болчихдог. Тиймээс чөлөөтэй болж туулан гэтлэхийн төлөө сая тийм шашны бүлгэмд шавилж суралцдаг. Гэтэл эсрэгээр харин үл харагдах хүлээсэнд бүр ч ихээр хүлэгддэг. Ингээд байвал чухам хэзээ сая нэг чөлөөтэй болж чадах билээ. Амьтдаа туулан гэтлэхгүй бол нас барсны дараа яаж туулан гэтэлж чадах вэ? Тийм үү, үгүй юу? Хэнээс ч сурсан бай таныг чөлөөтэй байлгах хэрэгтэй. Одоо чөлөөтэй байж чадахгүй бол хэзээ чөлөөтэй болж чадах вэ? Үүнээс бид хамгийн дээд хүч гэж юу болохыг ойлгон таньж болно. Хамгийн дээд дэс нь улам чөлөөтэй. Улам амарлингуй тайвуу, үүрмээр хариуцлага гэж байдаггүй бөгөөд албадах хэрэг ч байдаггүй.

Бидний шавь нарын зарим нь Багшдаа шавилаад хоёр жил болжээ. Дөнгөж эхлэн сурах үедээ хааяа ирдэг байснаа хожим нь дахиад ирэхээ болив. Гэвч хэн ч түүнийг эрж хайгаагүй. Яагаад ирэхээ больчихов гэж утастсан хүн бүр ч байхгүй, эргэж үзэх хүн ч үгүй, юу хийж байгаа бол, яагаад ирэхээ болив гэдгийг мэдэх хүн байдаггүй. Энэ бүхнийг бид анхаардаггүй. Аливаа хэрэг жамаараа болж, ирж буцах нь өөрийн чинь дур. Хүн бүрийн үйл түйтгэр өөр өөр, буян нь ч адилгүй. Бид түүний өөрийнх нь сонголтыг



хүндэтгэнэ. Бясалгах хүсэл төрвөл дахин ирж үргэлжлүүлэн бясалгаж болно. Шаардлагагүй бол явж болно. Гэхдээ түүний бодол сэтгэлийг нь үймүүлэх шаардлагагүй бөгөөд оюун санааг нь ч хязгаарлах шаардлагагүй, ойлгож байна уу?

Сонсож байх нь ээ, маш олон бүлгэм нь ийм байдаг гэнэ. Тэнд хэсэг хугацаагаар суралцсаны дараа салахад тун бэрх болдог. Бидний энд бол өөрийн чинь эрх мэдэл болон нууцыг онцгой хүндэтгэдэг. Харин хэн нэг хүн Багшаасаа суралцсаны дараа найз нөхөд, хөршийнхөндөө бүгдэд нь мэдүүлэх хэрэгтэй гэх буюу заавал Багшаас нь сурах шаардлагагүй. Ингэх албагүй, Багшаасаа сурах эсэх нь өөрийн чинь хэрэг. Зөвхөн авшигтнууд л мэдэхээс бусад хэнтэй ч холбогдолгүй.

Нэгэн Махасадвагийн уламжилдаг нь хамгийн дээд номын цогцос болно. Түүний сургаал ёс нь энгийн байдлаас өөр, олон хүн хайж бүлгэмдээ оруулдаг биш. Хэчнээн хүн сурна, түүнийгээ сургаж, аливаа бүхнийг хамаг төрөлтний үйл үрийн дагуу байлгадаг. Гэхдээ ерөөсөө албаддаггүй бөгөөд зарлан сурталчилдаггүй. Маш чөлөөтэй, эрх дураар, шавь нарын үүрэг хариуцлага гэмээр зүйл тийм ч их байдаггүй.

Надаас ганцхан хоног сурсны дараа насан туршид шавь нь болох албагүй. Эсвэл Багшдаа ирэх болгондоо заавал өргөл барьц өгөх юм уу, долоо хоног болгон заавал ямар нэгэн хариуцлага гүйцэтгэхээр ирэх албагүй. Ирэх, ирэхгүй нь өөрийн чинь дур. Энд ирж суралцвал өөрт чинь ач тустайгаас биш, надад ямар ашигтай байх билээ. Багшийнх нь цорын ганц хүсэл гэвэл бүр ч олон сүнс чөлөөлөгдөх явдал. Учир нь Багшаасаа ахиухан суралцсаны ачаар толгой тархи сэргэг болно. Яагаад бясалгал хийх хэрэгтэй вэ? гэдгийг ойлгохын зэрэгцээ гэртээ харьсны дараа аяндаа илүүхэн бясалгах болж, дэс нь улмаар дэвшиж, аливаа зүйлд хүлэгдэж баригдахаа больж, түүнчлэн их хүчтэй болдог. Ийм байвал Багш нь мэдээж баярлана. Харин Багш маань биднийг тоохгүй байна гэж хэлж болохгүй. Тоогоогүйдээ биш шүү! Харин өөрийн чинь эрх чөлөөг хүндэтгэж байгаа хэрэг билээ. Багш нь тун ардчилалтай, бүх зүйлсийг та нар өөрсдөө шийднэ.

**Асуулт:** -Төгс Гэгээрсэн Их Багш аа! Очирт сударт ярьсан: “Сэтгэл хоргодох оронгүй бол татагдах сэтгэл үүсэхгүй.” гэдэг нь ямар утгатай вэ?

**Багш:** -Хүлээснээс чөлөөлөгдсөн хүнийг хэлж буй. Өөрөөр хэлбэл хүлэгдэж баригдахгүй гэсэн үг. “Би”-гийн гэр гэж байдаггүй. “Би”-гийн дэс гэж хаана ч байдаггүй. Гэхдээ

эрхбиш бясалгал хийж л ийм дэсэд хүрч чадна. Энгийн хүн ихэд хүлэгдэж, “сэтгэл” нь олон газар уяатай байдаг. Нэг байшинд суух нь дэндүү давчуу санагдахаар дахин өөр байр худалдан авдаг. Энгийн нэгэн бясалгагчийн хувьд нэг сүмд ганцаар суух нь дэндүү ихээр үрэлгэн байгаа хэрэг. Гэтэл тэр нэг сүмээ барьж дуусгахгүйгээр дахин өөр нэгийг худалдан авдаг. Нөгөө сүмийг муу баривал дахин өөр нэгийг байгуулдаг. Гэрээс гараагүй зарим хүн нэг зүйлийн барааны мөнгөө төлж дуусгалгүйгээр дахин шаардлагагүй өөр зүйлийн бараа ихээр худалдан авдаг. Энэ бол сэтгэл нь олон газарт “уяатай” гэсэн санаа мөн. Сэтгэл хаана ч хоргодохгүй гэдэг нь хүлэгдэхгүй байхыг хэлдэг. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Гэр бүлээ огоорч, ертөнцийг огоорч, аглаг ууланд нуугдан бясалгал хийхийг “сэтгэл хоргодох оронгүй” гэдэг юм биш. Сэтгэл хоргодох оронгүй гэдэг нь энэ ертөнцөд амьдардаг ч энэ ертөнцтэй холбоогүй. Хань ижилтэй байдаг ч хүлэгддэггүй. Зөвхөн өөрийн үүрэг хариуцлагаа гүйцэтгэх төдий. Харин заавал гэр бүлээсээ хөндийрөх юм уу, нийгмээс холдох шаардлагагүй. Гэхдээ заавал бусдаас хэтийдсэн хандлагатай байх хэрэгтэй. Ингэвэл сая жинхэнэ “Сэтгэл хоргодох оронгүй” болно, ойлгож байна уу?

**Асуулт:** -Даяаны бүлэгтний Жи Гон хувраг (Багш: даяаны бүлэгтэнд яагаад Жи Гон хувраг байв? Жи Гон хувраг яасан бэ?) Тэр гартаа тахианы гуя атгаад мөлжиж байсан, угаас нэгэн гэрээс гарагч байтлаа яагаад тахианы гуя иддэг байна вэ?

**Багш:** -Бага хөлгөний хувраг байж ч мэднэ. Буддын шашинд их хөлгөн болон бага хөлгөн гэх хоёр зүйл байдаг. Бирм, Тайланд, Шри Ланка зэрэг оронд очвол шар хувцастай хуврагууд тахианы гуя иддэгийг үргэлж харж болно. Зөвхөн Жи Гон богд л иддэг төдий биш. Би Бирмд очиход тэд тахианы гуяыг амтархан идэж байхыг харсан. Тэд бол бага хөлгөний хувраг, үүнийг язгуур буддын шашин гэж нэрлэдэг. Язгуур буддын шашныхан өөрсдийн бясалгалын аргаа Бурхан Багшийнхтай адилхан гэж үздэг. Бурхан Багш бадарлах үеэр хүмүүс юу өгнө, түүнийг нь иддэг гэдэгт итгэдэг болохоор мах, тахианы гуя, үхрийн хөл, үхрийн толгой, гахайн зүрх гэх мэт юуг ч иддэг бөгөөд үүнийгээ Шагжамуни Бурханы уламжлалыг шууд залгамжилсан гэж үздэг. Тиймээс өөрийгөө язгуур буддын шашин гэж нэрлэдэг.

Гэхдээ ингэж мах идэхээ буруу гэж боддоггүй “Шагжамуни Бурхан бадарлах үедээ хүмүүс юу өгнө, түүнийг нь иддэг тул бид Бурхан Багштай адилхан.” гэж мэтгэн маргадаг.

Мэдээж Бурхан Багш ондоо байсныг тэд мартжээ. Шагжамуни Бурхан бол Энэтхэгт бясалгал хийсэн. Тэд харин Бирмд бясалгал хийсэн учраас адилгүй. Яагаад вэ? гэвэл эртний Энэтхэгт хүмүүсийн ерэн есөн хувь нь ургамал хоол иддэг байжээ. Одоо ч мөн ийм, тэд хэрвээ Багшийнхаа үгийг итгэхгүй бол өөрөө Энэтхэгт очиж харж болно. Би нэгэнт харсан, одоогийн Энэтхэгчүүдийн тал хувиас дээших хүмүүс нь ургамал хоол иддэг. Учир нь тэд бол угаас Энэтхэг шашнаас үүсэлтэй шашинтнууд мөн. Шагжамуни Бурхан бол угаас Энэтхэг шашны хувраг мөн. Тэр Бурханы хутгийг олсны дараа сая буддын шашин гэж нэрлэжээ. Гэвч мөн л Энэтхэг шашнаас үүсэлтэй. Энэтхэг шашинтнууд ургамал хоол иддэг, шоргоолж ч хөнөөдөггүй. Тэд бүгдээрээ маш ариун сэтгэлтэй билээ. Тиймээс Шагжамуни Бурхан шар өнгөтэй орхимж өмсөж бадарлах үеэр хүмүүс түүнийг гэрээс гарагч болохыг мэддэг. Одоо ч гэсэн шар орхимжтой хүнийг харвал гэрээс гарагч болохыг таньдаг юм чинь эрт дээр үеийг хэлэх хэрэг юун? Яаж мэдэхгүй байж болох вэ? Энэтхэг бол төрөл төрөлдөө нэгэн ариун дагшин орон байсан. Та шар орхимж өмсвөл тэд хармагц хувраг болохыг таньж мэддэг. Ихэнх хүн нь багаасаа ургамал хоол иддэг. Шашны уур амьсгал маш их ийм нэгэн орны хүмүүс шар орхимжтой нэгэн настай хуврагт яаж мах өгөх боломжтой байх вэ? Тэдэнд угаас бусдад өгөх илүү мах байдаггүй. Би та нарт хэлье, Энэтхэг бол маш ядуу орон, тэд өөрөө идмээр махгүй байтлаа яаж бусдад мах идүүлэх боломжтой байж болох вэ? Тэдгээр бага хөлгөний хувраг Энэтхэгт очиж үзээгүй болохоор бодол санаа нь харанхуй хэвээр.

Энэтхэгт та шар орхимж өмсдөг л бол тэд дорхноо ургамал хоол идүүлж, мах иддэг хүн ч гэсэн ургамал хоолтон гэдгийг чинь мэддэг, ойлгож байна уу? Жи Гон хувраг нь хэн болохыг би мэдэхгүй. Тэр надад хэлээгүй, мах иддэг бол бага хөлгөний хувраг байж мэднэ. Бага хөлгөний хувраг бас ямар нэгэн дэсийг олж болно, болохгүй биш. Гэвч Бурханы хутгийг олж чадахгүй, мах идээд яаж бурхан болж чадах вэ?

Та “Баатар явагч их хөлгөн судар”-ыг уншсан уу? Мах иддэг хүн Бурханы хутгийг олж чадахгүй. Хамгийн дээд нь адын эзэн, дунд зэрэг нь адын иргэн, адаг доод нь шулам болдог гэж их хөлгөн сударт маш тодорхой бичжээ. Мах идвэл яасан ч бурхан болох боломжгүй. Бурхан болоход нигүүлсэнгүй байх хэрэгтэй. Хамаг төрөлтний гаслан зовуурь шингэсэн махыг яаж идэж болох вэ? Ямар төрлийн бурхан болох вэ? Хамаг төрөлтнийг гэтэлгэх биш, харин хамаг төрөлтнийг идэж хоослов, (Бүгд инээлдэв) нэг

талаар энэ төрөлтөнд ном тайлахын зэрэгцээ гэдэс нь өлсөхөөр өөр нэг төрөлтнийг шууд л бариад иднэ. (Бүгд инээлдэв.) Ингэх нь ёс зүйд огт нийцэхгүй. Жи Гон хувраг надтай уулзвал би түүнээс та үнэхээр мах иддэг байв уу? гэж асууна.

Гэхдээ ондоо нэг зүйлийн боломж бий. Жи Гон хуврагийн бясалгалын дэс нэгэнт маш өндөр болчихсон болохоор ид шидээр юм хувиргаж чаддаг. Жигнэмэг, тахиа гэхчилэн хувиргадаг. Ингэж хувиргаж байх нь хүмүүсийг шоглож тоглохын төлөө билээ, ойлгож байна уу? “Сансрын хүрдэнд эргэлдэх аяны тэмдэглэл”-д Жи Гон хувраг мах иддэггүй гэж маш тодорхой ярьсан. Бясалгалын дэс өндөр хүн юу хийсэн ч чадна. Түүний жинхэнэ санааг нь бид мэдэж чаддаггүй. Гэхдээ энгийн хүмүүс түүнийг дуурайж болохгүй. Учир нь бид ганц ширхэг тахиаг ч хувиргаж чаддаггүй болохоор тахиа нядалж болохгүй. Хожим бидний бясалгал дэвшиж, ид шидтэй, эрх дураар болбол тахиаг хувиргаж болно. Ямар нэгэн онцын шалтгаанаас хамаг төрөлтнийг сэхээрүүлэхийн төлөө, хүмүүсийг хэрхэн сэхээрэхэд нь ач тустай гэдгийг мэдэх тохиолдолд сая нядалж болно, ойлгож байна уу?

Өөрсдөө амь насыг үүсгэн бүтээж чадахгүй бол өөр нэгэн амийг яаж хороож болох вэ? Ингэх нь шударга биш, өөрөө бусдад алагдах дургүй байтлаа бусад төрөлтнийг яаж хороож болох вэ? “Сансрын хүрдэнд эргэлдэх аяны тэмдэглэл”-д нэгэн түүх байдаг. Нэг үхэр Жи Гон хуврагт идүүлэхийг гуйжээ. Ингэвэл үйл түйтгэр нь арилдаг. Тэгэхэд Жи Гон: “Би мах идэхээс тун айдаг, гэхдээ би ургамал хоол идээд маш удчихсан болохоор үснээс чинь хэдэн ширхгийг залгийг чамайг орлуулбал болно.” гэжээ. Энэ түүхээс бид Жи Гон хувраг бол ургамал хоол иддэг байсныг мэдэж болно.

**Асуулт:** -Урьд нь би нэг номын багшийн ном тайлахыг сонсоход Шагжамуни Бурхан гахайн шийр идсэнээс болж хожим нь суулгасан гэжээ. Энэ нь үнэн үү? Бурхны сударт ингэж байдаг уу?

**Багш:** -Үгүй, Шагжамуни Бурхан нирваандаа буцах үеэр нэг зүйлийн амтат мөөг идсэн. Тэр амтат мөөгний нэрийг самгарьд хэлнээс шууд орчуулбал гахайн шийр гэнэ, гэхдээ жинхэнэ гахайн шийр биш. Яг л нэг зүйлийн жимсийг эндхийн хүмүүс лууны нүд гэж хэлдэгтэй адилхан. Иймээс заримдаа та нар Багшдаа лууны нүд авчирвал би идэж зүрхлэхгүй гэж хэлдэг. Учир нь би ургамал хоолтон шүү! (Бүгд инээв.) Бор хоолны нэртэй идээ их байгаа хэдий ч үнэндээ ургамал хоол юм. Яг л зэрлэг лууны нүд буюу лууны нүд гэх жимстэй адил.

Шагжамуни Бурхан тийм амтат мөөгийг идсэнээс хэвлийгээр

нь өвджээ. Гэхдээ идэхээсээ өмнө ийм юм болохыг аль хэдийн мэдчихсэн байжээ. Тэрээр шавьдаа: “Та нар ийм амтат мөөгийг битгий ид, бүгдийг нь би идье, та нар шингээж чадахгүй. Идвэл төвөгтэй болно.” гэжээ. Тэрээр амтат мөөгийг идэхгүй байлаа ч мөн л таалал төгсөнө. Идэх, идэхгүй нь адилхан гэдгийг хэдийн мэдэж байсан бөгөөд энэ үйл үрийн хууль дүрмийг аялдан дагажээ. Мэдээж Бурхан Багш энэ үйл үрийг хувируулан үргэлжлүүлэн амьдарч болох бөгөөд үйл үрийн дагуу нирваандаа буцаж ч болно. Учир нь ажил нь дууссан бөгөөд цаг нь болсон болохоор буцах хэрэгтэй гэж бодсон байна.

Тийм амтат мөөгийг самгарьд хэлнээс орчуулбал гахайн шийр болж хувирдаг. Вьетнамын нэгэн номын багш, өөрөө Шагжамуни Бурхан болох тун дуртай. Долоо хоногт нэг толгой гахайн шийрийг бүгдийг нь иддэг. Би та нарт хэлье, энэ бол вьетнамын умард хэсэгт үүссэн үнэн түүх шүү. Та нар гахайн шийр идэж, Бурханы хутагт хүрэх үү? Тийм амтат мөөгийг хөрвүүлэхээр гахайн шийр буюу гахайн баясал гэх утгатай болдог. Бүгд л гахайтай холбоотой, яагаад ингэж нэрлэдгийг би та нарт тайлбарлая!

Энэтхэгт ийм амтат мөөгийг хайхад амархан олддоггүй бөгөөд маш ховор үнэтэй дээд зэргийн идээнд тооцогддог. Иймээс чин сэтгэлтэй хүмүүс түүгээр Шагжамуни Бурханд өргөл барьдаг. Ийм мөөг нь газрын дээр ургадаггүй, харин газрын доор ургадаг. Эрье гэвэл эрхбиш гахайтай хамт эрэх хэрэгтэй. Учир нь гахай бол амтат мөөг идэх тун дуртай тул “гахай баясах” гэж нэрлэжээ. Гахай хоншоороороо түүний байгаа газрыг нь үнэрлэн олдог. Үнэрлэж олонгуут тэр дорхноо шийрээрээ газар малтан олж иддэг. Гахай тун дуртай болохоор Энэтхэгт тийм амтат мөөгийг гахайн шийр гэх буюу гахай баясах гэж нэрлэдэг юм. Ойлгож байна уу?

Энгийн хүмүүс тийм амтат мөөгийг амархан эрээд олохгүй болохоороо эхлээд маш олон гахайгаар хайлгадаг. Хайж олсны дараа гахайгаа хөөж явуулдаг. Тиймээс гахайн шийр болон гахай баясах гэж ярьдаг нь адилхан. Гэтэл бид орчуулахдаа хайнга хандаж, цаадах утгыг нь гүнзгий ойлгоогүйгээс болж хойч үеийн хүмүүст маш олон эндүүрэл үүсгэж, Шагжамуни Бурханыг мах иддэг зэрлэг бурхан болгов. (Бүгд инээв.) Үнэхээр эмгэнэлтэй хэрэг мөн. (Гэхдээ ерэн хувиас дээш хүмүүс үүнийг мэддэггүй.) Тийм ээ! Яаж мэдэж чадах билээ! Мэдсэн бол энэ ертөнц оршихоо болино. Буруугаар ойлгодог хүмүүс байдаг болохоор энэ дэлхий ч орших ёстой. Үгүй бол бүгдээрээ бурхан болчихсон байж таарна.

Бүгд Багшийнхаа үгийг дагаж, бясалгаж суун Багшаасаа суралцвал асуудалгүй болно. Тиймээс хамаг төрөлтнийг гэтэлгэхэд үнэхээр хялбаргүй.

**Асуулт:** -Багш аа! Та одоо Тайваний амтат мөөгийг иддэг үү?

**Багш:** -Урьд нь идэх дуртай байсан, одоо дургүй болжээ. Учир нь би Нью-Йоркт байхдаа нэг өдөр хоол хийхээр хатаасан амтат мөөгийг усанд дэвтээсэн. Тэр үед дотроос нь жижигхэн хорхой маш олон гарч ирсэн бөгөөд агаар дутагдаж, яг л бид усанд сэлж чадахгүй тэлчилж байгаа шиг харагдсан. Тэгээд дахин идэж зүрхлээгүй. Бушуухан уснаас шүүн тэднийг аварсан. Дараа нь амтат мөөгөө бүгдийг нь тэдэнд өргөн: “За, өнөөдрөөс эхлэн би ийм амтат мөөгөнд гар хүрэхгүй. Та нар аятайхан зооглоорой!” гэсэн. (Муудсанаас болж хорхойтсон ч байж магад.) Тийм байж мэднэ. Гэхдээ хуурай идээ заримдаа бас хорхойтдог. Иймээс би идэх дургүй. (Тэгвэл бид амтат мөөг идэж болох уу?) Дуртай байвал идээрэй! Хамаагүй, учир нь зориудаар амь хороогоогүй. Багш нь тун мэдрэмтгий, бусдын идэхийг харахаар мөөгийг угаах явцад олон хорхой амиа алдчих нь гэж бодмогц жаахан ч дуршилгүй болдог тул идэх дургүй. (Та маш олон жижиг хорхойг харсан нь билгийн мэлмийгээрээ юу, эсвэл махан нүдээрээ юу?) Та нар сайтар ажвал харж чадна. (Гэтэл би яагаад хараагүй вэ?) Та нар буянтайгаас болжээ! (Бүгд инээв.) Амтат мөөг болгон нь хорхойтой гэсэн биш, гэхдээ алинд нь байгаа эсэхийг би мэддэггүй болохоор дахин идэхээ больсон. Ингэвэл сая сэтгэл зовохгүй болно.

**Асуулт:** -Багш аа! Та саяхан өмнөд орноос уламжлагдсан Бага хөлгөний Буддын шашинтнууд мах иддэг гэж ярьсан. Тэгвэл хожим тэд адын эзэн болох уу? Тэд Бурхан Багшийн шавь нар мөн үү?

**Багш:** -Та өөрөө “Баатар явагч их хөлгөн судар”-ыг уншаарай! Багшаасаа асуух шаардлагагүй. Би зөвхөн “Баатар явагч их хөлгөн судар”-ын сургаал ёсыг үндэслэн та нарт ярьсан. Энэ нь Багшийнх нь өөрийнх нь үзэл биш. Надад өөрийн гэсэн үзэл байдаггүй. “Баатар явагч их хөлгөн судар”-т: “Намайг нирваандаа буцсаны дараа энэ бурхан шашинтнууд хамаг төрөлтний махыг иддэг мөртлөө өөрийгөө бясалгал хийдэг гэж хэлдэг. Ийм хүн бол миний шавь биш.” гэж маш тодорхой ярьсан. Та Багшдаа итгэхгүй бол өөрөө “Баатар явагч их хөлгөн судар”-ыг уншвал мэдэж болно. (Бурхан багшийн шавь биш юм чинь тэгвэл адын эзний шавь биш үү?) Хоёр зүйлийн байдалтай. Адын, эсвэл Бурхан Багшийн шавь.

(Тийм юм бол нисваанисын зургадугаар тэнгэрийн төрөлтөн биш үү?) Ямар тэнгэр болох нь тэдний хэрэг. Үүнийг би мэдэхгүй, би зөвхөн та нарыг дагуулан гурван ертөнцийг гэтэлнэ. Өөр хэргийг би хамаарахгүй. Гэтэлгэх шаардлагатай төрөлтнүүд дэндүү их байхад тийм олон хэргийг яаж хамаарч чадах вэ? Тэд ийм дэсэд байдаг болохоор тэгж бясалгадаг. Цаг нь болохоор сэрж, их хөлгөний буддын шашинтнууд болно. Гэхдээ ургамал хоол идлээ гээд дорхноо Бурханы хутагт хүрч чадахгүй. Заавал нэгэн Махасадватай учирвал сая тийм боломжтой гэж би та нарт хэлье!

Америк эмэгтэй нэгэн Энэтхэг багшид шавилаад нэгэнт гуч гаруй жил бясалгажээ. Тэгээд нас барах үедээ: “Би гуч гаруй жил ургамал хоол идэж, маш цэвэр ариунаар амьдарч, садар самуун яваагүй бөгөөд эр эмийн явдал ч байгаагүй, аливаа зүйлийг Багшийнхаа зааврын дагуу хийдэг. Багшийнхаа заасан бясалгалын аргаар өдөр бүр бясалгаж суудаг. Ном тайлахыг нь байнга сонсож, Багшийгаа шүтэн дээдэлж сайхан бүхнээ Багшдаа өргөн, Багш юу ярина, түүнийг нь биелүүлдэг. Би өөрийгөө дуулгавартай, хичээнгүйлэн бясалгадаг сайн шавь гэж боддог. Гэтэл одоо болтол гэрэл ч хараагүй, аялгуу ч сонсоогүй, яагаад ийм байна вэ?” гэж гомдолложээ.

Хариулт нь тун амархан. Багш нь цаглашгүй гэрлийг бусдад дамжуулж чаддаггүй аж, ойлгож байна уу? Нэгэн сайн багш, нэгэн Махасадватай тааралдах нь хамгаас чухал.

Ургамал хоол идэх, өглөг үйлдэх, сахил сахих буюу цэвэр ариунаар амьдрах нь хамгаас чухал биш. Эдгээр зүйлийг чухал гэж хэлдэг нь бидний хичээнгүйлэн бясалгах болон түргэн дэвшихэд тусалдаг учраас тэр. Гэхдээ энэ нь мөн л хангалтгүй. Зөвхөн ачаагаа янзалсан төдий, онгоцны тасалбараа мөн л худалдан аваагүй бөгөөд суумаар онгоц ч байхгүй. Онгоцгүй бол хаана ч очиж чадахгүй, ойлгож байна уу?

Гадаад явахад мэдээж ачаа болон онгоцны тасалбар байх хэрэгтэй. Гэтэл онгоцгүй бол бид өөрөө нисэж чадахгүй тул явж чадахгүй. Махасадва бол яг л онгоц шиг биднийг ачаад явахад ямар ч асуудалгүй. Ачаа бол зөвхөн бидний амьдралыг жаахан тав тухтай болгодог. Гэхдээ ачаагүй ч гэсэн хамаагүй, онгоцны тасалбартай бөгөөд суумаар онгоцтой байх нь сая хамгаас чухал. Тийм үү, үгүй юү? Ачаатай, онгоцны тасалбартай байлаа ч онгоцгүй бол бас л хэрэгцээгүй. Иймээс нэгэн Махасадваг хайж олох нь хамгаас чухал.

**Асуулт:** -Зарим хүн өөрөө бясалгадаггүй. Харин мөнгөтэй болохыг Бодьсадвад даатгавал хүсэл нь биелэх үү?



**Багш:** -Өөрийнх нь буянаас хамаарна. Тийм ихээр мөнгөнд шунаж юу хийх нь вэ? Бодьсадвад даатгахад бас түүний буяныг харна. Харин Бодьсадва бүхнийг соёрхдог биш. Тэр муу хэрэг хийгээгүй бол Бодьсадва соёрхохгүй ч мөнгөтэй болж болно. Учир нь урьд төрөлдөө сайн үйл ихээр хийсэн болохоор энэ төрөлдөө хүн тэнгэрийн буянтай болдог. Жишээлбэл, урьд төрөлдөө хуврагт тахил өргөсөн юм уу, сүм хийд, эмнэлэг гэхчилэн байгуулсан бол үүнийхээ буяныг эдэлж болно. Тэр Бодьсадвагаас тусламж гуйхгүй ч гэсэн мөнгөтэй болдог. Үүнийг Бодьсадва соёрхсон биш, түүнд мөнгө өгч юу хийх вэ? Бодьсадва ийм хэрэгт сонирхолгүй. Бодьсадва биднийг мөнгө гуйхаар ирэхийг тэнд хүлээж зогсоод, өгөх эсэхээ бодож тархиа гашилгадаг биш. Бодьсадва тэгдэггүй, тэд маш яаруу, хамаг төрөлтнийг туулан гэтэлгэхээр завгүй байдаг. Харин хамаг төрөлтөнд мөнгө түгээдэг биш.

**Асуулт:** -Бодьсадва хамаг төрөлтний хүслийг сонсож, юу хүснэ, түүнийг нь өгдөг биш үү?

**Багш:** -Ингэх нь Бодьсадвагийн нигүүлсэнгүй сэтгэлийг буруугаар ойлгож байгаа хэрэг. Та хүн алья гэвэл танд туслан хүн алуулах уу? Ийм боломжгүй, Бодьсадва үүнд тусалдаггүй. Нэгэн эмэгтэйд атаархах юм уу, нэгэн эрэгтэйд дургүй хүрч Бодьсадвад даатган түүнийг алах, хорлох гэвэл Бодьсадва туслах уу? Туслахгүй, бидэнд тусалж хүн алуулах нь биднээр үйл түйтгэр үүсгүүлж, нөгөө хүнийг хорлож байгаа хэрэг билээ. Бодьсадва бол энэрэн нигүүлсэнгүй, яаж бидэнд тусалж, муу үйл үйлдүүлэх билээ? Ойлгож байна уу? Тийм гуйлтыг Бодьсадва тусалж биш, өөрийн чинь “бодол” үйлдсэн, өөрөө үйлдсэн үйл түйтгэр болно.

Мөнгөтэй болж чадвал мөн л урьд төрөлдөө өглөг үйлдсэнээс болдог. Харин Бодьсадва бидэнд тусалсан биш. Мэдээж ядуу айлын ядарсан нэг хүн чин сэтгэлээсээ Бодьсадвад даатган хүнд бэрхээс гарахыг гуйх үед бас тусалдаг. Гэхдээ Арьяабалын бясалгалтанд туслахад нэлээд хялбар бөгөөд нэлээд түргэн. Учир нь Бодьсадватай нэгэнт холбогдсон болохоор гуйхгүй ч гэсэн тусалж, чамайг харгалзана. Та бол жинхэнэ бясалгах хүсэлтэй байдгийг Бодьсадва мэддэг болохоор бэрхшээлтэй болох үед тусалдаг. Тэгээд хүнд бэрхийг туулсны дараа дахин үргэлжлүүлэн бясалгах болно.

Гэхдээ бид юу хүснэ, Бодьсадва бүхнийг зөвшөөрдөг болохоор бясалгал хийдэг юм биш. Ийм бодол яасан ч бодож болохгүй. Ийм “бодол санаа” өвөрлөн бясалгах нь ач тусгүй, зөн билиг мэдрэгдэхгүй. Чин сэтгэлээсээ бясалгадаг хүн бол юуг

ч хүссэн бүх зүйл байх болно гэж би та нарт баталж чадна. Би маш олон улс орноор очиж, бараг бүх дэлхийг тойрон аялсан. Тэгэхэд Бодьсадва ямагт надад тусалсан байдаг. Гэхдээ надад юу ч байгаагүй. Тайваньд ирэх үед бас л гар хоосон байсан. Мөнгө төгрөг, эр нөхөр, хүүхэд шуухад байгаагүй. Ямар ч ажил төрөл байгаагүй. Юу ч үгүй байсан хэдий ч юугаар ч дутаагүй. Аливаа зүйл аяндаа л байх болж, авахгүй гэсэн ч болдоггүй.

Бодьсадва хэн нэгнийг хамгаас онцгойлон харгалздаг биш. Тэгдэггүй, үнэнхүү цэвэр цайлган сэтгэлтэй, Хан тэнгэрийн өмнөөс ажиллаж, Хан тэнгэрийн өмнөөс шударга ёсыг гүйцэтгэж, хайр энэрэлтэй, нигүүлсэнгүй, хамаг төрөлтнийг гэтэлгэх хүсэлтэй л бол юугаар ч дутахгүй болно. Нээрээ ийм гэдгийг би батална. Учир нь би өөрөө үнэн бодитоор ойлгосон тул ингэж хэлж байна. Гэхдээ та нар: бясалгал хийсний дараа юугаар ч дутахгүй болно гэж Багш ярьсан болохоор даруй Багшид шавилах хэрэгтэй гэж битгий бодож бясалгаарай! Ийм бодолтой хүн байвал өөрийгөө сайтар хянан шалгах хэрэгтэй.

**Асуулт:** -Багш танаас энэ бясалгалын аргыг сураад хараахан амжилтад хүрч амжилгүйгээр нас барчихвал Багш та энэ ертөнцөөс салж яваагүй бол намайг дагуулан дээш гарч болох уу?

**Багш:** -Яагаад болохгүй гэж? Багш нь энэ махан цогцос биш, дэс болгонд байж байдаг. Та аль ертөнцөд хүрвэл тэнд таныг хүлээж байдаг. (Би бясалгаж хараахан амжилтад хүрээгүй бол.) Хамаагүй, та аль ертөнцөд хүрсэн ч Багш нь харгалзана. (Хожим шавь нар тань дэндүү олон болохоор намайг мартчихаас айж байна.) Та нар Багшийгаа мартчихаас санаа зовох хэрэгтэйгээс биш, Багш нь та нарыг мартахаас санаа зовох хэрэг юун? Шавь гэмээр улс үнэндээ тийм ч их байхгүй. Бүхий л ертөнц бултаараа шавилсан ч асуудалгүй юм чинь ганц, хоёрхон шавьд ямар асуудал үүсэх билээ? Жижигхэн Тайванийг хүртэл бүгдийг нь гэтэлгэж чаддаггүй.

Нэгэн жинхэнэ багш үй түмэн хувилгаан биетэй, авшиг хүртсэн шавь болгоны дотоодод нэгэн хувилгаан багш бий. Багшийн энэ бие цогцос нь чамайг дагуулж явах биш. Харин хувилгаан бие нь дагуулж явна. Учир нь тэр хаа сайгүй оршдог. Ойлгож байна уу? Багш чинь энэ бие цогцос биш.

**Асуулт:** -Багшийн хувилгаан бие нь Багшийг удирдан чиглүүлэхийг шаарддаг уу?

**Багш:** -Шаардахгүй, жишээлбэл, нэгэн бүрмөсөн шинэчилсэн ажиллах өрөөний аливаа зүйлс нь автоматчилагдсан

байдаг. Энэ “би” үгүй ч гэсэн хүссэн бүхэн чинь байх болно. Харин заавал Багшдаа ярьж байж л сая олдог юм биш. Яг л бараа худалддаг автомат машин шиг, юу авъя гэвэл товчлуурыг нь дарснаар болчихдог. Машин хүртэл бодлыг чинь ойлгож болдог байтал Багш нь яагаад ойлгож болохгүй байх вэ? Та Багшийгаа машины дайнд ч хүрэхгүй гэж бодож байна, тийм биш үү? (Бүгд инээв.)

Багш нь энэ махан цогцос биш гэж би байнга хэлдэг. Хэрвээ Бурхан Бодьсадвагийн хүч шууд дамжигдвал бидний эгэл хүн гэсэхийн аргагүй. Учир нь энэ ертөнцийн уур амьсгал нь Төгс баясгалант орны уур амьсгалтай адилгүй болохоор Бурхан Бодьсадва энэ ертөнцөд шууд илэрч болохгүй. Заавал нэгэн бие цогцосоор дамжих хэрэгтэй. Гэхдээ энэ бие цогцос нь зөвхөн нэгэн төхөөрөмж төдий. Усаар жишээлэхэд, эхлээд усны хоолойгоор дамжин дараа нь сая нэг хотын хүмүүсийн гэрт хүрдэг. Үгүй бол ус яаж ирэх вэ? Эхлээд усны хоолойг ашиглахгүйгээр усыг шууд уулан дээрээс урсгавал ихэд булиггартах болно. Ингэвэл яаж уух вэ? Цайгаа яаж чанах вэ? Тиймээс усыг заавал нэгэн хоолойд хадгалж, хэрэглэх үед хэзээ ч нээж болдог. Цай чанаж, хоол хийж болно. Бурхны хүч мөн л ийм. Ариун орноос шууд дамжин ирж болохгүй. Энэ хүч бол хэлбэр дүрсгүй, баригддаггүй, харагддаггүй, халаасандаа хийж болдог зүйл биш.

Иймээс нэгэн бие цогцос, нэгэн төхөөрөмжийг дамжих хэрэгтэй. Ингэвэл сая та нар хэрэглэж болно, ойлгож байна уу? Иймээс энэ бие цогцосын дотор бурхны хүч байдаг бөгөөд энэ бурхан нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг хэлж байгаа биш. Энэ бие цогцос нь бурхан биш. Харин дотоодын хүч нь сая бурхан мөн. Энэ хүчийг бид “Махасадва” гэж нэрлэдэг. Гэхдээ гадна талын хэлбэр төрх байхгүй бол та нар энэ хүчтэй нэвтрэлцэх боломжгүй, холбогдож чадахгүй. Ямар байдалтайг нь мэдэж чадахгүй, энэ бие цогцосыг задлан, доторх Махасадвагийн хүчийг хайж олох боломжгүй. Жишээлбэл, зурагтын дэлгэц дээр маш олон үзэгдэл гардгийг бяцхан хүүхэд мэддэггүй. Зурагтын дэлгэцийг задалбал цаадах тэр хүмүүс нь гарч ирдэг гэж боддог. Гэтэл задалсны дараа юу ч үгүй болдог. Учир нь зурагт нь энэ үзэгдэл биш. Гэвч зурагтгүй бол үзэгдлийг харж чадахгүй, ойлгож байна уу? Учир нь үзэгдэл нь агаар дотор оршин баригддаггүй бөгөөд харагддаггүй. Заавал нэгэн онцгой төхөөрөмжөөр дамжвал сая харагдаж чадна. Тиймээс Шагжамуни Бурхан эрхбиш энэ ертөнцөд ирэх хэрэгтэй. Шагжамунийн тус бие нь энэ бурхан биш. Гэхдээ бурхны хүчтэй. Энэ хүчийг хожим нь ахмад шавь Маха Гашибт уламжлан

дараа нь дахин Анандад уламжлав. Улмаар дахин үргэлжлүүлэн уламжилсаар одоо Багшид нь уламжилсан байж ч мэднэ. Хожим дахин өөр хүнд уламжилдаг. Тиймээс та нар санаа зоволтгүй шүү! (Бурханы хутгийг хараахан олоогүй хүнийг дагуулж дээш гарч болох уу?) Хаана хүрэх вэ? Дэсээр хангалтгүй бол хамгийн дээд түвшинд дагуулж очсон ч тэнд оршиж чадахгүй. Ахлах, дунд сургуулийн сурагчийг би яаж их сургуульд суралцуулж чадах вэ? Яарч хэрэггүй, алгуураар суралц. Хожим их сургуульд ороод дэвшиж сурч чадна. Тийм үү, үгүй юү?

## **ВЕГАН ХООЛНЫ АЧ ТУС**

Насан турш веган (ногоон) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгалын (Quan Yin Method) авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтан бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь яриангүй. Бусдад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь “ямар үйл хийнэ, тийм үр байна” гэсэн үйлийн үрийн хуулиар зохицуулагддагаас тэр юм. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан, өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг. Зарим хүн сүнслэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

## ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн цагаан хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбын их сургуулийн доктор Г.С.Хантингтон хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Махан дахь эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээс шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлхтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдэсэнд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез уураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез уураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хатах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махан дахь холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх

хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсэхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй. Амьтан нэг бүрийг бүү хэл зүсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаях маягаар өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ногоон хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: “Бид веган хоол идвэл хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллоно!” гэжээ.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стеройд зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодисууд хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махан дахь антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажилласан бөгөөд эмнэлгийн ажилтан, өвчтөн цөмөөрөө веган хоол иддэг эмнэлэг байгуулсан байна. Тэрээр: “Орчин үеийн шинжлэх ухааны ачаар эм, эмнэлгийн шинжлэх ухаанд их дэвшил гарсан ч эм нь зөвхөн өвчнийг л анагаана. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэнэ.” гэжээ. Мөн тэрээр: “Ургамлаас авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүнд байдаг ихэнх өвчнийг тээдэг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?” гэжээ. “Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч эрүүл саруул байх бүрэн боломжтой.” гэж Доктор Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард “Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй.” гэж зарлажээ.



Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 веган хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд веган хоолтнууд нь илүү гэсвэр хатуужилтай байжээ. Туршилтад оролцогсдыг удаан хугацаагаар гарыг нь өргүүлэхэд үр дүн нь тун тодорхой байв. Мах иддэг 15 хүний 2 нь л арван таваас гучин минут өргөсөн бол веган хоолтон 32 хүний 22 нь арван таваас гучин минут, 15 нь хагас цаг, 9 нь нэг цагаас дээш, 4 нь хоёр цагаас дээш, нэг нь гурван цагаас дээш хугацаагаар өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Мур 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг эвдсэн байна. Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ байхыг би хүссэн юм.” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний уураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4,5%-ийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%-ийн илчлэгийн эх үүсвэр нь уураг юм. Иймээс мах хэрэглэхгүй, веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тос хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин, батга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусан дахь чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно.

Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.

## **ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН**

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд, шагааж устгасан 5 метр квадрат ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр цочирдмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр бордоход хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болох сон. Хэрэв нэг акр газарт овьёос тарьж, малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас 8 дахин их уураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцаа (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их уураг, илчлэг, ниацин өгдөг. Иймэрхүү тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялаг илүү үр ашигтайгаар зарцуулагдана.

Веган хоол танд энэ гараг дээр “өр төлөөсгүй амгалан амьдрах” боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд, амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

## ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

## АМЬТНЫ ЗОВЛОН ЗҮДҮҮР

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100,000 гаруй үхэр нядалдгийг та бүхэн харсан уу?

Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг “үйлдвэржсэн аж ахуй”-д тэжээж байна. Эдгээр фермүүд бага зардлаар олон мал амьтдыг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд, тэжээлийн мах бэлтгэдэг машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. “Та нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно.” гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Цагаан хоол бол хүнлэг энэрэнгүй чанарын өндөр шалгуур юм.” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтанд ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.

## ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид, жишээ нь, Платон, Диоген, Сократ нар цагаан хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” гэж өгүүлжээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хувраг цагаан хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувуудын хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө.” (Эхлэл, 1:29) гэж Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай.” (Эхлэл, 9:4) гэсэн үг юм. Эзэн Бурхан: “Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэгтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ цустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм нүглээ наманчил.” (Исаиа, 1:11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг.” (Ромчуудад илгээсэн захидал, 14:21) гэсэн байдаг.

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр тодруулсан эртний олон судар ном олж илрүүлсэн байна. Есүс: “Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол хүний үхдэл хүүрийн мах идэж байгаа хэрэг юм.” гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь: “Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!” (Энэтхэг шашны сахил) гэснээс харагдана.

Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг.

Хятадын агуу их Зэн Багш Хань Шань-Зу мах идэхийг эрс эсэргүүцсэн найраглал туурвиж: “Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!” хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаач, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс цагаан хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолд Эмерсон, Хенри Дэвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Ж.Уэллс, Альберт Эйнштейн, Рабиндранат Тагүүр, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Альберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар цагаан хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв.

Альберт Эйнштейн хэлэхдээ: “Миний бодлоор бол цагаан хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай юм. Иймээс хүмүүс цагаан хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай юм.” гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, сэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

## АВШИГ ХҮРТЭХҮЙ - АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг сэтгэлийн авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажих” гэдэг нь хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажих багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан.” (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) гэжээ. Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Шабд”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн, бүхий л орчлон ертөнцийг гэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэн, бүхий л хүсэл эрмэлзлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл- “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авхуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь

авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

- Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.
- Насаараа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.
- Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө бясалган дадуулж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод бясалгал дадалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авна.



## ТАВАН САХИЛ

1. Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ.\*
2. Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ.
3. Өөрийн бус зүйл авахыг цээрлэнэ.
4. Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ.
5. Согтууруулах, мансууруулах бодис болон хорт зүйл хэрэглэхийг хориглоно.\*\*

\* Энэ сахил нь веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг) гэх мэт амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

\*\* Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи, тамхи, хар тамхи, мөрийтэй тоглоом, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг, уран зохиол, цахим тоглоом тоглох зэрэг аливаа хорт зүйлээс зайлсхийх явдал багтана.

## **ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр**

Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-10), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Төвөд (1), Унгар (1), Фин(1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт**

Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1-2), Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багш шавийн хоорондын захиа**

Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)

### **Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд**

Ау Лак (1-2), Хятад (1-2)

### **1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал/ тусгай хэвлэл**

Англи (1), Ау Лак (1)

### **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал**

Англи (1-6), Хятад (1-6)

### **Их Багшийн ярьсан үлгэр түүх**

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

### **Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн үлгэрүүдийг ухаарахуй**

Англи, Ау Лак, Хятад

### **Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам**

Англи, Ау Лак, Хятад

### **Амьдралаа солонгоруулъя**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

### **Эрүүл мэндээ ухаарахуй - Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг**

Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**

Англи/Хятад (ном + CD)

**Онч мэргэн үгс (1)**

Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман, Англи/Солонгос, Англи/Япон

**Онч мэргэн үгс (2)**

Англи (1), Хятад (1)

**Тэнгэрлэг зоог - Олон улсын цагаан хоолны гал тогоо**

Англи/Хятад, Ау Лак, Япон

**Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт**

Англи/Хятад

**Диваажингийн урлаг**

Англи, Ау Лак, Хятад, Монгол

**Жинхэнэ хайр**

Англи, Хятад, DVD, MP4

**Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)**

Англи/Ау Лак/ Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог**

Англи/ Ау Лак/ Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог - Уран зургийн цувралууд**

Англи (1), Хятад (1)

**Тэнгэрийн хувцас**

Англи/Хятад

**Шувууд миний амьдралд**

Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

**Эрхэм ариун амьтад**

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

**Аниргүй нулимс**

Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

**Вуузуу шүлгүүд**

Англи, Ау Лак, Хятад

**Мартагдсан дурсамж**

Англи, Ау Лак, Хятад

**Хайрга ба Алт**

Англи, Ау Лак, Хятад

**Эрвээхэйн мөрөөдөл**

Англи, Ау Лак, Хятад

**Өмнөх амьдралын зам мөр**

Англи, Ау Лак, Хятад

**Хуучин цаг**

Англи, Ау Лак, Хятад

**Эрин зууны хайр**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Аниргүйхэн нулимсыг хайрлахуй**

Англи, Хятад, CD, DVD, MP4

**Амьдрал болоод ухамсрын тухай бодрол:**

Доктор Янезын бичсэн ном, Хятад хэл дээр

**Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс**

<http://crisis2peace.org> хаягаар олон хэл дээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

Бусад айлдварууд болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Балба, Норвег, Перс, Филиппин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланка, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэл дээр хэвлэгджээ.

## **БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?**

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса, БНХАУ (36899)  
Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе, Калифорни 95173-0247, АНУ

### **Суприм Мастер Телевиз**

И-мэйл: [Peace@SupremeMasterTV.com](mailto:Peace@SupremeMasterTV.com)

Утас: 1-626-444-4385

Факс: 1-626-444-4386

### **Ном орчуулгын групп:**

И-мэйл: [divine@godsdirectcontact.org](mailto:divine@godsdirectcontact.org)

(Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд оролцож болно.)

### **Мэдээний групп:**

И-мэйл: [lovenews@godsdirectcontact.org](mailto:lovenews@godsdirectcontact.org)

### **S.M. Celestial Co., Ltd:**

И-мэйл: [smclothes123@gmail.com](mailto:smclothes123@gmail.com);

[vegan999@hotmail.com](mailto:vegan999@hotmail.com)

Утас: 886-3-4601391

Факс: 886-3-4602857

Веб сайт: <http://www.smcelestial.com>

<http://www.sm-celestial.com>

### **Асуулт хариултын баг:**

И-мэйл: [lovewish@godsdirectcontact.org](mailto:lovewish@godsdirectcontact.org)

### **Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани**

И-мэйл: [smchbooks@godsdirectcontact.org](mailto:smchbooks@godsdirectcontact.org)

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

Веб сайт: <http://www.smchbooks.com>

### **Онлайн дэлгүүр**

Celestial Shop: <http://www.theCelestialShop.com> (Англи)

Eden: <http://www.EdenRules.com/> (Англи, Хятад)

### **Цэвэр веган бүтээгдэхүүний онлайн дэлгүүр**

<http://www.lovingfood.com.tw>

### **“Loving Hut” Олон Улсын Веган Хоолны Сүлжээ ресторан**

И-мэйл: [service@lovinghut.com](mailto:service@lovinghut.com)

Утас: 886-3-4683345

Факс: 886-3-4681581

Веб сайт: <http://www.lovinghut.com/tw/>

### **Арьяабалын бясалгалын аргын веб сайтууд:**

Бурхангай шууд холбогдох – Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:

<http://www.godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm>

Энэхүү хаягаар дэлхийн олон хэл дээрх Арьяабалын бясалгалын аргын веб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.

Мөн олон орны хэл дээр “Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр” үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

### **Суприм Мастер Телевиз**

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.

Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнгаар үзэх хаяг:

<http://suprememastertv.com/mn1/>

**Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр) номыг олон хэл дээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэл дээр)**

<http://sb.godsdirectcontact.net>

## АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР-5

**Зохиогч:** Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон  
Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

Хаяг: Тайбэй хот, Жүнзэн дүүргийн баруун замын 1-р хэсэг,  
72-8-16

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

И-мэйл : [smchbooks@Godsdirectcontact.org](mailto:smchbooks@Godsdirectcontact.org)

<http://www.smchbooks.com>

Шуудангийн дугаар: 19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987-2016

Зохиогчийн эрх: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Энэхүү номын агуулгыг хэвлэлийн компаниас зөвшөөрөл  
авсны дараа хуулбарлаж болно.

### **5 дугаар боть**

1 дүгээр хувилбар 1991.04.01-ний өдөр

2 дугаар хувилбар 1992.10.20-ны өдөр

3 дугаар хувилбар 1993.07.20-ны өдөр

4 дүгээр хувилбар 1996.01.20-ны өдөр

5 дугаар хувилбар 1998 оны 10 дугаар сар

6 дугаар хувилбар 2004 оны 5 дугаар сар

7 дугаар хувилбар 2014 оны 11 дүгээр сар

Хялбаршуулсан хятад хэл дээр бичсэн хувилбар

2015 оны 11 дүгээр сар

Энэ хувилбарыг монгол хэлнээ орчуулсан

2023 оны 2 дугаар сар

Цахим хувилбар:<http://www.gegeerel.mn/>

2023 оны 6 дугаар сар





Энэ дэлхийд залран буй Төгс Гэгээрсэн Их Багштай учрахад хэцүү, жинхэнэ дээд номыг хүртэхэд бэрх гэдгийг үнэнийг эрж хайсан бидний бэрхшээлт замнал гүнзгий ухааруулсан юм. Арьяабалын бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлагдан ирсэн охь дээд номын дамжлага мөн учраас хүмүүний мөн чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн номыг ухааруулж чадна. Энэхүү номын ёсоор бясалгаад бид бүхэн хэмжээлшгүй их ач тусыг хүртсэн тул бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан дээдийн номын айлдваруудыг эмхэтгэж, энэ төрөлдөө сансрын хүрднээс ангижрахыг хүссэн, жинхэнэ үнэн номыг хайсан, үхэж төрөх, бясалгал, гэгээрэл, үнэн мэдлэгийн тухай асуултууддаа хариулт хайж буй хүмүүст туслахыг зорин энэхүү номыг өргөн барьж байна.